

MNS 2492: 2004

Улсын бүртгэлийн дугаар:

Аравтын бүрэн

гэрээний дугаар:

ангиллын код

Нууцлалын зэрэглэл: Б

Төсөл хэрэгжүүлэх

ШуГх/ОХУ/-2019/09

## БУРХНЫ ШАШИН СОЁЛ СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН

### **ӨНДӨР ГЭГЭЭНИЙ ТИГ ХИЙЦИЙН УРЛАГ СОЁЛЫН ӨВИЙГ СУДЛАХ, МОНГОЛ ОРОСЫН МУЗЕЙ, ОЛОН НИЙТИЙН БОЛОН ХУВЬ ХҮМҮҮСИЙН ГАР ДЭЭРХ ЦУГЛУУЛГЫН МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭХ, БҮРТГЭХ АРГАЧЛАЛ БОЛОВСРУУЛАХ НЬ**

**сэдэвт гадаадтай хамтарсан төслийн эцсийн тайлан**

**2019-2021**

Төслийн удирдагч:

Г.Мягмарсүрэн доктор (Ph.D)

Зүүн хүрээ Дашчойлин хийдийн Бурхны шашин соёл  
судлалын хүрээлэнгийн захирал

Захиалагч байгууллага:

Боловсрол, Шинжлэх Ухааны Яам

Санхүүжүүлэгч байгууллага:

Шинжлэх ухаан технологийн сан

Тайлан өмчлөгч:

Бурхны шашин соёл судлалын хүрээлэн

Сүхбаатар дүүрэг дүүрэг, 8-р хороо, Зүүн хүрээ

Дашчойлин хийд, 11-350279

УЛААНБААТАР

2023 ОН

## Гарчиг

Реферат.....	3
Төслийн зорилго.....	10
Төслийн үр дүнгийн даалгавар.....	12
Төслийн календарьчилсан төлөвлөгөө, түүний биелэлт.....	14
Төслийн гүйцэтгэгчдийн тайлант хугацаанд хийсэн ажлын жагсаалт.....	19
Төслийн судлагдсан байдал.....	21
Төсөл хэрэгжүүлсэн байдал.....	27
Томилолтоор ажилласан байдал.....	70
Дүгнэлт.....	86
Талархал.....	88
Хавсралт 1. Төсөл хүлээж авсан Эрдмийн зөвлөлийн тогтоол, хурлын протокол.....	89
Хавсралт 2. ОХУ-ын хамтран гүйцэтгэгч байгууллагын тодорхойлолт.....	95
Хавсралт 3. Төслийн үр дүнд гарсан бүтээлийн жагсаал.....	97
Хавсралт 4. Занабазарын уран бүтээлтэй холбоотой цахим санд оруулах эх хэрэглэгдэхүүн.....	101

## РЕФЕРАТ

**Төслийн нэр:** Өндөр гэгээний тиг хийцийн урлаг соёлын өвийг судлах, Монгол Оросын музей, олон нийтийн болон хувь хүмүүсийн гар дээрх цуглуулгын мэдээллийн сан бүрдүүлэх, бүртгэх аргачлал боловсруулах нь

“Выявление, учёт и исследование объектов художественного наследия Дзанабазара в музейных, общинных и частных коллекциях России и Монголии: создание базы данных и разработка методологии”

“Identification, accounting and researching of art objects of Zanabazar’s heritage in the Mongolian and Russian state museums, communities and private collections: database creation and methodology development”

Монгол Орос хоёр улсын хамтарсан төслийн хүрээнд 2019-2022 оны хооронд ОХУ-ын Москва, Санктпетрбург хот, Буриад улсын үндэсний болон шашин, угсаатны музей, Монгол Улсын зарим хийд, музей, хувь хүмүүсийн гар дээр хадгалагдаж буй Өндөр гэгээн Занабазарын өөрийн мутраар урласан болон түүний загвар хийцийн бүтээлүүдийг бүртгэсэн судалгааны ажлын үр дүнг энд авч үзнэ. Ташрамд, Өндөр гэгээн Занабазар урлагийн ямар төрөл зүйлээр уран бүтээлээ туурвиж байв, түүний уран бүтээлийн давтагдашгүй онцлог нь юу болохыг тодруулахыг хичээсэн болно.

Өндөр гэгээн Занабазарын уран бүтээлийн судалгаа сүүлийн үед эрчимтэй хөгжиж байна. Бид Өндөр гэгээн Занабазарын уран бүтээлийг бүртгэхдээ дүрслэх урлагийн төрөл зүйлийнх нь үүднээс түүний намтрын судалгаа болон сүүлийн арваад жилийн хугацаанд явуулсан археологийн судалгааны үр дүнд тулгуурлан дахин тодорхойлсны зэрэгцээ Өндөр гэгээн Занабазарын уран бүтээлийн гоо зүйн онцлогийн тухай асуудлыг хөндөж үзэхийг зорилго болголоо. Ингэснээр Өндөр гэгээн Занабазарын урлагийн мөн чанарыг зөвөөр ойлгож, түүний уран бүтээлийн онцлогийг тодорхойлон гаргахад чухал ач холбогдолтой юм. Энэ цаашлаад Өндөр гэгээн Занабазар монгол хүний гоо сайхныг бурхдын дүрээр илэрхийлсэн үү, аль эсвэл бурхдын үнэмлэхүй, төгс төгөлдөр гоо сайхныг дүрслэхийг зорьж байв уу гэсэн асуултад хариулт өгч, уг асуудлыг мухарлахад зохих үүрэг гүйцэтгэнэ хэмээн үзэж байна.

## Нэг. Өндөр гэгээн Занабазарын уран бүтээлийн төрөл чиглэл

Өндөр гэгээн Занабазарын бүтээл туурвилийг төрөл зүйлийнх үүднээс шинжлэн үзвэл уран баримал түүний дотор хүрэл цутгуурын чиглэлээр голлон ажиллаж байжээ. Хүрэл цутгуурын аргаар бүтээсэн олон алдартай бурхдын баримал нь эдүгээ хадгалагдан ирсэн нь Занабазарыг уран бүтээлчийнх нь хувьд алдаршуулсан гол бүтээлүүдэд тооцогдоно. Харин Өндөр гэгээн Занабазарын уран баримлын төрөлд шавар керамик урлал зохих түвшинд хөгжиж байсныг ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгээс 2013-2020 онд хэрэгжүүлсэн “XVII зууны Монголын хотууд” төслийн хүрээнд академич С.Чулууны удирдсан хээрийн судалгааны анги Сарьдагийн хийдийн турьд явуулсан малтлага судалгааны үр дүнд олж тогтоосон билээ. Эндээс илрүүлсэн зарим шавар бурхны баримлыг Өндөр гэгээн Занабазарын хүрэл цутгуурын аргаар бүтээсэн бурхны барималтай харьцуулан судлахад түүний мутрын бүтээл болох нь нотлогддог. Өндөр гэгээн Занабазарын намтар зохиолуудад Сарьдагийн хийд дэх уран бүтээлийн ажлынх нь тухай хэсэг бусаг мэдээ баримт бий. Тухайлбал: *Модон морин /1654/ жил Хэнтий хаан хэмээх газар Рибогэжайлин хэмээх хийдийг байгуулж..., төмөр мичин жилийн /1680/ зун..., Рибогэжайлинд (Өндөр гэгээн Занабазарыг) залрахад нь (Зая бандид Лувсанпринлэй) бараа болон явав. Хийдийн гадна талын ихэнхийг барьж дуусгаад бурхан шүтээнийг нь бүтээж байсан үе байв..., гал барс жилийн /1686/ зун Рибогэжайлин хийдийн бурхан шүтээн бүтээсэнтэй зохилдуулж зарим лам нараар равнай хийлгэж соёрхов* хэмээн тэмдэглэжээ.

Энд дурдсанчлан 1680-1686 онд шинээр байгуулсан Рибогэжайлин буюу Сарьдагийн хийдэд бурхан шүтээн бүтээх томоохон урлалын ажлыг дагнан гүйцэтгэж байсан бололтой. Өндөр гэгээн Занабазар шавар керамик бурхдыг бүтээхийн сацуу мөн Язгуурын таван бурхан тэргүүтэй хүрэл цутгуурын гол бүтээлүүдээ ч энэ үед туурвисан байна. Тухайлбал, намтар: *“Усан гахай /1683/ жил ... Богд Гэгээнтний өөрийн нь мутрын урлал Очирдара хийгээд Гэгээнтэн өөрөө зааварлан бүтээлгэсэн ялгуулсан таван язгуурт сайхнаар тэргүүлсэн алтан цутгамал бурхан маш олныг бүтээлгэж соёрхов”* гэжээ. Зая бандида Лувсанпринлэйн бичсэн “Живзундамба Лувсандамбижалцанбалсанбогийн ердийн товч намтар” зохиол нь он цаг, үйл явдлын дэс дарааг нарийн баримтлан бичигдсэн байдаг ба Язгуурын таван бурхан тэргүүтэй олон цутгамал бурхдын бүтээгдсэн цаг үе нь

Сарьдагийн хийд дэх бурхан урлалын ажил ид өрнөж байх үетэй давхцаж буйг заадаг. Тиймээс Өндөр гэгээн Занабазарын бурхан урлалын нэгэн идэвхтэй үе нь 1680-1686 онд Сарьдагийн хийдэд тохиожээ хэмээн үзэх бүрэн үндэстэй.

Өндөр гэгээн Занабазар *“тахилын зүйлэнд зулын мөнгөн цөгц, мөнгөн завьяа, мөнгөн цөгц, усан тахилын гуулин цөгцүүдийг бүслүүр сийлбэртэйгээр олон тоотой”* урлаж байсан мэдээ буй нь бурхдын баримлаас гадна тахилын эд зүйлс бүтээж дархны урлалын өргөн цараатай ажил гүйцэтгэж байсныг илтгэдэг.

Өндөр гэгээн Занабазарын уран бүтээлийн өөр нэг төрөл бол шашны шүтээн зураг буюу “танка” зураг юм. Шүтээн зургийн бүтээл туурвилтай холбогдох мэдээ баримт түүний намтарт тэмдэглэгдсэн нь бий. Тухайлбал *“Рибогэжсайлин хийд, бурхан шүтээний хамт, мөн ялгуулсан Очирдара тэргүүтэн бурхдын зурмал, цутгамал олон дүр ... тэргүүтэн гурван шүтээнийг бүтээхэд хичээн зүтгэсэн”* хэмээн тэмдэглэснээс үзвэл бурхдын зурмал дүр цөөнгүй бүтээж байсан нь мэдэгдэнэ. Энэ төрөлд хамаарах биет дурсгал уламжлагдан ирсэн нь нэн ховор боловч Өндөр гэгээн Занабазарын туурвисан гэх “Эх Ханджамцын хөрөг”, “Өөрийн хөрөг” хэмээх шүтээн зургийн бүтээлүүд эдүгээ Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейн сан хөмрөгт хадгалагддаг. Урлаг судлаач Н.Цүлтэм эдгээр зургийн тухай Занабазарын бүтээл гэж хадгалж ирсэн өөрийн нь хөрөг, Эх Ханджамцын хөрөг... дотоод гадаад дүр байдлаар хүний хувь шинжийг тодорхой гаргасан жинхэнэ хөрөг зургийн шилдэг бүтээлүүд юм хэмээн үнэлсэн байдаг.

Өндөр гэгээн Занабазарын монголын бурхны шашны шүтээн зургийн хөгжилд оруулсан хувь нэмрийг хожуу үеийн монгол урчуудын бүтээлүүдээс дам тодруулан үзэх боломжтой. Тухайлбал бурханч, зураач Д.Дамдинсүрэн Их Хүрээний нэрт урчууд хэмээх бүтээлдээ, "Г.Занабазар бол уран барималч, лав хүрлийн уран цутгуурч болохоос гадна зургийн уран бүтээлч хүн байсан байна. Түүний зурсан 45x35 см хавтгай дөрвөлжин буюу үзүүр тохой хэмжээтэй “Цагаан Дар-Эхийн” загвар зургаар Их хүрээнд 1924 оныг дуустал сар бүрийн шинийн найманд “Цагаан дар-Эхийг” өдөрт нь багтааж” зурж бүтээдэг албан ёсны уламжлалтай байсан" хэмээн тэмдэглэжээ.

Энэ бол Өндөр гэгээн Занабазарын уран бүтээл хожим монгол урчуудад хүчтэй нөлөө үзүүлж байсны нэгэн жишээ мөн. Судлаачдын зүгээс Өндөр гэгээн Занабазарын туурвилын нэг томоохон төрөл нь шүтээн зураг мөн болох тухайд онцлон тэмдэглэсэн санал дүгнэлтүүд бий. Тухайлбал академич Ж.Болдбаатар тэмдэглэхдээ, "Дүрслэх

урлагийн бүх төрлийг уран зургаас салгаж үзэх аргагүй юм. Эхэлж зурж сэтгэж байж, сая хийж бүтээдэг. Өндөр гэгээн бүтээж туурвих явцдаа Монгол зургийн дэг сургуулийг үндэслэжээ хэмээсэн бол, урлаг судлаач Д.Дашбалдан уран барималч хүн бол ерөөсөө зураач л гэсэн үг. Баримал барихын тулд эхлээд эх загвараа хар зургаар гаргадаг. Тэгээд хоёр орон зайд гаргасан хар зургаараа гурван орон зайд баримал барьдаг учраас барималчид хар зургийн тиг, хэлбэрийг мэдрэхдээ онцгой байдаг. Орчин үеийн урлагийн хэлээр бол Занабазар хар зургийн том мастер байсан нь түүний уран бүтээлүүдээс илт юм" гэж үзсэн байдаг.

Өндөр гэгээн Занабазарын уран бүтээлийн дараагийн нэг төрөл бол торгон зураг буюу зээгт наамлын бүтээлийг хамаатуулан үзэж болно. Энэ тухай Өндөр гэгээн Занабазарын намтарт “Усан гахай /1683/ жил ...нэг **торгон бурхныг бүтээж Жажун хийдэд өргөв**” хэмээн тэмдэглэсэн нь бий. Тус намтарт зурмал дүр, цутгамал дүр, торгон бурхан гэхчлэн бичсэн нь урлагийн өөр өөр төрлүүдийг зааж буй юм. Үүнээс үзвэл торгон зургийн төрлөөр уран бүтээл туурвиж байсан болох нь дээрх баримтаас тодорхой харагдаж байна.

### **Хоёр. Өндөр гэгээн Занабазарын уран бүтээлийн гоо зүйн онцлог**

**Уран сайхны тиг буюу хувь хэмжээний онолын асуудал.** Өндөр гэгээн Занабазарын уран бүтээлийн онцлогийн талаар судлаачид тус тусын үүднээс тодорхойлсоор ирсэн. Судлаачдын зүгээс нийтлэг дэвшүүлж буй нэг хандлага нь Өндөр гэгээн Занабазарын уран бүтээлд Буддын урлагийн хувь хэмжээний онол, лагшин биеийн 32 бэлгэ, 80 найраг шинжийг гойд илэрхийлсэн хэмээх дүгнэлт түгээмэл тохиолддог. Энэ нь Өндөр гэгээн Занабазарын уран бүтээлийн хамгийн гол онцлог шинж мөн гэдэгтэй маргах аргагүй.

Буддын урлагт бурхны дүрийг бүтээхэд нэн түрүүнд мөрдөх шаардлагатай зүйл бол хувь хэмжээний онол буюу “уран сайхны тиг”-ийн асуудал болно. Дорно дахинаа түгэн дэлгэрсэн урлагийн уран сайхны тиг нь ведийн урлагийн тиг дээр суурилан Энэтхэгт анхлан боловсруулагдаж, Төвөдөд нэмж засварлагдсан байдаг. Энэтхэг дэх Гуптын эзэнт гүрний үед буюу барагцаагаар IV зууны үеэс Буддын уран сайхны тиг өөрийн гэсэн бие даасан онцлогтой хөгжих болсон бололтой. Харин Буддын шашны ном сударт уран сайхны тиг буюу бурхны бие лагшны хувь хэмжээний номлолыг Бурхан багш анх айлдсан гэж үздэг. Хожим олон мэргэд уг хувь хэмжээний онолыг тайлбарлан номлосон олон судар шастир туурвижээ. Тухайлбал, Богд Зонхава (1357-1419), Манал Дондов (1440-?),

Дэсрид Санжаажамц (1653-1705), Сүмбэ хамба Ишбалжир (1704-1788), Хүрээ номун хан Агваанхайдав (1779-1838), Мипам Намбаржамц (1859-1925) нарыг жишээ болгон дурдаж болно. Буддын уран сайхны тиг нь бурхны хувилгаан дүр, бодь сэтгэлтэн, бурхны эх, охин тэнгэрүүд, хилэнтэнгүүд, жижиг одой тэргүүтэн бурхдын төрөл ялгамжид тохируулсан хувь хэмжээний шугамын 5 зүйл мөрийн дотор хамаг бурхдын лагшингийн хувь хэмжээг мөрдлөгө болгон арвай, хөл, хуруу, нүүр, бага хувь, их хувь зэрэг хэмжээсүүдээр босоо, хэвтээ, өнцөг, тойрог зэрэг шугамуудыг ашиглаж бурхдын лагшин дүрийн зөв харьцаа, төгс гоо сайхныг илтгэн гаргах онолын үүднээс танин барих арга болно гэж тайлбарладаг.

Эдүгээ Өндөр гэгээн Занабазарын уран бүтээлүүдийн дийлэнх нь тухайлбал, Г.Занабазарын нэрэмжит дүрслэх урлагийн музей, Богд хааны ордон музей, Монголын бурхан шашинтны төв Гандантэгчэнлин хийд, Чойжин ламын сүм музей зэрэг газруудад хадгалагдаж буй алдарт Язгуурын таван бурхан, Цагаан, Ногоон дара эх тэргүүтэн 21 дара эх, Очирдара, Сосорбарам, Майдар, Аюуш зэрэг бурхад, хожим Сарьдагийн хийдийн тууриас илрүүлсэн шавар язгуурын таван бурхан зэрэг олон бүтээлүүд бидний үед уламжлагдан иржээ. Эдгээр нь дээдийн хувилгаан болон төгс баясгалангийн дүртэй бүтээгдсэн, энэ нь 10 нүүрний буюу 125 хурууны хэмжээтэй байдаг. Буддын урлагийн уран сайхны тиг буюу хувь хэмжээний онолыг нийтээрээ даган мөрддөг ёстой. Өөрөөр хэлбэл нэг л тогтсон тигийг нийтээр мөрдлөг болгодог гэсэн үг. Энэ тухай бурханч лам Г.Пүрэвбат "Улс үндэстний урлагийн уламжлалаас хамаарч Хятад, Төвөд, Япон, Балба, Энэтхэгийн бурхдын дүр өөр өөр хэмээн эгэл лүгээ адилтган хүүрнэгсдийн яриа нь эндүүрсэн зүйл бөгөөд эгэл ертөнцийн бие махбодод ийм ялгамж байхаас бус ертөнцөөс хэтийсэн үнэмлэхүй гоо сайханд энэ ялгамж үгүй" гэж тэмдэглэсэн нь бий. Харин тэрхүү уран сайхны тигийг хэр хэмжээнд мөрдөж буй нь тухайн уран бүтээлчийн ур чадвараас хамаарах тул ур хийцийн ялгаа үүсэх нэг нөхцөл болдог. Өндөр гэгээн Занабазарын уран бүтээлийн гоо зүйн онцлогийн нэг нь уг уран сайхны тиг буюу хувь хэмжээний онолыг дээд зэргээр баримталсан явдал гэдгийг хэлэх нь зүйтэй.

***Бурхны лагшингийн бэлгэ, найрал.*** Өндөр гэгээн Занабазарын уран бүтээлийн тухайд өмнө үеийн зарим судлаачдын зүгээс монгол хүний гоо сайхныг бурхны дүрээр дүрслэн харуулсан хэмээх үнэлэлт, дүгнэлт өгсөн нь тохиолдоно. Буддын урлагийн онолын үүднээс үзвэл энэ нь учир зүйн зөрчил үүсгэж буй тул асуудлыг эргэж харах шаардлага тулгарч буй юм. Үүний цаад шалтгаан бол өнгөрсөн зуунд шинжлэх ухааны

судалгаанд марксист-ленинист арга зүйн нөлөөгөөр ангич байр сууринаас хандаж байсан нь Өндөр гэгээн Занабазарын түүх бичлэг, уран бүтээлийн судалгаанд ч нөлөөлж зоригтой дүгнэлт хийхээс зайлсхийх, өнгөц тайлбарлах, ерөнхийлөн хялбарчлах хандлага давамгайлж байсантай холбоотой бололтой.

Бурхны 32 лагшин, 80 найраг шинж гэдэг бол амирлангуй дүртэй бурхдын бие лагшныг дүрслэхэд чухал ач холбогдолтой шинж тэмдэгүүд юм. Чухам эдгээр 32 бэлгэ, 80 найрал шинжийнхээ мөн чанараар хүний гоо сайхнаас хэтийдсэн бурхдын үнэмлэхүй гоо сайхныг илэрхийлэх онолын үндэс нь оршдог. Өөрөөр хэлбэл, бурхны бие лагшин нь зарим шинжээрээ эгэл хүний биеэс ялгаатай, нийтлэгдээ хүнээс хэтийдсэн гоо сайхан болохыг нь илэрхийлэх үндсэн ухагдахуун мөн. Тухайлбал, Бурхны лагшингийн 32 бэлгэ шинжид “хурууд нь тороор холбогдсон, өвдгийн тойг илэрхий бус, дөчин тоо гүйцэд шүдэт” гэх мэтчилэн бичсэн байх ба түүний шалтгаан, үрийн барилдлагын тайлбарт өгүүлснээр: *...Мутар хийгээд өлмийн хуруу нь галууны хаан мэт хурууны анхдугаар үеэс эхлэн хурууны хооронд сиймхий үгүй бөгж тэргүүтэн чимэг оршиж болохоор тороор холбогдсон нь: Өглөг хийгээд яруу өгүүлэх тэргүүтэн хураахын дөрвөн бодод шүтэж зохиолын эцэст хүрснээр тороор холбогдсон. ...Өвдгийн тойг хийгээд шагай гадагш илэрхий бус төгс нь: Өглөг тэргүүтэн буяны номыг үнэхээр авснаар бүтсэн. ...Гучин хоёр бус, дээр доороо хорь хорь лүгээ дөчин шүдийг эрхшээсэн нь: Цаг урьд лугаа адилд ховын үгийг тэвчсэнээр дөчин тоо гүйцэд шүдэт хэмээн тэмдэглэжээ.*

Тэгвэл 80 найраг шинжид “судас илэрхий бус, судас зангилаа үгүй, шагай далд” гэх мэтчилэн дурсан нь бий. Лагшингийн наян найргийн шалтгаан, үрийн барилдлагын тайлбарт: *...Биеийн судас илэрхий бус нь: Урьд бие тэргүүтний үйлийн арван хар мөр хийгээд буруу амьжиргааг машид сахиснаар судас илэрхий бус. ...Судас зангилаа үгүй төгс нь: Нисваанисын зангилааг тайлсан бөгөөд гэтэлсний тул зангилаа үгүй. ...Өлмийн шагай илэрхий бус нь: Нууцын гүн орныг оносноор машид нууцлахын номын оюун төгссөний тул шагай илэрхий бус далд гэсэн нь бурхны лагшин бие нь хүний биеээс ялгамжаатай болохыг нь заана. Түүнчлэн дээр дурдаагүй бурхны бусад бүхий л бэлгэ, найргууд нь хүнээс хэтийдсэн гоо сайхан шинжийг илтгэдэг.*

Түүхэн цаг үеүүд дэх газар газрын уран сайхны дэгүүд нь ихэвчлэн дүрслэлийн ур маяг, чимэглэлийн элемент, техник ажиллагааны онцлогоор ялгардаг. Гэхдээ амирлангуй дүртэй бурхны нүүр царайны дүр төрхийн ялгаатай байдлыг анхааран үзэх шаардлагатай.



Бурханч, урчууд бурхны уран сайхны тиг, 32 бэлгэ, 80 найраг шинжид тулгуурлан бурхны төгс төгөлдөр бие лагшинг дүрслэхдээ нийтлэг нэг зарчим мөрддөг бол харин царайны төрхийг нь дүрслэхэд хувь уран бүтээлчийн антроморф төсөөлөл, ойлгоц хүчтэй нөлөөлдөг бололтой. Тодруулбал, уран бүтээлч бурхны нүүр царайны төрхийг өөрийн төсөөлөлд бага наснаас гүн хоногшсон ижил дасал болсон ард түмний царай төрхийн нийтлэг хэв шинжийг илэрхийлэн дүрсэлдэг онцлог түгээмэл байна. Тиймээс Өндөр гэгээн Занабазарын уран бүтээлүүдэд монголжуу төрх тод тусжээ.

Иймд бид Өндөр гэгээн Занабазарын бүтээлүүдийг сурвалжлан бүртгэх явцдаа "Түүний уран бүтээлүүд нь Буддын урлагийн онолыг чанд баримтлан бурхны төгс төгөлдөр үнэмлэхүй гоо сайхныг дээд зэргээр илэрхийлэн гаргахыг чухалчилсан байх бөгөөд түүний урласан бурхдын шүтээн дүрүүд нь аль нэг хэв загварыг баримталсан гэхээсээ илүүтэй бурхны шашны уран сайхны тиг, урлахуйн онол, шашны үзэл санааг бүрэн шингээсэн сор бүтээлүүд хэмээн хүн төрөлхтний урлагийн түүхэнд үнэлэгдэх болсон төдийгүй үүгээрээ тэрбээр нэгдүгээрт, XVII зууны монголын урлагийг шинэ агуулгаар баяжуулж, шинэ түвшинд гаргаж ирсэн, хоёрдугаарт, дэлхийн Буддын урлагийн түүхэнд өндөр үнэлэгдэхүйц хосгүй бүтээлүүдийг туурвижээ" хэмээн дүгнэж байна.

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО, ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮНДЭСЛЭЛ

Монголын анхдугаар Жэвзүндамба хутагт Өндөр гэгээн Занабазарын үүтгэн хөгжүүлсэн буддын урлагийн ховор нандин бүтээлүүд Монгол Улс болон ОХУ-ын музей, сүм хийд, хувь хүмүүсийн тахил шүтээн, хувийн цуглуулга зэрэгт янз бүрийн хэлбэрээр хадгалагдан иржээ.

Хорьдугаар зууны эхний хагаст Орос Монголд буддын шашны сүм хийд, лам хуврагийг олноор хомроглон хэлмэгдүүлэх арга хэмжээ явуулсны улмаас бурханы шашны урлагийн бүтээлүүдийг ч устгаж, хаана, хэний гарт, ямар бүтээл, хэдий үед очсон нь ч тодорхойгүй болсон юм.

Өндөр гэгээний урласан хосгүй үнэт өвийг ШУА-ийн хүрээлэн, их, дээд сургуулийн мэргэжлийн судлаачид бүртгэх, цуглуулах, улмаар улсын хамгаалалтад авч музейн сан хөмрөгт хадгалах, дэлгэн сурталчлах үйл ажиллагаа Монгол улсад өнгөрсөн зууны дунд үеэс эрчимтэй эхэлсэн билээ. Тийн боловч өнөө хэр нь эрдэм шинжилгээний эргэлтэнд ороогүй, эх материал нь хадгалалтын буруугаас болж дахин сэргэхээргүй болсон зэрэг шалтгааны улмаас үрэгдэж, олон нийтэд төдийлөн мэдэгдээгүй дурсгалууд ч байна. Түүгээр ч зогсохгүй улсын томоохон музейн сан хөмрөгт хадгалагдаж байгаа дурсгалууд ч андуу ташаа тайлбартай байгаа нь энэ талын судалгаа бүрэн бус болохыг харуулж байна.

1990 оноос Монгол оронд өрнөсөн ардчилал шинэчлэлийн үрээр шашин шүтэх эс шүтэх эрх нээлттэй болж, энэ нь буддын урлагийн шинжээч, сонирхогчид, цуглуулагчдад ч таатай орчин нөхцөлийг бүрдүүлж өгсөн юм. Тэдний олонх нь өөрсдийн хувийн цуглуулгын каталогийг нийтэд дэлгэн, нийтлүүлсэн байна. Үүнээс судлаачид хаана хэний цуглуулгад ямар урлаг соёлын өв хадгалагдаж байгааг мэдэх боломж нээгдсэн юм. Мөн олон тооны бурханы шашны сүм хийд сэргээн байгуулснаар сүсэгтэн ардууд цөөнгүй урлагийн бүтээлийг тэдгээр сүм хийдэд буцаж өргөсөн бөгөөд зарим нь янз бүрийн орны хувь хүмүүсийн цуглуулга, галерей, музей зэргээс ч олдож эхэлж байна. Гаднын улс орнуудын музейд тухайлбал БНУУ-ын Хопп Ференцийн Азийн урлагийн музейд Өндөр гэгээний хийцийн зургаан бурхан байна хэмээн судлаачид мэдээлж байна. Гэвч хилийн

чанадад хувь хүний цуглуулгад буй Өндөр гэгээний тиг хийцийн хичнээн тооны дурсгал байгааг нэгбүрчлэн бүртгэн гаргах боломжгүй болжээ.

Өндөр гэгээний урласан урьд өмнийн судалгаанд илрээгүй цөөнгүй тооны бүтээлийг хэдэн арван сая доллараар үнэлэн дэлхийн томоохон дуудлага худалдаанд оруулж байна. Түүний урласан бүтээлийн хуулбар, хувилбарыг хар зах дээр ч худалдаалж байна.

Ийм зах зээлийн өрсөлдөөнт нөхцөлд бид юун түрүүн түүхийн болон бусад шалтгаан, хүчин зүйлийн улмаас өөрийн улсын болон хөрш ОХУ-ын музей, хийдүүдийн сан хөмрөг, хувь хүмүүсийн гарт хадгалагдах болсон Өндөр гэгээний тиг хийцийн бурхад, урлагийн хосгүй үнэт өвийг бүртгэн тогтоож, үндэслэлтэй үнэн зөв тодорхой тайлбартайгаар нэгтгэн бүртгэж авахыг эрмэлзсэн болно.

Төслийн хүрээнд Занабазарын тиг загвараар бүтээж, өнөө үед уламжлан ирсэн бүтээлийн өв, бүртгэл, объектын тайлбар, эх сурвалж, судалгааны мэдээллийн сан байгуулахад шаардагдах эх материалуудыг бэлтгэх ажлыг хийв. Ингэж Монгол, Оросын музейн цуглуулга, сүм хийд, гэр бүлийн тахил шүтээн, хувь хүмүүсийн цуглуулгад байгаа Занабазарын уран бүтээлийн өвийг судлан, нэгтгэн дүгнэх нь уран бүтээлчийн талаарх цогц судалгаа, хувь хүний онцлог шинж чанар, дэлхийн хэмжээний урлаг, уран сайхны хөгжилд гүйцэтгэх үүрэг ролийг тодорхойлоход тодорхой хувь нэмрээ оруулна хэмээн үзэж байна.

**Судалгааны арга зүй:** Төслийг гүйцэтгэхдээ түүхэн эх сурвалжийг судлах судалгааны арга зүйд суурилсан бөгөөд холбогдох мэргэжилтнүүдийн судалгаанд түшиглэн хожим ашиглаж болох баримт материалыг бэлтгэхэд чиглэлээ.

Занабазарын бий болгосон буддын бурхад болон шашны бусад уран баримал, дүр зургийг харахад нэг талаас Монгол Төвөдийн бурхны шашны түүхийн судалгааны эх сурвалжид түшиглэн Монголын ард түмний ёс заншлын онцлогт суурилсан байдаг. Нөгөө талаас эдгээр объектууд нь урлагийн бүтээлийн ангилалд багтах учраас урлагийн түүхийн үүднээс авч үзэх хэрэгтэй. Иймд уран сайхны түүхэн судалгааны арга зүйг баримтлан ажиллах зүй ёсны шаардлага урган гарсан юм. Эдгээр арга зүйг баримтлан ажилласны үр дүнд инновацийн зэхэц ажил бий болсон хэмээн бид урьдчилан харж байна.

## ТӨСЛИЙН ҮР ДҮНГИЙН ДААЛГАВАР

/Техникийн даалгавар/

Д/д	Төслөөр бий болох үр дүн	Тоо хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт (параметр)	Үр дүнг хүлээлгэн өгөх хугацаа (он, сар)
1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл доор “Өндөр гэгээний үсгийн урлал” эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, эмхэтгэл хэвлүүлэх	1	Эрдэм шинжилгээний дотоод өгүүлэл, хурлын эмхэтгэл хэвлүүлнэ.	2019 он
2	Занабазарын хэв маягийн бүтээлийн мэдээллийн сан бүрдүүлэх судалгааны үр дүнгээр эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлэх	7	Эрдэм шинжилгээний өгүүлэл гадаадад-4, дотоодод 3 нийтэлнэ	2020-2021 он
3	Дашчойлин хийд, Занабазарын музей, Богд хааны ордон музей хамтран Өндөр гэгээний зохиосон соёмбо үсэг, уран бүтээлийн дурсгалуудаар үзэсгэлэн гаргах	1	Цуглуулагч, сонирхогчдын дээжээр үзэсгэлэн гаргана	2019 он
4	Өндөр гэгээн тэргүүтэй Монголын 8 богдын бүрэн зохиолыг орчуулж, хэвлүүлэх	1	Орчуулгын бүтээл /5 боть/ зохиол хэвлэгдэнэ	2020 он
5	Занабазарын уран бүтээлийн өв болох "Өндөр гэгээн Занабазарын загвар хийц" /А.Алтангэрэлийн цуглуулгын	1	Нэг сэдэвт бүтээлийн хэвлэлийн эх бэлэн болно	2020 он

	жишээн дээр/ ном хэвлүүлэх			
6	Занабазарын уран бүтээлтэй холбоотой объектуудын мэдээллийн сан бий болгох	1	Цахим сан	2021 он
7	Төслийн эцсийн тайлан бичиж захиалагч, санхүүжүүлэгчид хүлээлгэн өгөх	1	Төслийн дууссан ажлын тайлан	2021 он 12 сар

**ТӨСЛИЙН КАЛЕНДАРЬЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ БИЕЛЭЛТ**

Д/д	Гэрээнд заагдсан тодорхой үе шатны ажлын нэр	Гэрээнд заагдсан хугацаа (Он,сар)	Гэрээнд заагдсан ажлын үр дүнгийн товч танилцуулга	Биелэлтийн үнэлгээ /хувиар/
<b>2019 он</b>				
1	“Өндөр гэгээний үсгийн урлал” ЭШХ-ыг Монгол Улсын ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулах, эмхэтгэл хэвлүүлэх	11-12 сар	Төслийн гэрээ 9 сарын 23-нд батлагдсан тул 2019-10-02-ны өдөр ЭШ-ий хурал зохион байгуулав. Тус хуралд Оросын талын төслийн удирдагч ирж оролцов.	Хуралд илтгэл хэлэлцүүлж, өгүүллийн эмхэтгэлийг Шашин соёл судлал сэтгүүлд хэвлүүлэв.  100 хувь
4	Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн Музейтэй хамтран, Өндөр гэгээний уран бүтээлийн үзэсгэлэн гаргах	11 сар	ДУМ, Дашчойлин хийд, хувийн цуглуулгачидтай хамтран Өндөр гэгээний уран бүтээлээр үзэсгэлэн гаргав. 2019. 10.02-03	Нээлттэй үзэсгэлэн гаргав.  100 хувь
5	Гүйцэтгэж буй төслийн явц, ач холбогдлыг сурталчилсан мэдээ, ярилцлагыг голлох мэдээллийн хэрэгслээр явуулах	11 сар	ЭШ-ий хурал, үзэсгэлэнгийн үеэр Монголын үндэсний телевиз, Жавзандамба төвийн ярилцлагын цагаар төслийн ажлыг танилцуулав	100 хувь

6	Санхүүгийн болон үйл ажиллагааны явцын тайлан бичиж, санхүүжүүлэгч, захиалагчид хүргүүлэх	12 сард	Төслийн санхүүжилттэй холбоотойгоор төслийн 2019 оны үйл ажиллагааны тайланг 2021 оны 1-р сард бичиж явуулав	100 хувь
<b>2020 он</b>				
1	Урьд өмнө ижил төрлийн судалгаа хийсэн байгууллага, судлаачдын бүтээлтэй танилцах, шаардлагатай тохиолдолд гэрээ байгуулж ажиллах	1-4 сар	Судлаачдын урьд өмнө энэ чиглэлээр хийсэн бүтээлтэй танилцсан. Гэрээ байгуулж ажиллах хэмжээний судалгаа хараахан байсангүй гэж үзсэн болно.	100 хувь
2	Богд хааны ордон музей, Чойжин ламын сүм музейн хадгаламжид байгаа Занабазарын бүтээлийн жагсаалтыг гаргаж, тодорхойлолт бүхий нэгдсэн мэдээлэл бий болгох	1-6 сар	Ц.Гүнчин-Иш Богд хааны ордон музейд байгаа Өндөр гэгээний дэг сургуулийн бүтээлүүдийг үзэж, бүртгэл мэдээлэл гаргав. Доктор Сыртыпова Чойжин ламын сүм музейд буй дурсгалуудын бүртгэл хийв.	100 хувь
3	Дүрслэх урлагийн музейд хадгалагдаж байгаа Занабазарын бүтээлийн жагсаалтыг гаргаж, зураг, тодорхойлолт бүхий нэгдсэн мэдээлэл бий болгох	1-6 сар	У.Сарантуяа ДУМузейд байгаа Өндөр гэгээний тиг хийцийн бүтээлүүдийг үзэж, бүртгэл гаргав	100 хувь
4	Занабазарын намтрын	1-6 сар	Д.Наранцэцэг, Ц.Гүнчин-Иш	100 хувь

	монгол бичвэрүүдийг харьцуулж, шашин урлагт холбогдох бүтээлүүдийн жагсаалтыг гаргах		нар Өндөр гэгээний хэдэн зүйл төвөд, монгол намтрыг харьцуулж үзсэний үндсэн дээр тухайн үеийн шашин урлагт холбогдох байгууламжын талаар өгүүлэл бичив.  /хэвлэлтэд/	
5	Гандантэгчэнлин хийд, Дашчойлин хийдэд байгаа Занабазарын бүтээлийн жагсаалтыг гаргаж, зураг, тодорхойлолт бүхий нэгдсэн мэдээлэл бий болгох	1-6 сар	Дашчойлин хийдэд Өндөр гэгээний мутрын хийцийн бүтээл байсангүй. Гандан хийдэд байгааг гэрэл зургаар авах гэрээ байгуулж ажиллав.	100 хувь
6	Эрдэнэ зуу хийд болон хөдөө орон нутаг, хувь хүний гар дээр байгаа Занабазарын бүтээлийг сурвалжлах.  Судалгааны эх хэрэглэгдэхүүн цуглуулж ОХУ, БНХАУ-ын ӨМӨЗО, Монгол Улсын нутгаар судалгаа хийх	7-10	Эрдэнэ зуу хийд, Шанхын баруун хүрээ хийдэд буй Өндөр гэгээний тиг хийцийн бүтээлүүдийг нүдээр үзэж, бүртгэл гаргав. Зарим хувь хүнтэй уулзаж мэдээлэл цуглуулав.  Цар тахлын байдлаас ОХУ, БНХАУ-ын нутгаар явж чадсангүй.	50 хувь
7	Өндөр гэгээн тэргүүтэй Монголын 8 богдын бүрэн зохиолыг төвөд хэлнээс монгол хэлэнд орчуулан, редакторлаж,	11 сар	Өндөр гэгээн тэргүүтэй Монголын богдуудын зохиолыг орчуулж, хэвлэлийн эхээр бэлэн болгов.	100 хувь



	нийтийн хүртээл болгоно			
8	Занабазарын уран бүтээлийн өв болох "Өндөр гэгээн Занабазарын загвар хийц" /А.Алтангэрэлийн цуглуулгын жишээн дээр/ ном хэвлүүлэх	12 сард	374 хуудас бүхний тус номыг төслийн Оросын талын удирдагч Сүрэнханд Бурхны шашин соёл судлалын хүрээлэн, ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн санхүүжилтээр хэвлүүлэв.	100 хувь
<b>2021 он</b>				
1	Судалгаанд холбогдох эх хэрэглэгдэхүүн цуглуулах, материал боловсруулах	1-6 сар	Судалгаанд холбогдох эх хэрэглэгдэхүүн цуглуулж, эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж нийтлүүлэв.	Судалгааны ажлын үр дүнгээр эрдэм шинжилгээний 3 өгүүлэл хэвлүүлэв.  100 хувь
2	Занабазарын уран бүтээлтэй холбоотой объектуудын мэдээллийн сан бий болгох	1-5 сар	Өөрсдийн болон өмнөх судлаачдын хийсэн судалгаанд тулгуурлан Өндөр гэгээний тиг хийцийн бүтээлүүд, Өндөр гэгээний барьж байгуулсан хийд орны талаарх мэдээллийг бүртгэн гаргаж, мэдээллийн цахим санд оруулах материалыг бэлдэв.	Төслийн санхүүжилт танагдсантай холбоотойгоор цахим сан үүсгэх ажил хийгдээгүй болно.  90 хувь
3	Санхүүгийн болон үйл ажиллагааны явцын	6 сард	Явцын тайланг 2022.06 сард бичиж явуулав	100 хувь

	тайлан бичиж, санхүүжүүлэгч, захиалагчид хүргүүлэх			
4	Судалгааны эх хэрэглэгдэхүүн цуглуулж ОХУ, БНХАУ-ын ӨМӨЗО, Монгол Улсын нутгаар судалгаа хийх	7-11	2022 оны 1.16-30нд ОХУ-ын ОХУ-ын Москвагийн Угсаатны зүйн музей, Санктпетербургын Шашин угсаатны музейн, Өндөр гэгээний тиг хийцийн бүтээлүүдийг үзэж бүртгэж авав. 2022 оны 6.29-7.03-нд ОХУ-ын Буриад улсын музей, Өндөр гэгээний уран бүтээлийн холбоотой судалгаатай танилцав. 2022 оны 5 сарын 1-2, 8 сарын 12-14-нд Оросын талын удирдагчтай хамтран Монгол Улсын Эрдэнэзуу хийд, Шанхын Баруун хүрээ хийд, Дорноговь аймгийн Хамрын хийд, Өвөрхангай аймгийн зарим нэг хувь хүний хадгаламжид буй Өндөр гэгээний гэх бүтээлүүдийг биечлэн үзэж тодорхойлон, бүтээлийн жагсаалт гаргав.	100 хувь
6	Санхүүгийн болон үйл ажиллагааны эцсийн тайлан бичиж, санхүүжүүлэгч,	12 сард	Санхүүгийн болон үйл ажиллагааны эцсийн тайлан бичиж, илгээв	100 хувь

захиалагчид хүргүүлэх			
-----------------------	--	--	--

## ТӨСЛИЙН ГҮЙЦЭТГЭГЧДИЙН ТАНИЛЦУУЛГА

**Гомбодоржийн Мягмарсүрэн**-Төслийн удирдагч

Зүүн хүрээ Дашчойлин хийдийн Бурхны шашин соёл судлалын хүрээлэнгийн захирал,  
доктор (Ph.D)

### **Ном-1**

1. Монгол богдуудын бүрэн зохиол. 5 боть. Орчуулсан Г.Мягмарсүрэн. редактор Д.Наранцэцэг Уб., 2022 он.

### **Өгүүлэл-3**

1. Мягмарсүрэн Г., Андреев А. В. Таван богдын зохиол бүтээлийн тухай. //Шашин соёл судлал. Уб., 2020. Том II. Fasc 10. 148-164-р тал
2. Мягмарсүрэн, Г. Труды монгольских ученых лам и проект //Мирыне и ламы: Буддийские идеи и практики в трансформирующихся обществах России и Монголии. Улан-Үдэ. 2020. срт. 87-100
3. Мягмарсүрэн, Г. Богдуудын анхны зарлиг зохиолын тухай. //Наймдугаар богд Жэвзүндамба хутагтын 150 жилийн ойн эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Уб., 2020. 47-58-р тал

### **Илтгэл-4**

1. Мягмарсүрэн Г., Андреев А. В. Таван богдын зохиол бүтээлийн тухай. //Өндөр гэгээний үсгийн урлаг. Олон улсын эрдэм шинжилгээний хурал. Уб., 2019. 10.02
2. Мягмарсүрэн, Г. Богдуудын анхны зарлиг зохиолын тухай. //Наймдугаар богд Жэвзүндамба хутагтын 150 жилийн ойн эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэл. Уб., 2019. 11.16
3. Жавзандамба хутагтын зохиол бүтээл Монголын бурхан шашны түүхтэй холбогдох нь. Богд хааны ордон музейгээс зохион байгуулсан "Богд Жавзандамбын судлалд" эрдэм шинжилгээний хурал. Уб. 2022.12.26
4. Г.Мягмарсүрэн, Сүрэнханда Д.С "The Images of Past Lives of Undur Gegeen in Erdene Zuu Museum". ОХУ-ын ШУА-ийн Дорно дахин судлалын хүрээлэн, Дорно

дахины музей хамтран зохион байгуулж буй "Искусство на Востоке и Восток в искусстве" олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэл. Москва, 2022.06.30

#### *в/ Эмхэтгэл*

Өндөр гэгээний үсгийн урлаг. Соёмбо үсэг зохиогдсоны 333 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. *Шашин соёл судлал сэтгүүл. 2020 он*

#### *г/ Тайлан-1*

1. "Өндөр гэгээний тиг хийцийн урлаг соёлын өвийг судлах, Монгол Оросын музей, олон нийтийн болон хувь хүмүүсийн гар дээрх цуглуулгын мэдээллийн сан бүрдүүлэх, бүртгэх аргачлал боловсруулах нь " төслийн тайлан. Уб., 2023

#### **Дамбийхорлоогийн Наранцэцэг- Төслийн гүйцэтгэгч**

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Сурвалж бичиг, төвөд судлалын салбарын эрхлэгч, хэл бичгийн ухааны доктор (Ph.D), профессор

#### **Өгүүлэл-3**

1. Сурун-Ханда Сиртыпова., Наранцэцэг Д. Өндөр гэгээний язгуурын таван бурхдын урлалын онцлог //Шашин соёл судлал. Уб., 2018. Том II. Fasc 2. 18-39-р тал
2. Наранцэцэг, Д., Сыртыпова Д. С. Скульптуры Падмасамбхавы моделировки Дзанабазара в Монгольских коллекциях //Төвөд судлал. Боть 10. Уб., 2021. 138-147
3. Наранцэцэг. Д., Гүнчин-Иш. Ц., Сыртыпова. С. Д. Өндөр гэгээний намтарт түүний уран бүтээлийн ордыг тэмдэглэсэн нь. //Mongolia and the Mongols. Past and Present. Warsaw. 2022

#### **Илтгэл-1**

1. Сурун-Ханда Сиртыпова., Наранцэцэг Д. Өндөр гэгээний язгуурын таван бурхдын урлалын онцлог //Өндөр гэгээний үсгийн урлаг. Олон улсын эрдэм шинжилгээний хурал. Уб., 2019. 10.02

### **Цэгмидийн Гүнчин-Иш Төслийн гүйцэтгэгч**

ШУА-ийн Түүх угсаатны зүйн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний дэд ажилтан

#### **Өгүүлэл-3**

1. Гүнчин-Иш Ц., Сарантуяа У. Өндөр гэгээн Занабазарын нэгэн уламжлалын тухай. // *Шашин соёл судлал. Уб., 2018. Том II. Fasc 8. 102-111-р тал*
2. Гүнчин-Иш, Ц. Сарьдагийн хийдийн гол сүмийн шүтээний зохиомжийг тодруулах нь // Археологи, түүх, угсаатан судлалын сэтгүүл, Улаанбаатарын их сургуулийн сэтгүүл. УБ., 2020. Т.160-165
3. Гүнчин-Иш, Ц. Өндөр гэгээн Занабазарын ууц таллаж буй хөргийн тухай // *Угсаатан судлал, ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний сэтгүүл. Том. XXIX, Fasc. 12. 2021 он. Т.188-197*

#### **Илтгэл-3**

1. Гүнчин-Иш Ц. “Өндөр гэгээн Занабазарын уран бүтээлийн онцлог” // “Монгол дархны урлаг: Түүх, орчин үе” эрдэм шинжилгээний бага хурал, Уб, 2019.07.05.
2. Гүнчин-Иш Ц., Сарантуяа У. Өндөр гэгээн Занабазарын нэгэн уламжлалын тухай // *Өндөр гэгээний үсгийн урлаг. Олон улсын эрдэм шинжилгээний хурал. Уб., 2019. 10.02*
3. Ц. Гүнчин-Иш. Өндөр гэгээн Занабазарын уран бүтээл ба Сарьдагийн хийдийн шавар бурхад // *ШУА-ийн Археологийн хүрээлэн, МБШТГандантэгчэнлин хийд, Эрдэм соёлын хүрээлэн хамтран зохион байгуулсан “Буддын шашин ба археологи” сэдэвт эрдэм шинжилгээний хурал, УБ., 2021.11.12*

**ӨНДӨР ГЭГЭЭН ЗАНАБАЗАРЫН УРАН БҮТЭЭЛИЙН СУДАЛГАА:  
ШИНЖЛЭХ УХААНЫ ӨНӨӨ ЦАГИЙН СУДАЛГАА ХИЙГЭЭД ДЭЛХИЙН  
ТҮВШИНД ХҮЛЭЭГДЭЖ БУЙ БАЙДАЛ**

Эрдэмтэд өнөөг хүртэл Азийн бурханы шашны, ялангуяа Хятадын бурханы шашны урлагийн талаар нарийн нягт судалсаар иржээ. Төв Азийн өндөрлөгт оршин амьдрах Монголын нүүдэлчин ард түмний амьдрал ахуй, түүх болон газарзүйн байрлалын хувьд Хятадтай нягт холбоотой учир түүний түүх, соёлын түүхийн талаар харилцан холбоотой мэтээр үзэх хандлага саяхныг болтол өрнө дахинд байсан юм. Харин судлаачдын нарийн нягт судалгааны үр дүнд Монголын бурханы шашин нь Хятадын соёл иргэншил, Төвөдийн бурханы шашинтай урьд үзэж байсантай адил нэг хэв загварын зүйл биш байсан гэдгийг саяхнаас ойлгож эхлээд байна. Тэгсэн хэдий ч Монголчуудын Төвөдийн Буддизм, Хятад соёл иргэншилд оруулсан нөлөөлөл, шинэчлэлийг бүрэн дүүрэн үнэлж, бараг судлаагүй байна. Мөн хөрш зэргэлдээ улс орнууд болон Хятадын бус эзэнт гүрний үеийн Уйгар (745-847), Тангад - Ши Ся (1038-1227), Кидан - Баруун Ляо (907-1125), Монгол - Юань (1206-1368) - Жин (1115-1234), Манж - Чин (1644-1911) зэрэг нь буддын урлагийн түүхийн судлагдаагүй цагаан цэг хэвээр байна. Иймд сүүлийн үеийн археологийн судалгаанд үндэслэх, ОХУ, БНХАУ, Монгол улсын музейн цуглуулгуудад харьцуулсан судалгаа хийх, тэдгээрийг шинжлэн дүн шинжилгээ хийх, мэдээллийг системчлэх шаардлага урган гарч байна.

Буддын шашин ба дүрслэх урлагийн ертөнцөд нүүдэлчин монголчуудын оруулсан урлагийн бүтээлийн ач холбогдлын талаар бүрэн судлаагүй хэвээр байна. Үнэн хэрэгтээ XIII-XIV зууных шигээ монголчууд XVII-XVIII зуунд ч гэсэн Евразийн түүхэн үйл явдалд нөлөөлсөөр байсан бөгөөд тал нутгийн нүүдэлчид очирт хөлгөний Буддизмын урлагийг хөгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулсаар ирсэн юм.

Монголын шашны уран зураг, уран баримал нь мянган жилийн турш уламжлалаа үргэлжлүүлэн хадгалж, Скифийн-Сибирийн уран сайхны хэв маягийг санагдуулдаг гэж Оросын алдартай эрдэмтэн В.А.Кореньяко бичжээ. Хэдийгээр Орос, Хятад хоёр хөршийн асар их дарамт шахалт байсан ч монголчууд өөрийн онцлогтой эдийн засаг, соёл, түүхийг хадгалж үлдэхийн тулд урлаг, уран бүтээлийн өөрийн чиг хандлага, хэв маягийг төрүүлж, хөгжүүлсэн юм. Энэ үзэгдлийн оргил Өндөр гэгээн Занабазарын (1635-1723) суу билигт

бүтээлүүд юм. Занабазар нь Бурханы шашны урлагийн Энэтхэг, Балбаас гаралтай, санскрит, төвдийн судрын зарчмуудыг нарийвчлан дагаж мөрдсөн, монгол маягийн гэгээрсэн бурхад, бодьсатва нарын өвөрмөц хөрөг дүрийг бүтээсэн эрхэм хүн билээ. Занабазарын бүтээсэн буддын бурхдыг төгс төгөлдөр физик өгөгдөл бүхий амьд бодгалын бодит дүр төрхтэй бөгөөд бурхад ба бодьсатвын бурханлаг төгс төгөлдөрт хүрэх сэтгэл хөдлөлийн мэдрэмж гэж үздэг. Түүний бүтээлүүд нь дэлхийн ач холбогдол бүхий соёлын үнэт зүйлсэд багтдаг. Түүний өөрөө болон түүний арга барилаар бүтээсэн олон тооны бүтээлүүд бий. Эдгээр нь Монгол улсын голлох музей (Богд хааны ордон музей, Занабазарийн нэрэмжит Дүрслэх урлагийн музей, Чойжин ламын сүм музей) болон сүм хийд (Гандантэгчэнлин хийд, Эрдэнэ-Зуу), хувь хүмүүсийн гар дээр байна. Түүнчлэн бүх агуу уран бүтээлчдийн адил түүний манлайлал, шууд нөлөөллийн дор загваруудынх нь дагуу бүтээсэн Занабазарын тиг хийцийн олон тооны бүтээлүүд бий. Эдгээр бүтээлийн ихэнх нь сүм хийд, төвлөрсөн болон бүс нутгийн музей, сүсэгтэн, цуглуулагчдын хувийн эзэмшилд байдаг. Тэдгээрийн тоо, байршлыг хараахан тодорхойлж авч үзээгүй байгаа, бидний ажигласнаар хэдэн зуугаар тоологдох бүтээл бий бөгөөд шинээр илэрч байгаа эд зүйлсийн тоо улам бүр нэмэгдсээр байна. Санал болгож буй төслийн үндсэн зорилго нь Занабазарын бүтээлийг тодорхойлох, судлах аргачлал боловсруулах, цахим мэдээллийн санг бий болгох дата бүрдүүлэх боловсруулах явдал юм. Энэ нь Занабазарын урлагийн өвийг илүү нарийн тодорхойлох боломжийг олгож, зөв зохистой шүтэх, буддын шашны сүм хийд, музейн цуглуулгад байгаа урлагийн объектыг хамгаалахад тус болно.

Одоо Монгол Улс дахь Занабазарын дүрслэх урлагийн бүтээлүүдийн судлагдсан байдлын талаар товч өгүүлье.

Монголын урлаг, уран сайхан, Занабазарын бүтээлүүдийн тухай Судлаач Н.Цүлтэм анх удаа бичиж тэмдэглэснээс хойш энэ сэдвээр хийсэн судалгааны төлөв байдал сүүлийн хагас зуунд бараг өөрчлөгдөөгүй хэвээр байна. Занабазарын бүтээлийн тухай намтар судлалын болон хэл шинжлэлийн талаас нь тусгайлан судалсан байх боловч урлаг судлалын түвшинд ялангуяа дүрслэх урлаг судлалын хувьд хийгээгүй байна. Нийгэм, эдийн засгийн байдал өөрчлөгдөж, ялангуяа сүүлийн жилүүдэд мэдээлэл хөгжиж, олон янзын учир шалтгааны улмаас нуугдаж байсан эртний олон эд зүйл, хувь хүний цуглуулганд байгаа зүйлс нэгэнт ил болж байгааг олон тооны цомог, үзэсгэлэнгийн каталогууд, дуудлага худалдааны урьдчилсан мэдээлэл зэргээс тодорхой харж болно.

Монголын бурханы шашны урлагт бүтээлээ зориулж байсан уран бүтээлчид олон улсын музейн томоохон цуглуулгуудын талаарх каталогийг нийтэлжээ. 2011 онд монгол, англи хэл дээрх "Монголын Бурханы шашны урлаг" хэмээх томоохон бүтээлийг хоёр ботиор хэвлүүлжээ. Үүнд уран зураг, баримал, хатгамал зэргийг багтаасан байна. [Mongolian Buddhist Arts. V.1-2. Tangkas, appliques and embroideries. Serindia Publication, USA].

Хэдийгээр бүтээлүүдийг тодорхойлох, хэвлэн бэлтгэхэд асар их ажил хийгдсэн боловч мэргэжлийн судлаачийн нүдээр харахад харамсалтай нь хэвлэлтийн алдаа гарсан, өнгө алдагдсан гэх мэт учир дутагдалтай болжээ. Богд хааны ордон музей нь Занабазарын баримлууд, түүний дотор хорин нэгэн Дара эх зэрэг хамгийн үнэ цэнтэй бүтээлүүдийн талаар том цомог хэвлэн гаргажээ. [Masterpieces of Bogd Khaan Palace Museum. Ed. by D. Bar-Erdene. UB., 2011]. 2014 онд Монгол улсын орчин үеийн музей байгуулагдсаны 90 жилийн ойд зориулан том каталогийг гурван боть болгон хэвлүүлсэн бөгөөд түүнд Монгол улсын музейн сан хөмрөгт хадгалагдаж байгаа үнэ цэнтэй цуглуулгууд оржээ. Тиймээс энэхүү каталог нь Монгол улсын музейн сан хөмрөгийн ерөнхий зураглалийг харах боломжийг олгож байгаа боловч эдгээрээс Занабазарын бүтээлүүд байгаа эсэх талаар тусгайлсан судалгаа дүгнэлт гаргах ажил хийгдээгүй байна.

2015 онд Занабазарын 380 жилийн ойд зориулан Чойжин ламын сүм музейд хадгалагдаж байгаа баримал, зургийн каталог бэлтгэн гаргажээ. [Masterpieces of Undur Gegeen Zanabazar. Ulaanbaatar, 2015] Мөн энэ жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхийн хүрээнд Улаанбаатар хот, Будапешт хотод олон улсын бага хурал зохион байгуулагдсан бөгөөд Монгол улсын бурханы шашны өвийг хадгалан хамгаалахад судлаачдын анхаарлыг хандуулжээ. Хурлын материалын дагуу "Занабазар: Амьдрал, үйл ажиллагаа, өв" гэсэн ном хэвлүүлсэн байдаг.

Монголын шашны төлөөлөгчид тухайлбал Монголын бурхны шашны уран бүтээлч Пүрэвбат лам удирдан, Гандантэгчэнлин хийдийн дэргэдэх Бурханы шашны урлагийн сургууль өргөн хүрээтэй судалгаа хийж байна. Бурханч лам Г.Пүрэвбатын бүтээлүүдэд бурхны шашны уламжлалын дагуу бурхан, суварга бүтээх, барьж байгуулах дүрэм, журам зэргийн талаар өгүүлжээ. Түүний бүтээлүүд нь Бурхны шашны сонгодог онол сургаалд тулгуурласан байх бөгөөд Гандантэгчэнлин хийд болон Монголын музейн цуглуулгад байгаа Занабазарын бүтээлүүдийн судалгааны талаар дэлгэрэнгүй тайлбарлажээ.



Монгол Улсад энэ тэргүүтэн олон тооны судалгааны бүтээлүүд гарсаар байна. Гэвч Монголын бурхны шашны уран зургийн онолын судалгаанаас үзэхэд үндэсний сургуулиудын онцлог шинж чанар болон Занабазарын монголын хэв маягийн урлагийн хөгжлийн шинж чанарыг хараахан нэг мөр болгож тодруулаагүй байсаар. 30-40 жилийн өмнө Н.Цүлтэм энэ тухай илэрхийлсэн санаанууд нь хангалттай хэрэгжилтийг хүлээн аваагүй тул одоо ч гэсэн холбогдох зүйл хэвээр үлдэж байна гэж хэлж болно. Тэрбээр "Монголын эртний урлаг XX зууны эхэн үе" (1982), "Уран барималч Г.Занабазар" (1982), "Монгол уран баримал" (1989) номдоо Монголын урлаг, уран бүтээлийн гарал үүсэл, гоо зүйн үнэ цэн зэргийг өгүүлжээ. Гэхдээ уран бүтээлчдийн зан чанарыг бараг судлаагүй. Монголын сүм хийдийн уран бүтээлчид, уламжлалт шашны буддын гар урлалуудын талаарх хамгийн дорвитой нийтлэл бол 1995 онд хэвлэгдсэн Д. Дамдинсүрэнгийн "Их Хүрээний нэрт урчууд" ном юм. Дэлхийн уран зургуудыг Монголын уран зургийн уран сайхны онцлогтой харьцуулан харгалзан үзэж, эдгээр зүйлсийг танилцуулах, дүн шинжилгээ хийх аргачлалыг хөгжүүлэх шаардлагатай байна. Орчин үеийн урлагийг судлах онолыг хөгжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулж, Монгол улсын төрөл бүрийн гар урлалын тухай профессор Л.Батчулуун судалгаа хийжээ. Түүний бүтээлд Монголын уламжлалт гар урлалын урлаг, ардын гар урлалын бүтээлийн гарал үүсэл, орчин үеийн уран бүтээлчдийн хэрэглээний ач холбогдлын тухай санал дүгнэлт өгч байгаа боловч Монголчуудын Бурхны шашны нарийн урлаг урлалын тухай өгүүлсэнгүй.

Барууны орны судлаачид Буддын шашны үзэсгэлэнгийн материалыг үндэслэн Монголын бурхны шашны урлаг, гоо зүйн үнэ цэнийг тодорхой хэмжээгээр судлан тогтоохыг оролдсон байна. П.Бергер, Т.Ц.Бартоломео нарыг жишээ болгон тэмдэглэж болно. 1996 оны Сан Франциско дахь Азийн урлагийн музейн үзэсгэлэнгийн үеэр Бартоломео [Mongolia. The Legacy of Chinggis Khan. Asian art Museum of San Francisco. 1996. Patricia Berger, Teresa Tse Bartholomew], Нью-Йоркийн "Монголын эрдэнэс-Занабазарын сургуулийн бурханы шашны уран баримал" үзэсгэлэнгийн каталоги [Beaquin G. Treasures from Mongolia – Buddhist Sculpture from the School of Zanabazar. Rossi & Rossi. NY. 2005] гаргажээ. Герман улсад байгаа янз бүрийн монгол бүтээлүүдийн тухай ганц нэг хувийн цуглуулгад дүрсэлсэн туршлага бий. ОХУ-ын тухайлбал Буриад, Санкт-Петербург хотын эрдэмтэн судлаачдын томоохон баг [С.Meinert. Buddha in der Jurte. Buddhistische Kunst aus der Mongolei. Ed. by A.Terentyev. Munchen. 2011] ажиллажээ. Очирт хөлгөний

бурхны шашны урлагийн бүтээлүүдийн тухай [<https://www.himalayanart.org>; <http://www.asianart.com>] зэргээс Занабазарын бүтээл болон дэлхийн музей, хувийн музейн газруудын мэдээллийг олж авах боломжтой. Оросын зохиогчдын дундаас Т.А.Сергеевийн бүтээлүүдийг дурдах нь зүйтэй бөгөөд тэрээр Москвагийн Дорно дахины музейн монгол танга зураг, Э.В.Ганевский, А.Ф.Дубровина, Т.Д.Огневой нарын судалгаа зэргийг оролцуулжээ.

Гэсэн хэдий ч Занабазарын уран бүтээлч сэтгэлгээ, түүний уран бүтээлийн онцлог, түүний үүсгэн хөгжүүлсэн Монголын онцлогтой бурханы шашин, монголын онцлогтой бурхан урлалд онцгойлон чиглэсэн судалгаа байхгүй байна. Иймийн тул Занабазарын бүтээсэн урлагийн өвийг судлах нь Монголын дүрслэх урлагийн, Монголын түүхийн судлалд зохих хувь нэмэр оруулах юм.

## ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙДАЛ

Төслийн гол үйл ажиллагаа Өндөр гэгээн Занабазарын урлагийн өв, эх сурвалжийг судлах, үндсэн уран бүтээлийг бүртгэх, Монголын бурхаы шашны урлагийн субъектуудэд түүх, уран сайхны шинжилгээ хийхэд чиглэсэн бөгөөд ингэхийн тулд энэ талаар өмнө үеийн судлаачдын хийсэн судалгаа шинжилгээний ажил, архивын баримт материал дээр тулгуурлахын сацуу судалгааны багийн гишүүд өөрсдөө тухайн газар нутагт судлан байцаах ажлыг шинээр биечлэн хийж, хуучин баримтыг магадлах эрдэм шинжилгээний ажлыг ОХУ, Монгол улс дахь Өндөр гэгээний тиг хийцийн урлагийн бүтээл онцгойлон дэлгэрсэн буддын шашны сүм хийд, хувь хүмүүсийн дунд явуулав. Төслийн үр дүнд олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний хурал хийх, эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлэх ажлыг дэс дараатай хийж, хугацааны эцэст Орос Монголын талын хамтын зохиогчтой мэдээллийн дата бий болгов.

### *2019 онд гүйцэтгэсэн төслийн үйл ажиллагааны тайлан*

Орос Монголын хамтарсан төслийг 2019 оны 9-р сарын 23-ны өдөр Монгол Улсын БСШУСЯ-ы төрийн нарийн бичгийн дарга батлан, төслийн хүрээнд гүйцэтгэх ажлын гэрээ байгуулав. Монгол Улсын талаас төслийн удирдагчаар Г.Мягмарсүрэн, төслийн гүйцэтгэгчээр Д. Наранцэцэг, Ц. Гүнчин-Иш, У. Сарантуяа нар ажиллаж байна.

Төслийн удирдагч Г. Мягмарсүрэн тайлант хугацааны эхэнд Оросын талын төслийн удирдагч, ОХУ-ын Москвагийн Дорно дахин судлалын хүрээлэнгийн эрдэмтэн, шинжлэх ухааны доктор, профессор Сыртыповатай биечлэн уулзаж, онол арга зүй, судалгааны явцын талаар хэлэлцэж, чиглэл, нарийвчилсан төлөвлөгөө гаргахад санал нэгдсэн болно.

### *Олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулав*

Зүүн хүрээ Дашчойлин хийд, Бурханы шашин соёл судлалын хүрээлэн, “Зүүн хүрээ” коллежоос санаачлан Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “Өндөр гэгээний үсгийн урлал” эрдэм шинжилгээний бага хурлыг 2019 оны 10-р сарын 4-ний өдөр Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейн үзэсгэлэнгийн танхимд амжилттай зохион байгууллаа. Хурлын хамтран зохион байгуулагчаар Монгол Улсын

Ерөнхийлөгчийн Тамгын газар, МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхим, Монголын философийн холбоо, Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей оролцов.

Хурлыг нээж Зүүн хүрээ Дашчойлин хийдийн хамба лам, доктор Ч.Дамбажав, Монгол Улсын Ерөнхийлөгчийн соёл, шашны бодлогын зөвлөх Ц.Хулан, академич Д.Цэрэнсодном нар үг хэллээ.

Хуралд профессор Л.Тэрбиш, МФХ-ны ерөнхийлөгч, доктор Д.Гантөмөр, МСҮА-ийн ЭНБД доктор Д.Наранцэцэг, ШУА-ийн ХЗХ-ийн ЭША Р.Отгонбаатар, Варшавын Их сургуулийн Дорно дахин судлалын тэнхимийн багш Р.Бямбаа, МУИС-ийн багш С.Дэмбэрэл, “Зүүн хүрээ” коллежийн багш Ц.Мөнх-Эрдэнэ, Богд хааны ордон музейн эрдэм шинжилгээний ажилтан Ц.Гүнчин-Иш, МҮНС-ийн ажилтан Х.Түмэнбаяр, МФХ-ны Удирдах зөвлөлийн гишүүн, доктор Г.Мягмарсүрэн, ОХУ-ын Дорно дахин судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Сурун-Ханда Сиртыпова, А.В.Андреев нарын 12 илтгэгч өөрсдийн судалгааны үр дүнгээс хэлэлцүүлээ.

Төслийн гишүүдийн хэлэлцүүлсэн илтгэлд Өндөр гэгээн Занабазарын уран бүтээлүүдийн онцлог, тиг хийцийн асуудлыг дэлгэрүүлэн авч үзсэн бөгөөд Монголын бурхан шашны төв Гандантэгчэнлин хийд, Богд хааны ордон музей, Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей, Чойжин ламын сүм музейд хадгалагдаж буй Өндөр гэгээн Занабазарын мутрын бүтээлүүдийг хамруулан уран сайхны задлан шинжлэл хийсэн байна. Мөн Өндөр гэгээн Занабазарын сургууль хийцийн онцлогийг тодорхойлон гаргахын зэрэгцээ, Өндөр гэгээн Занабазарын загвар зургаар XIX зууны сүүлчээс, XX зууны эх хүртэл Их хүрээнд сар бүрийн шинийн найманд бурханч лам нарын бүтээж ирсэн “Нэг өдрийн Цагаан дара эх” хэмээх бүтээлийн тухай өгүүлсэн нь Өндөр гэгээн Занабазарын дэг сургуулийн уламжлал өнөө цагт ч үргэлжилж байгааг судалгааны баримтаар тодруулан гаргасан явдал болсон юм.



**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ИВЭЭЛ ДОР ЗОХИОН БАЙГУУЛЖ  
БУЙ СОЁМБО ҮСЭГ ЗОХИОСНЫ 333 ЖИЛИЙН ОЙ  
“ӨНДӨР ГЭГЭЭНИЙ ҮСГИЙН УРЛАЛ” ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ,  
“СОЁМБО-333” ХАМТАРСАН ҮЗЭСГЭЛЭН, СОЁМБО ҮСЭГТ ЗОРИУЛСАН  
ГЭРЭЛТ ХӨШӨӨ-ТААЛЛЫН ШҮТЭЭНИЙ НЭЭЛТИЙН ЁСЛОЛ**

Улаанбаатар хот,  
Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сум, Төвхөн хийд,  
Монгол улс  
2019.10.04-10.10

*Ерөнхий зохион байгуулагч:*

“Зүүн Хүрээ” Дашчойлин хийд  
Бурханы шашин соёл судлалын хүрээлэн  
“Зүүн Хүрээ” коллеж

*Хамтран зохион байгуулагч:*

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар  
МУИС, Философи шашин судлалын тэнхим  
Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей  
Монголын Философийн Холбоо

**“ӨНДӨР ГЭГЭЭНИЙ ҮСГИЙН УРЛАЛ” ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ  
ХУРАЛ,  
“СОЁМБО-333” ХАМТАРСАН ҮЗЭСГЭЛЭН**

Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей

**2019 оны 10 сарын 04, Баасан гараг**

- 08:30 - 09:00 Хуралд оролцох зочид, төлөөлөгчдийг угтах, бүртгэх
- 08:30 - 09:00 Хурлын танхимд зочид, төлөөлөгчид суудлаа эзлэх
- 09:00 “Өндөр гэгээний үсгийн урлал” Эрдэм шинжилгээний хурал, судлаач, цуглуулагч Р.Отгонбаатар, Р.Бямбаа, Б.Амарсанаа, Ч.Бямбасүрэн, Ц.Мөнх-Эрдэнэ нарын хамтарсан “Соёмбо-333” үзэсгэлэнгийн нээлт
- 09:00 - 09:15 “Зүүн Хүрээ” Дашчойлин хийдийн тэргүүн хамба лам, СГЗ, доктор, профессор Ч.Дамбажав нээж үг хэлнэ.
- 09:15 - 09:30 Хүндэт зочид, төлөөлөгчид үг хэлэх  
**Д.Цэрэнсодном** (Академич, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, Монголын нууц товчоо судлалын төв)  
**Ц.Хулан** (Монгол Улсын Ерөнхийлөгчийн соёл, шашны бодлогын зөвлөх)
- 09:30 - 09:45 Дурсгалын зураг авахуулах
- Хурлын дарга: **Г.Мягмарсүрэн** (доктор, Бурханы шашин соёл судлалын хүрээлэн)
- 09:45 - 10:00 “Соёмбо үсгэн тугтай “Халуун эх оронч Цогт тайж” хэмээх үзлийн тухайд хэлэх хэдэн үг”  
**Л.Тэрбиш** (Монгол Улсын Шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн, шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор, зурхайч)
- 10:00 - 10:15 “Өндөр гэгээний язгуурын таван бурхдын урлалын онцлог”  
**Сурун-Ханда Сиртышова** (ОХУ-ын ШУА, Дорно дахины судлалын хүрээлэнгийн тэргүүлэх ажилтан, түүхийн шинжлэх ухааны доктор, (Sc.D), профессор)  
**Д.Наранцэцэг** (Монгол судлалын үндэсний академийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор, дэд профессор)
- 10:15 - 10:30 “Соёмбо үсгийн дурсгалын тойм”  
**Р.Отгонбаатар** (ШУА, Хэл зохиолын хүрээлэн)
- 10:30 - 10:45 “Өндөр гэгээний ахуй ёсны үзэл”  
**Д.Гангөмөр** (доктор, Монголын философийн холбооны тэргүүн)
- 10:45 - 11:00 “Соёмбо бичгийн цагаан толгойнууд”  
**Р.Бямбаа** (Варшавын их сургуулийн Дорно дахины судлалын тэнхим)
- 11:00 - 11:15 Цайны завсарлага

	Хурлын дарга: <b>М.Батаа</b> (доктор, дэд профессор, Номын гурван хүрдэн сан)
11:15 - 11:30	“Соёмбо үсгийг юникодлох үйл явц, тулгамдаж буй асуудлууд” <b>С.Дэмбэрэл</b> (МУИС, Философи шашин судлалын тэнхим)
11:30-11:45	"Соёмбо үсгийн нэгэн шүтээний тухай" <b>Ц.Мөнх-Эрдэнэ</b> ("Зүүн Хүрээ" Коллеж)
11:45-12:00	“Өндөр гэгээн Занабазарын дэг сургуулийн нэгэн уламжлалын тухай” <b>Ц.Гүнчин-Иш</b> (Богд хааны ордон музейн эрдэм шинжилгээний ажилтан)
12:00-12:15	“Өндөр гэгээн Занабазарын соёмбо үсгийн тухайд” <b>Х.Түмэнбаяр</b> (Монгол улсын үндэсний номын сангийн бүртгэл мэдээллийн санч)
12:15-12:30	“Таван богдын зохиол бүтээлийн тухай” <b>Г.Мягмарсүрэн</b> (доктор, Бурханы шашин соёл судлалын хүрээлэн), <b>Андреев А.В.</b> (ОХУ-ын ШУА, Дорно дахины судлалын хүрээлэн)
12:30-13:00	Хэлэлцүүлэг
13:00	Эрдэм шинжилгээний хурлын хаалт
13:00-14:00	Үдийн зоог (Туул ресторан)

## **СОЁМБО ҮСЭГ ЗОХИОСНЫ 333 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛСАН ГЭРЭЛТ ХӨШӨӨ-ТААЛЛЫН ШҮТЭЭН**

Өвөрхангай аймаг, Бат-Өлзий сум, Төвхөн хийд

### **2019 оны 10 сарын 05, Бямба гараг**

09:00 - 16:00 Соёмбо үсэг зохиосны ойд зориулсан тааллын шүтээн гэрэлт хөшөөний нээлтийн ёслолд оролцох зочид төлөөлөгчид, албаны хүмүүс Улаанбаатар хотоос Төвхөн хийд рүү явах

### **2019 оны 10 сарын 06, Ням гараг**

Морь цаг Соёмбо үсэг зохиосны ойд зориулсан тааллын шүтээн гэрэлт хөшөө нээлтийн ёслол

"Соёмбо-333" ойн арга хэмжээг зохион байгуулагчид

Утас: 99195379, 93456464

Цахим шуудан: [buddhismcultureinstitute@gmail.com](mailto:buddhismcultureinstitute@gmail.com)





*Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл хэвлүүлэв.*

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор "Өндөр гэгээний үсгийн урлал" эрдэм шинжилгээний хурал, соёмбо үсэг зохиосны 333 жилийн ойд зориулсан уран бүтээлийн үзэсгэлэнг “Зүүн Хүрээ” Дашчойлин хийд, Бурхны шашин, соёл судлалын хүрээлэн, “Зүүн Хүрээ” коллежоос санаачлан, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхим, Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей, Монголын Философийн Холбоо хамтран зохион байгуулсан юм.

Хурлын эмхэтгэлийг 2020 онд Зүүн хүрээ Дашчойлин хийдээс эрхлэн гаргадаг "Шашин соёл судлал" сэтгүүлийн 2 дахь дугаарт хэвлэн гаргав. Тус эмхэтгэлд 11 илтгэгчийн 9 өгүүллийг хэвлэжээ.

"ЗҮҮН ХҮРЭЭ" ДАШЧОЙЛИН ХИЙД  
БУРХАНЫ ШАШИН СОЁЛ СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН



# ШАШИН СОЁЛ СУДЛАЛ



“ЗҮҮН ХҮРЭЭ”  
ДАШЧОЙЛИН ХИЙД

БУРХАНЫ ШАШИН СОЁЛ  
СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН

# ШАШИН СОЁЛ СУДЛАЛ

**БОТЬ II**  
Дэвтэр 1-10

“ӨНДӨР ГЭГЭЭНИЙ ҮСГИЙН УРЛАЛ”  
ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ  
ХУРЛЫН ЭМХЭТГЭЛ

Улаанбаатар  
2020

ДАА 294.3  
ННА 86.4  
Ш-378

ОХУ-ын суурь судалгааны сан, Монгол Улсын БСШУСЯ,  
ШУТС-ийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Өндөр гэгээн Занабазарын  
тиг хийцийн уран бүтээлийн өвийг бүртгэх, мэдээллийн сан  
бүрдүүлэх аргачлал боловсруулах нь” (ОХУ, РФФИ Монг-т  
№19-59-44011/19, Монгол Улс, Шу, Гх/ОХУ/2019/09)  
төслийн хүрээнд хэвлэв.

Проект РФФИ и МОКНСМ №19-59-44011 Монг\_т  
«Выявление, учёт и исследование объектов художественного  
наследия Дзанабазара в музейных, общинных и частных  
коллекциях Монголии и России: создание базы данных и разработка  
методологии»

## **ШАШИН СОЁЛ СУДЛАЛ**

Боть II, Дэвтэр 1-10

“Өндөр гэгээний үсгийн урлал” ОУЭШХ-ын эмхэтгэл

Эрхэлсэн: Г.Мягмарсүрэн

Copyright © Бурханы шашин соёл судлалын хүрээлэн

Цаасны хэмжээ 880x1190 1/12  
Хэвлэлийн хуудас 13,5  
Хэвлэсэн тоо 500

ISBN 978-99978-4-906-9

“Бэмби сан” ХХК-д эхийг бэлтгэж, хэвлэв.  
Улаанбаатар, 2020

## ГАРЧИГ

<b>Л.Тэрбиш</b>	
“Соёмбо үсгэн тугтай “Халуун эх оронч Цогт тайж” хэмээх үзлийн тухайд хэлэх хэдэн үг” . . . . .	5
<b>Сурун-Ханда Сыртыпова</b>	
<b>Д.Наранцэцэг</b>	
“Өндөр гэгээн Занабазарын язгуурын таван бурхад: Утга ба урлагийн онцлог” . . . . .	18
<b>Р.Отгонбаатар</b>	
“Соёмбо үсгийн дурсгалын тойм” . . . . .	34
<b>Д.Гантөмөр</b>	
“Өндөр гэгээний ахуй ёсны үзэл” . . . . .	46
<b>Р.Бямбаа</b>	
“Соёмбо бичгийн цагаан толгойнууд” . . . . .	58
<b>С.Дэмбэрэл</b>	
“Соёмбо үсгийг юникодлох үйл явц, тулгамдаж буй асуудлууд” . . . . .	71
<b>Ц.Мөнх-Эрдэнэ</b>	
“Соёмбо үсгийн нэгэн шүтээний тухай” . . . . .	83
<b>Ц.Гүнчин-Иш</b>	
“Өндөр гэгээн Занабазарын дэг сургуулийн нэгэн уламжлалын тухай” . . . . .	102
<b>Х.Түмэнбаяр</b>	
“Өндөр гэгээн Занабазарын соёмбо үсгийн тухайд” . . . . .	125
<b>Г.Мягмарсүрэн</b>	
<b>Андреев А.В.</b>	
“Таван богдын зохиол бүтээлийн тухай” . . . . .	148
<b>Зохиогчийн танилцуулга</b> . . . . .	167

*Өндөр гэгээний уран бүтээлийн үзэсгэлэн гаргав.*

Хурлын өдрүүдэд буюу 2019 оны 10 сарын 4-ний өдөр Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей дээр Өндөр гэгээний уран бүтээлийн үзэсгэлэн гаргав. Тус үзэсгэлэн цуглуулагч Амарсанаа, Бямбаа, Бямбасүрэн, Отгонбаатар, уран бичлэгтэн Мөнх-Эрдэнэ өөрсдийн цуглуулга болон бүтээлийн дээжээр оролцож, үзэгч сонирхогчдод тайлбарлан танилцуулав.

Тус эрдэм шинжилгээний хурал, үзэсгэлэн нь төслийн санхүүжилт орохоос өмнө, төслийн календарьчилсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан ажил тул энэхүү үйл ажиллагаанд зориулсан зардал санхүүжилтыг Дашчойлин хийдээс урьдчилан гаргасан болохыг энд тэмдэглэн хэлэх нь зүйтэй болов уу. Төслийн санхүүжилт 2020 оны 3 сард орж ирэхэд бид Дашчойлин хийд рүү урьдчилж авсан мөнгийг шилжүүлсэн болно.







### *2020 онд гүйцэтгэсэн төслийн үйл ажиллагааны тайлан*

Орос Монголын хамтарсан төслийг 2020 оны санхүүжилт 2021 оны 12-р сарын 22-ны өдөр орж ирэв. Энэхүү төсөл Монгол Улсын талаас төслийн удирдагчаар Г.Мягмарсүрэн, төслийн гүйцэтгэгчээр Д.Наранцэцэг, Ц.Гүнчин-Иш, У.Сарантуяа нар үргэлжлүүлэн ажиллаж, санхүүжилт хоцорч орж ирсэн ч, төслийн гэрээнд заасан хуваарьт ажлаа дараах байдлаар хийв.

Төслийн гүйцэтгэгчид тайлант хугацаанд Үндэсний номын сан, Өндөр гэгээний урлалын бүтээлүүд хадгалагдаж байгаа музейд ажиллаж байгаа давуу талаа ашиглан судалгааны эх хэрэглэгдэхүүн цуглуулах ажлыг хийв. Давын өмнө Өндөр гэгээн Занабазарын талаар урьд өмнө судалгаа хийсэн эрдэмтэдийн бүтээлтэй танилцаж ном зүйн бүртгэл гаргаж авав. Үүнд: Өндөр гэгээн Занабазарын намтар сурвалжийн судалгаа, Өндөр гэгээн Занабазарын намтар судлалын талаар судалгааны ажил хийсэн эрдэмтэд болох Академич Ш.Бира, эрдэмтэн Л.Хүрэлбаатар, С.Ичинноров, Х.Нямбуу, Д.Дашбадрах, Ш.Сонинбаяр, С.Дулам нар болон Үсэг бичгийн талаар судалгаа хийсэн




эрдэмтэд болох, Р.Отгонбаатар, Р.Бямбаа, Л.Мөнх-Эрдэнэ, Ш.Чоймаа, Урлахуйн ухааны үүднээс судалгаа хийсэн Н.Цүлтэм, Д.Дашбалдан, Л.Батчулуун, Ц.Уранчимэг, Г.Пүрэвбат, Сыртыпова С.Д нарын бичсэн судалгааны өгүүлүүдийг уншиж танилцан, цаашид нарийвчлан судлах чиг баримжаагаа тогтоов.

*Богд хааны ордон музейд хадгалагдаж буй Өндөр гэгээн Занабазарын мутрын уран бүтээлийн жагсаалт гаргав.*



Төслийн гүйцэтгэгч Ц.Гүнчин-Иш Богд Хааны ордон музейд хадгалагдаж буй Өндөр гэгээн Занабазарын холбогдолтой үзмэрийн жагсаалтыг гаргаж, түүн дотроос уран бүтээлийнх нь жагсаалтыг гаргаж, зураг тодорхойлолт бүхий мэдээлэл бэлтгэв. Одоогоор Богд хааны ордон музейд Өндөр гэгээн Занабазарын мутрын уран бүтээлээс 21 дэсийн 21 ширхэг бүтээл хадгалагдаж байна хэмээн судлаач дүгнэжээ.

Д/д	Нэр, хувийн дугаар, хэмжээ, он цаг, уран бүтээлч, материал	Зураг	Тодорхойлолт
1	<p>Ногоон дара эх 24-1-96 Өн76,5см, Өр48,5см Зу29,7см, 54520г XVII -зуун Г.Занабазарын бүтээл Хүрэл цутгамал,алт шармал</p>		<p>чимэг зүүлт,хувцасны хээ угалзыг их биетэй нь хамтаар нэрмэл цутгуурын аргаар гагнаасгүй урласан,үснэр дээгүүр гоёмсог чимэглэлтэй,баруун гарын алгыг дээш харуулан өвдөг дээгүүр унжуулсан, гарын эрхий долоовор хурууг нийлүүлэн чагж хийсэн,баруун хөлийг унжуулж зүүн хөлөө хагас завилан давхар бад цэцэг суурин дээр суусан,амирлангүй дүртэй,шүншиггүй</p>

2	<p>Дарь эх /Сэрдогжамаа/ 24-1-98 Өн40,5см, Өр26см Зу16,7см, 10445г XVII -зуун Г.Занабазарын бүтээл Хүрэл цутгамал,алт шармал</p>		<p>Хоёр мөрөндөө удвал цэцэгтэй,баруун гараа доош унжуулж баруун өвдгөн дээрээ тавьж дунд хуруугаар бумбаа түшсэн, зүүн гарын ядам эрхий хурууг нийлүүлж чагж хийсэн, бад цэцгэн суудал дээр баруун хөлөө унжуулж , зүүн хөлөө хагас завилж суусан,-баруун нүдний хар будаг цагаан суурь өнгө рүү урссан гэмээр халтартай, шүншиггүй</p>
3	<p>Дарь эх /Жүгдэрнамжилма а/ 24-1-99 Өн40см, Өр26см Зу16,5см, 10380г XVII -зуун Г.Занабазарын бүтээл Хүрэл цутгамал,алт шармал</p>		<p>баруун гараа өвдөг рүү унжуулж ,ядам долоовор хуруугаар бумбаа түшиж барьсан, зүүн гараараа чагж хийн бад цэцгэн суудал дээр баруун хөлөө унжуулан цэцгэн дээр гишгэсэн, шүншиггүй</p>
4	<p>Дарь эх /Дүгсэлжэдмаа/ 24-1-113 Өн40см, Өр26см Зу16см, 10755г XVII -зуун Г.Занабазарын</p>		<p>Хоёр мөрөндөө удвал цэцэгтэй,баруун гараа өвдөг рүү унжуулж ,дунд хуруугаар бумба түшиж барьсан, зүүн гарын эрхий ядам хуруугаар чагж хийсэн,баруун хөлөө унжуулж , зүүн хөлөө хагас завилж</p>


	<p>бүтээл Хүрэл цутгамал,алт шармал</p>		<p>суусан,шүншиггүй</p>
5	<p>Дарь эх /Гончигсүмцомба а/ 24-1-104 Өн40,6см, Өр26см Зу16,5см, 9810г XVII -зуун Г.Занабазарын бүтээл Хүрэл цутгамал,алт шармал</p>		<p>Хоёр мөрөндөө удвал цэцэгтэй,баруун гараа доош өвдөг рүү унжуулж ,дунд хуруугаар бумба түшиж барьсан, зүүн гарын эрхий ядам хуруугаар чагж хийсэн,баруун хөлөө унжуулж , зүүн хөлөө хагас завилж суусан,шүншиггүй -нүүр бусдаас онцгой халтартсан,зүүн талын бад цэцгийн ишний арын доод хэсэгт шармалгүй,арын сууринд цагаан цаасан дээр төвд бичээстэй</p>
6	<p>Дарь эх /Пэрэнлэйдүлжид/ 24-1-116 Өн40.5см, Өр25,5см Зу16.5см, 10435г XVII -зуун Г.Занабазарын бүтээл Хүрэл цутгамал,алт шармал</p>		<p>Хоёр мөрөндөө удвал цэцэгтэй,баруун гараа доош унжуулж баруун өвдгөн дээрээ тавьж,дунд хуруугаар бумба түшиж барьсан, зүүн гарын эрхий ядам хуруугаар чагж хийн зүрхэн тус газраа барьсан,баруун хөлөө унжуулж , зүүн хөлөө хагас завилж суусан,шүншиггүй -нүүр бусдаас онцгой халтартсан,зүүн талын бад цэцгийн ишний арын доод хэсэгт шармалгүй,арын сууринд цагаан цаасан дээр төвд бичээс бичиж</p>

			наасан
7	<p>Дарь эх /Жигдэнсумёови/ 24-1-112 Өн40,5см, Өр25,5см Зу16см, 9930г XVII -зуун Г.Занабазарын бүтээл Хүрэл цутгамал,алт шармал</p>		<p>Хоёр мөрөндөө удвал цэцэгтэй,баруун гараа доош унжуулж баруун өвдгөн дээрээ тавьж,дунд хуруугаар бумба түшиж барьсан, зүүн гарын эрхий ядам хуруугаар чагж хийн зүрхэн тус газраа барьсан,баруун хөлөө унжуулж , зүүн хөлөө хагас завилж суусан,шүншиггүй -Үснэрийн цэнхэр будаг нимгэн түрхэгдсэн,зүүн хацар халтар ихтэй,</p>
8	<p>Дарь эх /Жигдэнвандулма/ 24-1-105 Өн40,2см, Өр25,5см Зу16,5 см 8995г XVII -зуун Г.Занабазарын бүтээл Хүрэл цутгамал,алт шармал</p>		<p>Хоёр мөрөндөө удвал цэцэгтэй,баруун гараа доош унжуулж баруун өвдгөн дээрээ тавьж,дунд болон ядам хуруугаар бумба түшиж барьсан, зүүн гарын эрхий ядам хуруугаар чагж хийн зүрхэн тус газраа барьсан,баруун хөлөө унжуулж , зүүн хөлөө хагас завилж суусан,шүншиггүй -Нүүрний 2 шанаагаар будаг халтар</p>
9	<p>Дарь эх /Нурвабамуу, Мусармаабамуу/ 24-1-110 Өн40,5см Өр26см Зу16 см 9370г</p>		<p>Хоёр мөрөндөө удвал цэцэгтэй,баруун гараа доош унжуулж баруун өвдгөн дээрээ тавьж,дунд болон ядам хуруугаар бумба түшиж барьсан, зүүн гарын эрхий ядам хуруугаар</p>



	<p>XVII -зуун Г.Занабазарын бүтээл Хүрэл цутгамал,алт шармал</p>		<p>чагж хийн зүрхэн тус газраа барьсан,баруун хөлөө унжуулж , зүүн хөлөө хагас завилж суусан,шүншиггүй - Хүйсний нүх гүн биш өнгөцхөн,суурины зүүн урд доод бадан дээр үснэрийн цэнхэр будаг дуссан,бүдгэрч арилж байгаа</p>
10	<p>Дарь эх /Жигдэнсумжал/ 24-1-101 Өн40,5см Өр25,5см Зу16,2 см 9770г XVII -зуун Г.Занабазарын бүтээл Хүрэл цутгамал,алт шармал</p>		<p>Хоёр мөрөндөө удвал цэцэгтэй,баруун гараа доош унжуулж баруун өвдгөн дээрээ тавьж,дунд хуруугаар бумба түшиж барьсан, зүүн гарын эрхий ядам хуруугаар чагж хийн зүрхэн тус газраа барьсан,баруун хөлөө унжуулж , зүүн хөлөө хагас завилж суусан,шүншиггүй</p>
11	<p>Дарь эх /Чогдэрмаа/ 24-1-103 Өн40,5см Өр26см Зу16,2 см 10305г XVII -зуун Г.Занабазарын бүтээл Хүрэл цутгамал,алт</p>		<p>Хоёр мөрөндөө удвал цэцэгтэй,баруун гараа доош унжуулж баруун өвдгөн дээрээ тавьж,дунд ядам хуруугаар бумба түшиж барьсан, зүүн гарын эрхий ядам хуруугаар чагж хийн зүрхэн тус газраа барьсан,баруун хөлөө унжуулж , зүүн хөлөө хагас завилж суусан,шүншиггүй</p>

	шармал		
12	<p>Дарь эх /Донжидмаа/ 24-1-97 Өн41см Өр25,5см Зу16 см 9850г XVII -зуун Г.Занабазарын бүтээл Хүрэл цутгамал,алт шармал</p>		<p>Хоёр мөрөндөө удвал цэцэгтэй,баруун гараа доош унжуулж баруун өвдгөн дээрээ тавьж,дунд хуруугаар бумба түшиж барьсан, зүүн гарын эрхий ядам хуруугаар чагж хийн зүрхэн тус газраа барьсан,баруун хөлөө унжуулж , зүүн хөлөө хагас завилж суусан,шүншиггүй</p>
13	<p>Дарь эх /Хумдаадулам/ 24-1-100 Өн40см Өр25,5см Зу16,5 см 10325г XVII -зуун Г.Занабазарын бүтээл Хүрэл цутгамал,алт шармал</p>		<p>Хоёр мөрөндөө удвал цэцэгтэй,баруун гараа доош унжуулж дунд,ядам хуруугаар бумбаа түшиж барьсан, зүүн гарын эрхий ядам хуруугаар чагж хийн,баруун хөлөө унжуулж , зүүн хөлөө хагас завилж суусан,шүншиггүй, -арын сууринд цагаан цаасан дээр төвд бичигтэй</p>
14	<p>Дарь эх /Шинжитүгжамба/ 24-1-102 Өн40,2см Өр26см Зу16 см 9430г</p>		<p>Хоёр мөрөндөө удвал цэцэгтэй,баруун гараа доош унжуулж,дунд хуруугаар бумбаа түшсэн,зүүн гарын эрхий ядам хуруугаар чагж хийсэн, бад цэцгэн суудал дээр баруун хөлөө доош унжуулан зүүн хөлөө</p>

	<p>XVII -зуун Г.Занабазарын бүтээл Хүрэл цутгамал,алт шармал</p>		<p>завилан цэцгэн дээр гишгэсэн -арын сууринд цагаан цаасан дээр төвд бичигтэй,Баруун суурины доод ёроолд 3,5см газар шармал түрхэгдээгүй</p>
15	<p>Дарь эх /Пунсалдулам/ 24-1-106 Өн40,2см Өр26см Зу16 см 9545г XVII -зуун Г.Занабазарын бүтээл Хүрэл цутгамал,алт шармал</p>		<p>Хоёр мөрөндөө удвал цэцэгтэй,баруун гараа доош унжуулж баруун өвдгөн дээрээ тавьж,дунд хуруугаар бумбаа түшиж барьсан, зүүн гарын эрхий ядам хуруугаар чагж хийн зүрхэн тус газраа барьсан,баруун хөлөө унжуулж ,зүүн хөлөө хагас завилж суусан,шүншиггүй, -нүүр онцгой халтар</p>
16	<p>Дарь эх /Мидирварви/ 24-1-108 Өн39см Өр26см Зу17 см 9580г XVII -зуун Г.Занабазарын бүтээл Хүрэл цутгамал,алт шармал</p>		<p>Хоёр мөрөндөө удвал цэцэгтэй,гурван мэлмийтэй,баруун гараа доош унжуулж баруун өвдгөн дээрээ тавьж,дунд хуруугаар бумбаа түшиж барьсан, зүүн гарын эрхий ядам хуруугаар чагж хийсэн ,баруун хөлөө унжуулан ,зүүн хөлөө хагас завилж суусан,шүншиггүй, -нурууны үсний будаг гуя,ар нуруу,баруун дал хэсэгт хальж</p>

			будагдсан оромтой
17	<p>Дарь эх 24-1-109 Өн40,5см Өр25,5см Зу16,6 см 9300г XVII -зуун Г.Занабазарын бүтээл Хүрэл цутгамал,алт шармал</p>		<p>Хоёр мөрөндөө удвал цэцэгтэй,баруун гараа доош унжуулж баруун өвдгөн дээрээ тавьж,дунд хуруугаар бумбаа түшиж барьсан, зүүн гарын эрхий ядам хуруугаар чагж хийн зүрхэн тус газраа барьсан,баруун хөлөө унжуулж ,зүүн хөлөө хагас завилж суусан,шүншиггүй,</p>
18	<p>Дарь эх /Тониржамаа/ 24-1-107 Өн41,8см Өр25,7см Зу17см 10855г XVII -зуун Г.Занабазарын бүтээл Хүрэл цутгамал,алт шармал</p>		<p>Тэргүүндээ Авид бурхангүй,мөрөндөө цэцэггүй,догшин дүртэй,баруун гартаа дэгүг,зүүн гартаа аяга барьсан,бад цэцгэн суудал дээр зүүн хөлөө унжуулж,баруун хөлөөр хагас завилан суусан,шүншиггүй - баруун талын хондлой дээр хэвний сэв гэмээр 3 см урт босоо зураастай</p>
19	<p>Дарь эх /Одсэржамаа/ /Жанрайсэг/ 24-1-111 Өн42см Өр27см</p>		<p>Баруун мөрөн дээрээ удвал цэцгэн чимэгтэй,зүүн мөрөн дээгүүр гөрөөсний арьс нөмөрсөн,эрэгтэй цээжтэй,баруун гараа нугалж</p>



	<p>Зу17,7см 11390г XVII -зуун Г.Занабазарын бүтээл Хүрэл цутгамал,алт шармал</p>		<p>эрхий долоовор хуруугаар чагж хийн цээжин тус газраа барьсан, зүүн гараа доош унжуулан зүүн өвдөг дээрээ тавьж алгаа урагш харуулсан бад цэцгэн суудал дээр завилгаар суусан</p>
20	<p>Дарь эх /Дуламсэлвий/ 24-1-114 Өн40см Өр25,5см Зу16,5см 10090г XVII -зуун Г.Занабазарын бүтээл Хүрэл цутгамал,алт шармал</p>		<p>Хоёр мөрөндөө удвал цэцэгтэй, баруун гараа доош унжуулж, дунд хуруугаар бумбаа түшсэн, зүүн гарын эрхий ядам хуруугаар чагж хийсэн, бад цэцгэн суудал дээр баруун хөлөө доош унжуулан зүүн хөлөө завилсан</p>
21	<p>Дарь эх /Рэгнадсэлви/ 24-1-115 Өн40,5см Өр26см Зу16,5см 10985г XVII -зуун Г.Занабазарын бүтээл</p>		<p>Хоёр мөрөндөө удвал цэцэгтэй, баруун гараа доош унжуулж, дунд хуруугаар бумбаа түшсэн, зүүн гарын эрхий ядам хуруугаар чагж хийсэн, бад цэцгэн суудал дээр баруун хөлөө доош унжуулан зүүн хөлөө завилан цэцгэн дээр гишгэсэн</p>



	Хүрэл цутгамал,алт шармал		
--	---------------------------------	--	--



*Г.Занабазарын нэрэмжит дүрслэх урлагийн музейд хадгалагдаж буй Өндөр гэгээн Занабазарын мутрын уран бүтээлийн жагсаалт гаргав*



Төслийн гүйцэтгэгч У.Сарантуяа Өндөр гэгээн Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейд хадгалагдаж байгаа Өндөр гэгээний өөрийн мутрын уран бүтээлүүдийн жагсаалт, тодорхойлолт гаргав.



<b>Д/Д</b>	<b>Нэр, хувийн дугаар, хэмжээ, он цаг, уран бүтээлч, материал</b>	<b>Зураг</b>	<b>Тодорхойлолт</b>
------------	---------------------------------------------------------------------------	--------------	---------------------




1	<p>Цагаан дарь эх /Ситатара/ 69.43.21</p> <p>Өндөр: 68см, Жин: 53830г, Диаметр: 45см</p> <p>Г.Занабазарын бүтээл Хүрэл цутгамал, алт шармал</p>		<p>Баруун гарынхаа алгыг нааш харуулан хурууг тэнийлгэж баруун хөлийг өвдөг дээр зөөлөн тавьсан. Зүүн гараа тохойгоор нугалан зүүн хөхний харалдаа өргөж, алгыг нааш харуулан, эрхий, ядам хуруугаар удвал цэцгийн ишнээс чимхжээ. Очир завилгаагаар бад цэцэг суурин дээр суусан, шүншиггүй.</p>
2	<p>Маш гийгүүлэн зохиогч /Вайрочана/ 69.43.69</p> <p>Өндөр: 71.5см, Жин: 62900г Диаметр: 45.5см</p> <p>XVII зуун Г.Занабазарын бүтээл Хүрэл цутгамал, алт шармал</p>		<p>Дэлбээгээ нээж буй бадамлянхуа цэцгийн дүрст дугуй суурин дээр очир завилгаа суудлаар заларч, хоёр мутраа тохойгоор нугалан, бодь сэтгэлийг үүсгэн, хүсэл соёрхогч мутарлаг үзүүлэн цээжин тушаа аваачин, мунхаг харанхуйг бэлгэдсэн, шүншиггүй.</p>
3	<p>Үйл бүтээгч /Амогашиди/ 69.43.68</p> <p>Өндөр: 70см, Жин: 57400г, Диаметр: 45.5см</p> <p>XVII зуун Г.Занабазарын бүтээл</p>		<p>Дэлбээгээ нээж буй бадамлянхуа цэцгийн дүрст дугуй суурин дээр очир суудлаар заларч, зүүн гарын алгыг дээш харуулан баруун хөлийн өсгийд хүргэн тосож, баруун гараа</p>

	Хүрэл цутгамал, алт шармал		тохойгоор нугалан баруун хөхний зэрэгцээ оршоож, хурууг тэнийлгэн байна, Шүншиггүй.
4	<p>Үл хөдлөгч /Акшоба/ 69.43.70</p> <p>Өндөр: 71см, Жин: 60250г Диаметр: 46см</p> <p>XVII зуун Г.Занабазарын бүтээл Хүрэл цутгамал, алт шармал</p>		Дэлбээгээ нээж буй бадамлянхуа цэцгийн суурин дээр очир завилгаа суудлаар заларч, баруун мутраа сунган өвдөг дээрээ тавин алгыг доош харуулан дунд хурууны үзүүрээр газарт хүрэн, зүүн мутрын алгыг дээш харуулан өглөгийн зангаа буюу дээдийн зэрэгт бодь сэтгэлийг илтгэж, ялалт бэлгэдсэн мутрын тэмдэгтэй, шүншиггүй.
5	<p>Цаглашгүй гэрэлт /Авид/ 69.43.71</p> <p>Өндөр: 70.5см, Жин: 52250г, Диаметр: 45.5см</p> <p>XVII зуун Г.Занабазарын бүтээл Хүрэл цутгамал, алт шармал</p>		Дэлбээгээ нээж буй бадамлянхуа цэцгийн дүрст дугуй суурин дээр очир завилгаа суудлаар заларч, зүүн мутрын алган дээр баруунаа тавин, шийдвэр төгөлдөр бясалгалын мутарлаг үзүүлэн шунал тачаангуйг дарахыг бэлгэдсэн, шүншиггүй.

6	<p>Бодь суварга /Ступа/ 69.43.22 Өргөн: 46см, Өндөр: 70см, Жин: 36300г, Зузаан: 45см XVII зуун Г.Занабазарын бүтээл Хүрэл цутгамал, алт шармал</p>		<p>Дорно дахины босоо дөрвөлжиндүү маягийн суваргаас нэлээд ялгаатай бөгөөд газрын гүнээс урган гарч тэнгэр өөд тэмүүлэх мэт гурвалжин хэлбэрийн зохиомжтой, орой дээрээ уламжлалт бэлгэдэл болох нар, сар, галын дөл бадарч байгаагаар, Доод хэсэгт товгор 8ш арслан, заан, хангарьд, тогос зэрэг дүрсэлсэн.</p>
7	<p>Манзшир /Зөөлөн эгшигт/ 69.45.33 Өндөр: 58см, Жин: 13250гр, Диаметр: 20см XVII зуун Г.Занабазарын бүтээл Хүрэл цутгамал, алт шармал</p>		<p>Манзушир бурхны баруун мөрөнд цогцлох цэцгийн дээр буруу үзэл, мунхаг харангуйг тасчин гийгүүлэх утга бүхий илд, зүүн мөрөнд цогцлох цэцгэн дээр билэг төгс гэгээрэлд хүрснийг илтгэх судартай, хоёр мутраа цээжин тус авчран чагжаалж, удвал цэцгийн ишнээс барин зогсоно.</p>



8	<p>Аюуш /Насан цаглашгүй/ ДҮМ2012.0.42 Урт: 12.7см, Өргөн: 8.6см, Өндөр: 20.6см, Жин: 1420г XVII зуун Г.Занабазарын бүтээл Хүрэл цутгамал, алт шармал</p>		<p>Хоёр мутраа тэгш агуулан насны бумбыг галбирваасан модоор чимж барьсан. Үсээ жинсэлж боосон, торгон цээживч, хормогчтой, эрдэнэ хэлхсэн титэм, ээмэг зэрэг элдэв дээдийн чимэгтэй. Очир завилгаагаар лянхуа саран мандал дээр залрах, шүншигтэй түүндээ нацагдоржтой</p>
9	<p>Бурхан багш /Шакямуни/ 69.50.07 Урт: 17.3см, Өргөн: 12.1см, Өндөр: 25.2см, Жин: 3495г XVII зуун Г.Занабазарын бүтээл Гууль цутгамал, алт шармал</p>		<p>Зүүн гартаа өмнө, баруун гараа өвдөг тур газарт хүргэсэн. Суурин таган дээр шармал нацагдоржтой. 2 хөл, мутар дээрээ сийлмэл хоролтой.</p>
10	<p>Манла 69.43.09 Өндөр: 30см, Жин: 6850гр, Диаметр: 18.5см XVII зуун Г.Занабазарын бүтээл Хүрэл цутгуур, алтан шармал, алтан боронз, шороон будаг.</p>		<p>Зүүн мутартаа дээш харуулан барьж, баруун мутраа алгыг дээш харуулан өвдгөн тус унуулж, өндөр бад суурин дээр завилсан.</p>

11	<p>Богд Зонхов /Богд лам Зонхов/ 69.50.08 Урт: 9см, Өргөн: 7.3см, Өндөр: 12.9см, Жин: 527.8г XVII зуун Г.Занабазарын бүтээл Гууль цутгамал, алт шармал</p>		<p>Хоёр мөрөндөө арилд судар бүхий цэцэгтэй. Хоёр гараа цэцгийн ишнээс барьж өмнө чагжаалсан. Бүтэн товгор бад хээтэй дугуй суурьтай. Сууриндаа товгор, шармал нацагдоржтой.</p>
12	<p>Өөрийн хөрөг /Г.Занабазар/ 69.51.01 Өргөн: 46.5см, Өндөр: 64.7см, Хэмжээ: Зах: өн- 120см, өр-71см XVII зуун Г.Занабазарын бүтээл Монгол зураг, шороон будаг, даавуу</p>		<p>Тэрээр номын багш V багш лам, I Банчин богд , шүтээн болор Дэмчиггарав, Янжинлхам, Басудара эх болон Намсрай, Гонгор, Гомбо зэрэг сахиуснуудаар хүрээлүүлэн номын хувцастай, судар барин, олбог суудал залран байна.</p>
13	<p>Эх Ханджамцын хөрөг /Хандо жамцо/ 69.51.02 Өргөн: 38см, Өндөр: 54см, Хэмжээ: Зах. өн- 100см, өр-52см. XVII зуун Г.Занабазарын бүтээл Монгол зураг, шороон будаг, даавуу, торго.</p>		<p>Ханджамц хатан судар баруулан тэгш дүүрэн харцтай, амгалан дөлгөөн, хайр энэрэл дүүрэн,эгэл бус эмэгтэйн дүрээр илэрхийлэн гаргажээ.</p>

14	<p>Бурхан багш /Шакямунь/ 80.03.01 Урт: 16.3см, Өргөн: 11.9см, Өндөр: 22.2см, Жин: 2890г Г.Занабазарын бүтээл Гууль цутгуур, алт шармал, шороон будаг</p>		<p>Баруун мутраар нотлох, зүүнээр бясалгалын мутарлаг үйлдэн бадар аяга барьж зөөлөн амарлингуй дүрээр бадам цэцгийн мандал дээр очир завилгаагаар заларна. Суурины тагны ёроолд нацагдорж сийлж, алтаар шарсан.</p>
15	<p>Чагши Жанрайсэг // 70.60.01 Урт: 17.5см, Өргөн: 12.2см, Өндөр: 29.7см, Жин: 5685г Хүрэл цутгуур, алтан шармал, шороон будаг.</p>		<p>Дөрвөн мутартай. Жанрайсаг нь нэг тэргүүнтэй, бадам цэцгийн мандал дээр очир суудлаар заларна. Урд хоёр мутраар эрдэнэ наминчлан барьж, баруун дээд мутарт болор эрхи, зүүнд бадам цэцэг соёрхжээ.</p>
16	<p>Аюуш /Насан цаглашгүй/ ДҮМ2015.1.1 Өндөр: 19.5см, Жин: 2040г Диаметр: 12.3см Г.Занабазарын бүтээл Хүрэл цутгуур, алт шармал, шороон будаг.</p>		<p>Тэрээр амарлингуй мишээсэн дүртэй, хоёр мутраа тэгш агуулан насны бумыг галбирваасан модоор чимснийг барьсан, үсээ жинсэлж боон эрдэнийн титэм зүүж, торгон цээживч, хормогчтой, очир завилгаа суудлаар давхар</p>



			бад суурин дээр заларна. тагны ёроолд товгор нацагдоржтой.
17	<p>Манзшир /Зөөлөн эгшигт/ 70.53.02 Урт: 13см, Өргөн: 8.7см, Өндөр: 21.2см, Жин: 1715г Г.Занабазарын бүтээл Гууль цутгуур, алтан шармал, шороон будаг, зэс.</p>		Тэрээр баруун мөрөндөө буруу үзэл, мунхаг харанхуйг арилгагч илд, зүүн мөрөнд Бадамлянхуа цэцэг бүхий төгс гэгээрэлд хүрснийг илтгэх судар барин, лянх суурин дээр очир суудлаар заларна. Тагны ёроолд шармал нацагдоржтой.
18	<p>Ногоон дара эх, /Шяама Тара/ 95.01.01 Урт: 13.3см, Өргөн: 10.8см, Өндөр: 20.6см, Жин: 1495г Г.Занабазарын бүтээл Гууль цутгуур, алтан шармал, шороон будаг, зэс, алтан боронз.</p>		Баруун хөлөө унжуулан бадамлянхуа дээр тавьж, зүүн хөлөө сэнтий дээр тавьсан. Тэрээр удвал цэцгийн ишнээс чимхэн, баруун мутраар дээдийн өглөгийн, зүүн мутраар авралын мутарлаг үйлдэн, битүү тойрсон, давхар бадам цэцгийн саран мандал дээр заларчээ. Суурины тагандаа шармал нацагдоржтой.

19	<p>Занабазарын гарын хээ 76.16.747</p> <p>Өргөн: 33см, Өндөр: 44см</p> <p>Г.Занабазарын бүтээл /мутрын дардас/ Хадаг, улаан зосон будаг.</p>		<p>Гарын таван хурууны үе болон алганы хонхор хэсэг, зарим зураас тод харагдана. Хадгийн доод талд дардастай адил шунх будгаар төвд үг бичсэн нь баларч бараг уншигдахгүй болсон.</p>
20	<p>Дүншигийн бурхан 76.16.49</p> <p>Урт: 10.8см, Өргөн: 6.6см, Өндөр: 13.8см, Жин: 757.3г</p> <p>Г.Занабазарын бүтээл Гууль цуггуур, алтан шармал, шороон будаг.</p>		<p>Тэрээр баруун мутрын алгыг нааш харуулан цээжний өмнө авч зүүн мутрын алгыг дээш харуулан өвөр дээрээ барьсан байдлаар дүрсэлсэн овоолсон үсний дээр зэндмэнэ эрдэнэтэй. Шүншигтэй</p>

Энэ мэтээр цуглуулсан баримт мэдээлэлд дүн шинжилгээ хийж, өмнөх судалгааны ажил, эх хэрэглэгдэхүүндээ үндэслэж эрдэм шинжилгээний илтгэл хэлэлцүүлж, эрдэм шинжилгээний өгүүлэл, ном хэвлүүлэв. Бичсэн өгүүллүүд сэдэв агуулгын хувьд Монгол Улсад байгаа Өндөр гэгээний тиг хийцийн бүтээлүүд, цаашлаад Өндөр гэгээний намтар, сүнбум зохиолуудад холбогдож байна.

*Өндөр гэгээний байгуулсан шашин урлагийн түүхэнд холбогдох барилга, байгууламжийн жагсаалт гаргав*

Төслийн гүйцэтгэгч, доктор Д.Наранцэцэг календарьчилсан төлөвлөгөөний дагуу Өндөр гэгээний төвөд, монгол намтарт гардаг шашин урлагийн түүхэнд холбогдох барилга байгууламжууд, уран бүтээлийн төвлөрсөн газрыг нь тодруулах оролдлого хийв. Судлаач Монголын түүхийн судалгаанд харьцангуй бага хамрагдсан цаг үе бол 17-р зуун буюу Өндөр гэгээний амьдарч байсан цаг үе юм. Энэ цаг үеийн түүхийг судалж ирсэн гол эх сурвалж нь түүхийн тулгар хэдэн сурвалж бичиг бөгөөд намтар зохиол, аман түүх, археологийн эх сурвалжийн судалгааны үр дүнг төдий л ашиглалгүй өнөөг хүрч иржээ. Харин сүүлийн үед Монголын түүхийн судалгаа тэр тусмаа Монголын бурхны шашин, хот төлөвлөлт, уран барилга архитектур, урлагийн түүхийн судалгаанд ач холбогдолтой газар орныг тухайн газар орны тухай өгүүлсэн сурвалж бичиг, археологийн олдворуудаар давхар баталгаажуулан илрүүлж, судалгааны эргэлтэд оруулсаар байна. Үүний нэг нь Монголын нэрт соён гэгээрүүлэгч, анхдугаар богд Жибзундамба хутагт Өндөр гэгээн Занабазарын амьдрал, уран бүтээлд холбогдох хийд орон газар юм гээд төвөд, монгол хэлээр гарсан Өндөр гэгээн Занабазарын намтар зохиолуудад тулгуурлан түүний удирдлага санаачилгаар барьж байгуулсан байж болохуйц сүм хийд, урлалын газрын тухай асуудлыг хөндөн, түүний уран бүтээлийн ордон буюу шүтээн урлалын газар аль болох, өнөөгийн байршил, илрүүлэлтийн тухайд доктор Сүрэнханд, докторант Гүнчин-Иш нартай эрдэм шинжилгээний хамтарсан өгүүлэл бичиж, Варшавын Их Сургуулийн монгол судлалын сэтгүүлд хэвлүүлэхээр өгчээ. Тус өгүүлэл хөндлөнгийн хянан магадлагаагаар зөвшөөрөгдөөд, одоо хэвлэгдэх шатандаа явж байна.

Тус өгүүлэлд Өндөр гэгээний шашны ном, тарнийн бүтээл, уран бүтээлээ хийдэг байсан Шаддүвдаржайлин хийд (1663), Далай ижийн жас буюу Цахиуртын хурал (1666), Баруун хүрээ хэмээн алдаршсан Шанхын хийд (1647), Шивээт ууланд нямба бясалгалын бүтээлийн орон Дүвхан хийд (1653), Хэнтий ханы өвөр дэх Сарьдагийн хийд (1654), Хэрлэний Зүүн хүрээ (1711) тэргүүтэн орон хийд, түүнчлэн Өндөр гэгээн Их Хүрээний аймгуудыг байгуулах эхлэлийг тавьж, тэдгээр аймгуудын тус тусын хурал уншлагатай болгосон тухай "Төвөдийн Брайвүн хийдийг байгуулсан Жамьян цорж нь Брайвүн хийдийг байгуулаад долоон дацантай болгосны адилаар Өндөр гэгээн нь Жамьян цоржийн тэр журамтай нийцүүлж, Сангай, Зоогой, Ноёны, Дархан эмч, Ирлүүд, Амдуу нар, Жасын гэсэн долоон аймгийг байгуулсан" талаар өгүүлжээ. Харамсалтай нь эдгээр хийд орны

зарим нь цагийн аяс, он цагийн нугачаанд эвдэрч сүйтгэгтэн, хэзээ, хэн, хэрхэн байгуулсан нь нарийн тодорхой мэдэгдэхгүй шахам болоод байгааг манай судлаачид тодруулсан юм.

*Өндөр гэгээн тэргүүтэй Монголын 8 богдын бүрэн зохиолыг орчуулж гаргав.*

Төслийн гэрээний үр дүнгийн даалгаварт тусгагдсан "Өндөр гэгээн тэргүүтэй Монголын 8 богдын бүрэн зохиолыг орчуулж, хэвлүүлэх" ажлыг төслийн удирдагч доктор Г.Мягмарсүрэн хийж, төслийн гүйцэтгэгч доктор Д.Наранцэцэг редакторлав.

Үүнээс Өндөр гэгээн Занабазар Лувсандамбижанцан (1635-1723), IV Богд Лувсантүвдэнванчигжигмэджамц (1775–1813), V Богд Лувсанцүлтэмжигмэдданбижанцан (1815-1841), VII Богд Агваанчойживаанчигпэрэнлэйжамц (1850-1868), VIII Богд Агваанлуvsанчойжинямданзанваанчиг (1869-1924) нар сүмбүм буюу бүрэн зохиолын түүвэртэй, бусад богдууд сүмбүмгүй тул 5 богдын зохиолын орчуулга шинээр гарч байгаа юм. Тус номыг 2022 онд орж ирсэн 2021 оны төслийн санхүүжилтээр хэвлүүлж байна.

*Занабазарын уран бүтээлийн өв болох "Өндөр гэгээн Занабазарын загвар хийц" /А.Алтангэрэлийн цуглуулгын жишээн дээр/ ном хэвлүүлэв*

Төслийн Оросын талын удирдагч Сүрэнханда Сыртыпова Бурхны шашин соёл судлалын хүрээлэн, ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн санхүүжилтээр А-4 форматаар 374 хуудас бүхий, өнгөт зурагтай, англи монгол хавсарсан тайлбартай 3 бүлэг судалгааны ганц сэдэвт зохиол хэвлүүлэв.

Тус номын нэгдүгээр бүлэгт Монголын буддын шашны уран зураг дахь хөрөг дүрийн эх сурвалжийг авч үзсэн бөгөөд үүнд хөрөг дүрийн болон уран сайхны дүрийн эх сурвалж нь эртний амьтан шүтлэгтэй холбоотой ба энэ нь эл дүрслэх урлагийг судлах нэгэн гол тулгуур болж байгааг гаргажээ. Хоёрдугаар бүлэгт буддын шашны дүрслэх урлаг дахь монгол үндэстний хэв маягийг хөгжлийг үзүүлсэн байна. Ингэхдээ тухайн цаг үеийн алдартай түүх соёлын дурсгалд тулгуурлан нүүдлийн гоо сайхан ба түүнийг бүтээх арга барил буддын уран зурагт хэрхээн шингэсэн болохыг шинжлэн судалжээ. Гуравдугаар бүлэгт Өндөр гэгээн Занабазарын одоогоор илрүүлээд байгаа хувь хүний болон Монгол Улсын музейн цуглуулгад байгаа дурсгалуудын талаар өгүүлсэн нь Өндөр гэгээний бүтээсэн уран бүтээлийн онцлог шинж нь тус уран бүтээлчийн бүтээлд

хамааралтай, холбоотой бүтээл туурвилыг илрүүлэхэд голлох чиг баримжаа болж байгаа билээ.



**ӨНДӨР ГЭГЭЭН ЗАНАБАЗАРЫН  
ЗАГВАР ХИЙЦ**

ННА 63  
ДАА 900  
С-95

Энэхүү бүтээлийг Монгол улсын БСШУСЯ, ОХУ-ын Суурь судалгааны сан хооронд байгуулсан санамж бичгийн дагуу Орос, Монголын хамтарсан “Өндөр гэгээний тиг хийцийн урлаг соёлын өвийг судлах, Монгол, Оросын музей, олон нийтийн байгууллага болон хувь хүмүүсийн гар дээрх цуглуулгын мэдээллийн сан бүрдүүлэх, бүртгэх аргачлал боловсруулах нь” №19-59-44011/19 суурь судалгааны төсөл болон Олон улсын Монгол судлалын холбооны “Монголын түүх-соёлын өв” төслийн хүрээнд нийтлэв.

**Сыртыпова С.-Х.Д. ӨНДӨР ГЭГЭЭН ЗАНАБАЗАРЫН ЗАГВАР ХИЙЦ** (А.Алтангэрэлийн цуглуулгын жишээн дээр) - Улаанбаатар, “АДМОН ПРИНТ” ХХК, 2019. - 47 хх.

Ерөнхий редактор:

Сампилдондовын Чулуун

Англи хэлний редактор:

Сьюзан С.Бирне, Шайда Дорабжээ

Зөвлөх:

Лүндэнгийн Батчулуун, Валерий П. Андросов

Монгол хэлнээс орчуулсан:

Доржсүрэнгийн Бүрнээ, Батбаярын Амгалан

Англи хэлнээс орчуулсан:

Марина Фортманн, Густаво Фортманн

Гэрэл зургийг:

Гансүх Намгар, Сурун-Ханда Д. Сыртыпова

График ажил:

Анатолий В. Андреев

Хэвлэлийн эхийг бэлтгэсэн:

Дамбын Оюун

ISBN 978-99978-773-1-4

## АГУУЛГА

Редакторын өмнөх үг .....	7
Зохиогчийн өмнөх үг .....	9

## БҮЛЭГ I.

<b>ЗАНАБАЗАРЫН БҮТЭЭСЭН МОНГОЛ ЗАГВАРЫН БУРХАДЫН ДҮР ДҮРСЛЭЛ:</b>	
<b>ЭХ СУРВАЛЖ БА УТГА СОЁЛ</b> .....	13
Эсгий хивсний чимэглэл бурханы хөрөг бүтээх эх сурвалж болох нь .....	15
Эсгий дэвсгэрийн хаваас .....	17
Монгол хээ угалзын үндсэн махбод .....	18
Юань улсын үеийн эргүүлгэн хээн суурин дээр бүтээсэн бурхадын хөрөг (1271-1368) .	20
Хадны зураг бурхан бүтээх урлалын эх сурвалж болох нь .....	25
Тамга тэмдэг бурхан урлалын эх сурвалж болох нь .....	27
Буган чулуу болон буга, бурханы хөрөг урлалын нэг эх сурвалж болох нь .....	29
Эрхий тэмдэг монгол чимэглэлийн суурь болох нь .....	31
Байгаль болон урлаг дахь эргүүлгийн гомьёо .....	33
Занабазарын урлаг дахь алтан огтлол .....	35
Эргүүлэг нүүдэлчдийн амьдралын хэм хэмжээ болох нь .....	36
Монголын өвс ургамал бурханы хөрөг урлалын сурвалж болох нь .....	37
Монголын байгаль - Занабазарын гол багш бөгөөд уран бүтээлийн эх суурь болох нь .....	39

## БҮЛЭГ II.

<b>ӨНДӨР ГЭГЭЭН ЗАНАБАЗАРЫН УР ЗАГВАР БА НҮҮДЭЛЧДИЙН ГОО ЗҮЙ</b> .....	61
Монгол уран загвар хийцийн тухай ойлголт .....	61
Угсаатны шинж чанарыг агуулсан антропологийн харьцаа .....	69
Хувцас, үсний засалт ба гоёл чимэглэлийн онцлог .....	75

## БҮЛЭГ III.

<b>МОНГОЛЫН УРАН ЗУРАГ (XVII зууны сүүл - XVIII зууны эхэн үе)</b> .....	90
------------------------------------------------------------------------------	----

## CONTENT

Editor's Preface .....	7
Author's Preface .....	9

## CHAPTER I.

<b>ORNAMENTATION USED IN REPRESENTATIONS OF BUDDHIST DEITIES BY ZANABAZAR: THE SOURCES AND SEMANTICS</b> ...	13
Symbols found on felt carpets as an iconographic source in Mongolian Buddhist art .....	15
Felt carpet stitching .....	17
The main elements of the Mongolian Ornament .....	18
Buddhas on a background of Spirals in the Yuan Era (1271-1368) .....	20
Petroglyphs as the Iconographic Source .....	25
Tamgas (Eng: seal or stamp) as an Iconographic Source .....	27
Deer Stones and Deer Horns as an Iconographic Source .....	29
Erhiy as the basis of the Mongolian Ornament .....	31
Spiral in Nature and Art .....	33
Golden Spiral in the Art of Zanabazar .....	35
Spiral – Lifeline of a Nomad .....	36
Flora of Mongolia as an Iconographic Source .....	37
Mongolian Nature - the main Teacher and Model for Zanabazar .....	39

## CHAPTER II.

<b>ZANABAZAR'S STYLE OF BUDDHIST ART AND HIS USE OF NOMADIC AESTHETICS</b> .....	61
The concept of a Mongolian style of Buddhist art .....	61
Anthropological proportions as an expression of an ethno type .....	69
Features of attire, hairstyles and ornaments .....	75

## CHAPTER III.

<b>MONGOLIAN BUDDHIST PAINTINGS (the end of 17<sup>th</sup> - early 18<sup>th</sup> century)</b> .....	90
------------------------------------------------------------------------------------------------------------	----



ӨНДӨР ГЭГЭЭН ЗАНАБАЗАРЫН ЗАГВАР ХИЙЦ

КАТАЛОГ

ЛАМ, БАГШ НАР	106
1. Уран баримал. Бадамжунай	112
2. Уран баримал. Богд Зонхов	117
3. Уран баримал. Гэлүгба лам	121
4. Хөрөг. Занабазарын идэр насны өөрийн хөрөг	127
ТАВАН ЯЗГУУРЫН БУРХАД	132
5. Уран баримал. Очирдарь юмын хамт	137
6. Уран баримал. Очирдарь	147
7. Уран баримал. Минтүг бурхан	151
8. Уран баримал. Минтүг бурхан (том)	156
9. Уран баримал. Аюуш бурхан	161
10. Хөрөг. Аюушийн хувилгаан бие	169
ШАГЖАМҮН БУРХАН БАГШ	176
11. Хөрөг. Намжил суварга	184
12. Хөрөг. Шагжамүн бурхан ба Найман их суварга	190
13. Хөрөг. Шагжамүн ба Оточ бурхад	194
14. Хөрөг. Шагжамүн Будда хоёр шавь нарынхаа хамт	201
ЯДАМ БУРХАД, МАНДАЛ	205
15. Хөрөг. Дүйнхорын мандал	210
16. Хөрөг. Хар Ямандагийн мандал	216
17. Хөрөг. Жанрайсэгийн мандал	223
18. Хөрөг. Дамдин яв-юм	227
19. Хөрөг. Хаянхярваа / Дамдин	232
20. Хөрөг. Доржпагмын мандал	235
БОДИСАД НАР	242
21. Уран баримал. Майдар бурхан	249
22. Уран баримал. 4 мутартай Жанрайсэг	254
23. Хөрөг. 11 нигур, 1000 мутартай Арьяабал	260
24. Хөрөг. Арьяабала Балмо гэлэнмаагийн заншлын (торгон)	269
25. Хөрөг. Манзушир	273
26. Уран баримал. Манзушир	281
27. Уран баримал. Ногоон дарь эх	287
28. Уран баримал. Ногоон дарь эх	290
29. Хөрөг. Цагаан дарь эх	295
30. Хөрөг. Банзрагч	303
31. Уран баримал. Сосорбарам	307
32. Хөрөг. Гургули	314
САХИУСУУД	318
33. Хөрөг. Гонгор	321
34. Хөрөг. Намсрай ба найман морьтон	323
35. Уран баримал. Морьтой найман Намсрай	327
36. Хөрөг. Говийнлха	331
БУСАД	338
37. Хөрөг. Банчен эрдэнэ Гумбум хийдэд заларсан нь	341
38. Торгон пайз. V Далай ламын гэрээ бичиг (1617-1682)	348
39. Хонхтой очир	351
40. Өндөр гэгээн Занабазарын намтар. Хуучин монгол гар бичмэл	357
ЛАВЛАХ ТОЛЬ	361
НОМ ЗҮҮГ	367

CATALOGUE

LAMAS	106
1. Sculpture. Padmasambhava	112
2. Sculpture. Tsonkapa	117
3. Sculpture. Gelukpa Lama	121
4. Thangka. Zanabazar in his youth	127
TATHAGATA BUDDHAS (Pancakula)	132
5. Sculpture. Vajradhara Yab-Yum	137
6. Sculpture. Vajradhara	137
7. Sculpture. Buddha Akshobhya	147
8. Sculpture. Buddha Akshobhya	151
9. Sculpture. Buddha Amitayus	156
10. Thangka. Amitayus Nirmanakaya	161
BUDDHA SHAKYAMUNI	169
11. Thangka. Stupa of Perfect Victory	176
12. Thangka. Shakyamuni Buddha and the Eight Great Stupas of Tathagata	184
13. Thangka. Shakyamuni Buddha with Buddhas of Medicine	190
14. Thangka. Buddha Shakyamuni with two disciples	194
YIDAMS, MANDALAS	201
15. Thangka. Kalachakra Mandala	205
16. Thangka. Maṇḍala Deities Black Yamari	210
17. Thangka. Maṇḍala of Avalokiteshvara	216
18. Thangka. Hayagriva Yab-Yum	223
19. Thangka. Hayagriva	227
20. Thangka. Vajravarahi mandala	232
BODHISATTVAS	235
21. Sculpture. Bodhisattva Maitreya	242
22. Sculpture. Avalokiteshvara Caturbhuja	249
23. Thangka. Eleven-faced Thousand-armed Avalokiteshvara	254
24. Thangka. Eleven-faced Avalokiteshvara by bhikshuni Laksmi (silk)	260
25. Thangka. Manjushri	269
26. Sculpture. Manjushri	273
27. Sculpture. The Green Tara	281
28. Sculpture. The Green Tara	287
29. Thangka. White Tara	290
30. Thangka. Pancharaksha	295
31. Sculpture. Vajrapanjara Pratisara	303
32. Thangka. Kurukulla	307
GUARDIANS	314
33. Thangka. Gongor	318
34. Thangka. Nine deities of the Great Yellow Vaishravana	321
35. Sculpture. Kubera on horseback	327
36. Thangka. Gobilha	331
OTHERS	338
37. Thangka. Arrival of Panchen-Lama to the Kumbum Monastery	341
38. Thangka. Letter of mandate from the Fifth Dalai-Lama (1617-1682)	348
39. Bell with vajra	351
40. Zanabazar's biography (hagiography).	357

## 2021 оны төслийн үйл ажиллагааны тайлан

Орос Монголын хамтарсан төслийн 2021 оны санхүүжилт дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас тодорхой хугацаанд тасалдаж, 2022 оны 5-р сард орж ирсэн тул тайлант хугацааг 2022 оны 1-12-р сараар тогтов. Тайлант хугацаанд Монгол Улсын талаас төслийн удирдагчаар Г.Мягмарсүрэн, төслийн гүйцэтгэгчээр Д.Наранцэцэг, Ц.Гүнчин-Иш нар үргэлжлүүлэн ажиллав. 2019-2021 оны нийт 3 жилийн хугацаанд төслийн хүрээнд гүйцэтгэсэн эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалтыг хавсралтаар /Хавсралт-3/ үзүүлэв.

Өмнөх хоёр жилд ковидын улмаас төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж чадаагүй байсан томилолтоор ажиллаж, материал цуглуулах, цуглуулсан эх хэрэглэгдэхүүндээ тулгуурлан эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл бичиж нийтлүүлэхэд голлон анхаарч ажиллав. Тайлант хугацаанд гадаад, дотоодод томилолт, хээрийн шинжилгээний ангиар явж ажилласан тайланг Томилолтоор ажилласан байдал гэх хэсэгт тодорхой тайлагнав.

### *Төслийн үр дүнг сурталчлав*


Төслийн үр дүнг сурталчлах ажлыг цаг тухай бүрд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болох Монголын үндэсний телевиз, Жавзандамба хутагт төвийн зочинтой ярилцах цаг булан, Дашчойлин хийдийн болон Бурхны шашин соёл судлалын хүрээлэнгийн албан ёсны цахим хуудсаар мэдээлж, таниулга хийж ирэв. Мөн өөрсдийн гадаад, дотоодод хэлэлцүүлсэн илтгэлийн үеэр төслийн үр дүнгээс танилцуулж байв. Төслийн үр дүнг сурталчилсан талаарх мэдээллийг дараах хаягаас үзэж болно.

1. MNBC телевизийн 2019 оны 10 сарын 4-ний өдрийн Цагийн хүрд хөтөлбөрийн мэдээ
2. Монголын философийн холбооны албан ёсны цахим хуудас <http://mongolianphilosophy.org/97.html?fbclid=IwAR0VyCwMsNBep8-itA6nq5bpf6j8DMLIQFuVPnUfkOTVry8oDGYxn2OSak>
3. Жавзандамба хутагт төвийн 2019.10.20-ий өдрийн Зочинтой ярилцах цаг шууд нэвтрүүлэг. /[www.Buddha.mn/videos/502936740547671](http://www.Buddha.mn/videos/502936740547671)

### Занабазарын уран бүтээлтэй холбоотой объектуудын мэдээллийн сан бүрдүүлэв.

Өөрсдийн болон өмнөх судлаачдын хийсэн судалгаанд тулгуурлан Орос, Монгол дахь музей, олон нийт, хувийн цуглуулгад хадгалагдаж байгаа Өндөр гэгээн Занабазарын уран бүтээлийн өвийг тодорхойлж, бүртгэх, мэдээллийн сангийн суурь бааз бүрдүүлэхэд шаардлагатай текстүүдийг бэлтгэж, түүнийгээ орос монгол хэл хос хэлээр гаргахын тулд өөрсдийн бэлтгэсэн 10хх /бичгийн цаасны 162 нүүр хуудас/ бичвэрийг түүхч, орчуулагч Чулуунжавын Баасанжаргалтай гэрээ байгуулан цалинжуулж орчуулуулж аваад байна. Төслийн гэрээнд тусгагдсан цахим сан бүрдүүлэхэд шаардлагатай эх материалуудыг бэлэн болсон боловч, төслийн санхүүжүүлэлт танагдаж ирсний улмаас цахим сан байгуулах ажлыг хийх боломж гарсангүй. /Хавсралт-4/

Гэвч ОХУ-ын талын төсөл хэрэгжүүлэгчид энэхүү дата сан байгуулах ажлыг хийсэн нь дараах байдалтай байна. Уг мэдээллийн цахим санг Оросын талын төсөл санхүүжүүлэгч, хүлээн авагч байгууллагын зөвшөөрөл гарсны дараа олон нийтэд ашиглуулж болохоор гэрээнд заагдсан байна.



Главное меню\_2 Экспонаты

## Сокровищница Дзанабазара

Инвентарный номер №:  Имя:

Наименование:

Материал:

Тип произведения:  Статус:  Запись №:

Техника:

Размеры:

Датировка:

Местонахождение:

Мастер:



Классификатор:  Поиск Изображение

@ Сыртышова С.Х.Д. @ Андреев А.В.

Список экспонатов Список названий Выход в главное меню Найти запись Сохранить запись

История культуры История предмета Описание Аналоги Примечания Литература

Добавить запись

Таблицы	
Switchboard Items	
Аналоги в других коллекциях	
Аналоги в других коллекциях_eng	
Аналоги в других коллекциях_mng	
Интересные особенности примечания	
Интересные особенности примечания_eng	
Интересные особенности примечания_mng	
История предмета	
История предмета_eng	
История предмета_mng	
Литература, источники	
Литература, источники_eng	
Литература, источники_mng	
Описание предмета	
Описание предмета_eng	
Описание предмета_mng	
Статусы	
Тема	
Тема_eng	
Тема_mng	
Фото	
Экспонаты	

## ТОМИЛОЛТООР АЖИЛЛАСАН БАЙДАЛ

Төслийн гүйцэтгэгчид тайлант хугацаанд ОХУ-ын Москва, Ленинград хотод 1 удаа, ОХУ-ын Буриад улсад 1 удаа, БНХАУ-ын ӨМӨЗО-ы Шинэхээн буриадад 1 удаа, Монгол Улсын Өвөрхангай аймгийн Хархорин суманд 4 удаа тус тус төслийн томилолтын зардлаар, Монгол Улсын Дорноговь аймагт 1 удаа өөрсдийн хувийн зардлаар явж судалгаа, ажиглалт хийжээ.

### *Дотоод томилолт*

Төслийн удирдагч Г. Мягмарсүрэн, төслийн багийн гишүүн Д. Наранцэцэг нар тайлант хугацаанд Оросын талын төслийн удирдагч, ОХУ-ын Москвагийн Дорно дахин судлалын хүрээлэнгийн эрдэмтэн, шинжлэх ухааны доктор, профессор Сыртыповатай хамт

2019 оны 10-р сарын 5-нд Монгол Улсын Өвөрхангай аймгийн нутагт орших Төвхөн хийдэд очиж, хийдийн лам хуврагуудтай уулзан, Дашчойлин хийдийн лам нар, Өндөр гэгээний уран бүтээлийг цуглуулагч нарын хамтаар 10-р сарын 6-ны өдөр Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын Төвхөн хийдэд Соёмбо үсэгт зориулсан гэрэлт хөшөө-тааллын шүтээнийг залах нээлтийн үйл ажиллагаанд оролцов. Энэхүү үйл ажиллагааны зардлыг Дашчойлин хийдээс гаргасан болно.

Эрдэнэ зуу хийд, Өндөр гэгээний өвгөн хийд хэмээгддэг Шанх баруун хүрээ хийдэд өөрсдийн зардлаар явж, сүм хийдэд хадгалагдаж байгаа урлагийн бүтээл болон хувь хүмүүсийн аман хууч зэрэг төсөлд холбогдох мэдээ баримт цуглуулж, зарим байгууллагатай гэрээ байгуулан гэрэл зургуудийг авахаар тогтов. Гэрээ байгуулахын тулд Монгол Улсын Соёлын Яамны зөвшөөрлийг авсан байх шаардлагатай байсан тул бид албаны зохих хүмүүст өөрсдийн хүсэлт өргөдлийг өгч, судлуулан шийдүүлж авсан болно.

2021 оны 8 сар, 2022 оны 4.30-5.2-нд төслийн гүйцэтгэгч Ц.Гүнчин-Иш, Д.Наранцэцэг нар Оросын талын төслийн удирдагч С.Д.Сыртыповагийн хамтаар, 2022.05.26-нд Г.Мягмарсүрэн, Д.Наранцэцэг дахин Эрдэнэзуу хийдэд очиж, Соёлын Яамнаас олгосон тусгай зөвшөөрлийн дагуу төслийн ажилд шаардлагатай Өндөр гэгээний өөрийн мутрын бүтээлүүд болон холбогдох бусад бүтээлийг үзэж, гэрэл зургаар баталгаажуулж авав.

**ХААН БАНК** Огноо/Date: 2021-08-10 09:26:26

Шилжүүлгийн мэдээлэл / Transaction information  
Журналын / Journal No: 2986681

Системийн огноо/System Date: 2021/08/10

Дт	Дансны/Картын дугаар Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5031363858	ХАТАГТАЙ ДАМБИЙХОРЛОО НАРАНЦЭЦЭГ	250,000.00 MNT	1.00
Кт	Банкны дугаар/Branch No	Банкны нэр/Bank Name	250,000.00 MNT	1.00
	900000	Төрийн Сан		
	Дансны/Картын дугаар Account/Card Number	Нэр/Name		
	100101835403	Өв. ХАЯХОР ЭРДЭНЭЗҮУ МУЗЕЙ Н.С		

Гүйлгээний утга/Transaction description:  
ЗУРАГ АВАХ НИЙТЛҮҮЛЭХ ЭРХ АВАХ СЫРТЫПОВА

**ХААН БАНК**  
05037/01

Ардлагч танд баярлалаа./ Thank you to our customers

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:

Салбар, тооцооны төв/Branch, sub-branch:

Гарын үсэг/Signature:

Тамга/Stamp:

Санамж: Таны гүйлгээний дүн 3 сая ба түүнээс доош дүнтэй тохиолдолд шууд тухайн дансанд шилжин орно. Ажлын өдөр 16:00 цагаас хойш мөн амралтын өдөр хийгдсэн 3 сая төгрөгөөс дээш дүнтэй гүйлгээ дараагийн ажлын өдөр хийгдэнэ. КИОСК машинаас хэвлэсэн энэхүү баримт нь зөвхөн таны гүйлгээний мэдээллийг хүлээн авсан тухай бөгөөд, гүйлгээ бүрэн амжилттай хийгдсэн тохиолдолд таны банканд бүртгэлтэй и-мэйл хаягт баталгаажуулсан баримт хүргэгдэнэ.


2022 оны 5 болон 8 дугаар сард Оросын талын төслийн удирдагч С.Д.Сыртыпова, Монголын талаас Д.Наранцэцэг нар Гандантэгчэнлин хийд 3 удаа, Өвөрхангай аймгийн Шанхын баруун хүрээнд 2 удаа, Дорноговь аймгийн Хамарын хийдэд 1 удаа, Өвөрхангай аймгийн соёлын өв хадгалагч, цуглуулагчидтай хэд хэдэн удаа уулзаж, мэдээ сурвалжлага, тодруулга авсан болно.











sa gye  
sapa  
pa sa  
sapa  
sa samo  
lun

Энэхүү үзэж цуглуулсан баримт мэдээлэлд дүн шинжилгээ хийж, өмнөх судалгааны ажил, эх хэрэглэгдэхүүндээ үндэслэж эрдэм шинжилгээний илтгэл хэлэлцүүлж, өгүүлэл бичээд байна. Тухайлбал төслийн удирдагч Г.Мягмарсүрэн, С.Д.Сыртыпова нар хамтран ОХУ-ын Дорно дахин судлалын хүрээлэнгээс 2022.06.30-нд зохион байгуулж буй олон улсын эрдэм шинжилгээний хуралд судалгааны илтгэл бичиж, хэлэлцүүлэв. Энэ илтгэл нь Эрдэнэзуу хийдэд хадгалагдаж буй Өндөр гэгээний өмнөх 16 дүрүүдийн цаасан шуумал бурхдын тухай юм. Зохиогчид энэ тухай бичихдээ хэдийгээр одоо Эрдэнэзуу хийдэд буй эдгээр шуумал бурхад нь 1965 онд бүтээгдсэн сүүл үеийн бүтээл боловч энэ нь шинэ үеийн бүтээл биш, харин өмнө байсан бүтээлийг сэргээх аргаар хийсэн болохыг баримтаар тогтоосон байна.


Мөн энэхүү Эрдэнэзуу хийдэд хадгалагдаж буй Өндөр гэгээний өөрийн мутраар урласан ловон Бадамжунай бурхны онцлогийг гаргасан "Монголд буй Өндөр гэгээний загвар хийцийн ловон Бадамжунай бурхны тухай" өгүүллийг доктор Д.Наранцэцэг, С.Д.Сыртыпова нар бичиж Монголын Төвөд судлал сэтгүүлд хэвлүүлэв. Тус өгүүлэлд буддын шашны улааны урсгал чиглэлийг үндэслэгч хэмээгдэх ловон Бадамжунайг монголчууд өргөнөөр шүтдэг, энэ бурхныг хэд хэдэн янзаар бүтээсэн болохыг дурдаад Монголд буй ловон Бадамжунай бурхны анхны хөргийг Өндөр гэгээн Занабазар бүтээж, бусад хөрөг нь түүнээс эх загвар авч бүтээгдсэн маягтай байгааг Эрдэнэзуу хийдэд хадгалагдаж байгаа ловон Бадамжунай бурхныг цуглуулагч А.Алтангэрэлийн болон бусад хүмүүст буй хөргүүдтэй харьцуулан шинжилж, Өндөр гэгээний уран бүтээлийн өвөрмөц онцлогийг өгүүлсэн байна.


#### *Гадаад томилолт*

2020-2021 онд дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас бидний томилолтоор ажиллахаар төвөлсөн улс орнуудын хил хаалттай байсан тул төлөвлөгөөний дагуу цаг хугацаанд нь гүйцэтгэж чадаагүй байсан гадаад томилолтоор ажиллаж, материал цуглуулах, цуглуулсан эх хэрэглэгдэхүүндээ тулгуурлан эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл бичиж нийтлүүлэх ажлыг 2022 онд нөхөж хийлээ. Тухайлбал, 2022 оны 01 сарын 16-29-нд төслийн удирдагч Г.Мягмарсүрэн, төслийн багийн гишүүн Д. Наранцэцэг нар ОХУ-ын Москвагийн Дорно дахин судлалын хүрээлэн, Санктпетербург хотын Шашин, угсаатан судлалын музейд томилолтоор ажиллаж төсөлд холбогдох мэдээ баримт цуглуулж, давуу эрхтэйгээр Өндөр гэгээний тиг хийцийн гэж үзэж болох бурхдыг гараар барьж үзэж, шаардлагатай гэрэл зургуудийг авч, бүртгэл жагсаалтад оруулав.
















ОХУ-ын Буриад Улсад доктор Г.Мягмарсүрэн, Д.Наранцэцэг нар 2022.06.29-07.02-нд томилолтоор ажиллаж, Буриад Улсын Үндэсний музей, Улаан-Үд хот дахь Базар Барадины нэрэмжит Номын сангийн гар бичмэлийн архиваас эх сурвалжийн баримт хайх, Олон улсын эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавих зэрэг ажлуудыг хийв.





Төслийн санхүүжилт өгөхөөс өмнө доктор Г.Мягмарсүрэн, Д.Наранцэцэг нар БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хайлаар хот дахь Хөлөнбуйр дээд сургуульд багшилж байх хугацаандаа өөрсдийн зардлаар Хөлөнбуйрын угсаатны музей, зарим сүм хийдүүд болон ахмад настнууд, эрдэмтэн судлаачидтай уулзаж Өндөр гэгээний загвар хийцийн уран бүтээлийг тодруулах оролдлого хийсэн боловч бидний зорилтот хүрээний мэдээлэл олдоогүйг тэмдэглэе.

Харин бид Хөлөнбуйр дээд сургуулийн Үндэстний түүх сурвалж бичиг судлах хүрээлэнгийн хүсэлтээр өөрсдийн судалгааны байдлаас танилцуулахдаа төслийн үр дүнг сурталчлах, таниулах ажлыг хийж байв.



## ДУГНЭЛТ

Халхын бурхны шашны тэргүүн, анхдугаар богд Жавзандамба хутагт Өндөр гэгээн Занабазар (1635-1723) бол Монгол оронд бурхны шашныг дэлгэрүүлж, хөгжүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулсан нөлөө бүхий шашны зүтгэлтэн, их соён гэгээрүүлэгч агаад түүхэн цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан улс төр, нийгмийн харилцаанд ч идэвхтэй оролцож зохих үүрэг гүйцэтгэж байжээ. Түүний зэрэгцээ Монголд бурханы шашны олон сүм хийд байгуулж, бурхан шүтээн урлах ажилд ихээхэн зүтгэл гаргасан уран бүтээлч бөгөөд түүний бүтээсэн бурхан шүтээнүүд нь ур хийц онцгой ялгарам гайхамшигтай сайхан тул бурхны шашны урлагт жинтэй байр суурь эзэлдэг юм.

Өндөр гэгээн Занабазарын үүтгэн хөгжүүлсэн буддын урлагийн ховор нандин бүтээлүүд Монгол Улс болон ОХУ-ын музей, сүм хийд, хувь хүмүүсийн тахил шүтээн, хувийн цуглуулга зэрэгт янз бүрийн хэлбэрээр хадгалагдан иржээ.

Хорьдугаар зууны эхний хагаст Орос Монголд буддын шашны сүм хийд, лам хуврагийг олноор хомрогolon хэлмэгдүүлэх арга хэмжээ явуулсны улмаас бурхны шашны урлагийн бүтээлүүдийг ч устгаж, хаана, хэний гарт, ямар бүтээл, хэдий үед очсон нь ч тодорхойгүй болсон байв.

Өндөр гэгээний урласан хосгүй үнэт өвийг ШУА-ийн хүрээлэн, их, дээд сургуулийн мэргэжлийн судлаачид бүртгэх, цуглуулах, улмаар улсын хамгаалалтад авч музейн сан хөмрөгт хадгалах, дэлгэн сурталчлах үйл ажиллагаа Монгол улсад өнгөрсөн зууны дунд үеэс эрчимтэй эхэлсэн билээ. Тийн боловч өнөө хэр нь эрдэм шинжилгээний эргэлтэнд ороогүй, эх материал нь хадгалалтын буруугаас болж дахин сэргэхээргүй болсон зэрэг шалтгааны улмаас үрэгдэж, олон нийтэд төдийлөн мэдэгдээгүй дурсгалууд ч байна. Түүгээр ч зогсохгүй улсын томоохон музейн сан хөмрөгт хадгалагдаж байгаа дурсгалууд ч андуу ташаа тайлбартай байгаа нь энэ талын судалгаа бүрэн бус болохыг харуулж байна.

1990 оноос Монгол оронд өрнөсөн ардчилал шинэчлэлийн үрээр шашин шүтэх эс шүтэх эрх нээлттэй болж, энэ нь буддын урлагийн шинжээч, сонирхогчид, цуглуулагчдад ч таатай орчин нөхцөлийг бүрдүүлж өгсөн юм. Тэдний олонх нь өөрсдийн хувийн цуглуулгын каталогийг нийтэд дэлгэн, нийтлүүлж эхлэв. Үүнээс судлаачид хаана хэний цуглуулгад ямар урлаг соёлын өв хадгалагдаж байгааг мэдэх боломж нээгдсэн юм. Мөн

олон тооны бурханы шашны сүм хийд сэргээн байгуулснаар сүсэгтэн ардууд цөөнгүй урлагийн бүтээлийг тэдгээр сүм хийдэд буцаж өргөсөн бөгөөд зарим нь янз бүрийн орны хувь хүмүүсийн цуглуулга, галерей, музей зэргээс ч олдож эхэлж байна. Гаднын улс орнуудын музейд тухайлбал БНУУ-ын Хопп Ференцийн Азийн урлагийн музейд Өндөр гэгээний хийцийн зургаан бурхан байна хэмээн судлаачид мэдээлж байна. Гэвч хилийн чанадад хувь хүний цуглуулгад буй Өндөр гэгээний тиг хийцийн хичнээн тооны дурсгал байгааг нэгбүрчлэн бүртгэн гаргах боломжгүй болжээ.

Өндөр гэгээний урласан урьд өмнийн судалгаанд илрээгүй цөөнгүй тооны бүтээлийг хэдэн арван сая доллараар үнэлэн дэлхийн томоохон дуудлага худалдаанд оруулж байна. Түүний урласан бүтээлийн хуулбар, хувилбарыг хар зах дээр ч худалдаалж байна.

Ийм зах зээлийн өрсөлдөөнт нөхцөлд бид юун түрүүн түүхийн болон бусад шалтгаан, хүчин зүйлийн улмаас өөрийн улсын болон хөрш ОХУ-ын музей, хийдүүдийн сан хөмрөг, хувь хүмүүсийн гарт хадгалагдах болсон Өндөр гэгээний тиг хийцийн бурхад, урлагийн хосгүй үнэт өвийг бүртгэн тогтоож, үндэслэлтэй үнэн зөв тодорхой тайлбартайгаар нэгтгэн бүртгэж авах ажлыг эхлүүлсэн билээ.

Ингээд "Өндөр гэгээний тиг хийцийн урлаг соёлын өвийг судлах, Монгол Оросын музей, олон нийтийн болон хувь хүмүүсийн гар дээрх цуглуулгын мэдээллийн сан бүрдүүлэх, бүртгэх аргачлал боловсруулах нь" Орос Монголын хамтарсан төслийн ажлыг 2019-2022 оны хугацаанд гүйцэтгэсний үндсэн дээр бид дараах дүгнэлтэд хүрэв.

Өндөр гэгээний өөрийн мутрын урлал Монгол Улсад Богд хааны ордон музей, Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей болон цөөн тооны цуглуулагчийн гарт төвлөрч байна.

Бид үүнээс Өндөр гэгээн Занабазарын өөрийн мутраар болон, түүний тиг загвараар бүтээж, өнөө үед уламжлан ирсэн 81 бүтээлийн бүртгэл, объектын тайлбар, эх сурвалж, судалгааны мэдээллийн сан байгуулахад шаардагдах эх материалуудыг бэлтгэх ажлыг хийв. Ингэж Монгол, Оросын музейн цуглуулга, сүм хийд, гэр бүлийн тахил шүтээн, хувь хүмүүсийн цуглуулгад байгаа Занабазарын уран бүтээлийн өвийг судлан, нэгтгэн дүгнэх нь уран бүтээлчийн талаарх цогц судалгаа, хувь хүний онцлог шинж чанар, дэлхийн хэмжээний урлаг, уран сайхны хөгжилд гүйцэтгэх үүрэг ролийг тодорхойлоход тодорхой хувь нэмрээ оруулна хэмээн үзэж байна.

## ТАЛАРХАЛ

"Өндөр гэгээний тиг хийцийн урлаг соёлын өвийг судлах, Монгол Оросын музей, олон нийтийн болон хувь хүмүүсийн гар дээрх цуглуулгын мэдээллийн сан бүрдүүлэх, бүртгэх аргачлал боловсруулах нь" Оростой хамтарсан төслийг санхүүжүүлж, судалгаа хийх нөхцөлийг бүрдүүлж өгсөн Монгол Улсын Боловсрол, Шинжлэх Ухааны Яам, Шинжлэх ухаан технологийн сангийн удирдлага, шаардлагатай тохиолдолд зөвлөгөө заавар өгч төслийн ажилд туслалцаа үзүүлсэн Төслийн мэргэжилтэн С.Солонго, нягтлан бодогч нарт төслийн баг хамт олон гүнээ талархаж байна.

Та бүхний дэмжин санхүүжүүлж, төсөл хэрэгжүүлсний үрээр цаашид Өндөр гэгээн судлалын ажлууд улам даацтай болж, нарийвчлан тодорхойлох сэдвүүд олон болж байгаа бөгөөд сонирхон судлаач, эрдэмтэд ч өсөн нэмэгдэж байгаад туйлын их баяртай байна. Төслийн үр дүнд ШУА-ийн холбогдох хүрээлэнгүүд, их дээд сургуулийн дэргэдэх судалгааны төвүүд, Өндөр гэгээн судлалд холбоотой орон нутгийн төрийн бус байгууллагыг ч хамруулж Өндөр гэгээн Занабазарын үсгийн урлал, уран бүтээлийн дурсгал, хосгүй үнэт соёлын өвүүдийн талаар ихэд анхаарч, төсөл хэрэгжүүлж, судлагааны ажлын хамрах хүрээг тэлж байгаа нь хожмоо үр дүнтэй, сайн сайн судалгааны бүтээл туурвих хөрсийг сайтар бэлтгэж өгч байна гэж үзэж байна.



Хавсралт 1. Эрдмийн зөвлөлийн тогтоол, хурлын протокол



БУРХАНЫ ШАШИН СОЁЛ СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН  
RESEARCH INSTITUTE FOR BUDDHISM & CULTURE

2023 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

ТӨСЛИЙН ҮР ДҮНГ ХҮЛЭЭН АВАХ ТУХАЙ

Шинжлэх ухааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.2 дох заалт, 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалтын тус тус үндэслэн ТОГТООХ нь

1. Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яам болон Оросын Холбооны Улсын Оросын суурь судалгааны сан хооронд байгуулсан санамж бичгийн дагуу тус хүрээлэнд 2019 оноос хэрэгжиж буй "Занабазарын урлагийн бүтээлийн өв дурсгалыг судлах, Монгол, Оросын музей, олон нийтийн болон хувь хүмүүсийн цуглуулгын мэдээллийн сан бүрдүүлэх, бүртгэх, аргачлал боловсруулах" сэдэвт хамтарсан төслийн үр дүнг хүлээн авсугай.
2. Төслийн үр дүнгээр хэвлэгдсэн бүтээл, төслийн тайлан, холбогдох бичиг баримтыг Шинжлэх ухаан технологийн санд хүлээлгэн өгөхийг төслийн удирдагч Г.Мягмарсүрэнд даалгасугай.

ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Ч.ДАМБАЖАВ

БУРХНЫ ШАШИН СОЁЛ СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭНГИЙН

## ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

№ 01

2023 оны 01 дугаар сарын 31

**Хурал:** "Зүүн Хүрээ" Дашчойлин хийдийн тэргүүн хамба лам Ч.Дамбажавын албан өрөөнд 11:00-12:00 цагт болов.

**Хуралд:** Эрдмийн зөвлөлийн дарга, доктор (Ph.D), профессор Ч.Дамбажав, Эрдмийн зөвлөлийн нарийн бичгийн дарга, доктор (Ph.D) Г.Мягмарсүрэн, эрдмийн зөвлөлийн гишүүн, академич Д.Цэрэнсодном, доктор (Sc.D), профессор Л.Тэрбиш, доктор (Ph.D), дэд профессор М.Батаа, докторант И.Ядамсүрэн, докторант С.Дэмбэрэл, магистр Б.Наранбат, магистр Ц.Алтанхүү нар оролцов.

**Хэлэлцэх асуудал:** Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яам болон Оросын Холбооны Улсын Оросын суурь судалгааны сан хооронд байгуулсан санамж бичгийн дагуу тус хүрээлэнд 2019 оноос хэрэгжиж буй "Занабазарын урлагийн бүтээлийн өв дурсгалыг судлах, Монгол, Оросын музей, олон нийтийн болон хувь хүмүүсийн цуглуулгын мэдээллийн сан бүрдүүлэх, бүртгэх, аргачлал боловсруулах" сэдэвт хамтарсан төслийн үр дүнгийн тухай

**Хэлэлцсэн нь:**

Хурлыг эрдмийн зөвлөлийн дарга Ч.Дамбажав удирдав.

**доктор (Ph.D), профессор Ч.Дамбажав:** Өнөөдөр манай хийдийн дэргэдэх хүрээлэнд хэрэгжүүлсэн Орос, Монголын төслийн үр дүнгийн талаар хэлэлцэнэ. Төслийн удирдагч Г.Мягмарсүрэн ажлаа танилцуулаарай.

**доктор (Ph.D) Г.Мягмарсүрэн:**

Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. Монгол Улсын БСШУСЯам, ОХУ-ын Оросын суурь судалгааны сангийн захиалгаар хэрэгжүүлсэн "Өндөр гэгээний тиг хийцийн урлаг соёлын өвийг судлах, Монгол Оросын музей, олон нийтийн болон хувь хүмүүсийн гар дээрх цуглуулгын мэдээллийн сан бүрдүүлэх, бүртгэх аргачлал боловсруулах нь" хамтарсан төслийн үр дүнгийн талаар товч танилцуулья.

Өндөр гэгээн Занабазарын өөрийн болон түүний урлах арга барилын дагуу бүтээсэн урлагийн ховор нандин бүтээлүүд Монгол Улс болон ОХУ-ын музей, сүм хийд, хувь хүмүүсийн цуглуулга зэрэгт хадгалагдан иржээ.

Хорьдугаар зууны эхний хагаст Орос, Монголд Бурхны шашны сүм хийд, лам хуврагийг олноор хомрогolon устгах их гамшиг тохиосны улмаас Бурхны шашны урлагийн маш олон бүтээл устжээ. Тэдгээрээс цөөхөн тоогоор үлдсэн нь хаана, хэнд, хэрхэн хадгалагдаж буй талаар өнөөг хүртэл бүрэн тодорхой мэдээлэлгүй байна.

Гандантэгчэнлин хийд 1944 онд хийд "Мөргөлийн дуган" нэртэйгээр дахин сэргэж, социализмын жилүүдэд Засгийн газрын хяналт дор Монгол дахь Бурхны шашны ганц төв болж байсан учир нутаг, нутгийн олон сүсэгтэн олон, нэн ялангуяа үндэсний өв уламжлал, урлаг соёлоо дээдлэгч сайн санаатан нараас Бурхан шашны ном судар, бурхан шүтээн харамгүй өргөж байсны дотор Өндөр гэгээний тиг хийцийн олон бүтээл орсон байдаг.

Шашин ном дахин сэргэсэн 1990-ээд оноос эхлэн орон нутагт олон тооны бурхны шашны сүм хийд сэргээн байгуулагдаж, сүсэгтэн ардууд ном, бурхан, шашны хэрэглэл зэргийг тэдгээр сүм хийдэд өргөх болсон бөгөөд тэдгээрийн дотор хосгүй урлагийн бүтээл багтсан дам яриа бий. Янз бүрийн галерей, музей, хувь хүмүүсийн цуглуулгад Өндөр гэгээний бүтээл хадгалагдаж буй мэдээ бас байна. Өндөр гэгээний урласан урьд өмнө нь судалгаанд дурдаагүй, мэдэгдээгүй цөөнгүй тооны урлагийн бүтээлийг хэдэн арван сая доллараар үнэлэн, дэлхийн томоохон дуудлага худалдаанд оруулж байна. Түүний урласан бүтээлийн хуулбар, хувилбарыг хар зах дээр ч худалдаалж байна гэх зэрэг мөрөг мэдээлэл ч байна. Хувь хүний цуглуулгад буй Өндөр гэгээний тиг хийцийн хичнээн тооны дурсгал байгааг нэгбүрчлэн нарийн бүртгэн бүртгэл өнөө хэр гараагүй байна.

Иймд түүхийн болон бусад шалтгаан, хүчин зүйлийн улмаас өөрийн улсын болон хөрш ОХУ-ын музей, галерей, Бурхны шашны сүм хийдүүдийн сан хөмрөг, хувь хүмүүсийн гарт хадгалагдах болсон Өндөр гэгээний тиг хийцийн бурхад, урлагийн хосгүй үнэт өвийг бүртгэн тогтоож, үндэслэлтэй үнэн зөв тодорхой тайлбартайгаар нэгтгэн бүртгэж авахыг эрмэлзсэн болно.

Төслийн зорилгоо биелүүлэхийн тулд өмнөх судлаачдын хийсэн судалгааны ажлуудтай нэгбүрчлэн танилцах, өөрсдөө холбогдох музей орж, хувь хүмүүстэй уулзаж, бүтээлийн өнөөгийн байдалтай биечлэн танилцах зорилт тавьж ажилласан.

Төслийг гүйцэтгэхдээ төвөд, монгол хэл дээрх түүхэн эх сурвалжийг судлах судалгааны арга зүйд суурилсан бөгөөд холбогдох мэргэжилтнүүдийн судалгаанд түшиглэн, хожим бусад эрдэмтэн судлаачид ашиглаж болохуйц баримт материалыг бэлтгэх чиглэл барив.

Төслийн хүрээнд 2019 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл доор “Өндөр гэгээний үсгийн урлал” эрдэм шинжилгээний хурал 2019 оны 10 сарын 02-ны өдөр зохион байгуулж, хурлын эмхэтгэл хэвлүүлэв. Тус хуралд Оросын талын төслийн удирдагч ОХУ-ын ШУА, Дорно дахины судлалын хүрээлэнгийн тэргүүлэх ажилтан, түүхийн шинжлэх ухааны доктор, (Sc.D), профессор Сурун-Ханда Сиртыпова ирж оролцон, илтгэл хэлэлцүүлэв.

"Өндөр гэгээний үсгийн урлал" эрдэм шинжилгээний хуралд Монгол Улсын Шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн, шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор, зурхайч Л.Тэрбиш, Монголын философийн холбооны ерөнхийлөгч, доктор Д.Гантөмөр, Бурханы шашин соёл судлалын хүрээлэнгийн захирал, доктор Г.Мягмарсүрэн, Монгол судлалын үндэсний академийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор, дэд профессор Д.Наранцэцэг, ШУА, Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Р.Отгонбаатар, Варшавын их сургуулийн Дорно дахины судлалын тэнхимийн багш Р.Бямбаа, МУИС, Философи шашин судлалын тэнхимийн багш С.Дэмбэрэл, "Зүүн Хүрээ" Коллежийн захирал Ц.Мөнх-Эрдэнэ, Богд хааны ордон музейн эрдэм шинжилгээний ажилтан Ц.Гүнчин-Иш, Монгол улсын үндэсний номын сангийн бүртгэл мэдээллийн санч Х.Түмэнбаяр болон ОХУ-ын ШУА, Дорно дахины судлалын хүрээлэнгийн тэргүүлэх ажилтан, түүхийн шинжлэх ухааны доктор, (Sc.D), профессор Сурун-Ханда Сиртыпова, ОХУ-ын ШУА, Дорно дахины судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Андреев А.В нарын зэрэг эрдэм судлаачид оролцож, Өндөр гэгээний үсэг урлал, ялангуяа соёмбо үсгийн талаар олон сонирхолтой илтгэл хэлэлцүүлэв.

Хурлын эмхэтгэлийг 2020 онд Зүүн хүрээ Дашчойлин хийд, Бурхны шашин соёл судлалын хүрээлэнгээс эрхлэн гаргадаг "Шашин соёл судлал" сэтгүүлийн 2 дахь дугаарт хэвлэн гаргав. Тус эмхэтгэлд 11 илтгэгчийн 9 өгүүлэл оров.

Занабазарын тиг хийцийн урлагийн бүтээлийн мэдээллийн сан бүрдүүлэх судалгааны үр дүнгээр эрдэм шинжилгээний өгүүлэл гадаадад 4, дотоодод 3 нийтлэв.

Соёмбо үсэг зохиосны 333 жилийн ой 2019 онд тохиосон тул "Зүүн Хүрээ" Дашчойлин хийд, Бурхны шашин соёл судлалын хүрээлэн, Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей хамтран Өндөр гэгээний зохиосон соёмбо үсэг, холбогдох бусад дурсгал, шинэ туурвисан соёмбо үсгийн уран бүтээлийн "Соёмбо-333" нэрт уран бүтээл, цуглуулгын хамтарсан үзэсгэлэн зохион байгуулж, 2019 оны 10-р сарын 02-03 өдрүүдэд "Зүүн Хүрээ" коллежийн захирал Ц.Мөнх-Эрдэнэ өөрийн бичиж бүтээсэн соёмбо үсгийн олон бүтээл, судлаач, цуглуулагч Р.Отгонбаатар, Р.Бямбаа, Б.Амарсанаа, Ч.Бямбасүрэн нарын нандигнан хадгалж, цуглуулсан соёмбо үсэгтэй холбоотой бичвэр, дармал, хуйлмал хэвлэл, зураг, баримал, сийлмэл зэрэг олон үнэт дурсгал, цуглуулга бүхий үзэсгэлэнг олон нийтэд нээлттэй үзүүлэв.

Өндөр гэгээн Занабазар	Лувсандамбижанцан	(1635-1723),	IV	Богд
Лувсантүвдэнванчигжигмэджамц		(1775-1813),	V	Богд
Лувсанцүлтэмжигмэданбижанцан		(1815-1841),	VII	Богд
Агваанчойживаанчигпэрэнлэйжамц		(1850-1868),	VIII	Богд

Агваанлуvsанчойжинямданзанваанчиг (1869-1924) нарын бүрэн зохиол буюу сүмбүмийг төслийн ажлын хүрээнд Г.Мягмарсүрэн төвөд хэлнээс монгол хэл рүү орчуулан, "Богдуудын бүрэн зохиол" нэрээр 5 боть болгон хэвлүүлэв.

Занабазарын уран бүтээлийн өв болох "Өндөр гэгээн Занабазарын загвар хийц" (А.Алтангэрэлийн цуглуулгын жишээн дээр) хэмээх 374 хуудас бүхий номыг төслийн Оросын талын удирдагч Сүрэнханд Монголын талын гүйцэтгэгч байгууллага Бурхны шашин соёл судлалын хүрээлэнтэй хамтран хэвлүүлэв.

Төслийн Орос талын удирдагч доктор Сыртыпова, Монголын талын төслийн гүйцэтгэгч Д.Наранцэцэг нар Чойжин ламын сүм музей, Ц.Гүнчин-Иш Богд хааны ордон музей, У.Сарантуяа Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейд байгаа Өндөр гэгээний дэг сургуулийн бүтээлүүдийг биечлэн үзэж, бүртгэл мэдээлэл гаргав.

Д.Наранцэцэг, Ц.Гүнчин-Иш нар Өндөр гэгээний хэдэн зүйл төвөд, монгол намтрыг харьцуулж үзсэний үндсэн дээр тухайн үеийн шашин урлагт холбогдох байгууламжын талаар өгүүлэл бичив.

Өөрсдийн болон өмнөх судлаачдын хийсэн судалгаанд тулгуурлан Өндөр гэгээний тиг хийцийн бүтээлүүд, Өндөр гэгээний барьж байгуулсан хийд орны талаарх мэдээллийг бүртгэн гаргаж, мэдээллийн цахим санд оруулах материалыг бэлдэв.

Г.Мягмарсүрэн, Д.Наранцэцэг нар 2022 оны 1-р сарын 16-30-ны хооронд ОХУ-ын Москвагийн Угсаатны зүйн музей, Санктпетербургын Шашин угсаатны музейд хадгалагдаж буй Өндөр гэгээний тиг хийцийн бүтээлүүдийг үзэж бүртгэж авав. Мөн 2022 оны 6-р сарын 29-нээс 7-р сарын 03-ны хооронд ОХУ-ын Буриад улсын музейд очиж, Өндөр гэгээний уран бүтээлийн холбоотой судалгаатай танилцав.

2022 оны 5-р сарын 1-2, 8-р сарын 12-14-нд Г.Мягмарсүрэн, Д.Наранцэцэг нар Оросын талын удирдагчтай хамтран Монгол Улсын Эрдэнэзуу хийд, Шанхын Баруун хүрээ хийд, Дорноговь аймгийн Хамрын хийд болон Өвөрхангай аймгийн зарим нэг хувь хүний хадгаламжид буй Өндөр гэгээний гэх бүтээлүүдийг биечлэн үзэж, тодорхойлолт хийж, бүтээлийн жагсаалт гаргав.

Төслийн хүрээнд төслийн удирдагч Г.Мягмарсүрэн таван боть ном 1, өгүүлэл 3, илтгэл 4, эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, тайлан, төслийн гүйцэтгэгч Д.Наранцэцэг өгүүлэл 3, илтгэл 1, Ц.Гүнчин-Иш өгүүлэл 3, илтгэл 3 хийж гүйцэтгэжээ.

Төсөл хэрэгжүүлсэн үр дүнд Өндөр гэгээн Занабазарын урлагийн өв, эх сурвалжийг судлах, үндсэн уран бүтээлийг бүртгэх, Монголын бурхны шашны урлагийн субъектуудэд түүх, уран сайхны шинжилгээ хийхэд чиглэсэн бөгөөд ингэхийн тулд энэ талаар өмнө үеийн судлаачдын хийсэн судалгаа шинжилгээний ажил, архивын баримт материал дээр тулгуурлахын сацуу судалгааны багийн гишүүд өөрсдөө тухайн газар нутагт судлан байцаах ажлыг шинээр биечлэн хийж, хуучин баримтыг магадлах эрдэм шинжилгээний ажлыг ОХУ, Монгол улс дахь Өндөр гэгээний тиг хийцийн урлагийн бүтээл онцгойлон дэлгэрсэн буддын шашны сүм хийд, хувь хүмүүсийн дунд явуулав. Төслийн үр дүнд олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний хурал хийх, эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлэх ажлыг дэс дараатай хийж, хугацааны эцэст Орос Монголын талын хамтын зохиогчтой мэдээллийн дата бий болгов.

Төсөл хэрэгжүүлэх хугацаа гэрээ ёсоор 2019-2021 байсан боловч дэлхий дахиныг хамарсан цар тахал зэргийн улмаас төслийн санхүүжилт хойшилж орсон зэрэг шалтгаанаар 2019-2022 оны хооронд үргэлжлэв. Энэ хугацаанд бид түүхийн болон бусад шалтгаан, хүчин зүйлийн улмаас өөрийн улсын болон хөрш ОХУ-ын музей, хийдүүдийн сан хөмрөг, хувь хүмүүсийн гарт хадгалагдах болсон Өндөр гэгээний тиг хийцийн бурхад, урлагийн хосгүй үнэт өвийг бүртгэн тогтоож, үндэслэлтэй үнэн зөв тодорхой тайлбартайгаар нэгтгэн бүртгэж авах ажлыг эхлүүлсэн билээ.

Бид энэ удаад Өндөр гэгээн Занабазарын өөрийн мутраар болон, түүний тиг загвараар бүтээж, өнөө үед уламжлан ирсэн 81 бүтээлийн бүртгэл, объектын тайлбар, эх сурвалж, судалгааны мэдээллийн сан байгуулахад шаардагдах эх материалуудыг бэлтгэх ажлыг хийв. Ингэж Монгол, Оросын музейн цуглуулга, сүм хийд, гэр бүлийн тахил шүтээн, хувь хүмүүсийн цуглуулгад байгаа Занабазарын уран бүтээлийн өвийг судлан, нэгтгэн дүгнэх нь уран бүтээлчийн талаарх цогц судалгаа, хувь хүний онцлог шинж чанар, дэлхийн хэмжээний урлаг, уран сайхны хөгжилд гүйцэтгэх үүрэг ролийг тодорхойлоход тодорхой хувь нэмрээ оруулна хэмээн үзэж байна.

Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

**доктор (Ph.D), профессор Ч.Дамбажав:** За, төслийн үр дүнгийн талаар танилцуулга сонслоо. Эхлээд Цэрэнсодном гуай, та үг хэлэх үү?

**академич Д.Цэрэнсодном:** За, сайн байна аа. Сайн ажил хийжээ. Ер нь Өндөр богдын зохиол бүтээл, нэн ялангуяа бурхны урлал гайхамшигтай, хосгүй үнэт урлагийн өв гэдгийг хэн бүхэн мэдэж байгаа шүү дээ. Тэгэхээр музей, хувь хүний цуглуулгад байгаа Өндөр богдын бүтээлийг эрэн сурвалжилж, нэгтгэн бүрсгэсэн энэ ажил маш чухал юм. Би 2007 онд Өндөр гэгээний намтрын хамгийн дэлгэрэнгүй хувилбарыг Да багшийн гэр музейгээс авч хөрвүүлж, тайлбартайгаар хэвлүүлсэн. Үүнээс ч хойш ч хэд хэдэн монгол намтрыг Хүрэлбаатарын нэрээр Өвөр Монголд хэвлүүлсэн байна лээ. Эднийг бүрсгэж үзээ биз дээ?

**доктор Г.Мягмарсүрэн:** Түүнийг болон бусад монгол төвөд намтрыг ашигласан байна лээ.

**доктор (Sc.D), профессор Л.Тэрбиш:** Хүүхдүүд, сайн судалгаа хийжээ. Би баярлаж байна. Та бүхний хийж гүйцэтгэсэн ажлыг сонсоод, дэмжиж байгаагаа хэлье. Соёмбо үсгийн ойн хуралд би оролцсон. Илтгэл хэлэлцүүлсэн. Цогт тайж соёмбо үсэг хэрэглэж байсан гэх тэр түүхийн жаахан гуйвуулга засмаар байгаа юм. Илтгэлдээ энэ талаар дурдсан. Та нар сайн сонссон байх.

**доктор (Ph.D), дэд профессор М.Батаа:** Төслийн ажлын үр дүнгийн тайлан сонслоо. Сайн болжээ гэж би дүгнэж байна. Монголын шашны тэргүүн Өндөр гэгээн, IV, V, VII, VIII богдуудын сүмбүм зохиолыг монгол хэл рүү орчуулж, олон нийтийн хүртээл болгосон нь гадаад, дотоодын эрдэмтэн судлаачид, сүсэгтэн олонд тустай, тэдгээр



бүтээлийг эрдэм шинжилгээний эргэлтэд оруулсан, эрдэм шинжилгээ, судалгааны эх сурвалж баяжуулсан сайн ажил болсон гэж бодож байна. Их сонирхолтой сайн судалгаа хийж, үр дүн нь ч гарчээ. Дэмжиж, хүлээн авах саналтай байна

**магистр Ц.Алтанхүү:** Төслийн ажлын талаар ойлголоо. Сайн ажил хийсэн байна. Би энэ төслийн ажил анх авах цагаас хүрээлэнгийн захирал болон төслийн бусад хүмүүс маш идэвхтэй, сайн ажиллаж ирснийг харсан. Одоо ажлаа хийчихсэн, үр дүнгээ танилцуулж байна. Төслийн үр дүнг хүлээн авахыг дэмжиж байна.

**докторант И.Ядамсүрэн:** Дэмжиж байна

**докторант С.Дэмбэрэл:** Дэмжиж байна.

**магистр Б.Наранбат:** Дэмжиж байна.

**доктор (Ph.D), профессор Ч.Дамбажав:** За, сайн байна. Дараагийн асуудал хэлэлцэхийн өмнө энэ төслийг хүлээж авах саналтай гишүүд гараа өргөх үү?

**Бүгд дэмжиж, гар өргөв.**

**доктор (Ph.D), профессор Ч.Дамбажав:** Эрдмийн зөвлөлийн гишүүд бүгд дэмжлээ. Манай хийдийн дэргэдэх Бурхны шашин соёл судлалын хүрээлэнгээс Орос, Монголын хамтарсан төслийг амжилттай хэрэгжүүлж, үр дүнг бүрэн хангасан гэж үзээд, төслийг хүлээн авахыг эрдмийн зөвлөлийн гишүүд бүрэн дэмжсэн тул холбогдох тогтоолыг гаргахыг Эрдмийн зөвлөлийн нарийн бичигт даалгая.

**Шийдвэрлэсэн нь:**

"Занабазарын урлагийн бүтээлийн өв дурсгалыг судлах, Монгол, Оросын музей, олон нийтийн болон хувь хүмүүсийн цуглуулгын мэдээллийн сан бүрдүүлэх, бүртгэх, аргачлал боловсруулах" сэдэвт хамтарсан төслийн үр дүнг хүлээж авч, төслийн тайлан бусад материалыг холбогдох шатны байгууллагад хүлээлгэн өгөхийг дэмжиж байна.

**Протокол хөтөлсөн:**

**Г.Мягмарсүрэн**

Хавсралт 2. ОХУ-ын төсөл хамтран гүйцэтгэгч байгууллагын тодорхойлолт



МИНИСТЕРСТВО НАУКИ И ВЫСШЕГО ОБРАЗОВАНИЯ РОССИЙСКОЙ ФЕДЕРАЦИИ  
ФЕДЕРАЛЬНОЕ ГОСУДАРСТВЕННОЕ БЮДЖЕТНОЕ УЧРЕЖДЕНИЕ НАУКИ



**ИНСТИТУТ ВОСТОКОВЕДЕНИЯ  
РОССИЙСКОЙ АКАДЕМИИ НАУК**

основан в 1818 г.

107031 (РФ, СНГ), 107996 (международный), г. Москва, ул. Рождественка, 12, тел.: (495) 621-18-84, (495) 625-64-61, факс: (495) 623-19-09  
www.ivran.ru, inf@ivran.ru, acadsecretary@ivran.ru  
ИНН: 7702028909, КПП: 770201001, ОГРН: 1037739314084

26.01.2023 № 14106/5114-12

На № \_\_\_\_\_

В Министерство образования,  
культуры и науки Монголии

ФГБУН Институт востоковедения Российской академии наук подтверждает, что международный научный проект РФФИ монг\_т № 19-59-44011 «Выявление, учёт и исследование объектов художественного наследия Дзанабазара в музейных, общественных и частных коллекциях Монголии и России: создание базы данных и разработка методологии» осуществлялся нашими сотрудниками в период 2019-2021 и успешно завершён в августе 2022 г. Руководитель проекта с российской стороны - ведущий научный сотрудник ОСК ИВ РАН, д.и.н. С.-Х.Д. Сыртыпова; руководитель с монгольской стороны – директор Института буддологических исследований в монастыре Зуун-хурээ Г.Мягмарсурэн.

Директор, д.и.н.

А.К. Аликберов

**Ном-2**

2. Сүрэнханда Сыртыпова. Өндөр гэгээн Занабазарын загвар хийц.  
/А.Алтангэрэлийн цуглуулгын жишээн дээр/. Уб., 2019
3. Монгол богдуудын бүрэн зохиол. 5 боть. Орчуулсан Г.Мягмарсүрэн. редактор  
Д.Наранцэцэг Уб., 2022.

**Өгүүлэл-10**

**Гадаадад-3**

1. Г.Мягмарсүрэн, Сүрэнханда Д.С "The Images of Past Lives of Undur Gegeen in Erdene Zuu Museum". "Искусство на Востоке и Восток в искусстве" Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл.алд хэлэлцүүлсэн илтгэл. Москва
2. Мягмарсүрэн, Г. Труды монгольских ученых лам и проект //Миряне и ламы: Буддийские идеи и практики в трансформирующихся обществах России и Монголии. Улан-Үдэ. 2020. срт. 87-100
3. Наранцэцэг. Д., Гүнчин-Иш. Ц., Сыртыпова. С. Д. Өндөр гэгээний намгарт түүний уран бүтээлийн ордыг тэмдэглэсэн нь. //Mongolia and the Mongols. Past and Present. Warsaw. 2022

**Дотоодод-7**

1. Мягмарсүрэн Г., Андреев А. В. Таван богдын зохиол бүтээлийн тухай. //Шашин соёл судлал. Уб., 2020. Том II. Fasc 10. 148-164-р тал
2. Мягмарсүрэн, Г. Богдуудын анхны зарлиг зохиолын тухай. //Наймдугаар богд Жэвзүндамба хутагтын 150 жилийн ойн эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Уб., 2020. 47-58-р тал
3. Сурун-Ханда Сиртыпова., Наранцэцэг Д. Өндөр гэгээний язгуурын таван бурхдын урлалын онцлог //Шашин соёл судлал. Уб., 2018. Том II. Fasc 2. 18-39-р тал

4. Наранцэцэг, Д., Сыртыпова Д. С. Скульптуры Падмасамбхавы моделировки Дзанабазара в Монгольских коллекциях //Төвөд судлал. Боть 10. Уб., 2021. 138-147
5. Гүнчин-Иш Ц., Сарантуяа У. Өндөр гэгээн Занабазарын нэгэн уламжлалын тухай. //Шашин соёл судлал. Уб., 2018. Том II. Fasc 8. 102-111-р тал
6. Гүнчин-Иш, Ц. Сарьдагийн хийдийн гол сүмийн шүтээний зохиомжийг тодруулах нь // Археологи, түүх, угсаатан судлалын сэтгүүл, Улаанбаатарын их сургуулийн сэтгүүл. УБ., 2020. Т.160-165
7. Гүнчин-Иш, Ц. Өндөр гэгээн Занабазарын ууц таллаж буй хөргийн тухай // Угсаатан судлал, ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний сэтгүүл. Том. XXIX, Fasc. 12. 2021 он. Т.188-197

#### **Илтгэл-8**

1. Мягмарсүрэн Г., Андреев А. В. Таван богдын зохиол бүтээлийн тухай. //Өндөр гэгээний үсгийн урлаг. Олон улсын эрдэм шинжилгээний хурал. Уб., 2019. 10.02
2. Мягмарсүрэн. Г. Богдуудын анхны зарлиг зохиолын тухай. //Наймдугаар богд Жэвзүндамба хутагтын 150 жилийн ойн эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэл. Уб., 2019. 11.16
3. Жавзандамба хутагтын зохиол бүтээл Монголын бурхан шашны түүхтэй холбогдох нь. Богд хааны ордон музейгээс зохион байгуулсан "Богд Жавзандамбын судлалд" эрдэм шинжилгээний хурал. Уб. 2022.12.26
4. Г.Мягмарсүрэн, Сүрэнханда Д.С "The Images of Past Lives of Undur Gegeen in Erdene Zuu Museum". ОХУ-ын ШУА-ийн Дорно дахин судлалын хүрээлэн, Дорно дахины музей хамтран зохион байгуулж буй "Искусство на Востоке и Восток в искусстве" олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэл. Москва, 2022.06.30
5. Сурун-Ханда Сиртыпова., Наранцэцэг Д. Өндөр гэгээний язгуурын таван бурхдын урлалын онцлог //Өндөр гэгээний үсгийн урлаг. Олон улсын эрдэм шинжилгээний хурал. Уб., 2019. 10.02

6. Гүнчин-Иш Ц. “Өндөр гэгээн Занабазарын уран бүтээлийн онцлог” //“Монгол дархны урлаг: Түүх, орчин үе” эрдэм шинжилгээний бага хурал, Уб, 2019.07.05.
7. Гүнчин-Иш Ц., Сарантуяа У. Өндөр гэгээн Занабазарын нэгэн уламжлалын тухай //Өндөр гэгээний үсгийн урлаг. Олон улсын эрдэм шинжилгээний хурал. Уб., 2019. 10.02
8. Ц. Гүнчин-Иш. Өндөр гэгээн Занабазарын уран бүтээл ба Сарьдагийн хийдийн шавар бурхад //ШУА-ийн Археологийн хүрээлэн, МБШТГандантэгчэнлин хийд, Эрдэм соёлын хүрээлэн хамтран зохион байгуулсан “Буддын шашин ба археологи” сэдэвт эрдэм шинжилгээний хурал, УБ., 2021.11.12

#### ***г/ Эмхэтгэл-1***

Өндөр гэгээний үсгийн урлаг. Соёмбо үсэг зохиогдсоны 333 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. *Шашин соёл судлал сэтгүүл. 2020 он*

#### ***д/ Тайлан-1***

1. "Өндөр гэгээний тиг хийцийн урлаг соёлын өвийг судлах, Монгол Оросын музей, олон нийтийн болон хувь хүмүүсийн гар дээрх цуглуулгын мэдээллийн сан бүрдүүлэх, бүртгэх аргачлал боловсруулах нь " төслийн тайлан. Уб., 2023

## **Занабазарын өөрийн хөргүүд**

### ***Шүтээн зургийн агуулга***

Занабазар агуу уран бүтээлчдийн нэгэн адил өөрөө өөрийнхөө хөрөг дүрийг нэг бус удаа бүтээж байжээ. Тухайлбал, түүний шүтээн зургийн нэг бүрдүүлэгч хэсэг болсон өвөрмөц дүрүүдийг нь өөрийнх нь хөрөг гэж судлаачид үздэг бөгөөд уран зураг, зураасан зураг, бар, уран баримал зэрэг төрөл бүрийн хэлбэрийн Занабазарын дүр хөргүүд байдгийн дотроос Базарсад бурхны суудал, дүр төрхтэй нь хамгийн түгээмэл юм. Ингэхдээ өсвөр бага настай, залуу дүр, өтөл ахимаг олон дүр байдалтай байдалтай дүрслэгддэг түүнийг том нигур, пөмбөгөр дух, бүргэд хамар, том гялаан толгой, хөнгөхөн инээвхийлэхэд нь үүссэн хацрын хонхорхой зэрэг онцлогоор нь ялгаж таньж болно.

Төвөд, монголын түүхэн хүмүүсийн хувийн зан чанарыг хурц тод харуулсан ХIY-XY зуун<sup>1</sup> бүр ХIII<sup>2</sup> зуунд хамаарах нэлээн эрт үеийн гайхамшигтай ховор баримлууд байдаг, ер нь тодорхой хүмүүсийн дүрийг бүтээх үзэгдэл эртнээс нааш байсаар ирсэн боловч Очирт хөлгөний бурхан урлах аргыг судалгааны хэрэглэгдэхүүн хэлбэрээр судалж байсан нь үгүй юм. Гэхдээ бурхан бүтээх тиг, олшруулах журамд захирагддаг байсан учраас Бурхан багш, ертөнцийн зургаан чимэг тэргүүтэн буддын шашны ихэс багш нарын дүр нэгэнт хэвшмэл тогтсон загварт орсон байдаг бол харин хязгаар орны бурхны шашинтнуудын бүтээсэн дүр цор ганц давтагдашгүй хэлбэрээр, орон нутгийн чанартайгаар бүтээгдсэн байдаг. Харин энэхүү агуу монгол ламтан, уран барималч, удам сайт хүний тухайд бол гарал угсаанаасаа үүдээд (Чингис хааны алтан ургийн удмын хүн), мөн хувь хүнийхээ олон талт авьяас чадварынхаа хүчээр нөхцөл байдал өөр байсан юм. Сүсэгтэн олны хүсэл эрмэлзлийн үрээр анхдугаар богд Өндөр гэгээн Занабазарын дүр

---

<sup>1</sup> “Мастеруудын хөргүүд” хэмээх Төвөдийн хүрэл баримлуудын цомог нь нэн ховор бүтээл хэвээр байгаа бөгөөд уг цомогт

1970-аад оны цуглуулгад нь тулгуурласан Оливера Хоорын (Oliver Hoare), Николас Йоханнес Шмидт (Nicolas Johannes Schmidt) нарын цуглуулга оржээ; Энэ хоёр хоёулаа “Сотбис” (Sotheby’s) хэмээх олон улсын томоохон дуудлага худалдааны газар ажиллаж байсны хүчээр Төвөдийн алдарт зүтгэлтнүүдийн хөрөг дүрүүд бүхий үнэт цуглуулга бий болгож чаджээ. ([Portraits of the Masters 2003: №61–66-аас хар]).

<sup>2</sup> Тухайлбал, монгол уран дархны бүтээсэн шатрын хүрэл дүрс хэлбэрээр Өгөдэй хааны дүр хадгалагдан үлдсэн байдаг ([Сыртыпова 2018: 209–236]-аас хар).

олон тоогоор, зотон, шавар, мод, хүрэл зэргээр олон удаа хуулбарлагдсан байдаг. Жавзундамба хутугт буюу анхдугаар дүрийн богд, Өндөр гэгээний монгол дүрүүдийн хөргийг Элизабет Хадерер судлахдаа Монгол улс болон гадаадад тархсан олон тооны хуулбар, хувилбаруудын эх хувийг олж тодорхойлох, төрөл бүрийн шүтээн зургуудын технологи, зохиомжуудыг харьцуулах зорилго тавьжээ [Haderer 2019a; Haderer 2019b].

Э.Хадерерийн хэвлүүлсэн зургуудын дотор мэдээж анхдугаар Жавзундамба хутугт Занабазарын дүр зургууд, тэр дундаа өөрөө өөрийгөө зурсан дүрүүд нь орсон байв. Нэлээн алдартай бөгөөд нэлээн дээр үед хэвлэгдсэн хөргүүд нь 1) Будапешт хотын Непразжи музейн цуглуулгад байдаг. “Занабазар өмнөх дүрүүдийн хамт” хэмээх шүтээн зураг [Haderer 2019a: Fig. 4], 2) Анх 1995 онд хэвлэгдсэн Буриад улсын Үндэсний музейн санд хадгалагдаж буй “Занабазар өмнөх дүрүүдийн хамт” (Богд гэгээний малгайтай залуу дүр) [Бадмажапов 1995: 38–39, илл.10; Haderer 2019a: Fig. 7], 3) анх 1989 онд Цүлтэмийн хэвлүүлсэн, Улаанбаатар хотын Гандан хийдэд буй “Богд гэгээний малгайтай Занабазарын өөрийн баримал” юм [Цүлтэм 1989: илл. 87; Haderer 2019a: Fig. 8].

### **1.Чойжин ламын сүм музейд буй Занабазарын уран баримал**

Баримлын хэмжээ: 32x20x29см., жин 10340 гр. Эд зүйл. № О.42.34.

2012 онд уг баримлыг № 684 [ММШУД 2014: 138] дугаартайгаар Монгол Улсын түүх соёлын өвийн ховор уран бүтээлийн тоонд оруулжээ.

Занабазар монгол ламын хувцас өмссөн, Базарсад бурхны ялгах тэмдгүүдийг барьж бясалгалын суудлаар морилжээ. Мөрөн дээгүүрээ орхимж давуулж, үзүүр хэсгээр нь завилсан хөлөө хучжээ. Занабазар нэлээн залуу дүр байдалтай (25-30 настай) боловч аль хэдийн жинхэнэ лам багш болсон нь харагдана. Гавлын яс нь бөөрөнхий, жигд дугуй, нүдээрээ инээмсэглэсэн, өсвөр насны хөвгүүний царайтай боловч халзарч эхэлсэн, том нүд, том хамартай, жижиг гоё уруултай, унжсан том гэдэстэй том чихтэй ажээ. Зуувин болгож зурсан нүдээрээ чанх өөдөөс ширтэнэ. Хоёр хацрын хонхорхойг нь цэгүүдээр дүрсэлжээ. Мутрынх нь бугуй нарийхан, зөөлөн, зүрхэн тушаа газартаа баруун мутрынхаа уян налархай хуруунуудаар очир барьсан ба долоовор болон чигчий хуруу нь бага зэрэг дээш, эвэр маягтай өргөгдсөн нь үлдэн хөөх мутарлага (*самг. karana mudra*) юм. Үнэн хэрэгтээ, ялгарах тэмдгээ гурван хуруугаараа (эрхий, дунд, ядам хуруу) барьсан чагжийг "харина" (*самг. harina*) гэнэ.



Зураг 4.1.1. Өндөр гэгээн Занабазар (1635–1723). Баримал. Цутгамал, алтадсан хүрэл.

Хэмжээ: 32х20х29 см., жин 10340 гр. Улаанбаатар. Чойжин ламын сүм-музей [ММШУД 2014: 138].

Зарим бүтээлд энэ баримлыг “Занабазарын дэг сургуулийн бүтээл” буюу шавь нарынх нь бүтээл гэдэг. Гэхдээ Занабазар өөрөө бүтээсэн гэдгийг нь нотлох нухацтай үндэслэлүүд байгаа юм. Занабазарын бусад бүтээлүүдийнх нь адил биеийн хэлбэрийг маш цэвэрхэн, шударга гаргасан байгаа юм. Монгол ёсоор салхи, хүйтэн, агаарын хэмийн гэнэтийн уналтын улмаас дандаа дотортой оёгддог хувцасны нягт, зузааныг бодитойгоор гаргажээ. Чойгү намжирынх нь нугалаас, эмжсэн дүрс, өөдөсний оёос, зөөлөн мутар, жижиг хоёр бугуй, үл мэдэг инээмсэглэл тодруулсан гайхалтай амьд царай бол Занабазар хийцийн онцлог юм. Мөн маш чанартай цутгаж, алтадсаныхаа дараа гадаргууг нь маш гоё боловсруулдаг онцлогтой. Ийм загварын цутгамалууд байдаг ба Монголд хамгийн түгээмэл бөгөөд төрөл бүрийн материалаар янз бүрийн үед хуулбарлан цутгаж байжээ.

1995 онд Бергер, Бартоломео нар Монгол Улсад зориулан гаргасан цомогт хэвлэгджээ [Berger and Bartholomew 1995].

### **1.Богд хааны ордон-музей дахь Занабазарын баримал**

Хэмжээ 59 х 61,5 см



Занабазар очир завилгаагаар морилж, зүрхэн тушаа газартаа баруун мутраараа очир барьж (очир нь алга болсон), зүүн мутартаа хонх барьжээ. Өмнөх барималд дүрслэгдснээс ахимаг настай, толгой нь дөрвөлжиндүү, нүүрний төрх нь нас ахисныг нь харуулж байгаа бөгөөд хоёр чих нь томорсон (чих хүний насан туршид нь ургадаг) байна. Мутар нь орхимжон доороосоо бараг бүтнээрээ гарч ирсэн, мөр, тохой хоёр нь л хучигдсан, алгаа нааш харуулсан, хоёр мутрынхаа дунд, ядам ба эрхий хуруугаар очир, хонхоо барьжээ. Донгүгийг нь бадамлянхуа цэцгэн хээгээр нягт чимжээ. Хээ нь нэлээн гүн, зузаан зураасаар хийгдсэн нь хонхойлгож зураас гаргаагүй, шууд цутгахдаа гаргасан гэсэн үг юм.



Зураг 4.1.2. Занабазар. Баримал. Цутгамал, алтадсан хүрэл. ХҮШ зууны эхэн үе. Хэмжээ: 59x61,5.

Богд хааны ордон музей [БХОМ 2011]. Монгол Улс. Улаанбаатар. [ММШУД 2014: 69].

Чойгү намжир нь бага зэрэг борогдуу. Занабазар өөрөө эхлүүлээд, шавь нар нь хийж дуусгасан бололтой. Энэ баримал нь хамгийн сүүлийн үеийн өөрөө өөрийгөө дүрсэлсэн баримал ба хамгийн ахимаг дүртэй, үүний өөр нэг хувилбар бий гэж үзэх үндэслэл байгаа юм (4.1.2-той харьцуул). Өндөр гэгээний баримал дээр ч, шүтээн зураг дүр дээр ч Өндөр гэгээний жанч зүүн гар тал руугаа ярагдсан байгаа нь монголчууд дээлээ сугалдрагалахдаа баруун мутраа гаргадагтай холбоотой ба энэ нь бусад дүрслэлүүдээс ялгарах онцлог юм.

Уг баримлын зургийг Чехийн археологич Л.Йисл 1960 онд анх хэвлэж (тухайн үед уг баримал Чойжин ламын сүм-музейд байсан), дараа нь 1982 онд монгол эрдэмтэн Н.Цүлтэм хэвлэжээ [Jisl 1960: 25, fig. 72; Цүлтэм 1982: 26, илл. 5; Haderer 2019a: Fig. 3].

Энэхүү баримлыг Монгол Улсын түүх соёлын ховор бүтээлд №81 дугаартайгаар [ММШУД 2014: 69] бүртгэжээ. ХҮШ зууны эхэн үед хамаарагдана.

## 2.Шүтээн зураг . Залуу хүү Занабазарын өөрийн хөрөг

Уг шүтээн зургийг шороон будганд маш их хэмжээний, чанар сайтай алтан түрхэц хольж, 32x25 см хэмжээтэй зотон дээр бүтээжээ.

Түүний хөрөг зураг зурах анхны оролдлогуудын нэг нь өөрөө өөрийгөө зурах байсан бололтой. XVI зуун, XX зууны үеийн Монголын язгууртнуудын адил хувцас өмссөн залуу хүүгийн хөрөг. Занабазарын намтарт нэгэн дүр зураг байдаг нь Төвөд рүү сурахаар явах гэж байхад нь ээж Ханджамц хатан нь маш их гуниглаж явуулахгүй гэхэд тэрээр хайрт хүүгээсээ удаан хугацаагаар хол байхдаа хүүгээ бага санаасай гэсэндээ өөрийнхөө хөргийг зурж өгчээ [Öndör gegen-ü., л.12а]. Энэ явдал 1649 онд болжээ. Домгоос харахад 1-рт Занабазарын зурах авьяас бүр бага хүүхэд байхад нь илэрчээ. Бага насандаа элсээр сүм хийд зурж, барин наадах таалалтай байв. 2-рт, түүний эдгээр бага насны тоглоом наадгай дээр нь түүнийг хүрээлэн байсан буюу монгол нүүдэлчдийн дүрслэх урлагийн уламжлал туссан байх ёстой. Өндөр гэгээн Занабазарын бага насны уран бүтээлүүдийн нэг болох энэ бүтээлийг нарийвчлан судлахад тухайн нутаг орны урлалын уламжлал, нүүдлийн гоо зүйн нөлөө харагдана.

Энэ зургийг ширүүн зотон дээр зурсан бөгөөд будаг, бийрээ нарийн сайн хэрэглэж дадаагүй байсан гэмээр. Учир нь гялалзтал нь гялтайлгасан их хэмжээний алтан түрхэц нь зохиомжийг нь алдагдуулсан гэлтэй харагддаг. Үүнээс гадна энэ шүтээн зургийг зурахдаа бурхан зураачид шиг эхлээд дүрсийг нь гаргалгүйгээр өөрийн гэсэн тодорхой үйл явдалтайгаар, ховорхон нөхцөл байдалтайгаар бүтээсэн н урлаачийн зоригтой, хэв загварт баригддаггүй байдал, сэтгэлгээний бие даасан шинжийг тод томруун илтгэжээ. Хуйлаасандаа сайн хадгалагдаагүй бөгөөд барзгар гадаргуутай аргаар зурсан боловч чин сэтгэл гаргаж зурсан болохоор сэтгэл хөдөлгөх ер бусын удистай ажээ. Бараан дэвсгэрийг алтаар зурсан хэсгүүдтэй хоршуулж, төв хэсгийг нь гэгээтэй болгосон нь дүрсийг нааш төвийлгөж, бараг баримал шиг харагдуулна<sup>3</sup>.

Зотонгийн голд Базарсад бурхны дүртэй залуу үзэсгэлэнт хөвгүүн сийлмэл түшлэгтэй арслант сэнтий дээр суужээ. Толгойдоо хар ангийн үсэн хүрээтэй, алтан эмжээрийн дээр

<sup>3</sup> Энэ шүтээн зурагийн зургийг анх 2019 онд хэвлүүлжээ. [Syrtyrova 2019].

очиртой малгай өмсжээ. Халх Монголын төв хэсгийн хан байсан, Түшээт ханы удмыг үндэслэгч, Монголын эртний хийд Эрдэнэ зууг барьсан, Занабазарын элэнц өвөө Абатай хан (1534–1586) мөн ийм малгайтай дүрслэгдсэн байдаг. Хөвгүүн хар хамбан эмжээртэй хиазтай шар дээл өмсжээ. Монголд ийм хиазтай шар дээлийг өнөө цагт хүртэл зөвхөн дээд зиндааны лам нар, эсвэл онцлох баяр ёслолын үед өмсөх эрхтэй байдаг. Мөрөн дээгүүрээ орхимж (утгарасанга) тохжээ. Алтан хээгээр чимсэн орхимжоороо хөлөө бүтэн хучжээ. Хөрөг зурах үед нь амьд байгаа хүнийг очирт завилгаагаар сууж хөлөө хучсан байдлаар зурдаг [Syrtyrova 2019: 121–126].

Зураг 4.1.4. Шүтээн зураг. Зотон 32 x 25 см. Занабазар хүүхэд байхдаа (1635–1723). Өөрийн хөрөг.

≈ 1649 он. А. Алтангэрэлийн цуглуулга. Монгол улс


Цэвэрхэн, эелдэг царайтай, цог жавхаатай царайтай залуухан монгол ханхүү хэрэгт дурласан харцаар харах бөгөөд жижигхэн уруул дээр нь хөнгөхөн инээвхийлэл тодорчээ. Малгайн доорх өргөн магнайн дээр нь шингэрч буй үс нь цухуйжээ. Зүрхэн тушаа баруун мутартаа барьсан очроо юу юугүй өөдөөс сунгах гэж буй мэт байдалтай барьжээ. Давхарлаж тавьсан олон олбогон дээр сууж байх бөгөөд хамгийн дээд талын олбогийг лам хүний өнгө болох улаан, шараар хүрээлжээ. Суудлынх нь түшлэг маш өвөрмөц, маш өндөр, час улаан өнгөтэй, ягаавтар улаан дэвсгэртэй, алтан хүрээтэй дугуйрсан сийлбэртэй. Богд гэгээний ар талд том том цэцэгтэй чоймзад (тиб. chos mdzad) хэмээх зөөлөн унжлагатай дугуй зөөлөн зөөлөвч байна.

Залуу хүүгийн толгойноос дээш Очирдара бурхан харагдах боловч хадгалалт муу байснаас бараг харагдахгүй болж, будаг нь халцарсан боловч зүрхэн тушаа газартаа арга билгийн нэгдлийг илэрхийлсэн очир, хонхыг зөрүүлэн барьснаар нь таньж болно (Зураг 1-2). Шүтээн зургийн зүүн дээд буланд Байшажья гүрү, Манал бурхан (Зураг 1-3), баруун дээд буланд арван нэгэн тэргүүн, найман мутартай Жанрайсиг бурхан (Зураг 1-4) байна. Эдгээр бурхдыг Төвөдийн бурхан зурах уламжлалт аргаар саран дэвсгэр, нэл ягаан өнгийн бадамлянхуа цэцгэн дээр дүрсэлжээ.



Зураг 4.1.4а. “Залуу Занабазар” зургийн хэсгээс: Гол дүрийн толгойноос дээш заларч буй Очирдара бурхан. Зургийг С.С.

Зураг 4.1.4б. “Залуу Занабазар” зургийн хэсгээс Шүтээн зургийн зүүн дээд буланд буй Байшаджъя гүрү, Манал бурхан. Зургийг С.С.



Зураг 4.1.4в. “Залуу Занабазар” зургийн хэсгээс. Баруун дээд буланд буй 8 мутартай Жанрайсиг бурхан.

Суудлын өмнө тогосны өдөн иштэй цацагчтай рашааны бумба, дамар, хашаанаар дүүргэсэн хар бадар аяга, урт хүзүү, урт цорготой, тагтай бумба, арц уугиулах бойпор, өндөр суурьтай тахил болон зул тавих хоёр цом, утга санааны төв, энэ тэнцүү тогтвортой байдлыг харуулсан хорол бүхий эрдэнийн ваар дээр нь тавьсан лам хүний жижиг улаан ширээ тавьжээ. Ширээний ар талаас сэнтийн нүүрэн талын чимэг харагдана. Суудлыг мөрөн дээрээ тогтоож буй цаст уулын цагаан арслангийн сүүл харагдана.

Шүтээн зургийн доод өнцгүүдэд Цагаан Дарь эх (Зураг 4.1.4г), Ногоон Дарь эх (Зураг 4.1.4д) хэмээх хоёр суугаа эх бурхан дүрслэгджээ. Тэд саран дэвсгэр, хар хөх өнгийн зүрхэн хэлбэрийн дэлбээтэй, алтан судалтай бадамлянхуа цэцгийн дээр заларчээ. Улаан гэгээрлийн гэрэлтэй, бурхны биеэс гарсан алтан цацрагуудтай ягаан лагшингийн гэрэлтэй, алтан хээтэй улаан шамтавтай, эх бурхны бүх зүүлт чимэг зүүжээ. Алтлаг улбар шар өнгийн дагам нь мөрнөөс нь доош унахгүй байгаа бөгөөд дагамных нь доороос

баясалгагчийн бүс харагдана. Цагаан Дарь эх долоон мэлмийтэй, магнай, нигур, мутрын алга, хөлийн тавхай дээрээ мэлмийтэй.



Зураг.4.1.4г. “Залуу Занабазар” зургийн хэсгээс Зүүн доод булан дахь Цагаан Дарь эх. Зургийг С.С.



Зураг 4.1.4д. “Залуу Занабазар” зургийн хэсгээс Баруун доод булан дахь Ногоон Дарь эх. Зургийг С.С.

Цагийн эрхэнд будаг нь харлаж, олон газарт арилсан хэсгээрээ бүдүүн ширхэгтэй зотон зураг оочин цоочин харагдана. Уг зургийг ухаа шаргал өнгийн мушгиа хээгээр хүрээлжээ. Дугуй бадамлянхуа цэцэг ба дөрвөлжин доторх бадамлянхуа хээтэй хар ногоон торгоор эмжжээ.

Суудлын алтан мушгирсан хээ нь зургаас дээш төвийн харагдаж зургийн агаарыг хөдөлгөөнтэй болгож байна. Үүнтэй адилхан металаар цутгасан Занабазар хийцийн бурхны суудал буюу сэнтийнүүд хадгалагдан үлдсэн байдаг. Энэ дүрснээс харахад ийм хэлбэрийн суудлын санааг зураач маань бүр хүүхэд байхдаа гаргасан ба насанд хүрсэн хойноо ч том хэмжээний баримлыг хүрлээр хийхдээ хэрэглэж байжээ (зураг.4.1.5г-е).

Зураг 4.1.5. Баримал болон шүтээн зурган дээрх суудлын түшлэгийн бүтэц



*Зураг.4.1.5а. Суудлын хэсэг: Хамгийн дээд талын толгой хэсгээс баруун тийш орших мушгирсан хээ. “Залуу Занабазар” шүтээн зураг. Зургийг С.С.*



*Зураг.4.1.5б. Суудлын хэсэг: Орой дээрх Чандмань эрдэнэ. “Залуу Занабазар” шүтээн зураг. Зургийг С.С.*



*Зураг.4.1.5в. Суудлын хэсэг: мөр орчмын мушгирсан хээ . “Залуу Занабазар” шүтээн зураг. Зургийг С.С.*



*Зураг.4.1.5г. Бүтээлийн хэсэг. Толгойн баруун хэсэгт орших мушгирсан хээ, Аюуш бурхны суудал Цутгасан хүрэл. Чойжин ламын сүм музей. Монгол улс Улаанбаатар хот.*



*Зураг.4.1.5 д. Бүтээлийн хэсэг. Толгойн хэсэгт орших чандмань эрдэнэ, Аюуш бурхны суудал Цутгасан хүрэл. Чойжин ламын сүм музей. Монгол улс Улаанбаатар хот.*



*Зураг.4.1.5е. Бүтээлийн хэсэг. Мөрний орчимд орших мушгирсан хээ, Аюуш бурхны суудал Цутгасан хүрэл. Чойжин ламын сүм музей. Монгол улс Улаанбаатар хот.*

Хүрэл цутгамал хувилбаруд нь шүтээн зураг дээрх дүрсийн ерөнхий дүрсийг давтаад зогсохгүй зохиомжийн хувьд мөн адилхан хэсгүүдтэй. Мушгирсан хээнүүд нь яг адилхан толинд тусгасан мэт харин хэмжээ нь янз бүр. Энэ элемент бол Төв Азийн дүрслэх урлагийн маш эртний анхдагч хээ юм. Ийм хоёр алтадсан суудал Чойжин ламын сүм музейд хадгалагддаг ба нэгэн дээр нь Базарсад бурхан, нөгөө дээр нь Аюуш бурхны баримлыг байрлуулжээ.

Энэ шүтээн зураг нь нэг эгнээнд байрлуулсан зүрх хэлбэрийн алтан цацрагтай дэлбээ бүхий дугуй бадамлянхуатай Занабазарын хамгийн эхэн үеийнх нь уран зураг бололтой. Энд уг урлаачийн заавал хэрэглэдэг мушгирсан, монголоор эрхий гэж нэрлэгддэг таслалын тэмдэгтэй адилхан хээ нь үндсэн элемент болж байгааг анхаарах хэрэгтэй. Энэ нь том хэмжээний мушгирсан хээний нэг хувилбар юм. Энэ хээгээр Богд гэгээний хувцас, ширээний модон хавтан, суудлын түшлэгний дээд тал, ширээн дээрх зан үйлийн зүйлс зэргийг чимэглэсэн байх ба тэр дундаа хорол тэмдэг, суудлын түшлэг дээрх цэцгэн хээ бүгд эрхий хэмээх мушгирсан хээгээр мөн зөөлөвч, бурхны хувцас дээрх хээнүүд мөн ийм хэлбэртэй байна. (Зураг.4.1.6).

Зураг.4.1.6. Занабазарын бүтээлийн эхэн үеийн шүтээн зурган дээрх эд хэрэгслийн эрхий хээ.

			
<i>Зураг.4.1.6а. Орхимж дээрх хээ “Залуу Занабазар” шүтээн зургийн хэсгээс.</i>	<i>Зураг.4.1.6б. Хорол тойрсон хээ “Залуу Занабазар” зургийн хэсгээс.</i>	<i>Зураг.4.1.6в. Ширээний хажуу талын хээ “Залуу Занабазар” зургийн хэсгээс.</i>	<i>Зураг.4.1.6г. Суудлын түшлэг дээрх зөөлөвчний хээ “Залуу Занабазар” зургийн хэсгээс.</i>

Эрхий гэдэг нь нүүдэлчин монголчуудын гар урчууд мастеруудын эрт дээр үеэс өнөөг хүртэл хэрэглэж ирсэн энгийн хээ бөгөөд археологийн олдвор ба орчин үеийн өвөг дээдсийнхээ уламжлалыг хадгаладаг урчуудын бүтээлээс харагдана [Syrtypova 2019: 31-40].

Шүтээн зургуудад нь Занабазарын өөртөө байнга дадлага болгож байсан, түүний хувьд маш ач холбогдолтойд тооцогддог гол гол шүтээн дүрүүд байдаг. Эдгээр нь өөртэйгээ адилтган үздэг Очирдара бурхан, өөрийнхөө язгуурын багш гэдэг Манал бурхан, Дарнатын (1575–1634) хойд дүрд тооцогддог түүний нэрийн хуудас нь болсон дөрөвдүгээр Банчэн эрдэнэ (1570–1662), Дарь эх бурхан, Жанрайсиг бурхан юм. Эдгээр шүтээнүүд нь Богд гэгээний бүх хойд дүрүүдийн гол шүтээн нь юм.

1649-1651 онд Төвөдөд сурахаас нь өмнө эсвэл дараа нь энэхүү бүтээл бүтээгдсэн бололтой. Өөрөө залуу дүртэй, уран зургийн арга барил нь нэг их сайнгүй, Төвөд рүү анх

явахдаа багш нараасаа бүтээлийг нь авсан үндсэн бурхдын хамрах хүрээнээс нь харахад энэ цаг хугацаатай тохирч байгаа юм. Энд буй олон элемент ба бүтээх аргуудыг тэрээр бүр анхны бүтээлээ хийхдээ л хэрэглэж байжээ. Улаанбаатар хотод амьдардаг хуучны эд зүйлсийн цуглуулагч А.Алтангэрэлд энэхүү дэлгэмэл шүтээн зураг хадгалагддаг.

## 1.Төрөл бүрийн шүтээн зургийн хэсэг

### Жижиг хэмжээний өөрийн хөргүүд

Өвөрмөц гарын үсэг нь гэж үзэж болохуйц Занабазарын жижиг хөргүүд байдаг. Мэдээж, Базарсад бурхны хөрөг дээр түүний хижээл насны дүр маш олноороо байдаг ба толгой, нүүрнийх нь хувийн онцлог хэлбэр болох том гавлын ясан дээрх халзарсан үс, инээвхийлэхэд нь харагддаг хацрын хонхроор нь ялган таньж болно. Заримдаа эдгээр дүрсийн дор гарын үсэг байдаг ба үүгээр нь түүний хөрөг болохыг ялган танихад хялбар.

Жишээ нь, А.Алтангэрэлийн цуглуулган доторх “Долоон Манал бурхны дундах Шагжамуни бурхан” хэмээх шүтээн зурган дээр Шагжамуни бурхан тойрог хэлээрээр байрласан долоон Манал бурхны голд байдаг. Энэ шүтээн зургийн зохиомж нь монгол ноёдын орд өргөө эсвэл нүүдэлчдийн хүрээний уламжлалт хэлбэрийг санагдуулна. Зурган дээрх бурхадын нэрсийг алтаар, төвөд үсгээр тус бүрд нь зориулсан мөргөлийн үсгийн хамт бичжээ. Баруун доод буланд нь *jnyana' bajra* хэмээн төвөд үсгээр бичсэн гарын үсэгтэй Занабазарын дүр байна. Лам хувцастай Базарсад бурхны хэрэглэгдэхүүнтэй ажээ. Улбар шар шамтавтай (*самг. antaravasaka; төвөд sham thab /mthang gos*), улаан хүрэн өнгийн орхимж (*самг. uttārasanga, төвөд bla gos, монг. орхимж*), шар өнгийн жанчтай (*самг. sangati; монг. жанчи эсвэл тува*) гоё хээтэй олбог дээр очир завилгаагаар суужээ (*санскр.: guptasana; төвөд sbas pa'i 'dug stangs*). Суудлынх нь түшлэгийг *вишвабазар* хэмээх хөх торгоор бүрсэн нь тойрсон цацраг мэт харагдана. Бүх үс нь дээш чиглэгдсэн зурагдсан гэлэн хүний малгай болгох *неринг* өмсчээ. Толгойных нь эргэн тойронд алтан цагирагтай улбар шар гэгээрлийн гэрэлтэй ажээ. Зүрхэн тушаа газартаа баруун мутраараа очир, зүүн мутраа өвдөг дээрээ тавиад хонх барьжээ. Хацар дээрх хонхорхой нь харагдана (Зураг 4.1.7а). Хөл нь харагдахгүй, лам нь залуу төрхтэй байгаагаас харахад зураг дээрх хүн амьд байсан ба энэ шүтээн зургийг зурсан хугацаа нь 1655-1670 оны хооронд байж болох юм.



“Арван хоёр нөхөр сэлттэйгээ дүрслэгдсэн Шагжамуни” бурхан бүхий шүтээн зурган дээр мөн үүнтэй ижил зураг бий. Энэ шүтээн зураг мөн А.Алтангэрэлийн хувийн цуглуулгад байдаг. Шүтээн зургийн дээд талын гол хэсэгт нь хөх түшлэгтэй, хоёр олбогтой суудал дээр неринг хэмээх шар малгай өмссөн, баруун мутраа хорол барьцаар барьж, зүүн мутартаа бадар аяга барьжээ (Зураг 4.1.7б). Бадамлянхуа суудал дээр суугаагүй, зураг зурах үед амьд байвал хөлийг ил гаргадаггүй гэдэг журмаар зурагджээ. Хацрын хонхорхой нь харагдана.

Нагтан зургийн аргаар торгон дээр бүтээсэн “Цагаан чандмань Махагал” шүтээн зураг дээр ч мөн Занабазарын жижигхэн хөрөг зураг байна. Хөргийн дээд хэсэгт хоёр лам буйн нэг нь 5-р Далай лам (1617–1682), нөгөөх нь Занабазар бололтой. Хоёулаа очир завилгаагаар суужээ. Занабазар бурхны зүүн мутар талд олбог дээр суусан ба дугуй цацрагийн оронд суудлын түшлэг байгаа нь зураг зурах үед тухайн хүнийг амьд байсныг гэрчилнэ. Очирдара бурхны онцлогийг харуулж зүрхэн тус газартаа баруун мутраараа очир барьж, зүүн мутартаа хонх атгажээ (Зураг 4.1.7в).

“Хаянхирваа” (*самг. хауагтᠦа; төвөд rta mgrin, монг. Дамдин/Хаянхирва*) бурхны шүтээн зурган дээр Занабазар дүрслэгджээ. Тэрээр баруун буланд олбог дээр лам хувцастай, хөх канттай, улаан шар хосолсон донг хувцас, гурван эрдэнийн алтан хээтэй улаан хүрэн шамтав, улбар шар орхимж, хөлийг нь халхалсан шар жанчтай суужээ. Мөн Базарсад бурхны адил баруун мутартаа очир, зүүн мутартаа хонх барьжээ (Зураг 4.1.7г). Лам малгайгүй, том магнайтай, нэлээн халзарсан, том нүүртэй, чихнээс нь харахад дээрх зургууд дээрхээс нэлээн нас тогтсон харагдана. Базарсад бурхны дүр, суудал, суудлын түшлэг, хувцас, зөөлөвч зэрэг дээрх монгол уламжлалт хээ сайн хадгалагдан үлджээ.

Занабазар олон шавь нарынхаа багш тул өөрийгөө Базарсадын дүрээр зурсан нь уг бурхны зан үйлд их ач холбогдол өгч, зөв замаа сонгоход нь зориулж ном сургаалаа айлдаж байсан нь харагдаж байна. Харамсалтай нь Өндөр гэгээний сүмбүм буюу бүтээлийн түүврээс нь Монголын бурхны шашинд байсан Базарсад бурхантай холбоотой зан үйлийн тухай ямар нэгэн тайлбар олдоогүй билээ. Түүний өөрийнх нь бичсэн товч тэмдэглэл мэт бичвэрүүдээс харахад Өндөр гэгээн үг дуу цөөтэй, ном сургаалаа үггүйгээр илэрхийлэх дургтай байжээ.



Зураг 4.1.7а. “Долоон Манал бурхны хүрээлэл дэх Шагжамуни” хэмээх зургийн хэсэг дээрх Занабазар, Зотон, А. Алтангэрэлийн цуглуулга.

Зураг 4.1.7б. “Долоон Манал бурхны хүрээлэл дэх Шагжамуни” хэмээх зургийн хэсэг дээрх Занабазар, Зотон, А. Алтангэрэлийн цуглуулга.



Зураг 4.1.7в. “Цагаан чандмань Махагал” шүтээн зурган дээрх Занабазар. Торго. А. Алтангэрэлийн цуглуулга. Монгол Улс. Зургийг С.С.



Зураг 4.1.7г. “Хаянхирваа” бурхан зураг дээрх Занабазарын дүр. Зотон. А. Алтангэрэлийн цуглуулга. Монгол Улс. Зургийг С.С.

Базарсад бурханд хандуулж байсан Занабазарын энэ их анхаарлын шалтгааныг Буриадын алдартай дандарын лам Бизья Дандароны (1914–1974) туршлагаас харж болох юм. Дандарон буддын шашны мэдлэгээс гадна европ боловсролтой байсан болохоор Орос Улсын дорноос өрнөдөд очиж, буддын шашны багш болжээ. Тэрээр бурханд онцгой их анхаарал хандуулдаг, Базарсад бурхныг багш шавийн барилдлага тогтоох хамгийн сайн арга бөгөөд үүнийг хадгалж, хөгжүүлэхийн тулд тэрээр Шри Базарсад<sup>4</sup> 17 бурхны тусгай сахилын дамжлагыг өгчээ. Түүнээс гадна тэрээр Нацог Рандол Лончен рабжамбын (тиб. sna tshog rang grol, 1308–1363) “Карнатантрын” (төвөд:snying thig, үгч. ‘Мөн чанарын охь’)<sup>5</sup> гүн ухаан, түүх домгийн үндсийн тухай авч үзсэн, Мотлевичийн үздэгээр “төвөдийн бурхны шашны хуучин дэг сургуулийн онол, практикийн үндэс” болох “Забмо янтиг” (төвөд:zab mo yang thig — ‘Нууцын гүнзгий мөн чанар), номыг орос хэлэнд орчуулжээ.

<sup>4</sup> “Вагавана Шри Базарсадын 17 бурхныг бүтээх арга” (тиб. bcom ldan’das dpal rdo rje sems dp’a lha bcu bdun gyi sgrub thabs rab dkar bdud rtsi’i chu rgyun zhes bya ba bzhugs).

<sup>5</sup> Дандар баригдаж, хоёр жилийн дараа шоронд нас барсан болохоор гүйцэд орчуулж дуусгаагүй. Орчуулгын хэсгийг нь В.М.Монтлевич хэвлэж <http://dandaron.ru/rus/theory/karnatantra.html> [Монтлевич 2] сайтад тавьжээ.

Базарсадын гол мөн чанар бол тэр нь ухамсрын ядам ба хамгийн төгс хүний анхдагч дүр юм.

Монголчуудын оюун санааны манлайлагч Өндөр гэгээн Занабазар шавь нарынхаа гүүрү йогийн бүтээл хийхэд нь зориулж өөрийн хөргүүдийг өөрөө бүтээж байжээ. Өөрийн хөргүүдийг нь ерөнхийд нь тоймлон авч үзэхэд нь анхдугаар богд Өндөр гэгээн нь голдуу Базарсад бурхны хувилгаан дүрээр оршдог. Базарсад бурхан нь язгуурын таван бурхан эх үндэс болох хуучин уламжлал ба зогчин дандрын хуучин орчуулгад маш чухал ач холбогдолтой. Базарсад нь мөн төвөдийн бурхны шашны, бусад дэг сургуулиуд тухайлбал, гэлүгвагийн уламжлалд муу үйлийн үрийг арилгадаг маш чухал үүрэг гүйцэтгэдэг юм. Буриадын лам Б.Дандароны бодлоор Базарсад нь багш, шавийн хоорондын оюун ухааны холбоог орон зай, цаг хугацаанаас үл хамааран хадгалж байдаг ажээ.

Хэдэн зуун жилийн турш бурхан зурах тодорхой тигтэй явсаар ирсэн бурхны шашны дүрслэх урлагийн шүтээний шинж чанараас харахад өөрийн гэсэн хөрөг зургийн онцлогтой бурхны бодит хүн мэт хувилгаан дүр нь агаар, орон зай нь эрх чөлөөнд нэвчсэн Монголын нөхцөл ба зураач Занабазарын нөхцөл байдалд бол амьд, бодитой байв. Энд нүүдэлчдийн чөлөөт сэтгэлгээ ба урлаачийн нийгмийн дээд эрх мэдэл хоёрын одод давхацжээ.

### **1.Базардарын дүртэй Занабазарын өөрийн хөрөг**

Занабазар өөрийгөө Очирдара бурхантай төстэй болгож бурханчлан зурсан жишээ. Занабазарын үеэс эхлээд Очирдара бурхныг маш их шүтдэг болсон ба энэ талаар бас домог бий. Анхдугаар богд гэгээний бодит биед оршсон их багш уг биед хэр удаан байхаа тооцоолоод нас барсных нь дараа шавь нар нь багшгүй болно гэдэгт санаа зовж, тэднийг тайвшруулж, гүүрү йог хийхэд тустай хэмээн өөрийн дүрийг Очирдара бурхны дүрээр бүтээжээ. Иймээс Очирдара бурхан Гандантэгчэнлин хийдийн гол шүтээн нь болжээ.

Занабазарын маш гайхамшигтай бүтээсэн өөрийнх нь дүр 2016 онд Хятадад China Guardian дуудлага худалдаан дээр гэнэт гарч иржээ. Зарим мэдээллээс харахад энэхүү баримал Оросын хувь хүний сангаас ийшээ орж иржээ. Энэ бүтээлийг “Лам. Занабазарын цутгамал” (1635–1723) нэртэйгээр дуудлага худалдааны бараа хэлбэрээр 73 сая юаниар зарагджээ. Уг дүр лам хувцастай, урт чихтэй малгайтай ажээ (Зураг. 4а-г). Очир

завилгаагаар суусан, баруун мутартаа очир, зүүн мутартаа хонх барьж цээжнийхээ өмнө зөрүүлж барьжээ.



Зураг.4.1.8а-г. Занабазар (1635–1723). Өөрийн хөрөг. Баримал, цутгамал, хүрэл, алтадсан. А) Баримлын нүүрэн хэсэг; б) зүүн талаас нь харсан хэсэг; в) баруун талаараа хагас эргэсэн байдал; г) ар талаасаа. Хэвлэгдсэн: [Global Chinese 2016: 70].

Занабазар Очирдара бурхны хувилгаан дүрээр дүрслэгджээ. Хувилгаан дүр гэдэг нь бурхны шавь нарынхаа нүдэнд бодитоор, энгийн хүний байдлаар харагддаг дүр юм. Уг лам багшийн дүрийг бурхан зурах тиг зурагт тохируулан хийсвэр болгосон ч Занабазарын хөрөг зургийн шинж чанарууд, бусад хүмүүсийн дүртэй харьцуулсан хувь хүнийх нь онцлогийг олж харахад тун хялбар. Уг ламын царай маш гүнзгий анхаарлаа төвлөрүүлсэн, өдөр тутмын амьдралаас тасарсан, амгалан тайван байдалтай ажээ. Энэ байдлыг энгэртээ хоёр мутраа зөрүүлж, сэтгэлийн хөдөлгөөн, элдэв мэдрэмжээ тогтоон барьсан очир зангилаа үүсгэн улам тодотгожээ. Бүйлсний үр мэт хэлбэртэй том мэлмийгээрээ чанх урагш чиглэсэн боловч гаднах зүйлийг бус харин дотогшоо чиглэсэн ба царайн дээр нь ганц ч булчин нь чичигнэхгүй ажээ. Лам өргөн цээжтэй, хүчтэй булчинлаг нуруутай ажээ. Түүнийг эгц урдаас нь аливаа гадаад нөлөөг хаасан мутар, бойвных нь байрлалыг харахад бүрэн дүүрэн амар амгалан, анхаарал төвлөрөлт, бясалгал, эглийн үймээн бужигнаанаас хэлбэрэлтгүйгээр салсан нь харагдана. Гэхдээ хэрвээ энэхүү баримлыг ар нуруунаас нь харвал булчинлаг огт өөр дүр зураг олж харна. Эр хүний аазгай хөдөлгөсөн булчин шөрмөс нь зангирсан, хүдэр чийрэг, уян хатан, хүчирхэг нуруугаа бага зэрэг бөхийлгөжээ.

Энэ баримал нь өрнөл хөгжил дүүрэн амьдралтай, маш гоо үзэсгэлэнтэй биетэй, энэхүү бургилсан эрч хүчээ оюун ухааны өөр эрчимд хувиргаж чадсан залуу лам хүний асар их сэтгэлийн хүчийг гайхамшигтай бодитойгоор харуулж чаджээ. Зөвхөн агуу бөгөөд зүйрлэшгүй их зоригтой, нээлттэй ухамсартай урлаач л бурхны дүрээр эсрэг тэсрэгийн нэгдэл тэмцэл, бие бялдрын ба оюун ухааны ухагдахуунуудыг сүлжилдүүлж, оюуны асар том хөдөлмөрийг харуулж, үүгээрээ амьдралдаа хурааж хуримтлуулсан туршлагаа илэрхийлж чадна.

Ламын хувцасных нь нугалаасууд зөөлөн, уян хатан яг өөрөөрөө дэлхийн татах хүчинд доош татагдан унжсан мэт харагдана. Бадамлянхуа цэцгэн суурь нь Занабазар маягийн уламжлал ёсоор монголын тайгын хуш модны боргоцойн хээ мэт дэлбээтэй цэцгийн цоморлиг хэлбэртэй. Энэхүү баримлыг маш товч тодорхой, бараг харам хандсан мэт урлаач маань өөртөө маш их итгэлтэйгээр, ганц ч илүү, дутуу зураас гаргалгүй бүтээжээ. Гэвч энэ байдал нь гайхамшигтай амьд бодит байдал, хувь хүний онцлогийг хурц тодоор харуулахад нь огт саад болоогүй ажээ. Тэгээд нөгөө л өө сэвгүй, цэвэрхэн зураас нугалаасууд, хэсэг тус бүрийн нарийн нямбай ажиллагаа харагдана.

Зураг.4.1.8д. Очирдара бурхны дүрд хувилсан Занабазарын өөрийн дүр: ерөнхий байдал. Augum, Cina Guardian үзэсгэлэн худалдаа 2016 [[The First Jebtsundamba Khutughtu. Cina Guardian Auction. 2016](#)]

### **1.“Гурван лагшингийн төгс чанар” хэмээх шүтээн зураг**

#### **Б.Амарсанаагийн цуглуулга дахь Занабазар ба түүний өмнөх 14 дүр**

Энэхүү шүтээн зургийн голд Занабазар байх ба түүнийг тойроод 19 дүр байна. Бүтээлийг тод шороон будгаар зурж, маш нягт алтдаж, чимэглэлийг маш нарийн бийрээр алтаар зуржээ. Хэвтээ болон босоо чиглэлийн зохиомж нь маш тодорхой харагдана. Зургийн дээд хэсгийн гуравны нэгд нь номин хөх тэнгэр, дугуй цагаан үүлстэй. Дээд хоёр буландаа зурагтай: баруун талд нь алтан цацрагтай улаан нар, зүүн талд нь мөнгөн сартай. Төв хэсгийн хамгийн оройд нь яв юм (эцэг, эх) хэмээх тарнийн хос байна. Тэнгэрийн хэсэгт байгаа бусад найман дүр нь Амитаба бурхан, Амитаюс бурхан, эртний зургаан багш бөгөөд тус бүртээ үүлэн дээр хагас дугуй үүсгэн байрлажээ (Зураг 4.1.9).



Зураг 4.1.9. Шүтээн зураг. Торго, шороон будаг, алтадмал. Хэмжээ: 45,0 x 30,0 см. Хүрэн өнгийн торгоор эмжсэн. Монгол Улс. Б.Амарсанаагийн цуглуулга.

Шүтээн зургийн дээд хэсгийн голд Дэмчиг<sup>6</sup> хэмээн ядам бурхан Юмын хамт дүрслэгджээ. Энэ бол түүний нэг хэлбэр болох Дэмчиг Гарва Цэдүв буюу урт насны бэлгэдэл Цагаан Дэмчиг (төвөд: *bde mchog dkar po tshe grub*) юм. Түүний гол үүрэг нь үхлээс мулталж, урт нас өгөх юм. Тэрээр цагаан өнгийн лагшин, нэг нигур, хоёр мутартай ба харваачийн зогсолтоор (*самг. ālidhāsana*) зогсож, зүүн хөлөө бага зэрэг нугалан улаан Каларатригийн цээжин биеийг тулж, хөлрүүгээ чиглэсэн баруун мутраараа хар Бхайравын толгойг түшжээ. Ууц бүсэлхийн дээрээ барын арьс уяжээ. Базарварахи хэмээх улаан юм (*самг. Vajravāhī, төвөд rdo rje phag mo* (Доржпагма)) тэвэрч, нурууных нь ард зөрүүлсэн хоёр мутартаа очир, хонх барьжээ.

Доржпагма зүүн хөлөн дээрээ зогсож, баруун хөлөөрөө эцэг бурхны бэлхүүсээр ороож, рашаан дүүргэсэн аяга барьсан зүүн мутраараа Дэмчиг бурхныг хүзүүгээр нь тэвэрч, баруун мутартаа дигүг хутга дээш өргөн барьжээ. Хөлөн доорх суурь нь улаан

<sup>6</sup> Дэмчиг - *самг. sakrasamvara, төвөд 'khor lo sdom pa / 'khor lo bde mchog, үгч.* “Дээд амгалангийн тойрог” нь эхийн тарнийн төрөл буюу Ануттара-йог тарнийн ангид харьяалагддаг. Дэмчигийн тарнийг Шагжамуни бурхан Удияна хэмээх дагинасын оронд байхдаа айлджээ. Базарварахийн дагинууд Луиба (VI-VII в.) хэмээх бясалгагчид өөрсдийн номыг дамжуулж, Луйба цааш нь Энэтхэгт түгээжээ. Махасид Луиба нь чакрасамбараг бясалгах анхны ёсыг бичиж, үүнийгээ Дарикед (Салипутры Индрапала хаан хэмээн алдаршсан) ба түүний сайд Тенгипад өргөжээ. Тенгипа нь Диловад, Дилова нь Наровад дамжуулж, Наровагаас орчуулагч Марво (1012-1097 он) тэргүүтэй төвөд шавь нарт нь дамжжээ. Дэмчигийн тарни нь долоон зуу орчим шүлэгтэй ба “Маха йогини тантра раджа” и “Шри Херуга бидхана” янз бүрийн нэртэйгээр явж ирсэн бөгөөд Херуга нь мандлын гол бурхан нь юм. Грейгийн хэлснээр энэ тарнийг төвөд хэлэнд дор хаяж хоёр удаа орчуулж, төвөд хэлнээс монгол, хятад хэлэнд орчуулагдсан ба уйгур хэлээр бас орчуулга байдаг [Gray, 2007; Панчен-лама, 2020].

өнгөтэй байгаа нь дүрэлзэн байгаа цэцэн ухааны галыг илэрхийлж, интоорын өнгөт ар талын мандорл нь алтан эмжээртэй ба ядам бурхны биеэс цацарсан алтан цацрагуудтай. Оройн гэрэл нь дугуй цайвар ногоон өнгөтэй. Таван гавлын яс бүхий тэтимтэй, зургаан төрлийн ясан чимэгтэй, өндөр овоолсон үсээ сар ба зөрүүлсэн очроор чимжээ.



Зураг 4.1.9а

Шүтээн зургийг гурав хуваасны голын төв хэсэгт Занабазарын том хөрөг байна. Төвөдийн хуйлдаг бурхан бүтээх тигээр авч үзвэл маш ер бусын. Занабазар отрын жижигхэн гэр дотор сууж буй мэт бөгөөд гэрийн<sup>7</sup> үүд улаан хөшигтэй, хөшгийг хоёр тийш нь ярж, цагаан хадгаар уяжээ. Занабазарын хөлөө хучсан, олбог харагдахгүй байна. Баруун мутартаа очир атгаж, зүрхэн тус газартаа барьж, зүүн мутартаа хонхыг дээш харуулан атгаж өвдөг дээрээ тавьжээ. Гэлүгвагийн лам хүний улаан-улбар шар хувцас өмсөж, мөрөн дээгүүрээ улбар шар орхимж тохжээ. Араас нь цагаан хадгаар ороож, торгон унжлага унжуулсан суудлынх нь шар түшлэг харагдана.

Занабазарын нигур нь цав цагаан байгаа нь шүтээн зургийн тод дэвсгэртэй хоршиж, босоо шугамуудын гол хэсэгт, харин хэвтээ шугамуудын дээд хэсэгт хөх тэнгэр ба доод талын ногоон ургамлуудын завсарт байна. Энэ дүр түүний бусад олон зургаас ажиглагддаг хөргийн шинж чанаруудыг хадгалжээ. Нээлттэй, дугуй нигуртай, халзарсан том магнайтай, том бүйлсэн нүдтэй. Бор хүүхэн харааг нь маш нарийн гаргасан, тайван, нэвт шувт харцтай, гадаад ертөнц рүү ч, дотоод сэтгэл рүүгээ ч харц нь нэгэн зэрэг чиглэжээ.

<sup>7</sup> Монг. жодгор (sog po'i rhyid gur), цацар, асар, майхан (төвөд: rgya gur - жа гүр) – аян зам болон яаралтай нүүж яваад хоноглохдоо барьдаг авсаархан гэр майхан.





Зураг 4.1.96

Гэрийн улаан оройн дор, гэгээний толгой дээр улбар шар хувцастай алтаар зурсан Шагжамуни бурхны дүр байна. Бурхан багш цагаан бадамлянхуа цэцгэн дээр сууж, биенээс гарсан алтан цацрагтай гэрэл хар хөх дугуй дээр харагдах ба тэргүүнийг нь тойрсон дугуй цайвар ногоон өнгөтэй ажээ. Шүтээн зурагнаас янз бүрийн өнгийн хадаг зүүжээ. Гэрийн дотор хананд алтан хээтэй хар хөх торго татжээ. Гэрийн дээврийг номин хөх, ногоон өнгөтэй хөшгөөр халхалжээ. Хувцас, гэрийн эд хэрэглэл нимгэн алтан хээтэй. Бурхны дүр Дэмчигийн яг доор Занабазарын яг дээр нь байрлаж, босоо чиглэлийн зохиомж үүсгэсэн ба энэ босоо чиглэлийн хамгийн доор буюу төгсгөлд нь эд баялагийн бурхан Замбал бурхан байна. Занабазарын өвдөгнөөс доош Замбалын тахилын аяга хүртэл цагаан хадаг унжуулжээ.



Зураг 4.1.9в

Шагжамуни бурхантай уртаашаа нэг шугамд зүүн гар талд нь гэрийн гадна тэнгэрт цагаан үүлэн дээр лам хувцастай Авид бурхан, баруун гар талд нь найман төрлийн хааны чимэгтэй, торгон хувцастай Аюуш бурхан байна. Тэр хоёр хоёулаа улаан лагшинтай, алтан гэгээрлийн гэрэлтэй, улбар шар лагшингийн гэрэлтэй Амитаба бурхны оройн гэрэл нь оюу өнгөтэй, харин Амитаюс бурхных далайн давалгааны ногоон өнгөтэй ажээ.



Зураг 4.1.9г. Шүтээн зургийн хэсэг, Авид бурхан  
бурхан



Зураг 4.1.9д. Шүтээн зургийн хэсэг, Аюуш

Шүтээн зургийн голын хэсэг бол газрын хэсэг юм. Монголын намхан толгодууд, хар ногоон мод бут харагдана. Энэ орон зайд, толгодын дунд найман багш суугаа бөгөөд тус бүрдээ өөрийн гэсэн шинж чанартай нигур, хувцас, удам судар, эрх мэдэл, намтрууд нь ялгаатай ажээ.



Зураг 4.1.9е.

Шүтээн зургийг гурав хуваасны хамгийн доод талын дэвсгэр өнгө гүн хөх бөгөөд яг энд л бүх махбодиудын үүсэн гарсан сүүн тэнгис буюу мөнхийн ус, анхдагч далай дүрслэгджээ. Далайн голд Занабазарын хөлийн орчимд майга хөлтэй, амьтны дүрстэй хээтэй ширээ байх ба дээр нь эрдэнэсээр дүүргэсэн гурван улбар шар монгол аяга тавьжээ. Хамгийн доод эгнээнд цагаан бадамлянхуа цэцгэн дээр эд баялагийн бурхан Замбал амар тайван байдалтай суух ба гэдэс цээжээ ил гаргасан, том гэдэстэй, тод улаан доть, ногоон дагамтай ажээ. Түүний урд элдэв өнгийн эрдэнэсээр дүүргэсэн бас нэг улбар шар аяга, таван мэдрэхүйд зориулсан таван бадар аягатай өргөл, дамар, зэс тавагнууд гэх мэт зан үйлд хэрэглэдэг хөгжмийн зэмсгүүд байна. Гэрийн зүүн гар талд бас нэг жижигхэн ширээн дээр урт хөлтэй хоёр аяга тавьжээ.

Хагас бөмбөлөг хэлбэртэй гэрийн орой нь хангалттай чөлөөтэй байрлалтай, бүгд төв хэсэг рүүгээ харсан арван дөрвөн багштай нийлээд тойргийн дөрөв хуваасны гурвыг эзэлж байгаа бөгөөд энэ нь монгол ноёдын нүүдлийн орд өргөөнүүдийн дугуйрсан хэлбэртэй адилхан зохиомжтой ажээ. Энэхүү шүтээн зурган дээр Занабазарыг оруулахгүйгээр 14 багш, таван бурхан байна.

Занабазарын намтартай холбоотой бичгийн эх сурвалжуудад түүний урьдын дүрүүдийн нэрсийн хувилбаруудыг бичсэн байдаг. Жишээ нь, Занабазарын соёмбо үсгээр бичсэн “Жавзундамба хутугтын цадиг”-т Дарнатыг оруулаад 15 нэр байна [Бямбаа 2005].

Жатака гэдэг нь түүхийн янз бүрийн үед төрсөн гэгээрэгчид, хувилсан дүрүүд, янз бүрийн хүмүүсийн тухай өгүүлүүд юм.

“Төрөл үеийн залбирал” (монг.: *töröl üее-yin jarbiral*)<sup>8</sup> гэж нэрлэгддэг монгол хэлээр бичигдсэн байдаг. Үүнийг бүтээхийн тулд “Джатака мала сугитикатха”<sup>9</sup> хэмээх Дарнатын жэйравын төвөд бичвэрийг хэрэглэжээ. Уран зургийн дүрүүдийг харьцуулахад ийм эх сурвалж зайлшгүй хэрэгтэй, учир нь эдгээрт шүтээн зурган дээрх дүрүүдийн хийдэг ажил, ялгарах онцлогуудын тухай бичигдсэн байдаг. Заримдаа бичвэрүүдийн дэргэд бурхны зураг, багш нарын зураасан зураг байдаг нь харж байгаа дүрийг тодорхойлох ажлыг хөнгөлж өгдөг. Энэ тохиолдолд бурхадын зураг байгаа болохоор тэднийг шүтээн зурган дээрх бурхдыг зөв тодорхойлж, нэрийг нь олох боломж өндөр байв.

Тэгэхээр, Занабазарын түүх Шагжамуни бурхны үеэс эхэлсэн ба Бурхан багшийн анхны шавь нарын дунд Сувишудха мати гэгч байжээ. Монголчууд түүнийг Маш тийн ариун оюунт оюунту (*самг. Suvisuddhamati*; төвөд: *Shin tu blo gros rgyal mtshan*; монг.: *Maši tein arigün оуо-tu* - Лодой Ганден Намдак) гэдэг. Маш тийн ариун оюунт шүтээн зургийн зүүн дээд буланд цагаан үүлэн дээрх олбогон дээр лам хувцастай (тричивара) морилжээ. Толгой, мөрөө орхимжныхоо үзүүрээр хучжээ. Түүний баруун талд буддын шашны номын түүврийн бэлгэ тэмдэг болсон номын шогол харагдана. Тэргүүнийх нь ард алтан цагариг бүхий цайвар ногоон өнгийн дугуй байна. Яг энэ дүр Өндөр гэгээн Занабазарын анхны дүр юм. Гэхдээ төвөдийн бичгийн эх сурвалжид Таранататхе Сувишутхийн эхийн тухай дурдаагүй байдаг ба Таранатхийн жатака Барбаи цовоогоос эхэлсэн байдаг.

---

<sup>8</sup> Номын эхний хуудсан дээр “*pandita bar-bai döbö kemegdekü-yin olan ögüleg-sen oruśibai*” гэж бичсэн нь энэ түүврийн анхны жатакын нэр юм.

<sup>9</sup> *самг.:* *dza ta ka ma'a la su gi'i ti ka tha*; тиб.: *skyes pa'i rabs kyi phreng ba legs brjod pa'i gтам // xyl. 366 ff.* Энэ бичвэр төвөд хэлээр бичигдсэн ба хятадын цагаан будаанаас гаргасан цаасан дээр 366 хуудсаар бичигдсэн, бээжингийн бараар хэвлэгдсэн. Энэ түүвэр тус бүртээ бие даасан нэртэй “Нэрсийн магтаал” бүхий 12 бүлэгтэй, хуудсуудыг нь тусад нь дугаарласан, өөр өөр зохиогчидтой байж болзошгүй, гэхдээ бүлгүүдэд энэ тухай заагаагүй байна. Хамгийн эхний хуудсан дээр *paN+Di ta 'bar ba'i gtso bo'i rtogs pa brjod pa'i yal 'dab sogs* – “Барбаи цогпа бандидын магтаал”. 13-р бүлэг нь “Дарнатын нууц намтар” гэсэн нэртэй байв. Энэхүү ном Монголын үндэсний номын санд хадгалагддаг (цаашид МҮН), Улаанбаатар хот. Internet Archive Python library 1.8.5. Scanned at the National Library of Mongolia in collaboration with Asian Classics Input Project and with generous support from Khyentse Foundation. Electronic reproduction. Cambridge, Mass.: Buddhist Digital Resource Center сайтаас харж болно.



Зураг 4.1.9ж.

**Бадрангуйн эрхэн/бандида буюу Барбаи цовоог** (монг.: маᠨ-lai Ba-da-raᠭ-gūi; төвөд: 'Bar ba'i gtsog pa) Занабазарын шавь нар түүний хоёр дахь дүр гэж үздэг. Төвөдийн “... магтаал” түүвэрт эхний бүлэг ка<sup>10</sup> түүнд зориулагдсан бөгөөд түүнээс Даранатын хэд хэдэн хойд дүрүүд гарчээ. Барабаи цовогийн хөргийг 2-р хуудсанд байрлуулжээ. Тэрээр цэцэглэсэн модны дор, лам хувцастай, бодь сэтгэлийн ном барьсан ба ард нь шогол харагдана.

Занабазарын соёмбо бичгээр монгол хэлээр бичсэн жэйравт Барбаи-цово Энэтхэгт Нагаржунагийн үед (МТӨ II зуунд) амьдарч байсан хэмээн бичжээ [Бямбаа 2005, с. 74].

Шүтээн зурган дээр тэрээр хууз сахалтай, том бөөрөнхий нүдтэй лам хүний улаан хувцастай, улбар шар олбог дээр чөлөөт байдлаар сууж, зүүн мутартаа бодь сэтгэлийн ном барьжээ. Ар нуруунд нь номын тагтай сагс харагдана.

<sup>10</sup> Инв. №M0058468-001 объем 15 лл. (dza ta ka ma'a la su ga'i ti ka tha, часть1). НБМ, Улан-Батор.



Зураг 4.1.9з. Шүтээн зураг БА-2. Зургийн хэсэг.



Зураг.?? paN+Di ta 'bar ba'i gtso bo'i rtogs pa brjod pa'i yal 'dab sogs. Том КА. Инв. №М0058468-001. Л.2а.

**Махасиддха Кришначарья** (*самг.* Mahāsiddha Kṛṣṇācārya, *монг.*: ye-ke ši-di-tü Ka-la-sa-ra-ya; *төвөд:* grub chen Nag po spyod pa) нь монгол нэрсийн дотор гуравдугаар дүр, төвөд бичвэрт хоёрдугаар дүр гэж бичжээ. Тэрээр төвөд барын эхний хуудсан дээр хүний арьсан хөдрөгтэй, өвдөг дээгүүр нь бясалгагчийн бүс тавигджээ. Баруун мутартаа гавал аяга барьж, тохойндоо гурван шүдтэй сэрээ тулжээ. Зүүн мутартаа дамар барьсан ба агаарт нисэж байгаа шүхрүүдийн нэг нь толгой дээр нь тогтжээ. Ар нуруунд нь номын тагтай сагс харагдана. Ууланд хадан дээр морилжээ<sup>11</sup>.

Монгол цадигт Энэтхэгийн 84 шидтэний нэг болж, төрөл бүрийн шид үзүүлж Кришначарья нэрээр алдаршсан гэж бичжээ [Бямбаа 2005: 74].

Шүтээн зурган дээр дандрын ёсны бүжиг хийсэн байдлаар, өгзөгний улаан халхавчтай, урт хар үсээ ар шилэндээ овоолсон, мутартаа дамар, гурван шүдтэй сэрээ барьж, толгой дээрээ таван давхар шүхэр ба ялж төгссөний бэлгэдэл дуаз барьжээ. Ар нуруунд нь номын тагтай сагс харагдана.

<sup>11</sup> nag po spyod pa'i rtogs pa brdzod pa'i yal 'dab bzhugs so/ xyl. 30 ff. инв. №М0058468-002. НБМ, Улан-Батор.



Зураг 4.1.9и. Махасиддха Кришначарья. Шүтээн зураг. Зургийн хэсэг



Эд. №М0058468-002. Том КНА. Л. 1а.

Дөрөвдүгээр дүр нь **Их Радна** (самг.: mahāratna; төвөд: Ratna chen po; монг.: ye-ke Rat-na;). Төв түүвэрт түүний тухай КНА 3-р бүлэгт<sup>12</sup> бичсэн байна. 1а гэсэн хуудсан дээр модны дор мөчир дэвссэн суудал дээр очир завилгаагаар сууж, мутар нь бясалгалын мутарлагатай (дхьяни-мудра) байрлуулж, дээр нь урт хүзүүтэй ваар тавьж, ардаа номын тагтай сагс үүрсэн хүний зургийн доор Радна бакула гэдэг нэр бичжээ. Амьтны арьсан хувцас өмсжээ.

Монгол цадигт болохоор энэ дүрээ олж төрөхдөө Их Радна хаан хүний гэрт төрж, амьтан хүнд маш их тусалжээ [Бямбаа 2005: 74]. Энд авч үзэж байгаа шүтээн зурган дээр нэг дүр байхгүй байгаа нь Радна бакула бололтой.

<sup>12</sup> ra'a tna bha hu la'i rtog pa brjod pa'i yal 'dag / xyl. 4 ff. инв. №М0058468-003. НБМ, Улан-Батор





Зураг 4.1.9п

**Дармабадра** (*самг.*: Dharmabhadra; *монг.*: Dar-ma-ba-da-ra; *төвөд*: Rong zom chos bzang) нь монгол нэрсийн жагсаалтаар бол тав дахь дүр бөгөөд харин төвөд “...магтаал”<sup>13</sup> түүвэр дээр бол 4-р бүлэгт түүний тухай бичсэн ажээ. Тэрээр Адишагийн (982-1054) үед Ронг (Бутан) гэдэг газарт төржээ. Барласан номын 1а хуудсан дээр модны дор сэнтий дээр лам хувцастай хөлөө хувцасныхаа хормойгоор хучсан, зүүн мутартаа бодь сэтгэлийн ном, баруун мутартаа өдөн үзэг барьсан хүн зуржээ. Зүүн гар талд жижиг ширээ, ширээн дээр бумба тавьжээ. Үсээ толгой дээрээр хоёр эвэр мэт мушгин овоолжээ.

Монгол цадигт түүнийг бага байхад нь ээж нь тэр үед Төвөдөд морилж байсан Адиша дээр аваачихад Адиша түүнийг Энэтхэгийн эрдэмтэн Калачарьи (Кришначарьи)-ын хойд дүр байна гэжээ. Тэрээр Ганжуур, Данжуураас олон номыг төвөд хэлэнд орчуулжээ. Куннаре Дхармабхадра бандид хэмээн алдаршжээ [Бямбаа 2005: с. 74; rong zom., л. 2а-2г].

Шүтээн зурган дээр тэрээр олбогон дээр лам хувцастай сууж буй бөгөөд тэргүүнээс цацрах гэрэл нь алтан хүрээтэй улаан өнгөтэй, том нүдтэй, том хамартай, богино хар үстэй ажээ.

<sup>13</sup> Хул. 4 ff. Инв. М0058468-004. Раздел DA. НБМ, Улан-Батор.



Зураг 4.1.9к. Раднаачэнбо



Зураг 4.1.9к\*

Зургаа дахь дүр **Дармаваанчиг** (монг.: Dar-ma-dbang-phyugs; төвөд: Dar ma dbang chug) Дагво Ринбүчийн (1079-1153) шавь байжээ. Түүнд “Дармаваанчигийн магтаалын”<sup>14</sup> СА 5-р бүлгийг зориулжээ. Төвөд бичвэрийн 1а хуудсан дээр ардаа түшлэгтэй өндөр сэнтий дээр лам хувцастай сууж, хөлөө хучсан мөрийг нь дарсан урт хар үстэй, толгойныхоо ард дугуйтай, ард талдаа үүлстэй ажээ.

Монгол цадиг дээр Дармаванчигийг зургаадугаар дүр, төвөдийн Дагва ламын үйл хэргийг үргэлжлүүлэгч хэмээн бичжээ. Бүх шидийг эзэмшсэн байжээ. Тухайлбал, домогт бичсэнээр, таягийг харсан нохдыг айлгахгүйн тулд модон таягаа туяхан өвс адил нугалж байжээ.

<sup>14</sup> Тиб.: ‘bab rom ba dar ma bang byug gi rtog pa brjod pa’i yal ‘dab/ Хул. СА // 8 ff. Инв. М0058468-005. НАБ, Улан-Батор.



Зураг 4.1.9л

Зураг 4.1.9\*

Долоо дахь дүр **Одсэрбал** (монг.: Ge-rel-cog-tu; төвөд: 'Od zer dpal) Сажын багш Дагважалцангийн (1147-1216) шавь байжээ. Төвөд эх “... магтаал”-д түүний самгарди ба төвөд нэр нь **Авадхути**, Осербал<sup>15</sup> юм. 1а хуудсан дээр өндөр сэнтий дээр лам хувцастай сууж, хөлөө хучсан, зүүн мутартаа бадар аяга барьж, баруун мутраа аймшиггүйн мутарлагаар өргөжээ. Малгай өмсжээ. Толгойн ард дугуйтай. Ар талд нь хурц оройтой уулс, зүүн гар талд мод харагдана.

<sup>15</sup> Тиб.: A wa dhu'u ti 'od zer dpal gyi rtogs pa brjod pa'i yal 'dab. Часть 6. ChA. Хул. 3ff. Инв. M0058468-006. НБМ, Улан-Батор.

Монгол цадигт их мэдлэгтэй Одсэрбал маш даруухан, ууланд даяанчилж суудаг байсан гэжээ. Сажын Дагважалцан түүнд багш болох цаг чинь болсон гэхэд арай бэлэн болоогүй байна, бусдыг сургахаасаа өмнө өөрөө сурах юм их байна гэж байжээ. Удалгүй тэр нирвааныг олжээ. Түүний гавлын ясыг нээж үзэхэд дотор нь Дэмчигийн мандлыг сийлсэн мэт болсон байжээ. Иймээс түүнийг гайхамшигт багш Одсэрбал гэдэг.

Шүтээн зурган дээр тэрээр урт хар үснийх нь нэг хэсгийг овоолж, ясан чимгээр тогтоогоод, нөгөө хэсгийг нь мөрөн дээрээ сул хаясан байдалтай зурагджээ.



Найм дахь дүр нь **Луун дуут** (монг.: *Lō da-go-to do-ja*; төвөд.: *’Brug sgra rgyal mtshan*) юм. Төвөд эх дээр түүнд 7-р бүлгийг зориулсан ба түүнийг Жан<sup>16</sup> гэдэг газар төрсөн гэжээ. Түүнийг 1а хуудсан дээр дүрсэлсэн бүтнээр нь хуулсан амьтны арьсан дээр чөлөөтэй байдалтай сууж, ард нь уулын байгаль харагдсан байдлаар зуржээ.

Монгол цадигт түүнийг Төвөдөд Жан гэдэг газар төрсөн ба Ямандагийн бүтээл хийхдээ үр дүнд хүрсэн гэж бичжээ. Нэгэн удаа Луун дуут лам Их бурханд мөргөх зорилгоор Лхас орох хэрэгтэй болжээ. Тэгээд мөргөчихөөд буцах гэж байхад нь хийдийн нэг баримал амилж түүнийг Нял хэмээх газарт очих хэрэгтэй гэжээ. Тэнд очоод хамгийн захын нэгэн эмэгтэй амьдардаг байшинд буудаллажээ. Тэгээд өөртөө цай чанахаар худаг руу тонгойтол нэгэн навч байхаар нь гаргаж ирээд зүүгээр хатгаад орхижээ. Тэгтэл гэрийн эзэгтэй нүүрнээсээ цус асгаруулсаар гүйж ирээд, миний буруу байхгүй, намайг дэмий л алж байна даа гэжээ. Лам дахиад л нөгөө навчийг зүүгээр хатгахад эмэгтэйн нүүр шархгүй мөртлөө бүр их цус оргилжээ. Тэгээд чи биш юм бол өөр хэн буруутай юм бэ гэж лам асуужээ. Би эзний тушаалыг л биелүүлдэг тэр баруун зүгт байгаа, нар жаргахаар ирнэ гэж хэлжээ. Лам Ямандагийн дүрд хувилаад эзнийг нь хүлээжээ. Харуй бүрүй болоход нөгөө хүн хүрч ирэхэд лам илдээрээ цавчиж арьсыг нь хуулж аваад тулам хийжээ. Тэгээд жил ч болоогүй байхад нөгөө эмэгтэй нас баржээ. Тэр цагаас хойш тэр нутгийн хүмүүс элбэг хангалуун, баяр баясгалантай амьдардаг болсон ба лам Жангийн Самбуце, Луун дуут туг гэж алдаршжээ.

Шүтээн зурган дээр тэрээр домгийн аварга амьтны цагаан арьсан дээр суусан сайхан залуугийн дүртэй бүтээгджээ. Зиндаа өндөр ламын том хүрээтэй малгай, торгон хувцас, мөрөө давсан урт үстэй ажээ.

<sup>16</sup> Zhang ‘brug sgra rgyal mtshan gyi rtogs pa brjod pa’i yal ‘dab / раздел DA. xyl. 4 ff. Инв. M0058468-007. НБМ.



Зураг 4.1.9н Другда жалцан

Зураг.4.1.9н\*

Есдүгээр дүр нь **Бурхан бүст** (монг.: Bor-gaṅ ye-ke buṣ-tü; төвөд: Sang rgyas ras chen) гэдэг нэрээр алдаршсан. Төвөд эхэд нэг бүлгийг **Нэйчэн жалбо**<sup>17</sup> гэгчид зориулжээ. Барласан номон дээр өндөр түшлэг, тохойвчтой сэнтий дээр морилсон лам байдлаар дүрсэлжээ. Өндөр оройтой эргүүлсэн хүрээтэй малгай өмсжээ. Толгойнхоо ард тойрогтой, ард нь хад асга үүлс харагдана.

<sup>17</sup> Тиб.: gnyos chen po rgyal ba lha nang pa'i rtogs pa brjod pa'i yal 'dab. NYA. Хул.12 ф. Инв. М0058468-008. НБМ



Зураг 4.1.9о

Зураг 4.1.9о\*

Монгол цадигт энэ дүрээрээ Төвөдөд төрсөн, хоосон чанарыг маш сайн бүтээсэн, бүх шидийг эзэмшсэн гэж бичжээ. Түүнийг аагим халуунд үстэй, дулаан хувцас өмсөж, хар хүйтэнд нимгэн цамцтай явж биеэсээ дулаан ялгаруулж чаддаг гэж ярьцгаадаг байв. Ноёдын хаан, их бурхан гэж алдаршжээ.

Монгол шүтээн зурган дээр ламын улаан, улбар шар хувцастай, толгойдоо шовгор малгайтай, баруун мутраа зүрхэн тушаа газартаа номын хүрд эргүүлнэ гэсэн утгатай мутарлагаар барьжээ.

Аравдугаар дүр **Сангабадра** (монг.: Saṅ-gā-ba-dar (самг.: Sanghabhadra) гэдэг нэртэй байв. Төвөд эх дээр түүнд есдүгээр бүлгийг зориулсан ба түүнийг бүхнийг хөтлөгч<sup>18</sup> хэмээдэг ажээ. Номон дээр олбог дээр морилсон, орхимжныхоо үзүүрээр толгойгоо халхалж, мутартаа эрих барьснаар зуржээ. Шүтээн зурагны ар дэвсгэр нь уулын байгаль ажээ.



Зураг 4.1.9п



Зураг 4.1.9п\*

Цадигт энэ дүрээрээ Төвөдөд төрсөн, зургаан зүйл амьтанд тоолж баршгүй олон удаа тусалсан, Бурхны сургаалыг гүн гүнзгий судалсан, мэдлэг түгээж, ард түмнийхээ үнэнхүү чимэг болсон гэж бичжээ. Сангабадра нэрээрээ алдаршсан.

Шүтээн зурган дээр олбог дээр морилж, улаан улбар шар хувцас өмсөж, урт хар үсээ төвөд маягаар арагш унжуулж, толгойгоо бөхийлгөн, мутартаа урт бодь ном эсвэл самбар бариад саваагаар юм бичиж суугаагаар дүрсэлжээ.

<sup>18</sup> Тиб.: kun mkhyen sanggkha bhadra'i rtogs pa brjod pa'i yal 'dab. Хyl.8 ff. Инв. M0058468-009. НБМ.



**Арван нэгдүгээр дүр нь** монголчуудын **Жамьян цорж** (монг.: Jam-yaṅ ṣog-je; төвөд: 'Jam dbyangs chos rje) гэж нэрлэдэг төвөдийн алдарт эрдэмтэн юм. Төвөд эх дээр аравдугаар бүлгийг түүнд зориулжээ<sup>19</sup>.

Барласан зураг нь бурхны тигийн дагуу яг өмнөөс нь харж зуржээ. Жамьян Дашбалдан дэлгэрсэн дэлбээтэй бадамлянхуа цэцгэн дээр лам хүний бүрэн хувцастайгаар морилжээ. Неринг хэмээх шовх оройтой малгай өмсөж, зүрхэн тушаа газраа мутартаа бадамлянхуа цэцгийн ишнээс барьсан байх ба цэцгэн дээр баруун талд нь Манзушри, бурхны цэцэн ухааны бэлгэдэл илд, зүүн гар талд нь ном тавьжээ. Гэлүгбагийн дэг сургуулийн тэргүүн Зонхавааг мөн ийм байдалтай дүрсэлдэг.

Энэ дүрээрээ Төвөдөд төрж, үлэмж их номыг цээжилж, эзэмшиж, олон шавь нартаа ном айлдаж, номд нэвтрэн хэрэгжүүлж чаджээ. Богд Зонхава түүний мэдлэгийг маш гүнзгий гэдгийг харуулж Жамьян цорж хэмээх нэр, цол өгчээ. Уг нь өөрийнх нь нэр Дашбалдан билээ. Тэрээр маш гайхамшигтай лам байсан бөгөөд Гоман дацанг байгуулжээ.

Шүтээн зурган дээр тэрээр лам хувцастай, гэлүгба урсгалын шовх оройтой малгайтай ажээ. Будаг нь хуурсан болохоор хэсгүүдийг нь нэг бүрчлэн ялган харах аргагүй болжээ.



Зураг 4.1.9р Жамьян-цорж




Зураг 4.1.9р\*

<sup>19</sup> Тиб.: 'jam ba'i dbyangs bkra shis dpal ldan gyi rtogs ba brjod pa'i yal 'dab. Хул. 6 ff. Инв. М0058468-010. НБМ.

Арван хоёрдугаар дүр нь Чойги Нинжид төвөд эх дээр Бурхны шашны эрдэмтэн, сэнтий дээр морилж, шовгор малгай өмсжээ. Баруун гар талд нь олон давхар хятад номын тавиур байна. Дээр нь номын тагтай сагс тавьжээ<sup>20</sup>. Чойги Нинжидийн магтаалаар түүвэр зохиол төгсөж, цаашилбал 12-р бүлэгт Дарнатын нууц намтрыг өгүүлжээ.



Зураг 4.1.9с Чойки Нинжэд



Зураг 4.1.9с\*

Монгол цадигт бичихдээ энэ удаа тэр Сингалд (Шри Ланка) төрж, таван их ухаанд суралцаж, бандид болов гэжээ. Зургаан зүйл амьтанд тусална хэмээн Жанрайсиг бодисадвад тангарагласан тул Хятадад олон амьтан тусалсаар, тэндээ насан эцэслэжээ. Чойжи Нинжид бандида гэдэг нэрээрээ алдаршсан.

Монгол шүтээн зураг дээр зүүн гар талд дороосоо хоёр дахид лам хүний банзалтай, цээжин биеэ ил гаргасан зөвхөн зүүн мөрөө орхимжоороо халхлан, олбог дээр баруун мутартаа маш урт судар барьж, зүүн мутраараа хамгаалах, аймшиггүйн мутарлагатай (абхая мудра) хүн дүрслэгдсэн байгаа. Түүний дэргэд Буддын номнуудын түүвэр гэдгийг бэлгэдсэн номын тагтай ногоон сагс байна.

Нэрсийн арван гуравт байгаа нь Гунгаа-Долчог (монг.: Gūṅ-ge-sgröl-ṣog; төвөд: kun dga' grol mchog, 1507-1566) юм.

Монгол цадигаас харахад Төвөдийн Гири гэдэг газар төржээ. Одоо энэ вант улс Төвөд, Непалийн хэл дээр байдаг. Тэрээр Төвөдийн төвд ном сурч, маш их амжилт гаргаж,

<sup>20</sup> Тиб.: pandi ta chos kyi na mor byed pa'i rtogs ba brjod pa'i yal 'dab. Хyl.8 ff. Инв. M0058468-011

олон шидтэй болжээ. Нигумы дагинатай бодитойгоор уулзаж зургаан номыг нь дамжуулан авч уламжлалыг нь үргэлжлүүлжээ. Улааны дэг сургуульд харьяалагдаж амьдралынхаа сүүлийн 20 жилийн турш улааны дэг сургуулийн 24 багшийн нэг байжээ [Kun dga' grol mchog 1982].

Шүтээн зургийн баруун гар талд шар олбог дээр улаан, улбар шар лам хувцастай зүүн мутартаа бумба бариад суужээ. Орхимжныхоо үзүүрээр толгойгоо хучжээ.



Зураг 4.1.9т

Зураг 4.1.9у Рамагопала

Арван дөрөв дэх дүр нь Гажидсажон (монг.: Ga'a-byed-sa-sgyong; төвөд:Dga' byed sa skyong) буюу Рамагопала (санскр. gāmagopāla; төвөд:Dga' byed sa skyong 1567-1574) юм.

Тэрбээр зүүн доод буланд язгууртны хувцастай, шар дээл, алтан хээтэй цагаан орхимж, улаан гутал өмссөн ба чөлөөт амарч байгаа байдлаар (раджасана) суужээ. Толгой дээрх алтан титэм нь хаан язгууртай гэдгийг нь харуулж байна. Д.Тэмпелэний гэрчилж ярьснаар Рамагопала Энэтхэгийн сүүлийн үеийн бурхны шашны шидтэнгүүдийн нэг ба Дарнатын намгарт түүний өмнөх дүр хэмээн бичигдсэн байдаг [Templeman, 1992: p. 33-56].

Соёмбо бичгээр бичигдсэн Жавзундамба ламын монгол цадигт Гажидсажон нь алдартай раж (монг.: хаан) гаралтай бөгөөд 8 наслахдаа бусад хүмүүсийн 100 насалж байж бүтээх зүйлийг хийж амжаад, маш эрт нирваанд оржээ хэмээн бичжээ [Бямбаа, 2005: с.75].

Арван тавдугаар дүр нь **Дарнат** юм (самг.: Tāranātha; монг.: Gün-ga's ŋiŋ-bo-gra-šes-rgyal-čan; төвөд: Kun dga' snying po bkra shis rgyal mtshan, 1575-1634).

Дарнат нь баруун доод буланд дүрслэгджээ. Тэрээр цагаан ирвэсний арьсан дээр чөлөөт байдлаар сууж, зүүн мөрөн дээр нь дэлгэрсэн, дээрээ бодь сэтгэлийн ном тавигдсан цэцгийн цоморлигийн шилбэнээс нь барьжээ. Лам хүний хувцастай, шар орхимжоор мөр, бүсэлхийгээ хучсан байх ба банзал дороос нь нүцгэн хөл нь цухуйж, улааны уламжлалын шовгор оройтой малгай өмсжээ.

Монгол цадигт Жавзун Гунгаанянбо Дашжалцан Долви Гомбо Дарнат Төвөдөд Бранпу гэдэг газарт төрсөн бөгөөд түүний хуланц өвөөг Сэнгэ-Балдан, элэнц өвөөг Жамьянлодой, өвөөг Цүлтэм-Намжал гэдэг гэжээ. Тэрээр гэртээ дөрвөн хүүгийн хамгийн бага нь байсан ба ээжийг нь Намжалпунцаг, аавыг нь Дорж-Бууга гэдэг. Жавзундамбыг гахай жилийн зуны адаг сарын 8-нд модон махбодид төрөхөд аав нь 49 настай ээж нь 19 настай байв. Түүнийг төрөх үед хүүгээ агуу эрдэмтэн болоорой хэмээн ерөөсөн ба тэрээр өөрийнхөө өмнөх дүрүүдээ мэдэж байжээ. 8 настай байхаасаа ном үзэж Төвөдийн хамгийн алдартай багш нарын нэг болжээ. 49 настай байхдаа (1615 онд) Дагдан хэмээх хийд байгуулжээ. 61 настай байхдаа нирваан дүрийг олжээ (1634 онд) [Бямбаа, 2005: с. 75-76].



Зураг 4.1.9ф

Гэхдээ ил харагдах намтрын нууц тухайн хүнийг хэн болохыг тодорхойлсноор хязгаарлагдахгүй. 1-рт, дээр дурдсан хувилбар маргаангүй зүйл биш юм. Учир нь дүр бүрийн намтрыг тухайн үеийн бүх түүхэн эх сурвалжуудын хамт маш нарийн судлах хэрэгтэй бөгөөд энэ нь бүхэл бүтэн тусдаа бие даасан судалгааны сэдэв болно. Жишээ нь, Шагжамуни бурхны үед амьдарч байсан эхний дүр буюу Жавзандамба хутагтын анхны дүр нь Сувишудхамати юм. Дээд эгнээний зүүнээсээ хамгийн эхнийх нь Сувишудхамати байх ёстой байв. Гэтэл Занабазар өөрөө зурсан гэж үздэг Улаанбаатарын МИИД-д хадгалагдаж байгаа шүтээн зурган дээрх хамгийн эхний дүр нь эмэгтэй хүн, Занабазарын эх Ханджамц хатан байв. Бүр Ханджамц хатантай шүтээн зураг Занабазарын зурсан жинхэнэ эх биш байсан ч (ийм судалгаа зайлшгүй хэрэгтэй) жинхэнэ эхээсээ хуулагдсан, үүний хэлбэр, хэв маяг, гадаад хэлбэрийг хадгалсан байх ёстой. “Трикайягийн төгс байдал” хэмээх шүтээн зураг дээрх бүх хүмүүс үндэсний хурц тод хувь хүний онцлогийг харуулсан шинж чанартай болохоор олон эрэгтэйчүүдийн дундах цорын ганц эмэгтэй дүр тухайн дүрийг альтенатив аргаар тайлбарлахад хүргэж байгаа юм. Нэг бус удаа тэмдэглэж байсанчлан Занабазар бурхан зурах тигийг маш нарийн мөрдөж, бичигдсэн эх дээрх агуулгыг яс баримталдаг. Үүний сацуу түүний ажлууд нь ихэнх хуучны барилтай зураачдаас зоригтой илэрхийлэл, шийдлээрээ ялгардаг боловч бичгийн эх сурвалжад байнга тулгуурладаг. Тухайлбал, энэхүү шүтээн зураг утга санааны хувьд хоёр уламжлалыг, яг нарийндаа Цагаан Дэмчигийн ба Аюуш бурхны яв юм гэсэн нас уртасгах хоёр өөр аргыг харуулдаг. Эхний уламжлал нь босоо чиглэлээр, хоёр дахь нь хэвтээ

чиглэлээр явдаг ба энэ хоёр Занабазар дээр ирээд Шагжамуни бурханаар дамжин огтолцдог. Хэрвээ Аюуш бурхны арга хангалттай түгээмэл бол Цагаан Дэмчигийн (Дэмчиг) арга нэлээн ховор, тэр болгон хүмүүс мэдээд байдаггүй арга ажээ. Төвөдийн уламжлал дахь Дэмчигийн тарни Диловагаас (988—1069) Наровагаар (956—1040) дамжин иржээ.

Цагаан Дэмчигийн бүтээл түгсэн явдал нь Нигумагийн нэртэй холбоотой. Нигума бол XI зууны үед байсан Энэтхэгийн домогт бясалгагч, Наровагийн эхнэр байсан ба Нарова түүнтэй язгууртан удмаа цорын ганц хүүгээрээ үргэлжлүүлэх зорилготой эцэг эхийнхээ шаардлагаар гэрлэжээ. Нигума нь брахман давхрагын царайлаг, боловсролтой, ёс суртхуунтай бүсгүйчүүдийн төгс үлгэр дууриалал байв. Тэд гэрлээд нэг их удалгүй салсан боловч өөрсдийн оюун санааныхаа үйл хэргийг үргэлжлүүлсээр байжээ. Нигума тарнийн номоо хүмүүсээс бус, харин шууд Очирдара бурханаас авсан гэгцгээдэг. Учир нь тэрээр цэцэн ухааны дагинын увдистай байжээ. Нигумаг Марво ламын багш нарын нэг гэж үздэг. Тэрээр орчуулга тайлбарын ажилд нь тусалдаг байжээ [Guenther, 1963]. “Нигумагийн зургаан ном” гэдэг нэрээр алдаршсан Нигумагийн уламжлалд Дэмчигийн юмын эхийн аннутара тарнийн бясалгал багтсан байдаг. Нигумагийн тарнийн бүтээлийн онцлог нь бинду урсгалд дээрээсээ доошоо биш харин эсрэгээрээ доороосоо дээшээ чиглэлтэй, Дарнатын бодлоор бол гэгээрсэн Нигумагийн номыг дамжуулах илүү хурдан, ном ёсны үр дүнд хүрэх арга бол үзэгдлийн хэлбэр юм. “Нигумагийн зургаан номын” дамжлагад Занабазарын өмнөх дүрүүдийн нэрс байдаг, тухайлбал Гунгаа Долчога, Дарнат [Тарантаха, 2016; Guenther, 1963, Презель 2018]. Ийм учраас Занабазарын шүтээн зурган дээрх голын хос Дэмчиг, Базарварахи хоёрын дараах хамгийн эхний бурхан нь энэ зан үйлийн гол дүр болох эрхэмсэг шударга бясалгагч эмэгтэй Нигума байх бүрэн боломжтой юм. Ийнхүү Өндөр гэгээн Занабазарын бүтээсэн “Трикайягийн төгс байдал” хэмээх шүтээн зурагт түүний өмнөх дамжлагад Занабазарын олон бүтээлд байдгийн адил олон түвшний, олон утгатай агуулга, нууц утга санаа агуулагдаж байна. Ерөнхийдөө, уран яруу дүрслэл нь анхдугаар Богд гэгээнтний сүмбүмд орсон нууц намтрыг харуулдаг ба Аюуш ба Цагаан дэмчиг, Базарварахи улаан дагинийн бүтээлийг нэгтгэсэн урт наслах бүрэн дүүрэн тарнийг илэрхийлж байгаа юм.

Энэ бүтээлд Занабазарын бас нэг нууц байгаа юм. Дээр дурдагдсан уран баримал дээрх шиг (Зураг4.1.9) энэ шүтээн зурган дээр өөрийгөө буруу энгэртэй дээлтэй зурсан нь

монголчуудын дунд ер бус харагдана. Энэ хоёр бүтээлийг хоёуланг нь нас хэвийсэн үедээ бүтээсэн ба эдгээр нь энэхүү агуу урлаачийн эгэл амьдралаас гарч гэгээрэлд хүрэхийн өмнөх “сүүлийн үг ” байв. Түүний мэргэжлийн нягт нямбай байдал, маш жижигхэн зүйлд хүртэл анхааралтай хандаж байгаа, гүн гүнзгий бэлгэдэлтэй, оюун ухаан ба амьдралын туршлагадаа маш их санаа тавьдаг байсан болохоор түүнд дүрслэгдсэн дүрүүдийн талаар бид дөнгөж таамаглахаас цаашгүй. Тэрээр ханлиг хоорондын тэмцэл, маш хүнд, удаан үргэлжилсэн зовлон зүдгүүр туулсныхаа дараа түүхийн явцыг нөгөө тийш нь эргүүлж, монголчуудын түүхийн алдааг засаж буйн бэлэг тэмдэг болгож, ийнхүү буруу энгэртэй дээл өмссөн байх хэмээн ХХ зууны үеийн монголын томоохон зураач Д.Дамдинсүрэн таамаглан хэлсэн байдаг [Дамдинсүрэн 2012: с.90-91]. Түүний өвийг цаашид гүнзгийрүүлэн судалбал Өндөр гэгээн Занабазарын бидэнд кодлон үлдээсэн захиасын учрыг тайлж чадах биз ээ.

#### **IV Банчэн лам Лувсанчойжижалцангийн хөрөг**

##### ***Шүтээний агуулга***

Занабазарын намтар бичигч нарын нотолсноор Занабазар багш нарынхаа олон хөргийг зурж байжээ. Тухайлбал, 1698 онд Банчэн лам, Далай ламын хөргийг олон удаа зурсан байна. Хадгалагдан үлдсэн бүтээлүүд дотор түүний язгуурын багш Банчэн лам Лувсанчойжижалцангийн дүр ихээхэн тааралддаг. Бүтээлүүд намтар бичигчдийн хэлснийг баталгаажуулж байгаа юм. Тэдгээрийн дунд уран баримал, жижиг уран дүрүүд байна.

Банчэн лам Лувсанчойжижалцан(төвөд: blo bzang chos kyi rgyal mtshan 1567-1662) бол тухайн үеийнхээ Бурхны шашны онцгой алдартай багш байв. Бурхны шашны томоохон их сургуулиудад багшаар ажиллаж, Дашлхүмбэ хийдийн харьяанд ажиллаж амьдардаг, очирт хөлгөний агуу багш, олон ном зохиосон бөгөөд тэдгээрийн заримыг гэлүгбагийн бүх лам нар өдөр тутам уншдаг. Тэрээр дөрөвдүгээр Далай-лам (1589-1616), тавдугаар Далай-лам (1617-1682), Түлкү Дагважалцан (1619-1656), Занабазар (1635-1723), Ойрадын Зая бандида (1599-1662), Халхын Зая бандида (1642-1715), Галдан Бошигт (1644-1697) зэрэг XVII – XVIII зууны үеийн олон түүхэн хүмүүсийн язгуурын багш нь байжээ. Тавдугаар Далай ламыг улс төрийн эрхийг авахаас ч өмнө Банчэн лам монголчуудын дунд Бурхны шашны тал дээр маш их нөлөөтэй хүн байжээ. Тэрээр монголчууд, манж нартай сайн харилцаатай, гэлүгбагийн уламжлалыг цэцэглэн хөгжихөд нөлөөлсөн ба Ү Далай

ламын улс төрийн амжилтын үндсийг тавьсан, монголчуудын дунд гэлүгбагийн уламжлалыг тархахад ихээхэн нөлөө үзүүлсэн Гүш хаанд (1582-1655) нөлөө үзүүлж байжээ.

### **1.1Ү Банчэн лам цутгамал**

Уг уран баримлыг зэсийн хайлшийг хоёр хэсэг цутган бүтээж, алтаджээ.

Өндөр нь 27,5 см., өргөн нь 22,5, гүн нь 20 см. (Зураг 4.2.1в).

Зураг 4.2.1в. 7. 1Ү Банчэн лам Лувсанчойжижалцангийн хөрөг

Уг лам ханцуйгүй ламын хувцастай, малгайгүй суух ажээ. Очир завилгаагаар сууж, хөлөө хучжээ. Шимнусыг дарсны бэлгэдэл болгож, баруун мутраа алгаар нь доош нь харуулсан боловч мутар нь суудалд хүрээгүй, хувцасных нь нугалаас дээр байх ажээ. Зүүн мутраа өвдөг дээрээ бясалгалын байдлаар (диян мутар) тавьжээ. Орхимжоо нөмөрсөн бөгөөд орхимжныхоо үзүүрээр тохой, хөлөө хучжээ. Хувцасных нь зах орчмын нугалаас, долгиотсон хэсгээс нь харахад орхимж нь олон давхар бололтой. Том уужим бадамлянхуа цэцгийн суудал нь хоёр давхар бөгөөд доод талынх нь доош дэлгэгдсэн давхар дэлбээнүүдтэй, дээд талынх нь дээш дэлгэгдсэн давхар дэлбээнүүдтэй. Дээд үзүүр нь сувдан утсаар эмжигджээ.

Хөл нь хучигдсан байгаа нь 1Ү Банчэн ламыг жанч халаагүй байх үед нь уг бүтээлийг хийсэн гэсэн үг. Энэхүү авьяастай уран барималч үүнийг маш сайн мэдэж байсан болохоор түүнийг гэрэл цацарсан, сайхан сэтгэлтэй, цэцэн, бага зэрэг зальжин байдлаар бүтээгдсэн ба гэртээ байгаа мэт амгалан байдал мэдрэгдэнэ. Занабазарын юутай ч зүйрлэшгүй ур хийцийн ачаар орхимжны өвөрмөц нугалаас нь өмссөн хувцас нь үл мэдэг доош долгиотон унжиж, ламын нурууны хэсгийг маш гоё удаан хугацаагаар суусны улмаас доош суусныг харуулж байна. Занабазар орхимжоор хучигдсан ламын нурууг маш өвөрмөцөөр гаргадаг болохоор түүний баримлыг ар талын алслалтаар нь л шууд таньж болно. Мөн хуш модны боргоцой шиг хэлбэртэй бадамлянхуан цэцгийн дэлбээтэй сэнтийтэй. Багшийн туранхайвтар царайнаас нь хувийнх нь онцлог харагдана: Том ээтэн хамартай, өндөр шанаатай, инээмсэглэсэн нүдтэй, гоё амтай, том лам хүний бурханлиг



хэлбэрийн чихтэй, зулай нь шовгор ажээ. Занабазарын бүтээлүүдэд байдаг тойрог хэлбэрийн боловсруулалт харагдана (Зураг 4.2.1).



Зураг 4.2.1а. IY Банчэн лам Лувсанчойжигжалцаны дүр. Нүүрэн талаасаа. Г.Шмидтийн хувийн цуглуулгаас. Лондон. [Portraits of the Masters, p. 316, pl. 89a]


Зураг 4.2.1а. IY Банчэн лам Лувсанчойжигжалцаны дүр. Г.Шмидтийн хувийн цуглуулгаас. Лондон. [Portraits of the Masters, p. 316, pl. 89b]

Занабазарынх гэдгийг нь харуулах өөр нэг онцлог бол түүний баруун мутар юм. Мутрынх нь хуруунууд хорвоо дэлхийгээс гэгээрсэн гэдгийг нь гэрчлэхийг уриалсан Бурхны хөдөлгөөнтэй адилхан байдалтай боловч газарт хүрэхгүй газраас жаахан дээр байрлуулдаг бурхан зурах тигээс өөрөөр шийдсэн ажээ. Бүх зохиомжийг нь цутган гаргадаг ур чадвартай урлаачаас ямар ч алдаа гарахгүй гэдгийг харуулж чаджээ. Энэ бол сүм хийдийн нөхцөлд хатуу үүрэг хүлээсэн харилцаагүй, багштай маш ойр дотно хүнтэй тоглоом хийж байгаа байдлаар санаатай, зоригтойгоор гаргасан шийдвэр юм. Үнэн хэрэгтээ, төвөд дархан бол ийм зориг гаргаж чадахгүй. Гэтэл өндөр язгууртан гаралтай боловч сурахаар ирсэн монгол залуу хүү Занабазар ингэж чаджээ. Занабазар Төвөдөд багшийнхаа хажууд байхдаа өөрийг нь харж сууж байгаад 1650 эсвэл 1655 онд энэ бүтээлийг бүтээжээ.

Хэвлэгдсэн [Portraits of the Masters, p. 316, илл. 89; p. 321, илл. 90].

## 1.IY Банчэн лам Лувсанчойжигжалцангийн цутгамал

Хоёр ахимаг настай монгол хосын гэрт буй Ү Банчэн ламын дүр (Зураг 4.2.2). Цутгамлыг шар хадгаар маш сайн ороосон болохоор зөвхөн нүүр нь л харагдаж байв. Эзэд нь тэр цутгамлыг Өндөр гэгээн Занабазар урласан энэхүү агуу монгол эзний төвөд багш байсан гэдгийг мэдэж байв.



Зураг 4.2.2а. Монгол гэрт буй Ү Банчэн ламын цутгамал шүтээн. Монгол Улс, 2019 оны 8-р сар. Зургийг С.С. Зургийг С.С.

Зураг 4.2.2б. 8. Ү Банчэн лам Лувсанчойжижанцан. Монгол Улс, 2019 оны 8-р сар.

17 см өндөртэйгээр гуулиаар цутгаж, алтадсан ажээ. Энэхүү лам төвөд ламын уламжлалт хувцсыг өмссөн, очир завилгаагаар сууж (ваджрапьянка асана), баруун мутар нь гэрчлэхийг уриалсан мутарлагаар (бхумиспарша мудра) буюу хурууны үзүүрээр газарт хүрсэн байдалтай, зүүн мутар нь бясалгалын байдалтай, алган дээрээ бадар аяга барьжээ. Суурь нь хагас дугуй хэлбэртэй, утсанд татсан, хуш модны боргоцойн хэлбэртэй давхар бадамлянхуа цэцэг ажээ. Банчэн ламыг өвөрмөц шовгор зулай, гэдгэр гавлын ясаар нь ялгаж таних боломжтой. Нарийхан нүүртэй, шөвгөр эрүүтэй, бүргэд хамартай, бүх эрхтэн нь ялгарч харагдсан, урт чихтэй, Занабазарын хийцийн бусад бурхдын адил хөнгөхөн инээвхийлжээ.

Зураг 4.2.2в. Монгол гэрт байдаг Ү Банчэн ламын уран баримал. Ар талаасаа. Монгол Улс, 2019 оны 8-р сар.

Зураг 4.2.2в. Монгол гэрт байдаг Ү Банчэн ламын уран баримал. ¼ талаас. Монгол Улс, 2019 оны 8-р сар.

Урлаач маань багшийгаа тодорхой нэг багшийн дүрд хувирсан Бурхан багшийн байдалтай (нирманакая) дүрсэлжээ. Энэ уран баримал нь нэлээн сүүлийн үед хийгдсэн гэдгийг уг бурхныг дүрсэлсэн байдлаас харагдаж байна. Гэгээрэлд хүрсэн Бурхан маань үүний өмнө авч үзсэн сайхан сэтгэлтэй амьд, дотнолог, өвгөжөөр уран баримал биш харин залуу дүртэй бүтээгджээ (Зураг 4.2.1). Энд хувилгаан дүрд орсон гэж үзэн дүрийг илүү тиг бариулсан, илүү хийсвэрлэж гаргажээ. Гэхдээ л анх харангуут IV Банчэн лам Лувсанчойжижалцан гэдэг нь танигдаж байна (Зураг 4.2.2с-д).

### 1.АНУ дахь Росси галерейд хадгалагдаж буй

#### IV Банчэн лам Лувсанчойжижалцангийн дүр

Банчэн ламын өөр нэг дүр баруунд хувь хүний цуглуулгад байдаг ба 2004 онд Нью-Йорк хотноо Росси галерейгаас зохион байгуулсан “Монголын эрдэнэс. Занабазар хийцийн бурхдын уран баримлууд” гэдэг үзэсгэлэнд оролцжээ. Тухайн уран баримал 22 см өндөртэй, Занабазар хийцтэй, зэсийн хайлшаар цутгагдсан ажээ. Банчэн лам Лувсанчойжижалцан очир завилгаагаар сууж, хөлөө хучсан, лам хүний бүтэн хувцастай, мөрөн дээгүүрээ орхимжтой ба өндөр оройтой “Банчэн лам” малгай өмсжээ.



Зураг 4.2.3а. IV Банчэн ламын дүр. Занабазар хийц, XVII зууны төгсгөл, XVIII зууны эхэн. Зэс хайлш, 22 см өндөр. Өмнө талаасаа. Хувийн цуглуулга. “Росси ба Росси” галерейн үзэсгэлэн. [Beguin 2005: n.14]

IV Банчэн ламын дүр. Занабазар хийц, XVII зууны төгсгөл, XVIII зууны эхэн. Зэс хайлш, 22 см өндөр. Өмнө талаасаа. Хувийн цуглуулга. “Росси ба Росси” галерейн үзэсгэлэн. Зураг 4.2.3б. [Beguin 2005: n.14]

Баруун мутраа зүрхэн тус газартаа ном номлох мутарлагатай (витарка мудра) барьж, өвдөг дээрээ тавьсан зүүн мутраа бясалгалын мутарлагатай (дхъяна мудра) байрлуулж, дээр нь бадар аяга барьжээ. Цутгасны дараа шавь нар нь ажилласан боловч царайг нь хөнгөхөн инээвхийлэлтэй, зохиомжийн тэнцвэрийг нь нарийн гаргаснаас нь Занабазарын тиг хийц гэдэг нь танигдана.

## **1.ГҮ Банчэн лам Лувсанчойжижалцангийн дүр**

### **Шүтээн зургуудын хэсгээс**

Шүтээн зургийн жижигхэн хэсэгт тухайн урлаач ГҮ Банчэн лам Лувсанчойжижалцанба Далай лам Наваанжамц зэрэг багш нарынхаа дүрийг бүтээжээ. “Кришна ямарийн мандал” хэмээх шүтээн зурган дээрх жижиг хөргүүдэд Чойжижалцангийн туранхайвтар, нарийхан нигур, нас тогтсон царай, арай залуу, дугуй царайтай, жирэвгэр сахалтай, бүлтгэр нүдтэй Наваанжаму нарын дүрийг гаргаад зогсохгүй, бүр тэдний зан чанарыг гаргаж чаджээ. Хэрвээ Банчэн лам инээмсэглэсэн зөөлөн дүртэй бол тавдугаар Далай лам шийдэмгий, хатуу, нялуун зангүй харагдана.

Эдгээр зангийнх нь тухай түүхэнд тэмдэглэсэн байдаг. Түүнээс гадна Наваанжамц бага зэрэг долир харагдана. Шүтээн зурган



Зураг 4.2.4а. Банчэн ламын хөрөг. “Кришьямарийн мандал”. Монгол улс. А.Алтангэрэлийн цуглуулга.

Зураг 4.2.4б. Далай-ламын хөрөг. “Кришьямарийн мандал” шүтээн зургийн хэсэг. Монгол улс. А.Алтангэрэлийн цуглуулга.

дээр бурхдын биенийх нь согогийг нэг их харуулаад байдаггүй, хийсвэрлэж бүтээдэг. Ийм өндөр зэрэглэлийн чөлөөт сэтгэлгээтэй монгол урлаач Өндөр гэгээнээс өөр хүн гэлүгбагийн дээдсүүдийг ийм тиг алдуулсан байдлаар зурж зүрхлэхгүй. Ийм дур мэдсэн зан гаргах бас үндэслэл бий. Учир нь Дарнатын номын уламжлалыг үргэлжлүүлж буй

Занабазар урьд дүрүүдээ мэддэг, тэдэнтэй тохиолдсон үйл явдлуудыг мэддэг байжээ. Энэ түүхийг дараагийн хэсэгт авч үзлээ.



Зураг 4.2.6. Далай ламыг бага залуу овроор бүтээсэн дүр.  
“Цагаан Махагал” шүтээн зургийн хэсгээс. Монгол Улс.  
А.Алтангэрэлийн цуглуулга.

### 1.У Далай лам Лувсаннаваанжамцын дүр (1617-1680)

У Далай лам бол Занабазарын чухал багш нарынх нь нэг байсан бөгөөд жүд дамжлага харуулсан дүрүүдийн дунд олонтаа дүрслэгддэг ажээ. Өндөр гэгээний намтарт бичсэнээр Далай лам л язгууртан гаралтай нэгэн монгол хүүг төрөхөөс нь нэг жилийн өмнө нас барсан Төвөдийн эрдэмтэн Дарнатын (1575-1634) хойд дүр хэмээн таньж тодруулсан байдаг. Агуу тавдугаар Далай ламын бага залуу цагийн дүрүүдийг Занабазарын зураг дээрээс дугуй царай, бүлтгэр том нүд, үзүүр нь эргэсэн нарийхан жирэвгэр сахлаар нь танихад хялбархан байдаг. ХҮП зууны үеийн тэдний ер бусын харилцаа нь гэлүгба, сажа ба улааны дэг сургуулиудын өрсөлдөөн, тэдний үйлийн үр дагаврыг санаатай ч, санамсаргүй ч харуулахад хүргэжээ. Эрдэнэпилийн бичсэнээр IY Далай лам Ёндонжамцын хойд дүрээр тодорсон хөвгүүнд Дарнат дургүй байсан ба түүнийг аль хэдийн тодорсон багш дээр нь аваачаад ном уншиж байх үед шавийн нүдийг гэмтээсэн тул долир болжээ.



Зураг 4.2.5а V Далай лам. Алтадсан хүрэл. Нүүрэн талаасаа. Чикаго хотын Прицкеровын цуглуулгад байдаг [Karmey 2014: pl.17-18]

Зураг 4.2.5а V Далай лам. Алтадсан хүрэл. Нуруу талаасаа. Чикаго хотын Прицкеровын цуглуулгад байдаг [Karmey 2014: pl.17-18]

### Ловон Бадамжунай (ҮШ зуун)

#### *Шүтээний агуулга*

Бадамжунай (*самг.*: padmasambhava; *төвөд.*: slob dpon padma byung nas, *монг.*: Ловон Бадамжунай/Бадамсамбу) буюу бадамлянхуагаас төрөгч бол Төвөдөд тарнийн ёсыг нэвтрүүлсэн гавьяатай агуу шидтэн юм. Тэрбээр хуучны тарнийн ёсыг үндэслэгч юм. Монголд голчлон гэлүгбагийн уламжлалыг баримталдаг боловч ловон Бадамжунайг монголчууд өргөнөөр шүтдэг. Үр дүнд хурдан түргэн хүрэх тарнийн арга бол нүүдэлчдийн оюун санаа, зан чанарт үнэхээр ойр зүйл билээ. Ловон Бадамжунайн дүрийн анхны загварыг Занабазар гаргаж, урчууд цаашид энэ загварт суурилан уран баримлаа бүтээж байсан бололтой. Бөмбөлөг хэлбэрт тэмүүлсэн энэхүү дугуй зохиомж нь XII зууны үеийн шавар баримал, XIII-XIV зууны үеийн чулуун сийлбэрийг санагдуулна. Занабазар хийцийн ловон Бадамжунайн уран сайхны дүр энэхүү их багшийн нэрийн мөн чанарыг харуулжээ. Түүний биеийн хэлбэр нь цэцгийн цоморлогийн нэг хэсэг болж, бадамлянхуа цэцэгнээс төрж байна.

#### 1.Эрдэнэ-зуу музейд буй ловон Бадамжунайн баримал

Эрдэнэ зууд эртний загваруудынх нь нэг хадгалагдан байдаг. Энэ бол нэлээн том хэмжээтэй, зэсийг хайлшаар цутгаж, алтдаж, өнгө будаг оруулсан уран баримал юм. Өндөр нь 44 см, дугуй суурийнх нь диаметр 34 см (Зураг 4.2.7). Ловон Бадамжунайн хөл нь хучаастай, баруун мутартаа очир атгаж, зүрхэн тушаа газраа барьжээ. Өвөр дээрээ тавьсан зүүн мутар дээр нь гавал аяга, түүний дээр нэгэн суулга (pūṅakalaśa) байна. Толгой дээр нь мөрөө хүртэл унжуулсан чихэвчтэй, үзүүртэй очиртой тууз зангидсан мэт чимэгтэй, бариу малгай өмсөж (манай үед нэмсэн бололтой), малгайных нь нүүрэн талд хагас сар, нар, өөр бас таван дугуй тэмдэг харагдана. Хөмсөг, зовхийг нь хар будгаар зурж, нарийн хар сахал зуржээ. Билгийн нүд нь дугуй төвгөр ажээ. Хамар нь Занабазарын уламжлалт хэлбэртэй боловч онцлох ялгаа гаргаагүй байна. Цэцэглэсэн тууз мэт уруул нь улаан өнгөтэй, хамрын өргөнөөс илүү гараагүй ажээ. Урт чихийг нь малгай бараг таглах шахжээ. Мөрөн дээр нь унжсан том ээмэгтэй. Хоолойн дээрээ бурхны гурван зураастай, дугуй сувснуудтай хүзүүний зүүлт, бугуйндаа чимэг зүүлт зүүжээ.



Зураг 4.2.7. Ловон Бадамжунай. Гууль, цутгамал, алтадмал. Монгол Улс, Хархорин, Эрдэнэ-зуу.

Нөмөрсөн орхимжных нь (*самг.*: uttārasanga, төвөд: bla gos) үзүүр тохойноос нь доош мутар, ташаан дээр нь сул унажээ. Орхимжных нь доороос нь зөв энгэртэй дээл харагдана, дээр нь хийц сайтай додьёг өмссөн ба баруун мөрөн дээр нь додьёгны эврэн хээ харагдана. Ийм додьёг нь баатарлаг зан, хар хүчтэй тэмцэлдэж чадна гэдгийг нь илэрхийлж байгаа юм. Зүүн мөрөн дээр нь шидэт дуаз (ишнийх нь оронд мод хийжээ,



дуазны толгойн хэсгийг сэргээн засварласан бололтой) угласан гогцоо байна. Цагирагийг нь цэцэглэсэн тууз мэт байдлаар эгэмнийх нь орчимд тогтоожээ.

Бадамлянхуан сэнтий нь дугуй, цэцгийн цоморлиг мэт, том том хоёр давхар дэлбээнүүд нь тэгш хэмтэй, дэлбээнийх нь завсар хооронд цэцгийн дохиурууд харагдана.

#### **А.Алтангэрэлийн цуглуулганд буй ловон Бадамжунайн уран баримал**

Гууль, цутгамал, алтадмал, будагтай.

Өндөр нь 22 см., суурийн диаметр 17 см

Ловон Бадамжунайн хөл нь хучаастай, баруун мутартаа очир атгаж, зүрхэн тушаа газраа барьжээ. Өвөр дээрээ тавьсан зүүн мутар дээр нь гавал аяга, түүний дээр нэгэн суулга (pūrṇakalāśa) байна. Саравчгүй өндөр хүрээтэй, өдөн чимэгтэй, малгайн урд талд тал сар, нар, таван дугуй тэмдэг харагдана. Мутар нигурыг алтадсан, үсийг нь хараар будаж, нүдийг хар, цагаанаар нь ялган, уруулыг улаанаар, жирэвгэр сахлыг нь хараар зуржээ. Билгийн нүдийг нь дугуй том төвгөрөөр зуржээ. Хамар нь Занабазарын уламжлал ёсоор нарийн хянгатай, гурвалжин хэлбэртэй, үзүүр нь унжуу, самсаа нь өргөн ажээ. Уруул нямбай, цэцэглэсэн тууз мэт, хамарнаасаа өргөнгүй ажээ. Урт чих нь бараг мөрөндөө хүрчээ. Чихэн дэх том ээмэг мөрөн дээр нь унжина. Хүзүүн дээр нь бурхны хөргөн дээр байдаг ёсоор гурван зураас гаргажээ (Зураг 4.2.8).

Нөмөрсөн орхимжных нь (*самг.*: uttārasanga, *төвөд.*: bla gos) зах мушгирсан цэцгэн хээгээр чимэглэгдсэн, орхимжных нь үзүүр тохойноос нь доош сул унжиж, өвдөг дээр нь маш гоёор долгиотон унажээ. Орхимж доороос нь язгууртан хүний хувцас харагдана. Зөв энгэртэй дээлэн дээрээ гоё хэлбэртэй додьёг өмссөн ба баруун мөрөн дээр нь додьёгний эврэн хээ харагдана. Том том сувстай зүүлт хүзүүндээ, бугуйндаа бугуйвч зүүжээ. Зүүн суганых нь орчим дуаз (алга болсон) тогтоох гогцоо байна. Гогцоог цэцэглэсэн тууз хэлбэрээр хийсэн бөгөөд эгэмнийх нь орчим гурван үзүүр нь харагдана.



Зураг 4.2.8а. Ловон Бадамжунай. А.Алтангэрэлийн цуглуулгад байдаг уран баримал. Нүүрэн талаасаа.

Зураг 4.2.8б. Ловон Бадамжунай. А.Алтангэрэлийн цуглуулгад байдаг уран баримал. Ар талаасаа.

Бадамлянхуан сэнтий нь дугуй, цэцгийн цоморлиг шиг хэлбэртэй, том том хэрчлээстэй цэцгийн дэлбээнүүд нь долоо долоогоороо тэгш хэмтэйгээр хоёр эгнээ болсон ба дээд эгнээний дэлбээнүүдийнх нь завсраар шүхэр цэцгийн дохиурууд харагдана. Ёроол нь битүүмжлэгдсэн бөгөөд доторх шүн нь хэвээр үлдсэн. Нацагдорж хэлбэрийн тамгыг алтадсан байна.

### Зонхава лам

Зонхава лам (*төвөд*: rje tsong ka pa, *монг.*: Богд Зонхава, 1357 - 1419) бол сүм хийдүүдийн лам нарын хатуу чанга винайн ёсыг сэргээж, номын гүн ухааны агуулгад гүнзгий анхаарч, эртний Энэтхэгийн уламжлалд эргэн шилжсэнийг зарлан тунхагласан бурхны шашны агуу өөрчлөн байгуулагч юм. Уламжлал ёсоор монголчуудын олноороо амьдардаг байсан Хөх нуурын ойролцоох Зонха гэдэг газарт төрсөн бөгөөд зарим хувилбараар монгол угсаатан гэгддэг. Хар бага наснаас нь ер бусын их авьяас нь тодорсон, маш сайн боловсрол эзэмшсэн зохион байгуулах авьяастай хүн байжээ. Номыг багшаас

шавьд тасралтгүй хүргэж байх зайлшгүй шаардлагатай гэсэн үзлээ хатуу баримталж, Төвөдөд түлкү-брүлгү (*төвөд: sprgul sku, монг.: qubilyan*) сургууль – бурхны шашны багш нар хувилгаан дүрд дахин төрдөг гэдэг үзлийг баримталдаг сургууль байгуулжээ.

### **1.Эрдэнэ зуу музей дахь Зонхавын уран баримал**

Хүрэл, цутгамал, алтадсан, хар, цагаан, улаан өнгө орсон.

18 см өндөр. 12,5см өргөн. ХҮШ зуун.

Зонхава лам хувцас (мөр нь өргөгдсөн донгог, шамтав, орхимж), гэлүгбагийн урсгалын шовгор оройтой малгай өмсөж, очир завилгаагаар ажирч, (*самг.: vajrāsana*), хоёр мутраа цээжиндээ номын хүрд эргүүлэх мутарлагаар барьж (*самг.: dharmacakra pravartana mudrā*), мөн мөртэй нь зэрэгцсэн бадамлянхуа цэцгийг ишнээс барьжээ. Гурав ба таван ширхэг давхар дэлбээнүүд дээр баруун гар талд нь гал бадарсан илд, зүүн гар талд нь судар, судрын дээр чандмань эрдэнэ харагдана. Барьсан зүйлсийг нь тусад нь, хавтгайгаар, ар талынх нь дүрсийг гаргалгүй цутгажээ. Орхимжных нь зах (*самг.: uttārasanga, төвөд: bla gos, монг.: орхимж*) хагас, бүтэн дугуйрсан, эсвэл шулуун цэцгэн хээгээр чимэглэгдсэн, хувцасных нь нугалаас маш гоё дүрслэгдсэн, орхимжныхоо нэг үзүүрийг зүүн мөрөн дээгүүрээ шиджээ. Зонхава багшийн нигур нь том, тодорхой, чийрэг эрүү нь насанд хүрсэн бөгөөд хүчтэй гэдгийг нь харуулна. Бие бялдар чийрэг, мөр нь өргөн налуу, их бие нарийхан, малгайн дороос харагдах хүзүү нь чийрэг байгаа нь энэ хүнийг бүр нуруун талаас нь харсан ч шийдэмгий гэдгийг харуулна.

Зураг 4.2.9. Зонхава лам. Гууль, цутгамал, алтадмал. XIX зуун. Монгол Улс, Хархорин, Эрдэнэ зуу музей.

### **14. А.Алтангэрэлийн цуглуулга дахь богд Зонхавын уран баримал**

Гууль, цутгамал, алтадсан (зарим хэсэг нь халцарсан) өнгө будаг орсон.

Өндөр 18см. Өргөн 12,5 см. XVIII зуун.

Зонхава ламын хувцастай (Донгог, шамтав) гэлүгвагийн шовгор малгайтай, завилж суусан (*самг.: vajrāsana*), гар нь цээжнийхээ орчимд номын хүрд эргүүлэх (*самг.: dharmacakra pravartana mudrā*) мутарлага хийхийн сацуу бадамлянхуа цэцгийг ишнээс нь барьжээ. Бадамлянхуа цэцгүүд нь мөрнийх нь орчимд байна. Гурав ба таван дэлбээтэй хоёр давхар бадамлянхуа цэцгэн дээр баруун гар талд нь гал бадарсан илд, зүүн гар талд

нь судар дээр нь чандмань эрдэнэ байна. Ялгах тэмдгүүд нь тусад нь ард талыг нь харуулахгүйгээр хавтгай байдлаар цуггажээ. Орхимжийн нь зах нь ургамал, ногооны хээтэй, цэцгийг нь цагариг, хагас цагариг, зураасаар хийсэн. Төвийж харагдсан орхимжийнх нь нугалаас харагдах ба орхимжийнхоо нэг үзүүрийг зүүн мөрөн дээгүүрээ хаяжээ. Зонхава ламын нүүр нь том, нүд хамар нь ялгарч харагдсан, эрүү нь чийрэг байгаа нь насанд хүрсэн хүч чадал төгс хүн болохыг нь харуулна. Чийрэг биетэй өргөн налуу мөртэй, нарийхан бэлхүүстэй, чийрэг хүзүүтэй байгааг нь харахад ар нуруунаасаа ч шийдэмгий хүн гэдэг нь харагдана.



Зураг 4.2.10а. Зонхавын баримал. Гууль, цутгамал, алтадмал, өнгө будагтай. Өндөр 18 см, өргөн 12.5 см. XVIII зуун. Нүүрэн тал. Монгол Улс. А. Алтангэрэлийн цуглуулга.

Зураг 4.2.10б. Зонхавын баримал. Гууль, цутгамал, алтадмал, өнгө будагтай. Өндөр 18 см, өргөн 12.5 см. XVIII зуун. Ар тал. Монгол Улс. А. Алтангэрэлийн цуглуулга.

Бадамлянхуа цэцгэн суурь нь мөлүү гурвалжин хэлбэртэй, өндөр, тэгш хэмт хоёр давхар дэлбээнүүдтэй. Хуш модны самрын хэлбэртэй цэцгийн дэлбээтэй (монг.: самар

бадам сэнтий). Бадамлянхуа сэнтий нь дээд ба доод талдаа сувдан хэлхээтэй. Ёроолынх нь шүншиг хадгалагдан үлдсэн (*төвөд*: gzungs gzugs). Нацагдорж хэлбэртэй тамгыг алтаджээ.

## ЯЗГУУРЫН БУРХАД

### Анхдагч Очирдара бурхан

#### *Шүтээний агуулга*

Очирдара ба таван агуу Датагада, таван язгуурын бурхад Занабазарын бүтээлд гол байр суурь эзэлдэг (1635-1723). Очирдара бурхан нь Монгол Улсын томоохон бурхны шашны төвүүд, Гандан, Эрдэнэ зуу хийдийн гол шүтээн нь байдаг.

Очирдара (*самг.*: vajradhara, *төвөд*: rdo rje 'chang, *монг.*: Очирдарь, Базардар, Доржчан, Очир баригч - *үгч*. “Очир баригч”) бол язгуурын бурхан буюу Анхдагч бурхан (*самг.*: adibuddha, *төвөд*: thog ma'i sangs rgyas)<sup>21</sup>, Бурхны таван урсгалын тэргүүн (*самг.*: panca kula tathāgata, *төвөд*: sangs rgyas rigs lnga, *монг.*: Язгуурын таван бурхан), өөрөөр хэлбэл, Очирт хөлгөний бүх бурхны уг сурвалж, эх үндэс нь юм. Очирдара бол төгс гэгээрсэн бурхны хувилгаан дүр, тарнийн номыг номлох үед харагдаж байгаа Шагжамуни бурхан юм. Тэр энгийн байдалдаа номин цэнхэр өнгийн лагшинтай, нэг тэргүүн, хоёр мутартай. Тэр дангаараа болон яв-юмтай, өөрөөр хэлбэл, тарнийн ханьтай (*самг.*: vajra dhara uraya prajna; *төвөд*: rdo rje 'chang yab yum; *монг.*: Очирдарь Юмын хамт) байдаг. Түүний ялгарах онцлог баруун мутартаа очир, зүүн мутартаа хонх барьж энгэртээ зөрүүлсэн байдаг нь (*самг.*: vajrahumkara mudra) арга билиг, цаашилбал амар амгалан, хоосон чанарын нэгдлийг илэрхийлсэн барьц юм.

Очир (*самг.*: vajra, *төвөд*: rdo rje, *монг.*: ocir) *букв.* “доржпалам”, “цахилгаан” нь дээр үед хол зайтай байгаа дайсан руу шидэж ялдаг шиддэг зэвсэг байжээ. Бурхны шашинд бол ухааны анхдагч мөн чанар эвдэршгүй, хоосон чанарыг олох арга, эрэгтэй хүний мөн чанарын бэлгэдэл гэсэн утгатай. Хонх нь (*самг.*: ghanta, *төвөд*: dril bu, *монг.*: qonq) дуу авиа нь бурхны ном, цэцэн ухаан, үнэнд хүрэх, эмэгтэй хүний шинж чанарыг бэлгэддэг, зан үйлийн зэмсэг юм. Очирдара бурхан хөлийн тавхайгаа дээш хартал эргүүлж, өгзөг дээрээ тавьсан, очир завилгаагаар суудаг.

Унгарын алдарт эрдэмтэн Александр Чома де Кёрёши ба Энэтхэг Бенойтош Бхаттачарья [Csoma de Kőrösi 1833: 57-59; Bhattacharyya 1958: 42-43] нар

<sup>21</sup> Гэлүгба, гарма, сажыг багтаасан сарма хэмээх шинэ уламжлалд байдаг. Төвөдийн бурхны шашны хуучин уламжлалын тарнийн ёсонд (нянма) Самандбатарыг Ади Бурхан гэдэг.

Очирдара бурхан анхдагч бурхан, хоосон чанарын биелэл нь болдог Очир тарнийн бурхдын тухай ойлголт бүтэц нь анх X зууны үед Наланда их сургуульд бий болсон гэсэн байдаг. Сүүлд бусад сургуулиудад Очирдарын олон тооны дүрийг бүтээсэн байдаг. Уран барималчид Анхдагч бурхны тухай анхлан өгүүлэгдсэн Дүйнхорын тарнид өгүүлэгдсэн зүйлд тулгуурладаг. Дүйнхорын тарни энэ үед буюу өөрөөр хэлбэл, X зуун XI зууны эхэнд үүсжээ. Ийм хожмын огнооны учир язгуурын таван бурхны тэргүүний дүр хадгалагдан үлдээгүйтэй холбоотой хэмээн эрдэмтэд тайлбарласан байдаг. Гэхдээ өөр нэг эх сурвалж нь гол баатрууд нь язгуурын таван бурхан болох Сандуйн тарни юм. Сандуйн тарни хэмээх ойлголт өргөн хүрээтэй мандал хэлбэртэй ба мандлын дөвөн зүгт буй үүднүүдэд Очирдара бурхнаас үүссэн язгуурын таван бурхан тарнийн хамт махбодын өнгөөр юм, нөхөр сэлт, хамгаалагч нарын хамт байрласан байдаг. “Тарнийн тарни” болсон Сандуйн тарни үүссэн цаг хугацааны тал дээр судлаачдын санал зөрдөг. Алекс Вайман Сандуйн тарни (*самг.*: Guhyasamaja tantra, төвөд:bSangs 'dus) гарч ирсэн үеийг IV-V зуун гэдэг бол Б. Бхаттачарья и Р. С. Гупте нар манай тооллын III зуун, харин Оросын алдарт Бурхны шашин судлаач В.П.Андросов VIII зуунд гэж тайлбарладаг [Wayman 1968: 48-49; Wayman 1973: 99-110; Bhattacharyya 1958; Gupte 1972: 108; Андросов, Очерки 2019: 434-438].

Юань гүрний үед нүсэр бүтэцтэй бурхад шүтээний урлагт давамгайлж байсан ч Язгуурын таван бурхныг харуулсан бүтээлүүд хангалттай бий. Тухайлбал, говь, Алашаагийн элсэн дунд хаягдсан Хар хотоос олдсон тангад-монголын үеийн нэгэн шүтээн зурган дээр эдгээр тав байдаг. Тогоон Төмөр хааныг Бээжингээс хөөж, нутгийн торгууд, өөрөөр хэлбэл ойрадуудын хамгаалалтад орсны дараа Хар хот Монголын Юань эзэнт гүрний сүүлийн түшиц газар нь болж байжээ. Хятад цэргүүд Хар хотыг удаан хугацаагаар бүслэлтэд байлгасны дараа 1372 онд Хар хотыг эвдлэн сүйтгэж, Эзэн голын урсгалын гольдролыг өөрчилж, хотоос баруун тийш 30 км урсгажээ. Ухрахынхаа өмнө монголчууд бурхны шашны ариун шүтээнүүдийг хотын суварга дотор нуусныг П.К.Козловын хээрийн шинжилгээний ангийнхан 1907-1909 онд зөөж гаргасан ба одоо эдгээр шүтээнүүд Орос улсын Санкт-Петербург хотын Эрмитажид хадгалагддаг<sup>22</sup>. К.Ф. Самосюк [Самосюк, 2005] маш баялаг шүтээн зургийн цуглуулгыг судалж хэвлэж гаргасан байдаг. Хар хотоос авчирсан олон шүтээн зурган дээр хамгийн дээд эгнээнд байрласан Язгуурын таван бурхан байдаг, тухайлбал, Доржпалам суурин дээрх бурхан [мөн тэндээс хар: кат. 71, 72,

<sup>22</sup> См.: [Козлов, 1923; Шифрин 2013]. Первое описание коллекции было осуществлено С. Ольденбургом [Ольденбург 1914].

7], Арван нэгэн нигуртай Жанрайсиг бодисадва [мөн тэнд: кат. 112], гобелен дээрх Ногоон Дарь эх (мөн тэнд, кат. 121), Дэмчигийн яв-юм [кат. 133] байна. Хар хотын шүтээн зургуудын дунд XII-XIV зуунд хамаарагдах, гарцаагүй монгол гаралтай зургууд байдаг, тухайлбал **Ачала** бурхан [мөн тэнд: кат. 158), Курукулла) [мөн тэнд: кат. 168]. Язгуурын таван бурхан нь нэгэн номын гарал үүсэлтэй байх нь гарцаагүй бөгөөд тэр нь Очирдара бурхны дүрээр илэрдэг. Тэгэхээр Язгуурын таван бурхныг урлах уламжлал Монголд Занабазарын үеэс өмнө байсан ба тэдгээрийн дүр ганцхан Хар хотын бурхан шүтээнд байгаагүй нь ойлгомжтой. Буддын шашинтан бөгөөд урлаач Занабазар эдгээр бурхдын дүрийг мэддэг байсан нь гарцаагүй. Гэхдээ тэрээр эдгээр таван бурхний дүрийг урлах чанарыг байж боломгүй өндөр төвшинд хүргэсэн ба тарнийн ёсны анхдагч бурхад учраас хамаг анхаарлаа тэдэнд хандуулсан юм.

### **1.Гандан хийд дэх Анхдагч бурхан Очирдара**

Очирдара бурхан нь Жавзундамба хутугт Өндөр гэгээн Занабазарын бүтээлүүд дунд нэгдүгээр зэрэгт ордог бүтээл юм. Өөрөөр хэлбэл эхлээд дуусах хүртэл нь зөвхөн өөрийн гараар бүтээж дуусгадаг бүтээлүүдийнх нь нэг юм. Ийм бүтээлийн тоонд Гандан хийдэд хадгалагдан байдаг ганцаар нь бүтээсэн Очирдара бурхан орно. Хүрэл, цутгамал, алтадсан, өнгө будаг орсон. Уг уран баримлын өндөр 72 см, суурийн радиус нь 40 см. Зургийг нь анх Н.Цүлтэм хэвлүүлж байсан [Цүлтэм 1982; Desroches 2009].

Очирдара бурхан амгалан дүртэйгээр (*самг.*: sambhogakaya, *төвөд.*: long sku), өөрөөр хэлбэл туршлагатай бясалгагчийн дүртэй байна: тэрээр найман чимэгтэй бодисадын хааны хувцастай байгаа болохоор түүнийг заримдаа хаан ширээнд залжээ гэгцгээдэг. Энэ уран баримлыг гайхамшигтай амьд, хөдөлгөөнтэй харагдуулдаг гол онцлог нь бага зэрэг толгойгоо мэхийлгэж, их биеийг баруун гар тал руугаа үл мэдэг хазайлгасан явдал юм **(Зураг 4.3.1)**. Үүгээрээ Очирдара бурхан нь туйлын тэгш хэмтэй морилдог Язгуурын таван бурхнаас ялгардаг.

**Зураг 4.3.1.** Монгол Улсын Гандантэгчэнлин хийдэд байдаг Очирдара бурхны уран баримал. Хүрэл, цутгамал, алтадсан, өнгө будаг орсон. Өндөр 72 см, Суурийн радиус 45 см. Зураг нь хэвлэгдэж байсан [Цүлтэм 1982; Desroches 2009]

### **1.Гандантэгчэнлин хийдэд байдаг яв-юм Очирдара**

Гандантэгчэнлинд мөн 70 см өндөр, том оюун санааных нь хань Билиг барамидын бурхан яв-юмтэй нь хамт бүтээсэн уран баримал байдаг **(Зураг 4.3.16)**. Яг адилхан биш

боловч үүнтэй төстэй яв-юмтай Очирдарын баримал Хар хоринд Эрдэнэ зууд байдаг. Өндөр нь 22 см, суурийн диаметр нь 14 см. Үүнээс гадна 18 см өндөр, суурийн бадамлянхуагийн диаметр нь 12 см яв-юмтай Очирдара бас бий. Үүнтэй ижил уран баримал Унгар улсын Будапешт хотын Ференц Хоппын нэрэмжит Зүүн Азийн урлагийн музейд байдаг.

Зураг 4.3.2. Монгол Улсын Гандантэгчэнлин хийдэд байдаг яв-юмтай Очирдара бурхны уран баримал. Улаанбаатар. Гандан хийд: а) нүүрэн талаасаа, б) баруун гар талаас. Урлаач Занабазар, XVII зуун, Монгол Улс [Цултэм 1982: зур. 62, 63]

Монголын цуглуулагчдын хувийн цуглуулга болон музейн фондуудад Очирдара бурхны нэрд гараагүй хэд хэдэн уран баримал бий. Тэдгээр нь бага хэмжээтэй боловч агуу урлаач Занабазарын хийцийн давташгүй онцлогийг эргэлзээгүй харуулж байдаг. А.Алтангэрэлийн цуглуулгад буй хоёр уран баримлыг дэлгэрэнгүй тайлбарлая.

#### **1.А. Алтангэрэлийн цуглуулгад байдаг дан Очирдара**

Очирдара залуу хөвгүүний дүрээр очир завилгаагаар (*vajmsana*) морилжээ. Гоолиг бие нь баруун гар тал руу үл мэдэг хазайсан, энгэртээ очир, хонх хоёрыг зөрүүлэн барьжээ. [Desroches 2009; Монгол урлагийн үнэт бүтээлүүд 2005]. Дөрвөн дэлбээт суурин дээр эрдэнээр адистидлагдсан, цэнхэр үсээ бодисадвагийн үсний засалт *жат* хэлбэрээр буюу өндөр овоолжээ. Урт үс нь бараг тохой хүртэл нь унжжээ. Дугуйрсан таван хэсэгтэй титэм нь хэлбэрээрээ монгол тоорцог малгайг санагдуулна. Титэмний уяа, торгон туузнууд чихнийх нь ард унжиж харагдах ба дээр нь цэцгэн эрхийн багцууд харагдана.

Том том усан үзмийн багц мэт унжсан хүзүүний чимэг олон салбарлаж харагдана. Урт нөмрөгөн дунгуй нь нуруун дээр урнаар нугаларан, мөр, ташаан дээр нь тунарна. Урт сувдан зүүлт хөл хүртэл нь унжина. Дотиных нь доод тал 5-6 дэлбээтэй товгор цэцгэн хээгээр чимэглэгджээ. Бугалга, бугуй, шилбэний чимэгтэй ажээ. Ууц нуруун дээрх бүсний сувснууд том, тодорхой, бөөрөнхий харагдана. Нуруу, мөрөн дээрээ тохсон торгон дунгуй нь мутар дээр нь тохогдоод, ташаан дээр нь хүрчээ. Уг уран баримлыг дулаан шар өнгөтэйгээр халуунаар алтадсан байна. Нүд хөмсгийг хар цагаан өнгөөр, уруулыг улаан өнгөөр, үсийг цэнхэр өнгөөр зуржээ.





Зураг 4.3.3. Очирдарын уран баримал. Хүрэл, цутгасан. Өндөр 18 см., суурийн өргөн 13,5 см. XVII-XVIII зуун. Монгол Улс, хувийн цуглуулга:

Очирдарын энэхүү дүр цэвэр, цэл залуу хүний гоо үзэсгэлэнгээрээ хүмүүсийн сэтгэлийг татдаг. Уг бурхны хоёр хацар хүүхдийнх шиг бумбагар, гялгар уран баримал болохоор залуу хүний лагшингийн цэвэрхэн, уян хатан байдал харагдана. Энэ уран баримлын нигур ба хоолойн дээр хүйтэн аргаар алтдаж хүний арьстай адил бүүдгэр болгосон харагдана. Бадамлянхуа суурь нь гурвалжин, өндөр, давхар дэлбээтэй. Цэцгийн тэгш хэмтэй дэлбээнүүд нь шүүслэг, цул харагдана. Сэнтийн дээд ирмэг нь сувдан хэлхээгээр чимэглэгджээ. Уг уран баримлын овойсон товойсон болгоныг маш нарийн бодож гаргасан, зуу зуун жил усанд угаагдан мөлийсөн хайрга мэт ажээ. Шүн (*төвөд: gzungс gzhigs*) нь хадгалагдан үлдсэн. Ёроолд нь сийлсэн нацагдорж тамгыг алтаджээ.

#### **1.А. Алтангэрэлийн цуглуулгад буй яв юм хэлбэрийн Очирдара**

Энэхүү уран барималд Очирдара бурхан оюун санааны ханиа тэвэрсэн байдаг [Самосюк 2006., илл. 36; Цултэм 1984: илл. 128]. Арга билгийн нарийн нэгдлийг бэлгэддэг ба үүний үр дүнд туйлын үнэнд буюу ухамсрын сэргэлтэнд хүрч, бурхан болно. Гэгээрлийн арга (упайя) нь эцэг (яб), билиг (праджня) нь эх (юм) ажээ. Залуу сайхан ханхүү очир завилгаагаар сууж, юмынхаа ар нуруунд зөрүүлсэн хоёр мутартаа хонх, очир барьжээ. Урт чихэндээ үнэт ээмгээр чимсэн. Цэнхэр үс нь мөрөн дээрээ унасан. Таван дэлбээтэй титэмтэй ба титэмний туузыг чихнийх нь ард маш гоёоор цэцэглүүлэн уяжээ. Дотийг нь олон дэлбээтэй цэцгэн хээгээр эмжжээ. Бугалга, бугуй, шилбэний чимэг нь гурван бөмбөлгөн хээтэй. Ташаан дээрх бүс нь том том сувстай унжлагануудтай. Торгон

дунгуй нь ар нуруунд нь нугалаас үүсгэж, мөр, ташаан дээгүүр нь тунарчээ. Билиг барамидын юм нь ханийнхаа хүзүүнээс зөөлөн тэвэрч, баруун мутартаа очирт хутаг *дигүгийг* зүүн мутартаа барьсан *гавал аяганы* дээр байрлуулан барьжээ. Тэрээр үнэт чулуунуудаар чимэглэгдсэн таван дэлбээтэй титэмтэй, чихэндээ том ээмэгтэй, товгор цэцгэн хээтэй таншимтай, бугалга, бугуй, шагайн чимэгтэй гэх мэтээр язгууртан бүсгүйн ёсоор хувцаслажээ. Бүс нь унжлагануудтай. Очирдарын доть нь саран дэвгэр дээрх тэгш хэмтэй давалгаа мэт харагдана.

Бадамлянхуа цэцэг нь дугуй бөмбөлөг хэлбэртэй, боловсорсон цэцгийн дохиурын орон шиг бодитой. Уран барималтай нь харьцуулбал сэнтийн суурь нь арай том, өндөр нь нийт өндрийн бараг гуравны нэгтэй тэнцүү, уран баримлаасаа хамаагүй том. Бадамлянхуа цэцгийн шүдэрхэг ирмэг нэг талдаа 8 дэлбээтэй тэгш хэмтэйгээр хуваагджээ. Бадамлянхуаны дээд ба доод талын ирмэг сувдан утсаар хүрээлэгджээ. Шүн (төвөд: *gzungs gzhigs*) нь хадгалагдан үлдсэн. Таган дээрх тамга нацагдоржийг алтдаагүй ажээ.

Зөөлөн мөлгөр хэлбэр дүрсүүд, цэвэрхэн, төгсгөлттэй шугам, зураас, бодит дүрсүүдээс бүтсэн уран баримлын зохиомж бол Занабазарын бүтээлийн онцлог юм. Бурхад нь үзэсгэлэнтэй, гоолиг, нарийн бэлхүүс, өргөн мөртэй харьцаа сайтай бие бялдартай. Нигурууд нь бясалгасан зөв, хэлбэртэй, нүдэнд бараг өртөхөөргүй “Занабазарын” өөрийнх бүргэд хамрын төвгөр, хуруу, мутар, бойвны тавхай нь жижиг.

Занабазарын бурхдын үс нь гурав хуваагддаг хоёр хэсэг нь хоёр шанаанаасаа доош унжиж, гурав дахь хэсэг нь ардаа сэнтийд хүртэл унжсан байдаг ажээ. Энэ үс нь гадаадын аялагчдын нэг бус удаа дурсаж байсан, XIII-XIV зууны үеийн монголчуудын үстэй адилхан ажээ.

Уран баримлын чимэглэлийн үндсэн хэсгүүд энгийн бөгөөд дэгжин, монгол дүрслэх урлагийн уламжлалт дугуй, цагираг, ороомог, бөмбөлгүүдийг тоолшгүй олон янзаар зохиомжлон гаргасан байдаг.



Зураг 4.3.4. Очирдара бурхны яв юм байдлаар буй уран баримал. Хүрэл, цутгамал. Өндөр нь 21 см, бадамлянхуа суурийн диаметр 15 см, өндөр нь 6 см. XV11-XV111 зуун. Монгол Улс, хувийн цуглуулга.

### **Базарсад бурхан. Утга ба гүйцэтгэх үүрэг Шүтээний агуулга**

Базарсад (санскр. vajrasattva; төвөд: rdo rje sems dra'; монг.: Базарсада/Доржсэмбэ — алмас эрдэнийн мөн чанар буюу Очирын ухамсар) төвөдийн буддын шашны бүх дэг сургуулиудад хүндэлдэг. Заримдаа түүнийг зургаа дахь бурхан, язгуурын таван бурхны тэргүүн гэдэг. Энэ тохиолдолд түүнийг заан тулсан сэнтий дээр суулгасан байдаг нь очирын биеийн хөдөлшгүй бат бөх гэдгийг бэлгэдэж байгаа юм. Тиймээс тэрээр Очирдара бурхны адил утгатай боловч үүрэг зориулалтын хувьд зарим онцлогтой, өөр өөр уламжлалд шүтэгддэг.

Базарсадын үүрэг зориулалтын үндсэн утга нь түүний ариутган цэвэрлэх хүчинд оршино. Энэ утга нь дөрвөн хэсэгтэй урьдчилсан буюу суурь бясалгал *нёндро* (төвөд: sngon 'gro)<sup>23</sup> хэлбэрээр зуун үсэгт Базарсадын тарни *игжа*-г (төвөд: yig brgya) бусад гурвынх нь адил зуун мянган удаа унших зэрэгт хэрэглэгддэг. Гэмээ наминчлах ба санваартаа унал гаргах (самг. roṣadha; төвөд. so sbyongs-тэжээх, арилгах)<sup>24</sup> зэрэг лам хүний зан үйлийн үед Базарсад бурханд ханддаг. Базарсад бурхны бясалгал нь ухаан санаа самуурах, муу сэтгэл

<sup>23</sup> Бэлтгэл буюу заавал байх ёстой үе шат нь 1) Гурван эрдэнэд аврал одуулах (лагшин, зарлиг, таалал ба эдгээрт хүргэдэг Лам багш) 2) Багшийн бясалгал хийх, 3) Базарсад бурхны зуун үсэгт тарниар ариусах, 4) мандал өргөх энэ дөрвийг тус бүрд нь 100 мянган удаа хийнэ.

<sup>24</sup> Монгол, Буриадын сүм хийдэд зуны улирлын төгсгөл хэсэгт 45 хоногийн ярнай хайлан (төвөд. byan gnas mkhas lan, *үгч*. 'зуны тангараг') хэмээх гэмээ наминчилж, сахилаа сэргээдэг уламжлал бий.

зэрэг бүх нисваанисаас салахад тусалж, цаашдын гэгээрэх үйлст нь сайхан дэвсгэр суурь болж өгдөг.

“Ринжүнжамц” (*төвөд. rin byung brgya rtsa*)<sup>25</sup>-ийн бүтээл<sup>26</sup> ёсоор Дарнатын (1575–1634) бурхан зурах түүвэрт бичсэнээр Базарсад шар өнгийн лагшинтай Хум хэмээх шар үсгээс үүсэж бодисадын суудлаар морилжээ (*самг. sattvaparyāñkāśana*).

Дарнатын зохиосон бурхан зурах түүвэр “Ниспана-йогавали”<sup>27</sup>-д бичсэнээр Базарсад “Дэмчигийн зургаан эзний мандлын” (*төвөд bde mchog 'khor los gyur drug*) голд нь байдаг. Уиллсон, Брауэн нарын бодлоор Базарсадыг Гэрэлтсэн джнянадак (санскр. *śrījñānaḍāka*) хэмээн нэрлэгддэг Авидармын тарнийн зүйлтэй нийцнэ. Түүний лянхуан дэвсгэрийг цагаан арслан өргөсөн байх ба өөрөө цагаан лагшинтай, очир завилгаагаар морилсон, Очирдагинаа тэврэн, мутартаа очир, хонх хоёрыг барьжээ. Мандал нь Бэрозана, Минтугва, Раднаасамбаа, Авид, Амгаасид [Willson & Brauen 2000: n. 482, p. 407] нараар хүрээлэгдсэн байдаг.

Базарсад бурхны уламжлалд хуучин тарниуд (*тиб. rnying ma ra*), ялангуяа зогчинд (*тиб. rtsogs chen*) чухал байр суурь эзэлдэг. Тэрээр анхны Ади Самандбазар бурхны дүрд буюу Төвөдийн бурхны шашны бусад дэг сургуулиудын тарнийн шинэ орчуулгын номтой Базарсадын дүр хэлбэрээр оршдог. Базарсад зогчны зан үйлийг анхны мэдлэг баригч Гаарав Доржид (*тиб. dga' rab rdo rje*)-д өгчээ [Garab Dorje 1996]. Гаарав Дорж өөрийн цээжилсэн олон тарнийг хүмүүст зааж өгч, ном тайлбарлаж, тухайлбал “Базарсадын агуу орон” (*тиб. rdo rje sems dra' nam mkha' che'*) [Dargyay 1998: 19] номыг тайлбарлаж байжээ.

“Их Бэрозанын тарнид” (VI–VII зуун) [Nakamura 1999; Тулку Ургъен 2000] Базарсад бурхны тухай өгүүлсэн байдаг. Базарсадыг Дүйнхор (X зуун), Дэмчиг (VII зуун), Ямандаг (VII зуун), Хэбазар (V зуун), Сандуйн (III зуун) гэсэн бүх үндсэн тарнийн номонд тухайн уншиж байгаа номонд саад болох үйлийн үрээс үүдэлтэй бүх саад тотгорыг урьдчилан арилгах цэвэрлэх үүрэгтэйгээр оруулдаг. Иймээс В. М. Монтлевич түүнийг

<sup>25</sup>Ринжүнжамц (*төвөд. rin 'byung brgya rtsa*, бүтэн нэр нь: *yi dam rgya mtsho'i sgrub thabs rin chen 'byung gnas*) нь Дарнатын зохиосон 483 хуудас ном “Ядамын бүтээлийн далай хэмээх эрдэнийн эх сурвалж оршвой” буюу товчоор хэлбэл, “охь шимийн бүтээл”. Дарнат XII – XIII зууны эхэнд зохиогдсон бурхан зурах арга заасан “Садханасамучайи”-д тулгуурласан. Сүүлд Ринжүнжамц нь Банчэн ламын “500 бурхан”-ы гол суурь болсон юм.

<sup>26</sup>Бүтээл (*самг.: sādhanā*, *тиб.: sgrub thabs*) гэдэг нь тодорхой нэг Бурхныг бүх шинж чанарыг бодит болгох ба бүтээлд хувь хүнийг бясалгахад зориулсан бурхныг дүрсэлж бичсэн, бясалгахтай холбоотой ямар зан үйл хийхийг бичсэний дагуу бүтээнэ.

<sup>27</sup> Ниспаннайогавали (*самг. nispannayogavali*) XI зуун XII зууны эхэнд Викрамашила их сургуулийн алдарт эрдэмтэн байсан Абхаякарагуптагийн зохиосон Энэтхэг бурхдын мандлын бурхдын түүвэр. Самгарди хэлээрх эх сурвалжийг нь анх 1949 онд Б. Бхаттачарья хэвлүүлжээ [Bhattacharya 1949].

нэлээн эрт үүссэн ба манай тооллын I зуунд Базарсадыг шүтэх зан үйл нь бүрэлдэн бий болсон гэж үздэг [Монтлевич 1]. Энэтхэгийн эрдэмтэн Б. Бхаттачарья эсрэгээрээ Базарсадын шүтлэг нь Очирдарын шүтлэгээс хуулбарласан, Непал, Төвөд, умардын буддын шашинтнуудын хүлээн зөвшөөрсөн хоёрдогч зан үйл юм хэмээн үздэг [Bhattacharya 1958: 39].

Занабазарын өөрийн хөргийн тухай авч үзсэн бүлэгт түүний бодит бүтээлүүдийн жишээн дээрээс авч үзэхэд тэрээр өөрийн дүрүүдийн хамгийн эртнийх нь Базарсад бурхантай холбоотой, энэ бурхны бүтээл тасрахгүй явж байгаа хэмээн шавь нартаа хичээнгүйлэн захисан байдаг. Тэрээр Базарсад бурхны хувилгаан дүрд орох бүрдээ энэхүү дамжлагыг дахин дахин дамжуулсаар иржээ. Базарсад бурхан нь хуучныг баримтлагчдын хувьд илүүтэйгээр анхдагч бурхан гэж тооцогдож, харин гэлүгбагийн уламжлалд Очирдара бурхан анхдагч бурхан гэж тооцогддог. Занабазар нь Базарсадыг Очирдариас илүүтэй шүтэж байсны шалтгаан нь Базарсадыг байр суурь илүү чөлөөтэй, уян хатан, нээлттэй байсанд оршино гэж тайлбарлаж болох юм.

### **1. Анхдагч бурхан Базарсад**

Базарсад бурхан нь нүд гялбам гялалзсан цагаан лагшинтай бадамлянхуа, саран дэвсгэр дээр, хоёр бойвныхоо тавхайг зөрүүлэн дээш харуулж ташаан дээр тавьсан очир завилгаар (*самг. vajraparyāṅkāśana*, тиб. *rdo rje 'i skyil krung*) морилдог. Зүрхэн тушаа газартаа нарийн арга, эвдэршгүй ухамсар, эрэгтэй хүний эрч хүчийн бэлгэдэл очирьг баруун мутраараа барьж, ташаан дээрх зүүн мутартаа цэцэн ухаан, бүх зүйлсийн мөн чанар болсон хоосон чанар, эмэгтэй эрч хүчийн бэлгэдэл болсон хонхыг дээш нь харуулан барьжээ. Базарсадаас нүд гялбам их гэрэл гарч, бясалгаж байгаа хүний биед орж, түүний биеийг рашаанаар дүүргэж, оюун ухаан, бие бялдар, сэтгэл санааных нь бүх нисваанисыг нь арилгана. Энэхүү сэтгэлгээний хог хаягдал гадагш гараад зогсохгүй рашаан болон хувирч, түүнийг залгиад байсан өлсгөлөн, ууртай амьтдыг хооллож, тайвшруулж, тэднийг газрын гүнд аваачин очроор түгжих нь хамгийн чухал юм.

Зураг 4.3.5. Анхдагч бурхан Базарсад. Хүрэл, цутгамал, алтадмал, өнгө будаг орсон. Хэмжээ нь: 72x40 см. Монгол улс. Гандан. [Цултэм 1982; Desroches 2009].

Энэхүү уран дүрийн бүтээсэн арга нь Ганданд байдаг Очирдара ба Чойжин ламын сүм музейд байдаг бурхныг (Зураг 4.4.?) бүтээсэн аргатай адилхан, тэргүүн зэргийн ач холбогдолтой бүтээлүүдийн нь тоонд багтана. Эдгээр бүтээлүүдийн онцлог нь олон

бүтэцтэй хийгдэх, титэм нь тансаг, чимгүүд нь торон эдлэл гаргах мэт нарийн нандин байх явдал юм. Занабазар өөрийн бага залуудаа хийж байсан бүтээлүүдээ ч бас ийм онцлогтойгоор бүтээж байжээ. Гэхдээ бас XVII зууны 70-80 онд бүтээсэн бүтээлүүдэд нь ч энэ онцлог бий.

### **Ялж төгс нөгчсөн Язгуурын таван агуу бурхан**

Язгуурын таван бурхан (*самг.*: pañca kula tathāgata, төвөд:sangs rgyas rigs lnga, монг.: Язгуурын таван бурхан) буюу таван Диян бурхан нь агуу уран барималч бүтээлийн төдийгүй, орчин цагийн Монголын бурхны шашны нэрийн хуудас болдог.

### **Сарьдагийн хийдээс олдсон шавар Диян бурхад (1654-1686 гг.)**

Шашны номынх нь гол багш нарын нэг Банчэн лам IV Лувсан Чойжижанцаны (1570-1662) зөвлөснөөр Төвөдийн Брайбун хийдийн загвараар 1654-1680 онд Занабазарын Хангайн нурууны өндөр уулын энгэрт (далайн төвшнөөс дээш 1500-2500 метрт) бариулсан хийдийн тууринд 2013-2017 онд хийгдсэн малтлагаар очир биедээ оршсон (эгэлд харагдах дүртэй, лам хувцастай) Бэрозана, Минтугва, Раднаасамбаа, Авид, Амгаасид хэмээх Ялж төгс нөгчсөн таван бурхан тэргүүтэй 600 гаруй шавар бурхан олдсон билээ.

Эдгээр уран баримлууд бараг нэг хэмжээтэй, хэдхэн мм-ийн л ялгаатай, 14-15 см өндөр, ижилхэн гурвалжин 10,0 x 5,5 см хэмжээтэй сууринууд дээр байрлажээ<sup>28</sup>. Дүрсүүдийн хажуу талд гарсан мөрийг харахад хоёр талтай модон бололтой хэвд хийж бүтээжээ.

Занабазар уран бүтээлийнхээ эхэн үед хийж эхэлсэн жижиг хотхонуудаа 20 нас ч хүрээгүй байхдаа барьж эхэлжээ. Эдгээр шавар бурхад түүний уран бүтээл эхэлснийг харуулж байгаа юм. Орд газар нь хийдээс холгүй байсан бололтой шавраар дүр бүтээх нь түүний хувьд хамгийн амархан бөгөөд энгийн арга байв. Шавар бүтээл маш олон тоотой байгаа нь (хийдийг эзэлж шатаахад ямар их зүйл эвдэрч сүйрсэн гэж санана) Занабазар Язгуурын таван бурхныг ямар их эрч хүчтэй бясалгаж байсныг нь нотолно.

**Зураг 4.4.1. Сарьдагийн хийдээс олдсон, Ялж төгс нөгчсөн язгуурын таван бурхан. Шавар. Өндөр нь 15 см. Занабазар, 1654–1686 он. Монгол улсын Угсаатны зүйн музейд гаргасан үзэсгэлэн дээр. Монгол Улс, Улаанбаатар хот, 2016 оны 7-р сар. Зургийг СС.**

<sup>28</sup> [Чулуун С., С.Өлзийбаяр, Б.Батсүрэн, Н.Хатанбаатар, Э.Уртнасан, Ч.Энхтуул, Г.Бямбарагчаа, М.Энхбаатар. Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дахь Сарьдагийн хийдэд ажилласан тайлан. УБ. Түүхийн хүрээлэнгийн Баримт мэдээллийн төв. - Отчеты Института истории и археологии АНМ о полевых работах по исследованию монастыря Сарьдагийн хийд в Эрдэнэ сомоне Центрального аймака 2013-2017 гг.]-аас хар.

Сарьдагийн хийдийн бүтээгдэхүүнүүд бол энэхүү уран барималчийн маань хамгийн эхэн үеийн бүтээлүүд бөгөөд суурийг нь бүтэн тойруулж боловсруулаагүй, бадамлянхуа цэцгийн дэлбээнүүдийг ганцхан нүүрэн талд нь хийсэн байх боловч үүнээс ч гэсэн түүний ялгарах онцлог харагдана. Юу гэвэл, юуны түрүүнд бурхан бүтээх тигийг баримталж, өргөн мөр, нарийн бэлхүүс, гавлын яс нь тэгш, дугуй, жижиг булбарай бугуй, дугуйрсан хэлбэрүүдтэй, гаргасан зураасууд нь гүйцэд, барзгар материал болох шавраар ч хэлбэр дүрсийг маш цэвэрхэн гаргажээ. Энд өтгөн хуш модтой тайга дотор Занабазарын нэгэн онцлог хэв маяг болох самрын боргоцой хэлбэрийн (лат.: *Pinus sibirica*, монг.: хуш мод) бадамлянхуа цэцгийн дэлбээтэй сэнтий (монг. самар бадам) хийх санаа төрсөн бололтой. Сарьдагийн хийдийн шавар дүрснүүдийг Занабазарын алдарт цутгамлуудтай харьцуулахад хэлбэр дүрс гаргах үндсэн аргууд нь харагдаж, энэхүү залуу насандаа бүтээж байсан энгийн хэлбэрүүдэд нь ч үндэсний гоо зүй харагдаж байна.

Зураг 4.4.1а. Сарьдагийн хийдийн шавар Раднасамбаа. Уран баримлын хэсэг. ШУА-ийн Түүх археологийн хүрээлэнгийн фонд. Баруун мутраа буян хайрлахыг илтгэсэн варада мутарлагатай (самг.: *varada mudrā*) барьжээ. Зургийг СС.

Зураг 4.4.1б. Сарьдагийн хийдийн шавар Амгаасэд. Уран баримлын хэсэг. ШУА-ийн Түүх археологийн хүрээлэнгийн фонд. Баруун мутраараа хамгаалах ба зоригтойг илтгэсэн хөдөлгөөн хийжээ (самг.: *varada mudrā*) барьжээ. Зургийг СС.Глиняный

Зураг 4.4.1в. Бэрозана бурхны номын хүрдийг эргүүлэхийг илтгэсэн хөдөлгөөн. ШУА-ийн Түүх археологийн хүрээлэнгийн архиваас. Бэрозана бурхны шавар баримлын хэсгээс Зургийг СС.

Зураг 4.4.1г. Бэрозана бурхан хажуу талаасаа. ШУА-ийн Түүх археологийн хүрээлэнгийн архиваас. Зургийг СС.

Зохиомж нь тэгш хэмтэй, геометр дүрсийн хэлбэр бараг зөв болохоор бурхдын сэтгэл санаа тогтвортой байгааг харуулна. Уг урлаач гэгээрсэн бодьгалуудын шинж байдал буюу гоолиг бие, арслангийн мэт их бие, мутар, бойв нь дугуйрсан, арьс нь гөлгөр, уян зөөлөн зэрэг шинжүүдийг ном ёсоор нь гаргажээ. Занабазарын бүтээлд хувцаснуудынх нь материалыг харуулж чаддагчлан таншиных нь (лам хүний өмсдөг банзал) нугалаас дэвүүр мэт хэлбэрээр сэнтий дээр нь тунарч, зүүн мөрөн дээрх орхимжных нь булан маш нарийн гарчээ.

**Минтүгва бурхан: Уурын ерөндөг болсон нугаршгүй тэвчээр**

***Шүтээний агуулга***

Нэрийг үгчлэн орчуулбал “Нугаршгүй” хэмээх Минтүгва бурхан (самг. *Akṣobhya*; төвөд *‘khrugs pa med pa/mi bskyod pa*; монг.: Минтүгва бурхан / Минтүгва/ Үл хөдлөгч) бол Таван агуу ялж төгс нөгчсөн буюу Дияан бурхдын нэг, өөрөөр хэлбэл гэгээрсэн бурхан юм. Агуу таван ялж төгс нөгчсөн бурхан нь Бурхны шашны таван язгуурын эцгүүд юм. Гэхдээ тэд бол үүсгэгч бурхад биш, харин хэлбэр, мэдрэмж, ойлголт, авьяас, ухамсрын

чуулганаас (скандха – *самг.*: skandha, *төвөд.*: phung po, *монг.*: цогц) чөлөөлөгдөхийг бэлгэдсэн аргууд юм. Муу сэтгэл бол уур, омог, шунал, атаархал, мунхгийг төрүүлдэг бие сэтгэлийн онцлогуудын тулгуур нь юм [Андросов, 2019, с. 315]. Тэгэхээр Ялж төгс нөгчсөн бурхад уур, омог, шунал, атаархал, мунхгийн хүний дүрээр илэрхийлсэн ерөндгүүд ажээ. Минтүгва бурхан нь таван бурхны хамгийн эхэнд байрлаж, нугаршгүй, тэвчээртэй тунгалаг ухаанаараа харгис зан, уур цухал, үзэн ядалт ба тэдгээрийн сүйтгэгч нөлөөнөөс салахад тусалж, эдгээр муу сэтгэлүүдийг эсрэгээр нь болгодог ажээ.

“Адвайя-ваджра-санграха” (*самг.*: Advaya vajra saṅgraha)-д Минтүгва бурхны дүрийг тодорхой бичсэн байдаг. Очир язгууртай (*самг.*: kula, *төвөд.*: rigs, *монг.*: ijaγur – язгуур, гарал үүсэл, овог удам) гэдгийг нотлох очирьг босоогоор нь барьсан, энэ язгуурынхаа тэргүүн бөгөөд мөнхийн хувиршгүй бурхны ухамсар, оюун ухааны бэлгэдэл юм. Очирын хоёр үзүүрийн таван хэл нь эрэгтэй, эмэгтэй бурхдын таван язгуурыг бэлгэддэг.

Минтүгва бурхны нугаршгүй зан нь бодит байдлыг элдэв шуналгүйгээр яг толинд туссан мэт тусгасан булингартаагүй, цэвэр мэдлэгийн биелэл юм. Түүний шийдэмгий зан нь Шагжамуни бурхны баруун мутраараа газарт хүрч гэрчлэгчдийг урин дуудах үеийн хатуу чанга байдал юм. Минтүгва бурхны үүрэг бол уур, омог, харгис зангийн эрчмийг эвдэршгүй, цэвэр цэцэн ухаан болгон хувиргах юм. Минтүгвагийн цэцэн ухаан бол туйлдаа хүртэл хөгжсөн ялган салгах чадвар, оюун ухааны задлан шинжлэх чадвар юм.

Түүний муу сэтгэлийн мөн чанар бол хэлбэр юм. Хэлбэр дүрс хамгийн бүдүүлэг мөртлөө амархан эвдэрдэг үйлийн үр юм. Уг бурхныг бүтээх явцад чөлөөлөлт Минтүгва-хэлбэрээс эхэлж илүү нарийн, илүү тогтвортой Бэрозана бурхны дүрээр илэрч байгаа ухамсар руу чиглэдэг. Бардо тойдол хэмээх үхэгсдийн тухай төвөд номонд хүн нас бараад зуурдад бардо байдалтай байхад язгуурын таван бурхан түүнд туслах гэж мэрийдэг. Цэвэр хэмжээсийн төвөөс эхлээд цагаан лагшинтай Бэрозана, араас нь хөх лагшинтай Минтүгва бурхан гарч ирдэг ажээ [ТКМ 1992: 60-61].

Минтүгва бурхны махбод нь ус бөгөөд хүний ухаан байгаль дээрх ус шиг уян хатан хэлбэр дүрсэд орохдоо амархан байх ёстой. Үүнээс гадна ус хөлдөж, мөс болохоороо хатуу, хурц болдог боловч доржпалам шиг тунгалаг, гялалзсан байдгийн адил оюун ухаан хэрвээ хөдөлгөөнгүй болбол хатуу, мөс шиг хүйтэн, харгис болдог. Хөдөлгөөнд орсон их ус бүтээх ч, сөнөөх ч чадалтай дийлдэшгүй хүч болон хувирна. Очир язгуурын өнгө нь цагаан ба хөх. Мандал дээр заримдаа Минтүгва ба Бэрозана



бурхдын лагшингийн өнгө, байрлал нь солигддог. Тэгвэл Минтүгва бурхан цагаан өнгийн лагшинтай таван бурхны голд, харин Бэрозана хөх өнгийн лагшинтай зүүн талд байрлана. Минтүгва бурхны зүг нь Төгс баясгалант (*самг. abhirati; төвөд: mngon par dga' ba* – Совершенная радость) хэмээх ариун газар оршдог зүүн зүг юм. Минтүгва бурхны улирал нь өвөл, өдрийн цаг нь үд дунд юм. Билиг бол Мамаки эх бурхан бөгөөд энэ хоёрын унаа нь хүч чадал нугаршгүй занг бэлгэдсэн хос заан юм. Энэ бурхны ойрын хоёр шавь нь Майдар, **Кшитигарбха** нар юм.

Мөн бусад тарнийн номнууд дээр Минтүгва бурхныг дүрслэн бичсэн байдаг ба дөрвөн мутар, зургаан мутартай, гурван нигуртай, зогссон, суусан, ганцаараа, Юмтайгаа зэрэг олон дүртэй байдаг [Bhattacharyya 1958: 40-41, 49-52]. 147-р онд бичигдсэн гэх “Минтуг бурхны орны судар” гэдэг Руханы ариун орны тухай хамгийн эртний дүрслэл болсон ном Алс дорнодын бурхны шашинд байдаг. Тэр номонд Минтүгва бурхан хэрхэн гэгээрсэн тухай бичсэн байдаг. Энгийн нэгэн лам хүн байснаа Дорнын оронд ном бүтээж ганц ч амьтанд уурлаж, хорсохгүй, гэгээрэхээс нааш хөдлөхгүй гэсэн амлалт өгч суугаад Минтүгва бурхан болжээ.

Ялж төгс нөгчсөн Язгуурын таван бурхад дотроосоо Минтүгва бурхан олон тоотойгоор цуглуулагчдад байдаг нь сонин. Дэлхийг байлдан дагуулсан таагүй дүр зураг, түүхэд тулгуурлан уур хилэнг цэвэр мэдлэг болгон хувиргах нь монголчуудад их ач холбогдолтой байсан бололтой. Жишээ нь Занабазар (1635-1723) өөрөө бүтээсэн гэгддэг Минтүгва бурхны сонирхолтой загварууд байдаг. Өмнө нь Улаанбаатар хотын томоохон музейнуудад хадгалагддаг Минтүгва бурхны хоёр том цутгамал баримлын зурагнууд ихээхэн түгээмэл байв. Монголд хэвлэгдсэн материалууд, сайт, музей, бурхны шашны нийгэмлэгүүдэд гээд тэдний зураг хаа сайгүй байдаг байв. Гэхдээ сүүлийн жилүүдэд энэхүү уран барималчийн бүтээлийн шинэ шинэ хуудсууд эргэсээр байна, тухайлбал Минтүгва бурхны дүр байна.

Занабазар бурхан бүтээх тиг, харьцааг нягт нямбай мөрдөж, монгол уламжлал ёсоор дугуй бүхэл дүрсүүдийг хэрэглэдэг онцлогтой юм. Үүн дээр нэмээд Улаанбаатар хотын Занабазарын нэрэмжит дүрслэх урлагийн музей дэх Агуу ялж төгс нөгчсөн бурхад, Цагаан Дарь эх бурхдын цутгамал зүйрлэшгүй өндөр төвшний ур хийц, гүн бясалгал, гадаад үзэмж, эд хэсгүүдийн боловсруулалт, алтдалтын чанар, өнгөлгөө, сийлсэн хэсгүүдийн нарийн ур хийцээрээ ялгарч харагддаг. Эдгээр бүтээл бурхдын амьдлаг, уян

зөөлөн арьс, хэзээ ч хөгшрөхгүй гоолиг биенийх нь уян хатан булчин, хувцасных нь налж унасан байдал, бүх зүйлийг үлдээлгүй анхааралдаа авсан боловч хязгааргүй эвдэршгүй амар амгаланг бясалгасан бурхдыг мэдрүүлнэ. Учир нь энэ бурхад энд, яг одоо байгаа юм.

## Улаанбаатарын Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейд хадгалагдан буй

### Минтүгва бурхны уран баримал

Эд. №69.43.70. 71-642. Хүрэл, цутгамал, алтадмал. 1683 г.

Хэмжээ: 71 х 46 см. Жин: 60250 гр.

Амгалангийн биед (*самг.*: saṃbhoga kāya) оршиж буй Минтуг бурхан очир суудлаар (*самг.*: vajra paryāṅka āsana) үзэсгэлэнт хаан хүү мэт заларчээ. Нэг нигур, хоёр мутартай ба баруун гарынхаа алгыг доош харуулан өвдөг дээрээ тавьж, дунд хуруугаараа газарт хүрсэн нь Гэгээрсэн гэдгийг минь батлаад өг гэж газраас уриалж байгаа утгатай (*самг.*: bhūmi sparśa mudrā) гэдэг. Зүүн мутар нь бясалгалын үеийн барьцтай (*самг.*: dhyaṇa mudrā). Урт бүйлс самар мэт мэлмийгээ нээсэн ба 45° өнцгөөр харж сууна. Занабазар хийцийн онцлог болсон үл мэдэг монхор хамар, цэцэглэсэн тууз мэт жижиг бамбагар уруул, зөөлөн зуувиндуу царай, хамрын доод үзүүрийн үрчлээсгүй байдал, хамарны хянганаас эхлээд хоёр тийш уртаар далавчилсан хөмсөг, духан дээрх том төвгөр билгийн нүд харагдана.

Зураг 4.4.2. Ялж төгс нөгчсөн Минтүгва бурхны уран баримал. 1683 он. Хүрэл, цутгамал. Хэмжээ: 71х46х46 см. Монгол Улс. Занабазарын нэрэмжит дүрслэх урлагийн музей. Эд. 69.43.70 71-642.

Өндөр овойсон *зүгдорынх* нь маш төвөгтэй байдлаар сүлжсэн үсийг тусгай (Зураг4.4.2г) дундад зууны үеийн монгол цэргийн байлдааны дуулганыхтай адил яс төмрөөр тогтоон барьж бадамлянхуа сууринд шигтгэсэн дүрэлзсэн эрдэнэсийн галан титмээр хүрээлэгджээ. Долгиотсон хөх үс нь титэмний доороос гурав хуваагдан, хоёр нь мөр рүүгээ уншиж, нэг хэсэг нь ар тал руугаа унжсан ба гурван хэсгийн завсраар мушгирсан үснүүд харагдана.

Титэм нь бадамлянхуа сууринд шигтгэсэн таван хэсэг дүрэлзэн асаж буй эрдэнэс мэт хэлбэртэй ба духан талын хэсэг нь бусдаасаа том, доод талдаа нэг том шигтгээ, дээр нь бас нэг том шигтгээ байх ба гурван жижиг цуварсан шигтгээ доод талын эрдэнээс салбарлаж, гурвалжиндуу хэлбэртэй болсон. Титмийг тогтоодог туузнууд дэвүүр хэлбэртэй нугаларч титэмний үргэлжлэл мэт харагдаж, ар шилэнд нь байлдааны дуулганы яс төмөр шиг товгор хадааснуудтай дугуйрсан хэсэг титмийг барьж тогтооно. Бугалга,

бугуй, шагайн чимэг нь тансаг, хүнд галын дөл хэлбэртэй эрдэнийн шигтгээнүүдтэй. Дүрэлзэж байгаа гал мэт хэлбэртэй асар том ээмэг нь дээд тал хоёр доод хажуу гэсэн гурвалжилсан хэлбэртэй. Титэм, бугалга, бугуйвч, шагайны чимгүүд монгол хээнд уламжлал болсон бугын эврэн хэлбэртэй.

Зураг 4.4.2а. Минтүгва бурхны газрыг гэрчээр дуудсан мутарлагатай. Баримлын хэсэг. Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей. Зургийг СС.

Зураг 4.4.2б. Минтүгва бурхны титмийн нэг салаа Баримлын хэсэг. Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей. Зургийг СС.

Зураг 4.4.2в. Минтүгва бурхны зүүн мутар дээр хорол дүрсэлсэн нь. Баримлын хэсэг дээрээс харагдах байдал. Монгол Улс. Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей, Эд. 69.43.70 71-642. Байнгын үзэсгэлэн. Зургийг СС.

Зураг 4.4.2г. Минтүгва бурхны үсний хэрэгсэл. Уран баримлын хэсэг. Ар талаасаа. Зургийг СС.

Занабазар бурхдыг бүтээхдээ бурхан зурах тигийг хэзээ ч алддаггүй учир бусад урлаачдын бүтээл үнэн зөв тигтэй эсэхийг түүний бүтээлтэй харьцуулж тогтоож болно. Бүгдийг судар ба тарнийн номон дээр бичсэний дагуу хийдэг. Бүтээсэн бурхад нь гэгээрсэн бодьгалын 32 үндсэн, 80 нэмэлт шинжүүдийг агуулсан байдаг. Тэр дундаа бусад урлаачдын голдуу орхигдуулдаг мутрын алга, хөл бойвын тавхайн дээрх *чакрын хүрдийг* Занабазар хэзээ ч орхигдуулдаггүй. Жишээ нь Минтүгва бурхны зүүн мутрын алган дээр *чакрын хүрдийг* сийлснийг олж харж болно (Зураг 4.4.2в). Энд босоогоор нь байрлуулсан, язгуурыг нь харуулсан очир байх ёстой байв. Гэхдээ одоо очир нь алга болсон бөгөөд сийлсэн дүрсийг нь бодит очир халхалж байсан ч дүрс нь байна.

Зураг 4.4.2д. Минтүгва бурхны суудал ба мутрын мутарлага. Уран баримлын хэсэг. Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей, Монгол Улс. Зургийг СС.

Бурхны хоёр улан дээр алтан түрхцийнх нь доор дараа нь нэг биш удаа нэмж тодруулсан гэгээрсний тэмдэг болох жижигхэн чакрын хүрд байна. Агуу урлаачийн цорын ганц дураараа хийсэн юм бол бурхны тигийн тухай номонд дурдагдаагүй, нэмэлт зүйл болгож ялж төгс нөгчсөн бурхан ядам хуруунд зүүсэн бөгж бөгөөд энэ нь Занабазарын бүтээсэн дияан бурхдын ховор онцлог юм. Минтүгва бурхны газар хүрсэн баруун мутрын ядам хуруунд нь жижигхэн усны дусал шиг хэлбэртэй, дээш чиглэсэн дөл шиг шигтгээтэй

бөгж зүүсэн байдаг (Зураг 4.4.2а). Зүүн мутрынх нь ядам хуруунд бас бөгж харагдана (Зураг 4.4.2в). Очир нь алга болсноос гадна уг баримлын магнай, зүүн хөмсгөн дээр бүйлсний самар хэлбэрийн хонхорхой эсвэл илүү гарсан метал тайрсан хэсэг болов уу гэмээр жижигхэн механик гэмтэл бий.

#### **Чойжин ламын сүм музейд хадгалагдаж буй Минтүгва бурхан**

Хүрэл, цутгамал, алтадсан, өнгө будаг орсон.

Өндөр нь 35 см, суурийн диаметр 20 см. Жин: 8720 гр.

Уг уран баримлын онцлог нь оюу, сувд, шүр, ногоолин, уулын ягаан болор зэрэг хагас эрдэнийн чулуудаар хийсэн чимэг юм [Каталог 2015: 32-33]. Бурхны барьсан очир нь хадгалагдаж үлдсэн (Зураг 4.4.3). Энэхүү уран баримал нь Занабазарын бүтээлийн бараг бүх давуу талыг агуулсан боловч ур хийц нь Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейд байдаг түүнтэй адилхан том бурхныхаас арай доогуур. Занабазарын гаргасан загвараар шавь нар нь бүтээсэн бололтой. Музейнхан энэ баримлыг ХҮШ зуунд бүтээгдсэн гэх боловч Хятадын эзэн хаан Хунли (Чиан лун, 1735-1795) хаан ширээнд сууж байх үед эрдэнийн чулуугаар чимэх урлал дэлгэрч эхэлсэн ХҮШ зууны эхэн үед хамруулж болох юм. Занабазар жинхэнэ урлаач хүний хувиар шинэ эрэлтийг мэдэрсэн байж болох мэт. Хэлбэр ба чимэглэл нь маш баялаг, олон янз гэдгийг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Үндсэн их биеийг нэг загвараар цутгадаг боловч бусад хэсгүүд, чимэг нь хэзээ ч давтаагүй ажээ. Харамсалтай нь уг уран баримал шүтээн хэлбэрээр гуун дотор байрлаж байсан болохоор нарийвчлан үзэх боломжгүй байв. Энэ уран баримлын сэргээн засварлалт, алтдах, будалт, эрдэнийн чулуу шигтгэхийг олигтой хийж чадаагүй бололтой.

Зураг 4.4.3. Чойжин лам, Монгол Улс. Чойжин ламын сүм музейд хадгалагдан буй Минтүгва бурхны уран баримал. XVIII зууны эхэн. Гууль, цутгамал, алтадсан, хөх, хар, улаан өнгө орсон. Өндөр 35 см., бадамлянхуаны диаметр 20 см., жин 8720,0 гр.

Энэхүү Минтүгва бурхны хуруунд бөгж байхгүй, Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейд хадгалагдаж байгаа бурхныхаас хуруунууд нь нэлээн урт, нарийхан. *Зүгдорынх* нь титэм ба үзүүр нэлээн шовх байгаа нь юуны түрүүнд Занабазарын бүтээл биш гэдгийг нь харуулж байна.

#### **А.Алтангэрэлийн цуглуулгад буй Минтүгва бурхны уран баримал**

Дээр дүрслэгдснээс гадна хувь хүний цуглуулгад энэ бурхан бас бий. Жишээ нь, Монголын алдарт цуглуулагч А.Алтангэрэлийн (азаар эрдэмтэдтэй хамтран ажиллах сонирхолтой) цуглуулгад анхаарал татам Минтүгва бурхны уран баримал байдаг. Энэ том уран баримлын зургийг 2005 онд цуглуулгын каталогид хэвлэж [ТМА 2005] Бээжин, Парисын үзэсгэлэнд дэлгэж байсан боловч түүнийг Раднаасамба<sup>29</sup> хэмээн эндүү тайлбарлаж байжээ. Минтүгва бурхны Раднаасамба бурханаас ялгарах гол шинж чанар нь хэрвээ барьж байгаа зүйл үгүй бол баруун мутрын мутарлага юм. Мятаршгүй энэхүү бурхан нь үр дүнд хүрэхээс нааш байрнаасаа хөдлөхгүй гэж шийдсэн Шагжамүний бурхны адил гэгээрснийг маань газар гэрчилнэ хэмээн баруун мутрын хуруугаа газарт хүргэсэн байдаг.

#### **14. А.Алтангэрэлийн их цуглуулга дахь Минтүгва бурхны уран баримал**

Гууль, цутгамал. Өндөр нь 34,5 см. Бадамлянхуа суурийн диаметр 22,5 см, высота 5 см. Алтадсан, хар, цагаан, хар хөх, улаан өнгө будагтай. Очир нь оройн үснэр *зүгдор* дээрх үнэт чулуу гоёл нь алга болсон (Зураг 4.4.4). Ёроолыг нь битүүмжилсэн болохоор шүн нь хадгалагдсан гэсэн үг ба алтадсан *нацагдорж* товойлгожээ.

Минтүгва бурхан бурхан бүтээх тиг ёсоор *амгалан дүртэй*, өөрөөр хэлбэл, нэг нигүүр, хоёр мутартай ба баруун мутраа алгаараа доош харуулан өвдөг дээрээ тавьж, дунд хуруугаа газарт хүргэжээ. (*самг.*: bhūmi sparśa mudrā). Зүүн мутраа бясалгалын байдалтай өвөр дээрээ алгаа дээш харуулан тавьжээ (*самг.*: dhyāna mudrā). Урт бүйлс хэлбэрийн мэлмий нь нээлттэй, урагш чиглэсэн харцтай, хүүхэн харааг нь хар дээр цагаанаар ялгаж зуржээ. Шулуун нарийн хамар, жижиг бумбагар цэцэглэсэн тууз мэт уруул, зөөлөн гонзгой нүүр, дугуй хацар, хамрын хянганаас эхэлсэн урт нумарсан хөмсөгтэй, духан дээр нь төвгөр *билгийн нүд* харагдана. Өндөр овоолсон зүгдорыг нь сүлжсэн үсээр гоёж, дөрвөн дэлбээт үнэт чулуун хэлхээгээр (үнэт чулуунууд нь алга болжээ) тойруулжээ. Хоёр бөөн үс мөрнийх нь урдуур унжиж, мөн зургаан төвгөр мушгирсан үс байна. Титэм нь таван хэсэгтэй, титмийг тогтоож байгаа тууз нь дэвүүр хэлбэрээр зангигдсан тул титэмний үргэлжлэл мэт харагдаж, толгой, хүзүүг нь тойруулан хамгаалсан мэт.

<sup>29</sup> Ийм зүйл тохиолдсон байх нь аргагүй. Учир нь тарнийн ёсонд Раднаасамбаа ба Минтүгва хоёрыг зарим үед “ижил ойлгодог” Өөрөөр хэлбэл, “Сандуйн тарнийн ёсоор” Раднаасамбаад очир юм Мамаки, мунхаг-уур, хорсол, очир махбод-ус байдаг бол “Адвайя-ваджра-санграх”-д энэ бүх чанар Минтүгва бурханд байдаг.

Зүүн мөрөндөө тохсон дунгуй нь нуруун талд нь тунарч, тохойноос нь доош ташаан дээр нь унжжээ. Додийг нь төвгөр цэцгэн эрх, хагас цагаригласан ороомог хэлбэрийн хээгээр чимэглэжээ. Ташааны бүс нь үнэт чулуун унжлага чимгүүд нь цэцгэн хэлхээн суурь дээр шигтгэсэн гоёмсог шигтгээнүүдээс бүтсэн байна. Мутар нь жижиг, булцгар, урт уян хатан хуруунууд ба гоё хэлбэртэй хумстай нь маш гоё зохицжээ. Очироо барихын тулд зүүн мутрынхаа дунд хурууг жаахан дээшээ өргөжээ (очир нь алга болсон). Хөлийн тавхай нь жижигхэн бөгөөд эрхий хуруу нь ээтгэр.

Энэхүү уран баримлын хийцэд хэд хэдэн онцлог бий. Жишээ нь чийрэг цээжийг нь бүхэлд нь хучсан хүзүүний чимэг нь маш чамин, байлдааны додьёог шиг. Маш том зүүлтний салаа мөчрүүд нь сувснууд завсраар нь орсон, дан цэцгэн эрхүүдээс бүтжээ. Гол нь 6 ба 10 дэлбээтэй цэцгэн эрх байна. Мөн мөрөн дээгүүр нь гарч ташаа хүртэл нь үргэлжилсэн урт сувдан зүүлт байна. Энэ нь бодисадва хүний бүс ажээ.



Зураг 4.4.4а. Минтүгва бурхны уран баримал. Гууль, цугтамал, алтадсан, өнгө будаг орсон. XVIII зууны эхэн. Хэмжээ: 34.5x22,5 см. Монгол улс. А.Алтангэрэлийн цуглуулга. Ерөнхий байдал. Зургийг СС.

Зураг.4.4.4в. Минтүгва бурхны уран баримал. Монгол улс. А.Алтангэрэлийн цуглуулга. Дээрээсээ. Зургийг СС.

Зураг 4.4.4б. Минтүгва бурхны уран баримал. Монгол улс. А.Алтангэрэлийн цуглуулга. Ар талаасаа. Зургийг СС.

Зураг 4.4.4г. Минтүгва бурхны уран баримал. Монгол улс. А.Алтангэрэлийн цуглуулга. Ёролын тамгатай

**А.Алтангэрэлийн бага цуглуулгад буй Минтүгва бурхны уран баримал**

Гууль, цутгамал, алтадмал, өнгө будаг орсон. XVIII зуун

Өндөр 19 см., суурийн өргөн 13.5 см.

Минтүгва бурхан (*самг.*: *nirmāṇa kāya*) хувилгаан дүрдээ орж, очир завилгаагаар суужээ (*самг.*: *vajra paṅka āsana*). Сударт бичсэнээр бясалгаж буй хүнд Минтүгва бурхан хөх Хум үсэгнээс үүсэж гэрэл цацруулдаг. Минтүгва бурхан ламын улаан хувцастай цэнхэр лагшинтай байдаг. Баруун мутар нь газарт хүрсэн (*самг.*: *bhūmi sparśa mudrā*), харин зүүн мутар нь бясалгалын байдалтай бөгөөд очирьг босоогоор нь барьсан байдаг. Нүдээ хагас нээсэн, магнай дээр нь билгийн нүд тод харагдана. Толгой дээрх үс нь овгоруудтай, хар хөх өнгөөр будагдсан ба зүгдорьг нь дугуй үнэт чулуун эрх хүрээлжээ (Зураг 4.4.6а-г).

Орхимжоо зүүн мөрөн дээгүүрээ тохсон нь зүүн мөр, мутрыг нь бүрхэж, харин баруун мөр нь ил харагдана. Хувцасных нь захыг ургамлан хээгээр (цэцэг, долгиотсон зураасууд) чимэглэглэгдсэн ба нуруун дээр нь орхимжны нэг үзүүр унжиж, харин нөгөө үзүүр нь өмнө талаасаа, зүүн мөрөн дээгүүр давсан байдалтай харагдана. Шамтавных нь үзүүр бадамлянхуа суурин дээр тэгш хэмтэй дэвүүр хэлбэрийн нугалаастай товойж харагдана. Бадамлянхуа сэнтий нь гурвалжиндуу хэлбэртэй, өндөр, хоёр давхар, голоор нь хуваагаад хоёр тийш нь татчихсан юм шиг тэгш хэмтэй давхар дэлбээнүүдтэй. Дэлбээнүүд нь Занабазар хийцийн боргоцой хэлбэртэй (*монг.*: самар дэлбээ). Сэнтийний дээд ба доод талын ирмэг нь сувдан хэлхээгээр эмжигджээ. Хээг үүсгэж байгаа үндсэн элементүүд нь цагираг, хагас цагираг, ороомог хэлбэртэй.

Том овортой Занабазарын бурхдаас энэ бурхан нь бүтнээр цутгах аргаар бүтээгдсэнээрээ ялгаатай боловч түүний хийцийн хэв маягийн шинж тэмдгүүд байна.

Зураг 4.4.5а. Минтүгва бурхны уран баримал. Гууль, цутгамал. Өндөр нь 19 см, суурийн өргөн 13.5 см. Монгол улс, А. Алтангэрэлаийн цуглуулга. Зургийг СС. Нүүрэн талаасаа.

Зураг 4.4.5б. Минтүгва бурхны уран баримал. Монгол улс, А. Алтангэрэлаийн цуглуулга. Зургийг СС. Ар талаасаа.

Ёроолд нь шүн нь (төвөд: *gzung zhig*, сокровищница) хадгалагдан үлдсэн. Нацагдорж хэлбэртэй товгор тамгыг алтаджээ. Уг цутгамлыг халаах аргаар алтдаж, үсийг нь хараар буджээ. Уруул дээр нь улаан будгийн ул мөр үлджээ. Зарим хэсэгтээ элэгдсэн, зүүн мутрынх нь ар тал, мэлмийн нүд, үсэн дээр нь хар толбо байна.

Минтүгва бурхан чийрэг залуухан, өргөн цээжтэй, бүсэлхийгээрээ нарийхан, агаараар дүүрсэн мэт. Эвдэршгүй хүч, шийдэмгий зан нь биеийн хөдөлгөөн төдийгүй царайнаас нь ч харагдана. Энэ баримал Занабазарын бүтээлүүд шиг туйлын энгийн бөгөөд товч тодорхой харагдана.

### **Олон янзын цуглуулгад буй Минтүгва бурхныг бүтээсэн онцлогууд**

Дээр дурдсан овор хэмжээ томтой Минтүгва бурхны уран баримлууд Бурхны амгалан биед оршсон (зөвхөн сайн дадлагажсан бясалгагч нар л бурхныг ийм байдалд нь харж чадна) хааны газарт байхдаа л хэрэглэдэг бодисадвагийн хааны хэрэглэдэг чимэгтэй ажээ. 19 см өндөртэй жижигхэн цутгаж ба шавраар бүтээсэн Минтүгвава бурхад бол хувилгаан дүрдээ, өөрөөр хэлбэл лам хувцастай эгэл хүмүүст харагдах дүрээр байгаа юм. Эдгээр бурхад бүгдээрээ бурхан бүтээх тигийг ганц ч алдаагүй баримталсан, дугуй хэлбэртэй, хэлбэр дүрс цэвэрхэн, зурааснуудыг гүйцэд гаргасан, царайны байдал ижилхэн байх зэрэг Занабазарын хийцэд байдаг бүх шинж чанаруудтай адилхан бурхдын тигийн зөв тэгш харьцаатай ажээ. Уран баримлын загварыг нь Занабазар гаргасан гэж хэлэхэд буруудахгүй. Үүний сацуу тэдгээр нь гадаад байдал, зан байдал, сэтгэлийн хөдөлгөөн, нарийн ур хийцээрээ ялгаатай. Энэ нь тухайн уран баримлыг бүтээхэд урчууд янз бүрийн байдлаар оролцдогийг харуулж байгаа юм. Бурхан бүр янз бүрийн бадамлянхуа сэнтийтэй. Шавран дүрснүүд тойрсон чимэггүй, гурвалжин суурьтай ажээ. Гол хэсгээс нь татчихсан бөмбөр шиг, дугуй суурин хоёр давхар бадамлянхуа суурин дээр Минтүгва бурхан морилно. Өөр хоёр бурхан шууд цэцгний дугуй цоморлиг дотроос урган гарч ирж мэт, бүтнээр нь цутгасан бадамлянхуаны үргэлжлэл мэт харагдана. Алтадсан аргууд нь өөр өөр ажээ. Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейн том бурхныг бурхны лагшины ил гарсан хэсгүүдийг хүйтэн аргаар алтадсан учраас бүүдгэрдүү харагдаж, харин чимэг, хувцсыг халуун аргаар алтадсан болохоор гялалзаж, бүүдгэртэй хоршиж жинхэнэ хүний



амьд арьс шиг харагдана. Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейн бурхан гайхалтай бодитой болохоор амьсгалаад байгаа мэт сэтгэгдэл төрүүлдэг. Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейн том Минтүгва бурхны галбир зөөлөн, ууссан, *зүгдортой* титэмний хэлбэр монголын *тоорцог* малгай шиг харагддаг<sup>30</sup>.

А.Алтангэрэлийн хувийн цуглуулгад буй Минтүгва бурхны царай Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей, Чойжин ламын сүм музейд хадгалагдаж буй нөгөө хоёр бурхнаас арай эрэлхэг, нэлээн хүйтэн хөндий харагдана. Ингэснээрээ тэр Базар-Херукагийн шинж чанарын биелэл болжээ. Өөрөөр хэлбэл, Очир баатар цэрэг байх нь Минтүгва бурхны нэг дүр юм. Титэм туузнуудтайгаа мөр хүртэл нь толгойг нь тойрсон тойрог үүсгэж том ээмэгтэй хоёр том чих, хүзүүний чимэгтэй нь уусаж үргэлжлэн, эртний баатар цэргийн хамгаалалт мэт харагдана. Үүнд энэхүү Минтүгва бурхны нэлээн чухал онцлог орших бөгөөд маш нүсэр чимэг зүүлт нь уг бурхныг тод, баатарлаг харагдуулж байгаа юм. Тэгэхээр хувь хүний цуглуулга, музейнуудын санд ч Занабазарын бүтээсэн, нэг их алдаршаагүй уран баримлууд байдаг ажээ. Мэдээж, Занабазар өөрийнхөө бүтээлийг яг ижилхнээр хэзээ ч хуулж байгаагүй бөгөөд бүтээл бүр нь давтагдашгүй онцлогтой, тодорхой өнгө аястай байдаг ажээ. Уран сайхны хэв маягийг нүүдэлчдийн уламжлалт гоо сайхантай нэгтгэн харуулсан, дугуйрсан хэлбэр, битүү зураасыг голлож, хий угалзыг амьдчилж, Бурхны шашны уран барималд агуу ур чадварынхаа давтагдашгүй ялгарах онцлогийг бий болгожээ. Бүтээсэн бурхадых нь нүүр царайг харахад Занабазар өөрөө бүтээжээ гэж ялгарч харагддаг боловч бүтээлийг бэлэн болох бүх үйл явцын аль хэсэгт тэр өөрийн гараар оролцсон нь ч бас харагдана. Тухайлбал шавар дүрснүүдийг гаргахад тэрээр зөвхөн хэвлэх модон хэвийг нь бүтээж байжээ. Харин Улаан батар хотын Дүрслэх урлагийн музейд байгаа том, цутгамал бурхдыг Занабазар эхнээс нь дуустал яг өөрийн гараар 1683 онд бүтээжээ. Энэ тухай эх сурвалж дээр бичигдсэн байдаг ба эдгээр бүтээл түүний бүтээлийн нэгдүгээрт бичигдэнэ. А.Алтан гэрэлийн цуглуулгад байдаг Минтүгва бурхны том уран баримал арай хожуу ХҮII-ХҮIII зууны заагт түүний ойрын шавийн оролцоотойгоор бүтээгдсэн бололтой. Бүр сүүлд ХҮIII зууны эхээр бүтээгдсэн Минтүгва бурхны жижиг баримал мөн шавийнх нь оролцоотой хийгдсэн гэж хэлж болно.

---

<sup>30</sup> Тоорцог – дөрвөн дэлбээтэй цэцэг шиг хэлбэртэй, бөмбөгөр оройтой, дээрээ товчруутай, чих, саравчгүй монгол малгай.

## **РАДНААСАМБА бурхан: омголон зангийн ерөндөг төлөв төвшин болох нь**

### ***Шүтээний агуулга***

Раднаасамба (*самг.*: ratnasambhava; *төвөд.*: rin chen 'byung gnas, *монг.*: Ринченжунай, Раднасамбава, Эрдэнээр үүсэгч) – эрдэнээр үүсэгч буюу эрдэнэсийн эх сурвалж. Энэ бурхан нь Раднаа язгуурын бурхдын тэргүүн бөгөөд хүслийг биелүүлэгч чандмань эрдэнийн дүрс бол энэ язгуурын бэлгэ тэмдэг юм. Мандалд Раднаасамба бурхан өмнө зүгт, өмнө зүг рүү харж байрладаг. Түүний эмэгтэй дүр нь **Ваджрадхатвишвари**, гол бодисадва нь **Кшитигарбха** эсвэл **Ратнапани**, махбодь нь шороо, хөлөг нь морь эсвэл хос арслан. Сансрын гурван мэдрэмж, хаврын улирлыг төлөөлдөг өдөр, шөнийг дөрөв хуваасны дөрөв дэх хэсэг буюу үүр цайхын өмнөх ба харуй бүрүйд оршдог. “Ниспанайогавали”-д бичсэнээр Раднаасамба нь олон мутартай байж болдог [Bhattacharya 1958: 73-74]. Ялж төгс нөгчсөн Раднаасамба бурхны эгэл хүмүүст харагдах дүр нь Шагжамуни бурхны өмнө байсан Одсүрэн бурхан ажээ.

“Зуурдын тухай төвөд” номонд бичсэнээр хүн нас бараад зуурдад байхад нь Минтүгва бурхны дараа гурав дахь өдөр нь Раднаасамба бурхан гарч ирдэг. “Адхвайясанграха тантр”-д Раднаасамба бурхан нь саран саран дэвсгэр, бадамлянхуа цэцгийн өмнө зүгт буй дэлбээнүүдээс шар өнгийн ТРАМ үсэгнээс үүсч гардаг гэдэг. Лагшин нь шар өнгөтэй. Раднаасамба бурхан зүүн мутраа ташаан дээрээ алгаа дээш нь харуулан хүсэл хангагч чандмань эрдэнэ (*самг.*: cintā maṇi, *монг.*: зэндэмэни, чиндмань) барьжээ. Баруун мутраа мөн алгаар нь дээш харуулж, өгөөмөр сэтгэлийг бэлгэдэж бэлэглэх мутарлага (*самг.*: varada mudrā), үзүүлжээ. Раднаасамба бурхны үндсэн үүрэг нь омог бардам (*самг.* māna) муу сэтгэлийг төвшин мэргэн ухаан болгон хувиргах юм. Сэтгэлээ ариусгасны дараа таны чухал хүн гэдгийг бүх хүн мэдээсэй, нөлөөгөө ихэсгэе гэсэн туйлын их хүслийг цэцэн ухаан буюу жинхэнэ эрдэнэ болгон хувиргаж, өөрийнхөө эргэн тойрныг баялаг болгож, сайхан зүйл бүтээхэд бэлэн бүтээлч сэтгэлгээтэй болгоно. Раднаасамба бурхнаас Жамбал, **Васудара** бурхад үүсдэг.

### **Чойжин ламын сүм музейд буй Раднаасамба бурхан**

Эд.№ О 42.62. Хүрэл, цутгамал, алтадсан, өнгө будаг орсон.

Хэмжээ: 70 х 45 см. Жин: 55740 гр.

Раднаасамба бурхны энэ том баримал нь Язгуурын таван бурхдын баримлын тоонд ордог ба эдгээрийн дөрөв нь Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейд тавигдсан байдаг харин Раднаасамба нь ганцаараа Чойжин ламын сүм музейд байдаг. Урлаачийн бусад ажлын адил өөрийн гэсэн дараах онцлогтой: титэм дээр нь Раднаа язгуурын гол бэлгэдэл (*самг.*: *ratna* - эрдэнэ) гурван нүдтэй *чандмань* гол чимэг болон байрладаг<sup>31</sup>. Чандмань нь сүм хийдийн хаалгыг манадаг Зээбадын (*самг.*: *kīrtimukha* – лик величия) сүрт хоншоор дээр байдаг (Зураг 4.4.6).

Зураг 4.4.6б. Ратнасамбава бурхны мутарлага. Гууль, цутгамал, халуун, хүйтэн аргаар алтадсан. Хэмжээ: 72x45 см. Монгол улс. МХЧЛ-ийн байнгын үзэсгэлэн. Уран баримлын хэсэг. Мудра Ратнасамбын мутарлага. Зургийг СС.

Зураг 4.4.6а. Ратнасамбава. Хүрэл, цутгамал, халуун, хүйтэн аргаар алтадсан. Өндөр 72 см. Суурийн диаметр 45 см. Монгол улс МХЧЛ-ын байнгын үзэсгэлэн.

Бусад дөрвөн ялж төгс нөгчсөн бурхдын уран баримлаас ялгаатай нь Раднаасамба бурхны бясалгалын мутарлагатай (*самг.*: *dhyani mudrā*) зүүн алган дээр нь байх ёстой чандмань эрдэнэ алга болсон, зүгдорынх нь оройны дүрэлзэж буй гал мэт хэлбэртэй эрдэнийн хэсэг нь халцарсан ажээ. Зүүн өвдөгнийх нь доод тал гэмтсэн байна.

#### **АВИД бурхан: хүсэл шуналын ерөндөг**

##### ***Шүтээний агуулга***

Авид бурхан (*самг.*: *amitābha*, *төвөд.*: 'od drag-med; *монг.*: Абида бурхан) бурхны нэр нь “Хязгааргүй гэрэлтэгч” буюу “Хязгааргүй гэрэл” гэсэн утгатай. Ялж төгс нөгчсөн таван бурхдаас Авид бурхан л Бурхны шашинтай улсуудад тэр дундаа Их хөлгөн ба Очирт хөлгөний бурхны шашинтай орнуудад хамгийн их тахин шүтэгдэг. Авид бурхан монголчуудын дунд түгээмэл баруун диваажин Сугавадийн орны (*самг.*: *sukhāvati* ; *төвөд.*: *bde ba chan*; *монг.*: Диваажингийн орон) эзэн ба сүсэгтнүүдийн ихэнх нь нас барсныхаа энэхүү оронд төрөхийг мөрөөддөг. Авид бурхны ариун оронд очиж төрөхийг мөрөөддөг. Үүнтэй холбоотой Авид бурхны ариун оронд очиж төрөх ухамсраа *пхова* (*төвөд.*: *pho ba*)-гоо шилжүүлэх бясалгал байдаг. Мандал дээр Авид бурхан баруун талд байрладаг.

<sup>31</sup> Чандмань (*самг.*: *cintā maṇi*, *төвөд.*: *yid bzhin norbu*, *монг.*: зэндэмэни) бол хүсэл биелүүлдэг шидэт чулуу юм. Газар доорх эрдэнэсийг хамгаалагч нагуудын хаан Шагжамуни бурханд далайн ёроолоос авчирч бэлэглэсэн гэдэг. Алс дорнодын бурхны шашинд үүнийг “шатаж буй эрдэнэ” гэж нэрлэдэг ба том сувд хэлбэрээр дүрсэлдэг. Энэ нь Жанрайсаг ба **Кшитигарбхи** бодисадва нарын барьдаг **зүйл** юм. Чандмань эрдэнэ үүссэн талаар Төвөдийн буддын шашинд Төвөдийн хаан Лхатоторийн (Ү зуун) ордны орой дээр тэнгэрээс “Ум ма ни бад мэ хум” хэмээх маанийн үсэгтэй чулуу тэнгэрээс унаж ирсэн гэж ярьдаг. Дээд хэсэгтэй нүдтэй гурван дусал хэлбэрээр дүрслэгддэг, хийморь хэмээн морины нуруун дээр байрлуулсан нь байдаг (*төвөд.*: *rlung rta*) [DDB <http://www.buddhism-dict.net/ddb/indexes/term-sa.html>; Beer 1999].

Тэрбээр хэл ярианы ухагдахуунтай холбоотой улаан ХРИ үсэгнээс үүсдэг. Очир завилгаагаар морилж, хоёр мутраа өвдөг дээрээ бясгалын мутарлагтай (*самг*: dhvani mudrā).байрлуулжээ. Түүний толгойлдог бурхны язгуурыг Бадма-бадамлянхуа гэдэг болохоор энэ язгуурын бэлгэдэл нь бадамлянхуа юм. Улаан лагшинтай. Унаа нь хорноос айдаггүй тогос шиг гай зовлонг шүүрдэн хаян гэсэн утгатай тогос байдаг. Эмэгтэй дүр нь **Пандара**, үндсэн бодисадва нь Бадмапани Жанрайсиг. Махбодь нь гал [Shakya 1994: 54-55].

Авид бурхны тухай бичсэн хамгийн анхны судар бол “Пратьютпанна судар” (pratyutpanna sutra)-ын хятад орчуулга юм. Энэ судрыг 1979 онд Төв Азийн лам Локакшема (Кушаны хаант улсын) хятад хэлэнд орчуулжээ. Энэ бүтээлд Шагжамуни бурхан бясалгал хийж Авид бурхан болон бусад бүх бурхдыг олж харж болно гэж хэлсэн байдаг. Их хөлгөний гүн ухаантан Нагаржуна (II–III зуун) “Найрсаг илгээлт” гэдэг номондоо бас Авид бурхныг бас дурссан билээ. “Сугвади вьюха” (Жаргалын орныг дүрслэхүй), “Авидын дияан судар” (Авидыг бясалгах судар) хэмээх гол шүтээн номтой Авидизмийн урсгал үүссэн Япон, Хятадад Авид бурхныг онцгойлон шүтдэг [Андросов: 607]<sup>32</sup>.

Дэлхий дээрх гадаа байдаг хамгийн том бурхан гэж тооцогддог байсан Японы Камакурэд (Дайбуцу) дэх асар том Авид бурхны хөшөөг дэлхий даяараа мэднэ. Хамгийн эртний Авид бурхны хөшөөний нуранги манай эриний II зуунд хамаарагдана. Энэтхэгийн Матхура музейд Говиндо-Нагарийн хөөмөл дээрх бичиг хадгалагдан үлдсэн байдаг. Авид бурхны уран баримлыг “Хувишкийн 28-р онд”, өөрөөр хэлбэл II зууны 2-р хагаст Кушаны эзэнт гүрний үед нэгэн худалдаачин гэр бүлээрээ босгосон байдаг.

Авид бурхан бий болсон түүхэнд түүнийг Бхикшу Дхармакара гэдэг бодисадва байсан гэдэг. Нэрийг нь чанга дуугаар дурдсан бүх бодьгалын очиж болох хязгааргүй их аз жаргалтай орон газрыг бүтээнэ хэмээн өөртөө амлалт өгсөн байжээ. Энэ амлалтад тулгуурлан амлалт өгч, итгэж сүжиглэн, бясалгасан аливаа бодьгалыг Сугавадийн ариун хязгааргүй амар амгалан орондоо хүлээн авна гэсэн байдаг.

Авид бурханаас бас Аюуш, Хаянхирваа, Гүрүгүлэ эх, Брикхути, Дарь эхийн зарим дүрүүд төрөн гардаг. “Төвөдийн зуурдын ном”-нд бичсэнээр зуурдад Раднаасамба бурхны дараа дөрөв дэх өдөр нь Авид бурхан гарч ирдэг. Түүнтэй холбоотой муу сэтгэл бол

<sup>32</sup> [https://bigenc.ru/religious\\_studies/text/1818448-aac](https://bigenc.ru/religious_studies/text/1818448-aac) хар

шунал юм (*самг.*: *rāga*). Бусад бүх ялж төгс нөгчсөн бурхдын адил Авид бурхны гол үүрэг нь эд зүйлст татагдаж, хурааж хуримтлуулах дуртай шунал хүслийг хувирган өөрчлөх юм. “Би”-г дээдлэх, шуналд авахаас салсны дараах цэцэн ухааныг ялган ухамсарлах цэцэн ухаан гэдэг.

Бадмын язгуур (*самг.*: *padma*) нь Очирт хөлгөний түүх ба Монгол, Төвөдийн харилцаанд нөлөөлөх үүрэг гүйцэтгэжээ. Далай лам бол Жанрайсиг бурхны эгэл хүмүүст харагдах хувилгаан дүр, Банчэн лам болохоор Авид бурхны хувилгаан дүр ажээ. Тиймээс, Занабазар өөрийн язгуурын багш IY Банчэн лам Лувсан Чойжижалцангаар (*төвөд.*: *blo bzang chos kyi rgyal mtshan*; 1570-1662) дамжин Авид бурхны язгууртай нягт холбоотой ажээ. Үүнтэй холбоотойгоор агуу уран барималч маань олон тооны Аюуш бурхан (*самг.*: *amitāyus* *төвөд.*: *tshe drag med*; *монг.*: Аюш бурхан – *үгч.* Хязгааргүй амьдрал) бүтээсэн байж болох юм. Аюуш бурхан бол Авид бурхны урт нас хайрладаг дүр нь юм.

#### **Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейд буй Авид бурхны уран баримал**

Эд.№69.43.71. 72-642. Хүрэл, цутгамал, алтадмал. Өнгө будаг орсон.

Хэмжээ 70,5 х 45,5 см. Жин: 52250 гр.

Ялж төгс нөгчсөн таван дияан бурхны цувралд багтдаг их Авид бурхан өөрийн гэсэн онцлогтой. Тухайлбал, дотиных нь үзүүр нь бадамлянхуаг хажуу талаас нь харж зурсан хээтэй, дараагийн тойрог нь бадамлянхуа цэцгийг эгц дээрээс нь харсан хээгээр чимэж, бадамлянхуа язгуурын Авид бурхны бэлгэдлийг харуулжээ.

Дотиных нь ар талын чимэг нь том том баглаа бадамлянхуа цэцэг ажээ. Үснэр нь таван хэсэг болж унжжээ. Хоёр хэсэг нь хоёр мутрыг нь даган могой мэт мушгирч, Гурав нь цагираглан нуруун дээр унажээ. Орхимжоороо цээжээ ороож зүүн мөрөн дээрээ тохсоны ар нуруунд нь хоёр хэсэг тахир хэлбэр үүсгэжээ. Хүзүүний чимэг нь нэг их томгүй, доош харсан гурвалжин хэлбэртэй ажээ. Мутраа Бясалгалын мутарлагтай байгаа болохоор бугуйн чимгийг нь харах боломжгүй болжээ **(Зураг 4.4.7в).**

Зураг 4.4.7а. Авид бурхны уран баримал. Гууль, цутгамал, алтадмал, сийлбэртэй. Монгол улс. Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей.

Зураг 4.4.7б. Авид бурхны уран баримал. Монгол улс. Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей. Ар нуруу талаас.

Зураг 4.4.7в. Авид бурхны уран баримал. Гууль, цутгамал, Зураг 4.4.7г. Авид бурхны үс засалт. Баримлын

алтадсан, сийлбэртэй. Монгол улс. Занабазарын нэрэмжит хэсэг. Зургийг С.С. Дүрслэх урлагийн музей. Баримлын хэсэг. Очир суудал ба бясалгалын мутарлага (самг.: vajraparyāṅkāṣana; dhyāni mudrā) Авид. Зургийг СС.

## АМГААСИД бурхан: Атаархлын ерөндөг

### *Шүтээний агуулга*

Амгаасид (самг.: amoghasiddhi, төвөд: don yod grub pa, монг.: Дондуб /Үйл бүтээгч/Амогашиди, букв. Амжилттай бүтээх) бурхан нь Үйл язгуурын тэргүүн нь юм. Дан ганц Амгаасид бурхан нь Дияан бурхны хувьд бадамлянхуа цэцгийн дэвсгэр дээр бясалгалын суудлаар морилж, барун мутраа цээжиндээ алгаа гадагш нь харуулан, хуруунуудаа тэнийлгэн, хамгаалах аймшиггүй зоригийн мутарлагаар (самг.: abhaya mudrā) барьжээ. Зүүн мутраа өвдөг дээрээ алгаар нь дээш харуулан, нацагдорж (самг.: visva vajra, төвөд: rna tshogs rdo rje).барьжээ. Амгаасид бурхны лагшин ногоон. Ногоон нь донтох муу сэтгэлийн (самг.: saṃskāra; төвөд: ‘du byed – үүсмэл туршлага) ба атаархлын (самг.: irshya) өнгө юм. Цэвэр хэмжээсээр бол атаархал нь саад тотгорыг арилгадаг цэцэн ухаан болж хувирдаг. Амгаасид бурхан нь шаргуу зан, бүх бясалгалд амжилт гаргах хүчин чармайлт, зөв үйлийнхээ үр дүнг алдаагүй таних чадвар бэлгэлдэг. Хий махбодтой. Өвлийн улиралтай холбоотой. Хойд зүгт Гэгээрлийн үйлийг төгөлдөржүүлдэг (төвөд: las rab rdzogs pa byang phyogs ‘i zhing khams / las rab rdzogs pa) Ариун газарт Амгаасид бурхны орон байдаг. Түүний нөхөр сэлт нь Очирваань ба **Сарваниварана вишкамбхин** бодисадва нар юм. Амгаасид бурхнаас **Кхадиравани Тара, Арья Тара, Махамаюри и Парнашавари** нар төрдөг. Зуурдад (төвөд. chos nyid bar do) Амгаасид бурхан Авид бурхны дараа тав дахь өдөр нь гарч ирдэг.

Зураг 4.4.8а. Амгаасид бурхан. Хүрэл, цутгамал, алтадмал, өнгө будаг орсон. Хэмжээ: 70x45,5 см. Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей. Эд.№69.43.68. 69-642. [ММШУД, v.I. н.182].

### **Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейд буй Амгаасидын уран баримал**

Эд.№69.43.68. Өндөр: 70 см, диаметр: 45,5 см. Жин: 57400 гр.

Амгаасид бурхны хувцсан дээрх хээ хуар Занабазарын бусад Дияан бурхадын адил язгуурыг нь илэрхийлдэг бөгөөд өөрөөр хэлбэл *Үйлийг* илэрхийлсэн *зөрүүлсэн очир* буюу

нацагдорж юм. Энэ хээгээр дотиных нь үзүүрийг чимсэн ба хоёр дахь тойрог нь иштэй цэцгэн хээ ажээ (Зураг 4.4.8в).

Зураг 4.4.8б. *Үйлийн* язгуурын Амгаасид бурхны ялгарах тэмдэг болсон *нацагдоржоор* зүгдороо чимсэн байдал Занабазарын нэмрэмжит Дүрслэх урлагийн музей, Монгол улс. Зургийг С.С.

Зураг 4.4.8в. Амгаасид бурхны дотийг цэцгэн эрх ба нацагдорж хээгээр чимсэн нь. Уран баримлын хэсэг. Занабазарын нэмрэмжит Дүрслэх урлагийн музей, Монгол улс. Зургийг С.С.

Дотиных нь ар тал хэрээс хэлбэрийн хээтэй байгаа нь мөн л нацагдоржийг илэрхийлж байгаа юм. Мөн *зүгдор* дээрх хавчаар нь бас нацагдорж хээтэй (Зураг 9а). Амгаасид бурхны хүзүүний чимэг тэгш өнцөгт хэлбэрийн шигтгээтэй суурьтай (хийг илэрхийлдэг) ажээ. Хамгаалах болон эр зоригийн мутарлагатай (абхайя-мудра) мутрынхаа ядам хуруунд зүүсэн бөгж нь цээнэ цэцгэн шигтгээтэй ажээ. Мөр рүү нь таван хэсэг мушгирсан үс унасан Минтүгва бурхан ба гурван хэсэг мушгирсан туг үс унасан бусад дияаны бурхдаасаа ялгаатай нь Амгаасид бурхны үс гурван хэсэг боловч мушгираагүй шулуун ажээ. Зүүн мутар нь бясалгалын мутарлагатай алгаа дээш нь харуулсан ба эрхий хурууг тусад нь бүтээж алгатай нь нийлүүлжээ.

### БЭРОЗАНА бурхан: мунхагийн ерөндөг

#### *Шүтээний агуулга*

Бэрозана бурхан (*самг.*:vairosana; *төвөд.*:gnam par snang mdzad; *монг.*:Бирузана/Нанзад бурхан/Маш гийгүүлэн зохиогч). Энэ бурхны нэр бүх ертөнцийн өнцөг булан бүрт нэвтрэн ордог Гялалзсан буюу Туяарсан гэрэл гэсэн утгатай. Тэрбээр Бурхан буюу Ялж төгс нөгчсөний язгууртай бөгөөд бүх бурхдын мөн чанарыг нэгтгэдэг ба бүхнийг мэдэгч, хаа сайгүй байдаг ухамсрын анхдагч, үнэн байдлын биелэл болдог. Бэрозана бол Ялж төгссөн таван бурхныхаа хамгийн сүүлийн буюу хамгийн эрхэм бурхан нь юм. Бурхны язгуур нь бүх мандлын үндэс болж эсвэл голд нь эсвэл зүүн зүгт байрладаг ба түүнээс бусад дөрвөн язгуур нь төрдөг ажээ. Бэрозана бурхны үүрэг нь мунхаг ба төөрөгдлийг хаа сайгүй хязгааргүй нэвтэрдэг цэцэн ухаан болгон хувиргах юм. Бэрозаныг Гаутама бурхны түгээмэл мөн чанартай гэж бас үздэг.

Бэрозана бурхныг лагшин нь цагаан өнгөтэй, цээжин дээрээ хоёр мутраа алгаар нь нийлүүлэн *номын хүрдийг эргүүлэх* гэсэн мутарлагатай (*самг.*: dharmacakra pravartana) бүтээжээ. Энэ мутарлагаараа арван зүг, гурван цагийн бүх бурхад ба Шагжамуни бурхны

ном айлдах үйлийг биелүүлж, байгалийн дотоод чанар, бүх үзэгдлийн зүрхэн утгыг (дхармадхату) ертөнцөд нээж өгдөг. Заримдаа энэ мутарлаганы оронд Бурхны шашны найман зөв замыг төлөөлсөн найман хигээстэй хорлыг мутартаа барьсан байдаг.

“Адьяабазарын самграха тарни” номонд бичсэнээр цагаан Бэрозана бурхан саран дэвсгэр дээр бадамлянхуа цэцгийн зүүн талын дэлбээн дээр цагаан УМ үсэгнээс үүсдэг. Түүний үндсэн мутарлагын бэлгэдэл нь гэгээрэл (*самг.*: bodhyangi mudrā) юм. Түүний унаа нь арслан эсвэл луу юм [Bhattacharyya 1958: с. 53]. Бэрозанаас Зүгдорнамжилмаа (*самг.*: ushnisha vijaya, *монг.*: Жүгдорнамжалмаа), Осоржамаа (*самг.*: marichi, *төвөд.*: ‘od gser chan ma; *монг.*: Одсэржанмаа), Цагаан шүхэрт (*самг.*: sitatapatra, *төвөд.*: bdug kar rgyal mo; *монг.*: Чаган шихүрт), Доржпагма (*самг.*: vajravarahi; *төвөд.*: rdo rje drag ma; *монг.*: Доржпагма) зэрэг түгээмэл шүтэгддэг олон бурхан төрдөг.

Бэрозана бурхны махбодь нь хий бөгөөд амгалан, цэвэр ариуны бэлгэдэл цагаан өнгөтэй. Сансрын хязгааргүй орон зай ба хязгааргүй хөх тэнгэр бол түүний задгай, тунгалаг, гэрэл асгарсан ухамсрын жинхэнэ мөн чанарын бэлгэдэл юм. Бэрозанын үндсэн үүрэг бол мунхагийг (*самг.*: avidyā) хоосон чанарт хүрсэн цэцэн ухаан болгох юм. Билигт Бэрозана нь бас мунхагийн харанхуйгаас сэрээхийн бэлгэдэл Ваджра-дхатешвари буюу Цагаан дарь эх юм. Бэрозана бурхны орон нь Агнистын диваажингийн орон (*самг.*: akaniṣṭha, *тиб.* 'og min, что значит, Мөнхийн залуу тэнгэрүүд буюу Дээд тэнгэр) юм.

Алс Дорнодын Бурхны шашинд Бэрозаныг онцгойлон шүтдэг. Их Бэрозанын судар буюу тарни (*самг.*: mahāvairocana abhisambodhi vikurvita adhiṣṭhāna tantra) Хятадад ҮII зуунаас эхлэн танигджээ. Энэ судар нь Японы Шингон дэг сургуулийн хоёр үндсэн номын нэг юм. Энэ сургуулийг Хятадын Тан улсаас авчирсан алдарт лам Кукай (774–835) байгуулжээ. Шингоны уламжлал ёсоор Бэрозана бурхан нь байгалийн мөн чанар шиг бүх мөн чанарт байдаг ба бясалгаж байгаа хүний зорилго нь Бэрозанатай ижилхэн өөрийн үнэн мөн чанартаа хүрэх юм. Бэрозана бурхан нь хоосон чанар гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл, боломжит хоосон чанар учраас Бэрозана нь анхдагч бурхан гэж тооцогддог [History of Shingon school see: <http://www.shingon.org/history>].

Бэрозана бурхны хамгийн эртний дүрслэл нь Тан улсын үеийн (VII—IX зуун) Хойд Вэй (V зууны төгсгөл) улсын Хэ нань мужийн алдарт агуй сүмийн цогцолбор Лун мэнь агуйд байдаг. Бэрозанаас Самандбазар бодисадва гардаг. Бэрозана бурхны бидэнд



харагддаг дүр нь Сайн цагийн мянган бурхны хамгийн эхнийх нь буюу Хорвоонжиг бурхны (дараагийн гурав нь Сэртэв, Одсүрэн, Шагжамүни бурхад) дүр юм.

Монгол, Буриадад Бэрозаныг дөрвөн тийшээ харсан дөрвөн нигуртай (Сарвавид Вайрочана) бүтээдэг ба энэ дүрээрээр тэрбээр бүх дияаны бурхны мөн чанарыг өөртөө агуулдаг. Сарвавид Бэрозана хоёр эсвэл 8 мутартай дүрслэгддэг. Мутрууддаа хүрд, эрих, нум, сум барьдаг. 30-аад оны хэлмэгдүүлэлтээс өмнө Буриадын Янгажины дацанд Сарвавид Бэрозаны бүтэн мандал байжээ. Тэр үед тэр хийдийн багш нь одоогийн алдарт Хамба лам Даждорж Итгэлт байжээ<sup>33</sup>. Одоо Буриадын домогт урлаач Санж Цэвэг Цыбиковын (1877-1934) бүтээсэн дөч орчим Гүнрэгийн мандал Буриад улсын түүхийн музейд хадгалагдаж байна. Энэхүү уран баримлын зохиомж холбооны улсын хэмжээний түүхэн дурсгал хэмээн хүлээн зөвшөөрөгджээ.

### **Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейд буй Ялж төгс нөгчсөн Бэрозана бурхны уран баримал**

Эд. №69.43.69. Хүрэл, цутгамал, алтадмал, өнгө будаг орсон.

Өндөр: 71.5см, диаметр: 45.5см. Жин: 62900 г.

Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейд буй Ялж төгс нөгчсөн Бэрозана бурхны уран баримлын тухайд энэхүү бүлэгт ордог бүх таван бурханд байдаг шинж чанарууд бий. Хэсэгчлэн цутгасан, дундад зууны үеийн монгол цэргийн дуулгыг санагдуулсан *зүгдорынх* нь тусгай чимгийг алт мөнгөний дархны аргаар зассан, нуруун дээрх нимгэн дунгуй нь дундад зууны үеийн монгол язгууртнуудын хувцасны нэг хэсэг байсан додьёогоор хамгаалсан мэт, туузтай титэм ба хүзүүний чимэг нь толгой ба хүзүүг нь бүхэл тойргоор нь хамгаалсан, үс нь XIII-XIV зууны үеийн монголчуудын үс засалт мэт, туг үснүүд хажуу тал руугаа унжжээ.

Эдгээр бодисадва нарын иж бүрэн чимэг зүүлт ерөнхий дүрсийн хувьд ижил боловч бусдаасаа ялгарах өөрсдийн гэсэн зураг, сийлбэртэй (Зураг4.4.9в). Яг одоо авч үзэж байгаа бурхныхаа бусдаас ялгарах онцлогуудыг харъя. Тухайлбал, Бэрозанын дотийг Бурхны язгуурын бэлгэ тэмдэг болсон найман хигээстэй хүрдэн хээгээр эмжиж чимжээ (Зураг4.4.9в).

Зураг 4.4.9а. Бэрозана бурхан. Хүрэл, цутгамал, алтадсан, өнгө будаг орсон. 71,5x45,5 см. ЗДУМ [ММШУД, v.I. н.180]

<sup>33</sup> Буриадын Иволгын дацанд байгаа муудаж задардаггүй бие нь монгол, орос бурхны шашинтнуудыг өөртөө татах хүч болсон.

Зураг 4.4.106. Бэрозана бурхны мутарлага. Зураг 4.4.10в. Язгуурыг илэрхийлсэн хүрдэн хээтэй Бэрозана бурхны уран баримлын хэсгээс ЗДУМ. дотины ирмэг. Зургийг СС. Зургийг СС.

Мутрын хуруунуудын байрлал: хоёр мутрын эрхий ба дунд хурууг нийлүүлэн цагариг үүсгээд, бусад хуруунууд нь нугаларч, зүүн мутрын алганы хажуу өөр рүү нь харж, баруун мутраа алгаар нь гадагш эргүүлж, дээш өргөж, зүүн мутрын долоовор хуруу баруун мутрын цагариг руу оржээ. Зүүн мутрын долоовор хуруун дээр маш нарийн аргаар нийлүүлсэн мөр байгааг харахад уг баримлын зарим хэсгийг салангид цутгажээ. Хоёр мутрынх нь ядам хуруунуудад хоёуланд нь дугуй шигтгээтэй бөгж зүүжээ (Зураг4.4.106). Дотиных нь ирмэгээр сийлсэн хээ угалз нь Бэрозаны язгуурын онцлогийг харуулсан найман хигээстэй хүрд ба цэцгүүд ажээ (Зураг 4.4.10в). Титэмнийх нь сууринд тэгш өнцөгт шигтгээ (Бэрозана бурхны хий махбодын тэмдэг) байна. Ерөнхийдөө Бэрозана бурхны бүх гоёл чимэг бусад дөрвийгөө бодвол илүү баялаг ажээ. Ялангуяа уг бурхны цээжийг бүрэн халхалсан хүзүүний чимэг нь онцгой ялгарна. Бүсний чимэг нь битүү цэцэг, сувдан хэлхээ. Орхимж нь ар нуруундаа додъёг шиг харин урд талдаа нарийн тууз маягаар, тэгш хэмтэйгээр тунаж, нугалсан тохойн дээр нь тохогдож, ташаан дээр нь унаж сэнтийн гадаргууд тулжээ.

Занабазар бурхан зурах тигийг нарийн баримталж, бурхны шинж чанарыг нарийвчлан гаргаад зогсохгүй, энэ шинэ чанарын мөн чанарыг бас гаргадаг. Бурхны биеийн харьцаа, зохиомжийн бүх хэсгийн таарсан хэмжээний талаар дуусашгүй урт яриа үүсгэж болно. Занабазар бурхан бүтээхдээ тигийг нь хэрхэн ёсчлон баримталдаг тухай Монголын алдартай бурханч лам Пүрэвбат гурван боть бүтээлдээ янз бүрийн түвшний бурхдын тигийг хэрхэн гаргах талаар тиг торон дээрээ дэлгэрэнгүй тайлбарлаж, Занабазарын уран баримлын харьцааг харуулсан байдаг [Пүрэвбат 2016].

Дугуйрсан, бүтэн дүрс ба зураасууд нь битүү бүтэн байх нь түүний ур хийцийн ялгарах онцлог бөгөөд үүнийгээ урлаач маань монгол нүүдэлчдийн урлагаас уламжлан авч, бурхны дүрслэх урлагт нэвтрүүлж чаджээ. Энэтхэг, Непал, Кандагар, Төвөдийн сонгодог уран баримлууд хөдөлгөөнгүй, тусгай хананы хөндийд байрлуулдаг, зөвхөн нүүрэн талаас нь хардаг болохоор баримал гэхээсээ илүү маш гүн товойлгосон дүрс гэлтэй. Харин ид бяр нь тэнцсэн Занабазарын уран баримлууд бол тойруулж харах зориулалттай, дүр нь ч, суурь нь ч өмнө талаасаа төдийгүй хажуу тал, нуруун талаасаа ч

маш нарийн гүйцэтгэлтэй. Бүх хэсгүүд нь бүрэн дүүрэн гурван хэмжээст эзлэхүүнтэй, тус тусад нь цутгаж, зүлгэж, эцэст нь нийлүүлж бүтээсэн байдаг. Бүр титэм, хүзүүний чимэг, бүсний унжлага зэрэг чимгүүдийг нь тусад нь нэг нэгээр нь хийгээд бурхны баримал бэлэн болонгуут өмсгөж, зүүлгэдэг ажээ. Жишээ нь бугалганы том чимэг нь мутрын залгасан хэсгүүдийг халхална. Зарим баримлын бүсний унжлаганы цаана бүсэлхий, хуруун дээр залгаасны мөр харагдана. Биеийн хэсгүүдийг нийлүүлэхэд яв цав таарахаар байлгахын тулд ямар нарийн тооцоо шаардлагатайг ойлгох хэрэгтэй. Чухам ийм учраас бодисадва нарын чимэг нь ийм бодитой, унжиж буй дүрс төдий бус. Харин бурхны лагшин дээр үнэхээр өөрсдийнхөө жингээр унжиж харагддаг. Баримал асар их жинтэй (70 см өндөр ялж төгс нөгчсөн бурхад 50-60 кг) байгаа болохоор нэг их нимгэн цутгаагүй бололтой, битүү элс чихсэн хэв ашиглаж тусгай монгол аргаар цутгадаг ажээ. Уян хатан бөгөөд зөөлөн металлын зузаан давхарга нь бүх талаасаа төгс дугуйрсан хэлбэр гаргаж, илүү гарсныг нь тасалж, дуртай хэлбэрээ гаргах боломжтой болдог байжээ.

### **ШАГЖАМУНИ бурхан**

#### ***Шүтээний агуулга***

Шагжамуни бурхан бол бурхны шашны бүх дэг сургуулиудын гол шүтээн юм. Занабазарын бүтээсэн Бурхан багшийн дүр олон байдгаас бага хэмжээтэй баримал, маш ховор уран зураг байдаг. Тэдгээр нь гоёмсог, товч тодорхой, гоё бүтээлүүд юм. Д.Дамдинсүрэнгийн гэрчлэн ярьснаар Их хүрээний хийдэд бусад бүх бурхдаас хэмжээгээрээ том “Их зуу” буюу Их Бурхан байсан боловч одоо түүнийг хадгалагдан үлдсэн эсэх, байгаа газрынх нь талаар ямар ч мэдээлэл байдаггүй ажээ [Дамдинсүрэн Д., 2012: 83].

### **Шүтээн зураг. А. Алтангэрэлийн цуглуулгад байдаг Шагжамуни бурхан ба Ялж төгс нөгчигсдийн найман том суварга**

Шүтээн зураг. Зотон, 53х27 см. Хар торгоор эмжсэн. XVII зууны төгсгөл.

Зэс үзүүртэй хөндлөвчтэй. Маш нарийхан хул амсуургатай.

Ялж төгс нөгчигсдийн найман агуу суварга нь Гаутама Шагжамунигийн амьдралын гол гол үйл явдлуудыг мөнхөлсөн юм. Үүнд: 1) Лумбини цэцэрлэгт (pad spungs mchod rten) ханхүү мэндэлснийг дурсан санах бадамлянхуа суварга. Төрөөд гишгэх болгондоо бадамлянхуа цэцгийн дэлбээ ургуулж байсан анхны долоон алхмыг нь дурсаж дөрвөн

талын шатны гишгүүрүүдийг дугуй хэлбэртэй хийж бадамлянхуануудаар чимжээ. Бурхан багшийн аав Шудодана хаан энэ суваргыг барьжээ. 2) Марууд гэгээрч, номхорсныг дурссан (byang chub snying por bdud 'dul mchod rten) суварга. Үүний энгийн дөрвөлжин дөрвөн талын дөрвөлжин шатнууд нь огт чимэггүй байгаа нь Гаутама 35 насандаа долоон жилийн эрэл хайгуулын эцэст энгийн агуу, түгээмэл байдлаараа муу сэтгэлийг амирлуулдаг Хутагтын дөрвөн үнэнийг ухаарсныг илэрхийлж байгаа юм. Бодьгаяад Бурхны агуу өглөгийн эзэн Бимбисара хаан энэ суваргыг босгожээ. 3) Олон хаалгат суваргыг (Sgo mang mchod rten) нь Бугын цэцэрлэгт хүрээлэнд Сарнатад Номын хүрдийг анхлан эргүүлснийг мөнхөлж босгожээ. Дөрвөн талын шатнууд дээр ухамсраа нээж, гэгээрлийг олох сургаал болсон Хутагтын дөрвөн үнэн, зургаан барамид, найман зам, арван хоёр шүтэн барилдлагыг тус тус илэрхийлсэн 4, 6, 8, 12-оор хуваасан олон хаалга дүрсэлсэн байдаг. Түүний анхны таван шавь нь энэ суваргыг босгожээ. 4) Рид хувилгааны суваргыг (Cho 'phrul mchod rten) Бурхан багш 50 настай байхдаа зургаан тэрсүүдийг ялж, сарын шинийн арван таван өдөрт ид шид үзүүлсэнд нь зориулж босгожээ. Төв хэсгээсээ дөрвөн тал руугаа алслалттай харагдана. Личхави аймгийнхан барьжээ. 5)Түшидийн орноос (Lha babs)/ буусан суварга. Дөрвөн тал бүртээ 33 гишгүүртэй гурвалсан шаттай. Шанкаст уран барилгач Вишвакарман барьжээ. 6) Девадаттын зохион байгуулснаар чуулган хуваагдаж салсны дараа буцан нэгдсэнийг бэлгэдсэн эвлэрлийн суварга (Dbyen mchod rten). Дөрвөн талын шат нь хэвтээ чиглэлээр огтолцсон зөв найман өнцөгт хэлбэртэй. Магадигийн иргэд Ражагрихт босгожээ. 7) Бурхан багш төгс нирваан дүрд орохоосоо өмнө шавь нарынхаа гуйснаар насаа гурван сараар уртасгасанд зориулж барьсан төгс ялалтын суварга (Rnam rgyal). Гоёл чимэглэлгүй гурван дугуй гишгүүртэй. Вайшали барьжээ. 8) Төгс нирвааны суварга (Myang 'das). Бурхан багшийг төгс нирваанд орсныг бэлгэдэж барьсан, шатгүй, хонх хэлбэртэй, Кушинагарт баригджээ.

Суварга хэрхэн барих талаар “Бхадракальпика судар”-т бичсэн байдаг. Винайн номонд суварга босгох тухай Бурхан багшийн дэлгэрэнгүй заавар байдаг бөгөөд сүсэгтэн Анатхапиндака багшаасаа өмнө нас барсан Шарибудрагийн чандрыг агуулах сав бүтээхээр шийджээ. Савны суурь нь дөрвөн хэсэг шаттай, бөмбөгөр сав, тэгш өнцөгт **хармик**, тэнхлэг, шүхэр, гэгээнтний зиндаанаас хамаардаг нэгээс гуч хүртэлх тоотой номын хүрд байх ёстой гэсэн байдаг.

Олон орны буддын шашинтнууд үнэхээр төрөл бүрийн суваргыг бүтээжээ. Агуу хүмүүсийн ариун чандар дээр босгосон дурсгалын байгууламжуудын нэлээн эрт үеийн энэтхэг хэлбэр нь суварга хэмээх оршуулгын толгойг өөрчилсөн өндөр дугуй пөмбөгөр орой юм. Өнөөдөр мэдэгдээд байгаа хамгийн эртний суваргыг ч Шагжамуни бурхныг нас барснаас хойш зуун жилийн дараа босгожээ. Төвөд-Монголын уламжлалын дагуу барьсан суварганууд бусад Бурхан шашинтай улсуудынхаас маш өөр бөгөөд нэлээн сүүлийн үеийн загвар гэж олон эрдэмтэд үздэг. Гэхдээ Будда бурхны өөрөө хэлсэн нэлээн эхэн үед нь хамрагдах номонд бичснээс харахад төвөд, монгол хувилбар нь Шагжамуни бурхны өөрийнх нь зөвлөсөн уран барилгыг сэргээх гэсэн оролдлого юм. Суварганы төвөд-монгол хэлбэр нь, “дөрвөн нугалаастай” тэг дөрвөлжин суурин дээр үнэхээр доош хөмөрсөн бадар аяга хэлбэртэй ба урт шивээтэй.

Шүтээн зургийн голд Шагжамуни бурхан улбар шар лам хувцастай (дотор нь ногоон өнгөтэй болох нь зүүн мөрөн дээрх үзүүрээс харагдана), баруун мөрөө ил гаргасан, очир завилгаагаар морилсон, баруун мутар нь газрыг гэрчээр дуудсан мутарлагтай (*самг.*: *vhūmisparśa*), зүүн мутартаа хар бадар аяга барьжээ. Толгойны арын оройн гэрэл нь ягаандуу туяатай хүрээтэй ногоон. Бурхан багш алтан дэвсгэр дээр морилж, дэвсгэрийн дор улбар шар, хөх, ногоон, ягаан өнгийн шүүслэг дэлбээтэй бадамлянхуа цэцэг байна. Бадамлянхуаны доор төвөд уламжлалаар арслант сэнтийний өмнө тал руу унжсан алтлаг торгон дэвсэр унжуулжээ. Сэнтийг өргөж байгаа цагаан арслангууд нарийхан уян налархай биетэй, урт хөлтэй байгаа нь Занабазарын бүтээлийн нэг онцлог юм. Бодит байгалийн зураг нь шилмүүст ойгоор бүрхэгдсэн Хангай, Хэнтийн нурууг санагдуулна. Бурхан багшийн хувцас дээрх хээ угалз нь эрхий, онги хэмээх монголын уламжлалт урлагийн элеменентүүд байгаа нь Занабазарын бүтээлийн бас нэг онцлог юм.

Сэнтийн өмнө хацарт усан давалгаан дээр хөгжмийн зэмсэг, толь, билва жимс, анхилуун үнэртэн уугьсан хясаа, торго гэсэн таван мэдрэхүйг баясгадаг таван өргөлөөр дүүргэсэн улбар шар, шар өнгөтэй хоёр монгол аяга байна.

Бурхан багшийг улаан хүрэн суурьтай найман алтан суварга хүрээлснээр дүрсэлжээ. Тэдгээрийн доор төвөд улаан үсгээр (Зүүнээс баруун тийш, хүснэгт I (1-8)):

Ум! Хамаг амьтны хамгийн дээд хүү Лүмбүнид төржээ. Агуу гавьяаг ихэд чимэхийн тулд лам, сүсэгтнүүдийн хотод баригдав./Ялж төгс нөгчигсдийн суваргад мөргөөе!//

Ум! Магадад бодь модны доор тэрээр Найранзана нэртэй голын эрэгт хүрэв//Агуу суварга// Бодийн суурьт мөргөө!

Ум! Варанасид тэрээр номын хүрдийг эргүүлэв! Сансрын харанхуйгаас салав! Агуу суваргад мөргөө!

Ухаан санаанд буй муу сэтгэл ариллаа! Ид шид үзүүлэв ...) Агуу суваргад мөргөө!

Ум! Агуу зүйл тохиолдсон ариун хотод бурхдын орноос зүйрлэшгүй бурхан бууж ирэв. Гишгэсэн мөр нь адислагдав. Гучин гурван бурхны дээд орноос ирсний бэлгэдэл суваргад мөргөө!

Ум! Хааны ордны оройд Бурхны шавь нар чуулганы нэгдлийг сэргээсний бэлгэдэл агуу сайхан сэтгэлийн суваргад мөргөө!

Ум! Бүхнийг таньсан нинжин сэтгэлт хүү Шагжамунийн гэр бүлд төрлөө. Бусдын тусын тулд бүх муу сэтгэлийг ялж, алтан биендээ буцаж ирсэн танд мөргөө! Бодисадвын харагдах биеэр номын хүрдийг эргүүллээ. Эргэж ирлээ...амь насаа уртасгаж, нирваан дүрд оров! Сайн болтугай!

Уг шүтээнийг жинхэнэ нимгэн хар торгоор эмжсэн нь алтан суварганууд, бадамлянхуа цэцгэн дунд морилсон Бурхныг тодруулан харуулж байна.

Найман суваргатай уг шүтээн зураг нь Шагжамуни бурхны амьдралыг товч тодорхой харуулжээ. Бүгдийг тойргоор, тэгш хэмтэйгээр хүрдний гол дахь Бурхан багшаас салбарласан мэт дүрсэлсэн нь уран зургийн өгүүлэмжийг жигдхэн, орон зайн алслалттай болгожээ.

Өнгөний хоршил дулаан бас бусад элементүүдтэйгээ гүнзгий хоршсон байна. Байгалийн зурган ар дэвсгэр нь өтгөн ногоон өнгөтэй, алтадсан суварга, бадамлянхуа цэцгийн алагласан тод өнгө уламжлалт хавтгай зургийн дүрслэлийн гол элементүүдийг уран баримлын хэлбэртэй болгожээ. Цэвэрхэн шугам зураасууд, Бурхан багшийн нигурын ер бусын бясалгасан байдал, нэгбүрчлэн зурсан дүрс хэлбэрүүд, Бурхан багшийн нүүрний зөв тиг зэрэг нь Занабазарын бүтээлийн онцлог юм.

Зураг 4.5.1. Шүтээн зураг “Шагжамуни бурхан ба Ялж төгс нөгчсөний найман агуу суварга”. Зотон, 53х27 см. А. Алтангэрэлийн цуглуулга. Монгол улс.

### **Шүтээн зураг. Шагжамуни бурхан**

Шүтээн зураг. Шагжамуни бурхан.

Торго. Хэмжээ: 39,5 x 26,5 см. Хүрээ х/б: 48,5 x 34,5 см.

Монгол улс. Б.Амарсанаагийн цуглуулга.



Зураг 4.5.2. Шүтээн зураг “Шагжамуни” Торго, 39,5 x 26,5 см. Монгол улс. Б. Амарсанаагийн цуглуулга.

### ***Шүтээн зургийн тайлбар***

Энэхүү шүтээн зураг тод, товч тодорхой зохиомжтой, хэлбэр дүрс нь маш цэвэрхэн бурхны тигийн харьцааг баримталсан, өнгө гэрлийн зохицол, зурах хэв маяг, Бадамлянхуа цэцэг ба түүний дэлбээнүүдийн хэлбэр, гүн аяганд хийсэн таван мэдрэмжийг баярлуулах өргөлийг дүрсэлсэн байдал, алга ба бойвон дээрх дээрх жижигхэн улаан хүрд бол Занабазарын бүтээлд байдаг онцлог юм. Торго, алт зэрэг үнэт зүйлсийг хэрэглэх нь урлаач эсвэл захиалагчийн онцгой болохыг харуулж байгаа юм. Гэхдээ зарим хэсэгт зураасууд жигд биш байна. Мөн Бурхан багшийн нүүрний хэлбэр бусад уран бүтээлүүд дээрхээс өөр байна. Энэ бүтээл урлаачийн ойрын шавийн бүтээл бололтой, гэхдээ Занабазар бас оролцжээ.

### **Шүтээн зураг. Тийн ялсан суварга**

(*төвөд*: rnam rgyal mchod rten; монг.: namjil suburga / teiyn ilagsan suburga)

Зотон. Хэмжээ: 43.5 x 29,5 см. Хүрээ: торго 77 x 41 см.

Шороон будаг, алтадмал. XVII зууны төгсгөлөөс XVIII зууны эхэн.

### ***Шүтээний агуулга***

Дурсгалын байгууламж болсон суварганы загварыг Бурхан багш анх өөрөө Бхаллика, Тапусса хэмээх хоёр худалдаачны гуйлтаар харуулж байжээ. Тэд бол Бурханаас дурсгалтай зүйл (туг үс, хэсэг хумс) авсан хамгийн анхны хүмүүс байсан ба яаж хадгалах

ёстой вэ хэмээн асуужээ. Хариуд нь Бурхан багш дагамаа тайлж дөрөв нугалаад бадар аягаа дээр нь хөмөрч тавиад, дээр нь ламын таягаа байрлуулжээ [Tarthan Tulku: 10].

Төвөд-Монгол уламжлалт бурхны суваргууд хэлбэрээрээ бусад улсын суваргануудаас маш их ялгаатай бөгөөд одоо ч тэдгээр загвар тигийг хадгалан бүтээж байна. Гэхдээ төвөд-монгол суварга (*төвөд. chos brtan, монг.: суварга*) Бурхны хөмөрсөн аягатай хэлбэрийн хувьд хамгийн адилхан нь юм. Ийм суварга дандаа дөрвөлжин суурьтай, маш урт шивээтэй байдаг. Төвөд-монгол хувилбар Шагжамуни бурхны үеийн, өөрийнх нь зааварласныг пали хэл дээр бичсэний дагуу босгосон эртний уламжлалтай уран барилгыг сэргээсэнтэй адил ч байж болох юм. Юу гэвэл, одоо мэдэгдээд байгаа Бурхны шашны суваргуудаас хамгийн эртнийхийг нь хүртэл Шагжамуни бурхныг мөнх бусыг үзүүлснээс хойш зуун жилийн дараа босгожээ. Суваргыг босгох санаа гаргасан олон газар орны хаад ноёд асар том дурсгалын байгууламж барьж өөрийн нэр ба өөрийн түүхэн үеийг мөнхлөхийг хичээсэн байдаг.

Ер нь төвөд-монгол шүтээний урлагт шүтэж байгаа зүйлээ сэнтийд залах гэх зэргээр ер нь дээшээгээ л байрлуулах эрмэлзэлтэй байдаг. Дээшээ гэдэг нь сэнтий юм. Сэнтий элсэн цаг шиг, эмэгтэй хүний бие шиг хэлбэртэй дунд хэсгээрээ нарийссан байдалтай байдаг. Сэнтийний энэ эртний хэлбэр нь газрын ертөнцийг тэнгэрийн ертөнцтэй холбодог тахилын ширээтэй дүйцнэ. Хурал номын үеэр, эсвэл шавь нартаа ном айллдах бол лам багш нар ийм сэнтий дээр морилдог. Бурхны тахилын аяга бас ийм хэлбэртэй. Занабазар хэрвээ

Зураг 4.5.3. Шүтээн зураг. “Төгс ялалтын суварга”. Зотон. Хэмжээ: 43.5 х 29,5 см. Шороон будаг, алтан түрхэц XVII зууны төгсгөл ба XVIII зууны эхэн.

сэнтий дээрх бурхныг газрын бодьгалиудыг дээд ертөнцтэй холбогч нь юм гэдгийг тодотгон харуулахыг хүсвэл бүслүүртэй давхар бадамлянхуатай суурийг сонгодог. Ийм логикийг бас суварган дээр баримталдаг ба бурхны дурсгалын зүйл сэнтий дээр л тавигддаг. Байгаль ба нийгмийн нөхцөлийн нөлөөг харгалзах нь чухал. Эртний Энэтхэгийн суваргууд ба Алс дорнодын суваргууд нь овор ихтэй уран барилгын загварууд юм. Төв азийн тахилын суваргууд нь уран барилгын овор багатай байгууламжууд боловч хэлбэрийн хувьд овор ихтэй уран баримлуудтай адилхан. Тэдгээрийг нэмэлт өндөрсгөсөн суурин дээр байрлуулдаг нь хүрээлэн байгаа орчны шаардлагад нийцэх гэснийх юм.



### *Суваргын тайлбар*

Шүтээн зургийн хамгийн наад талд цагаан арслан тулгуурт ваар хэлбэрийн алтан суварга байна. Сэнтий ба үндсэн хэсгийн харьцаа нь 4:11 (2:3:6) ажээ. Сэнтийн суурин дээр дээш чиглэсэн гурван гишгүүр доош чиглэсэн гурван гишгүүр байна. Сэнтийн нүүрэн талд сэнтийн суурийг урд хоёр хөлөөрөө өргөж байгаа дүртэй цаст уулын цагаан арслан эрслэнтэйгээ зогсоно. Арслан бол Шагжамуний бурхныг бэлгэдэж байгаа ба Төвөдийн сүлд юм. Ертөнцийн зүг бүрт хандсан найман арслан Шагжамуни бурхны Гэгээрлийн сэнтийг өргөн зогсжээ. Суурийн гишгүүрүүдийн хажуу болон дээд талыг ромбон жааз хэлбэрийн монгол хээгээр чимжээ. Сэнтийн нүүрний голд тэнгэрээс бууж ирж, Маяа хатныг зовоолгүйгээр баруун хажуугаар орж жирэмслүүлж байгаа цагаан зааны дүртэй Бурхан багшийг дүрсэлжээ. Зурсан барил нь Занабазарынх гэдэг нь харагдана. Гол хэсгийн доод талд бадамлянхуан алтан дугуй суудал, түүний дээр эрдэнийн гурван давхар чимэггүй дугуй суурь, түүний дээр жижиг алтан бадамлянхуан суудал байна. Вааран хэсгийг унжлагуудаар чимжээ. Энэ хэсгийн ханан дахь нумарсан гууг өнгө өнгийн эрдэнэсээр чимжээ.

Гуун дотор очир завилгаагаар (ваджрапарьянка асана) морилсон Шагжамуни бурхны алтан баримал харагдана. Баруун мутраа гэгээрснийг минь гэрчил хэмээн газарт сануулж, алгаа доош нь харуулж хуруугаа газарт хүргэсэн гэрчлэлийн мутарлагаар (бхумиспарша мудра) барьж, зүүн мутартаа бадар аяга барьжээ. Хар хүрэн өнгийн орхимжоо (уттарасанга) зүүн мөрөн дээгүүрээ давуулж, баруун мөр нь ил харагдана. Шамтав нь (*төвөд*: sham thab) улбар шар өнгөтэй. Оройн гэрэл нь (*самг.*: śiraśakra) нил ягаан өнгөтэй, лагшины гэрэл нь (*самг.*: grabhamandala) төв хэсэгтээ улбар шар байснаа цаашид цагаан болж хувирсан цацрагуудтай. Бурхны суудал бадамлянхуа дэвсгэрийг шүүслэг мэт хөх, ногоон, улбар шар дэлбээтэйгээр зуржээ.

Суварганы цүдгэр хэсгийн дээд талын гонхонд буюу “бурхдын ордонд” (*монг.*: суулга) голд нь буй цэцэгнээс урт шивээ босгоод түүнд 13 номын хүрд углаж, бадамлянхуа цэцгэн шүхэр барьжээ. Шивээний хоёр талаар лянхуа цэцэг, унжлагууд эрдэнэс унжина. Суварганы хамгийн дээр нар, сар, гал (nadi) байх ажээ.

Шүтээн зурагны доод хэсэгт, суварганы өмнө талд таван мэдрэхүйг баярлуулах өргөл (*самг.*: pancakamaguna, *төвөд*: ‘dod yon sna lnga) сонсголыг баярлуулах утаст хөгжим (*самг.*: vina), амт мэдрүүлэх таван ногоон навчтай гурван жимс (*төвөд*: bil ba), нүд баясгах

гоё хүрээтэй толь, үнэрээр баярлуулах мушгиран уугиж байгаа үнэртэнтэй цагаан хясаа, мэдрэхүйг баярлуулах үзүүр нь аяганаас гарч намирсан улбар шар хадгий улбар шар аяганд хийж тавьжээ. Таван өргөл байрлуулах нь Занабазарын үеэс эхэлсэн монгол бүтээлийн уламжлал болжээ.

Цэнхэр тэнгэрт буй мөнгөн саран, алтан наран монгол шүтээн зурагт заавал байх ёстой зүйл ба эдгээр нь монголчуудын эртнээс хүндэлж ирсэн Мөнх хөх тэнгэр юм. Шүтээн зургийн дээд хэсэгт тэгш хэмтэй цагаан үүлс дээрх улбар шар бадамлянхуа цэцгүүд ба саран дэвсгэр дээр хоёр бурхан морилжээ. Зүүн гар талд Амгаасид бурхан очир завилгаагаар завилж, баруун мутар нь бэлэглэх ба хамгаалах мутарлагатай (abhaya-mudra), зүүн мутар нь бясалгалын мутарлагатай (dhyana-mudra) морилжээ. Баруун гар талд нь Сэртэв бурхан очир завилгаагаар завилж, хоёр мутар нь номын хүрд эргүүлэх мутарлагатай (dharma-sakra pravartana) морилжээ. Шүтээн зурган дээрх гурван бурхны чойгү намжир нь хөх дотортой болох нь зүүн мөрөн дээрх үзүүрээс нь харагдана. Лагшин нь нягт алтан түрхэцээр бүтээгдсэн, эрдмийн галан мандал нь нил ягаан өнгөтэй толгойг тойрсон титэм нь ногоон өнгөтэй ажээ.

Арын байгаль нь зөөлөн ногоон өнгөтэй, гурвалжин уулнууд нь тэгш хэмтэй, хоорондуур нь долгиотсон зураасуудаар далай усыг дүрсэлжээ. Уулс нь шинэс, бут модоор бүрхэгджээ. Өнгөнүүд нь ногоон-хөх байгаль, цагаан-алтан суварга гэх мэтээр хоршжээ. Өнгө, хэлбэрийн бэлгэдэл нь Шагжамуни бурхан ялсныг, түүний язгуурын багш нарын ач холбогдлыг харуулж байна. Маш цэвэрхэн, нарийн дүрс, зөөлхөн өнгөтэй байгаль, мандлыг төлөөлсөн зөв конус хэлбэрийн арван гурван уул нь дөрвөн талаасаа далай, тивээр хүрээлэгдсэн Ертөнцийн төв, Сүмбэр уулыг бэлгэджээ. Үүний сацуу уул, ургамлуудыг бодитойгоор дүрсэлсэн нь Хангай, Хэнтийн уулсыг санагдуулна.

Нимгэн, бүрзгэр, хар хөх торгон хүрээтэй ажээ. Ирмэгүүдийг нь шар өнгийн нэг миллиметр кантаар эмжжээ. Мөн дотор талын шүтээн зураг, хүрээ хоёрыг нийлүүлэхдээ бас кант хэрэглэжээ. Ар талыг нь нимгэн хул торгоор доторложээ.

Суварга бол Занабазарын бүтээлийн үндсэн сэдвүүдийн нэг юм. Хүрлээр цутгаж бүтээсэн, ялж төгс нөгчсөн бурхны найман агуу суварга энэхүү урлаачийн үндсэн бүтээлүүдийн тоонд багтана. Цутгахаасаа өмнө маш удаан хугацаагаар загвар, таталбарыг нь гаргасан нь ойлгомжтой. Суварга бүхий шүтээн зураг бас урлаачийн маань бүтээлд тодорхой байр суурь эзэлнэ. Бурхны дурсгалт зүйлс хадгалах байгууламж, том

суваргуудын тухай сэдэв XII-XIV зууны үеийн Хар хотын уран зургийн амьдралд гарч ирдэг боловч энэ уран барилга нь монгол барилгуудаас ялгаатай (Самосюк, №75-80-тай харьцуул).

Сэртэв бурхан ба Шагжамуни бурхны мутарлага нь Занабазарын хоёр гол багш V Далай лам Агваанлуvsанжамц (nga dbang blo bzang rgya mtsho 1617-1682), IV Банчэн эрдэнэ Лувсан Чойжижалцангийнхтай (blo bzang chos kyi rgyal mtshan 1570-1662) адил байгаа нь сонин. Эдгээр эрдэмтдийн хувилгаан дүрүүдийн тигийг “Гурван зуун бурхан”-д оруулсан байдаг (№ 46-47). Энэ шүтээн зурагт голлох өнгө нь хөх-ногоон ажээ. Дашрамд хэлэхэд ногоон өнгө бол Амгаасид бурхны өнгө, харин хөх нь Сэртэв бурхны өнгө. Ийнхүү хэлбэр, өнгө, зохиомжийн бэлгэдлийн нэгдэл нь Шагжамуни бурхны ялалт ба түүний язгуурын багш нарын ач холбогдлыг харуулж байгаа юм.

### **Шүтээн зураг. Шагжамуни бурхан шавь нарын хамт**

Зотон 54,5 x 38,6 см. Шороон будаг, алтан түрхэцтэй.

1 мм нарийн канттай. XVIII зууны эхэн

Гол төвд нь Шагжамуни бурхан бүхий 12 бурхантай зохиомж. Шагжамуни бурхан маш том, тод харагдах бөгөөд ургамал ногоо цэцэглэсэн, диваажингийн мододтой ба дээр нь түүний шавь нар морилсон зургийн ихэнх зайг эзэлж байгаа юм (Зураг 1). Түүний суудлыг өнгө өнгийн бадамлянхуа цэцэгсийг алтан түрхэц, шүүдэр мэт гялалзсан эрдэнийн чулуун шигтгээнүүдээр бялхтал чимж, эр эм арслан өргөн зогсоо байдалтайгаар дүрсэлжээ.

Бурхан багш очир завилгаагаар (*санкр.:* vajrā paṇyānkāsa) морилж, лам хүний гурван зүйл хувцастай: ногоовтор туяатай улбар шар шамтав (*төвөд.:* sham thab, Skt: antaravasaka), улаан хүрэн орхимжтой, баруун мөрөнд тохогдох төдий харин зүүн мөр биеийг тэр чигээр нь халхалсан улбар шар дагам асаажээ. Баруун мутар нь газрыг гэрчид дуудсан мутарлагатай, (*самг.:* bhūmisparśa), зүүн гар нь бясалгасан мутарлагатай (*самг.:* dhyāna) бөгөөд бадар аяга барьжээ. Оройн гэрэл нь ногоон өнгөтэй, лагшингийн гэрэл нь хөх өнгөтэй, нил ягаан өнгөнөөс хөх өнгө хүртэл ууссан ба Бурхан багшийн биеэс алтан гэрэл цацарна. Аура нь бүхэлдээ олон өнгө туяарсан алтан цагирагаар хүрээлэгдсэн ажээ.

Бурхан багшийн өлмийн орчим хоёр шавь нь байх ба улаан, шар хосолсон лам хувцастай Монголжийбуу, Шарибудра хоёр таяг, бадар аягатай зогсоно. Төвөдийн уламжлалд тэр хоёрыг адилхан гэж үздэг боловч энэ хоёрын нэг нь залуу, нөгөө нь нас

ахьсан ажээ. Шарийбууг шавь нараас нь хамгийн ахмад нь гэж Шагжамуни бурхны үг пали хэлээр бичигдэн үлдсэн байдаг. Мөн монголчуудын дунд их түгээмэл “Билиг билгүүнийг онохуй сударт” (самг.: prajñāpāramitā hridaya sūtra) Шаарийбууг мөн насаар ахимаг гэж бичсэн байдаг.

Шүтээн зургийн дээд талын гол хэсэгт хөх өнгөтэй түшлэгтэй сэнтий дээрх хоёр давхар олбогон дээр неринг хэмээх шар малгайтай лам хүн морилно. Баруун мутраа номын хүрдийн мутарлагаар барьж, зүүн мутартаа бадар аяга барьжээ. Тэрээр бадамлянхуа дэвсгэр дээр суугаагүй, амьд байх үед нь хөргийг бүтээвэл хөлөө ил гаргадаггүй ёсоор хөлөө хучин морилжээ. Хацар дээрх хонхорхойг нь харвал Занабазар ажээ. Энэ бол түүний нэлээн хожуу үеийн шүтээн зургуудын нэг ажээ. Манжийн Энх-Амгалан хаан (1662-1722), ялангуяа Тэнгэр тэтгэсэний (1736-1795) үед моод болоод байсан өнгө будаг ихтэй ажээ.

Дээр нь буржгар цагаан үүлэн дээрх шүдэрхэг дэлбээнүүдтэй цагаан хөвсгөр бадамлянхуа дээр Ногоон Дарь эх бодисадва (зүүн гар талд), Цагаан Дарь эх бодисадва (баруун гар талд) морилжээ.

Тэр хоёрын хоёр талд дөрөв дөрвөн бодисадва морилно. Тэд бадамлянхуа цэцгэн дээр очир завилгаа ба нэг хөлөө унжуулан морилцгоожээ. Зүүн гар талд нь зүүн мутартаа цэцэг барьсан цагаан Жанрайсиг, бумба барьсан шар Майдар, баруун гар талд нь очир барьсан Очирваань, илд, ном барьсан Манзушри бурхан харагдана. Бурхдын гартаа барьдаг зүйлс зүрх хэлбэрийн бадамлянхуа цэцгийн дэлбээн дээр тавигджээ. Бадамлянхуа цэцгийн зүрх хэлбэрийн дэлбээнүүд дээш чиглэжээ.

Мөн Бурхан багшийн хоёр талаар бадамлянхуа дэвсгэр дээр Энэтхэгийн зургаан чимэг хэмээн алдаршсан Нагаржуна, Арьяандэв, Васубанду, Асанга, Дигнага, Дармакирти нарыг дүрсэлжээ.

Уг шүтээн зургийн ар дэвсгэр нь өтгөн ургамалтай, янз бүрийн жимст моднуудтай, цэцэгтэй, цэцэг, навчин хээтэй ажээ.

Занабазар хийцийн шинж чанарууд нь: 1) өмнө талын хоёр хөлөөрөө сэнтийг өргөж байгаа цасан цагаан арслангууд нь нарийхан уян налархай биетэй, дэл сүүл нь өтгөн байдаг нь Занабазарын нэг ялгарах онцлог юм. 2) Бурхдын бадамлянхуа цэцгүүдийн хэлбэр ба өнгөнүүд өөр өөр байдаг. Бурхны сэнтий хурц тод олон өнгөтэй: хар хөх, нил ягаан, улаан хүрэн, ягаан, улбар шар, ногоон, цэнхэр, нягт алтан түрхэцтэй, танан өнгөтэй

ажээ. 3) Шагжамуни бурхан, Цагаан Дарь эх, Ногоон Дарь эх, Банчэн эрдэнийн ниугуруудыг монгол аргаар дугуй хэлбэртэй, монгол хүний төрхтэй, булбарай бугуйтай, жижиг мутартайгаар маш сайхан зурсан байдаг. 4) Өнгөний зохицол нь гол элементээ тодруулж харуулдаг нь зургийг том болгож харагдуулдаг. Алтан түрхэц нь чанартай, мэдэгдэм тансаг харагддаг.

Хятад хийцийн шинж чанарууд: 1) Маш их ургамал ногоогоор хамаг зайг дүүргэдэг. 2) Хувцаснууд нь элбэг, олон давхар, сул унжсан хувцас нь лам нарын биеийн хэлбэрийг мэдэгдэхгүй болгодог ба орхимжоор халхлагдсан, нарийн хээ угалзаар битүү чимэглэгдсэн байдаг. 3) Чимэглэж, нарийвчлан зурсан нь хэт их.

Энд яригдаж байгаа шүтээн зурагт Занабазар хийцийн үндсэн шинж чанарууд, Занабазарын бүтээлд байдаг нэмэлт элементүүд ихтэй ч товч тодорхой, бүхэл бүтэн байдлаа аддаагүй, чамин энгийн зүйлгүй харагдана. Энэ нь уран зурагт шинэ уур амьсгал орж ирснийг харуулж байна. Манжийн Энх-Амгалан хааны дараа Иньчжэнь / Юнчженя (1723-1735) хааны үед, ялангуяа Хунли хааны үед /Цяньлун (1711 онд төрсөн, 1736-1795 онд хаан ширээнд сууж байсан) цэцгэн хээг ихээр хэрэглэдэг байжээ. Занабазарын язгуурын багш Лувсан Чойжижалцангийн (1570 - 1662) хойд дүр хоёрдугаар Банчэн эрдэнэ Лувсан-Ишийн (1663-1737) дүртэй шүтээн зургаас харахад уламжлалыг баримтлахын сацуу шинэ субъектуудыг оруулжээ. Энэ шүтээн зураг 1721-1723 онд зурагдсан бололтой.

Зураг 4.5.4. Шүтээн зураг. Шагжамуний бурхан шавь нарын хамт. Зотон 54,5 x 38,6 см. Шороон будаг, алтан түрхэц. XVIII зуун. Монгол улс. А. Алтангэрэл.

### **Анагаагч МАНАЛ бурхан**

(самг.: *Bhaiṣajyaguru*, төвөд: *Sangs rgyas sman la*; монг. Оточ-Манал).

### **Шүтээний агуулга**

Шагжамуни бурхан агуу их нинжин сэтгэлдээ тулгуурлан хамаг амьтныг өвчнөөс салгахын тулд анагаагч Манал бурхны (төвөд: *sman gyi bla*, самг.: *bhaiṣajyaguru* монг.: *em-un qaṣan/otoṣi*) дүрээр өөрийн амлалтыг биелүүлэхээр болжээ. Энэ бурхан эмч л гэсэн үг, учир нь энэ бурхны ном нь хүн төрөлхтний бүх зовлонгийн гол шалтгаан нь болдог сэтгэлийн өвчнийг анагаах замыг нээж өгдөг. Занабазарын уран баримлын өв уламжлалаас Манал бурхан түүний амьдрал ба уран бүтээлд чухал байр суурь эзэлдэг. Тэрээр язгуурын багш IY Банчэн эрдэнэ Лувсанчойжижалцангаасаа (1569-1662) Манал бурхны ванг авч,

“sman bla’i mdo chog yid bzhin dbang rgyal” хэмээх тусгай зан үйлийн тарни бичиж өгөхийг хүсэж байжээ. Энэ цагаас хойш энэ номыг шинийн найман бүрд уншсаар ирлээ.

Адишагийн уламжлал ёсоор бол бясалгаж буй хүний зүрхэнд Манал бурхан Ум үсэгнээс үүсдэг. Цэнхэр өнгийн (түүний биеэс цэнхэр туяа ялгарна) лам хувцастай бадамлянхуа цэцэг, нар, саран дэвсгэр дээр очир завилгаагаар морилжээ. Өвдөг дээрээсээ доош унжсан баруун мутар нь бэлэглэх мутарлагатай (варада-мудра) байхаас гадна ар үр ургамлын жимс эсвэл навчийг (*санскр. haritaki*; лат. *terminalia chebula*)<sup>34</sup> барьжээ. Зүүн мутар нь өвдөг дээрээ бясалгалын мутарлагатай бөгөөд мөнхийн рашаан дүүрэн аяга барьжээ. Манал бурхан бүрэн бүрэлдэхүүнээрээ бол долоон Манал бурхан Бурхан багшийн хамт байдаг [DTV 2000: п. 40-48].

Монгол улс болон бусад орнуудад хүмүүсийн цуглуулгад Занабазар хийцийн Манал бурхан цөөнгүй тохиолддог. Монголын нийслэлд “Ноёны шүтээн” хэмээх жижиг модон сүм байсан ба дотор нь нэлээн том хэмжээний Занабазар хийцийн найман иж бүрэн Манал бурхан байсан ба харамсалтай нь одоо хаана байгааг мэдэхгүй болжээ хэмээн Д.Дамдинсүрэн бичсэн байдаг [Дамдинсүрэн 2012: с. 83-84]. Эдгээр эмийн хаан бурхны ердөө ганц ширхэг нь л Улаанбаатар хотын Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейд эдүгээ хадгалагдаж байна.

### **Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейд буй**

#### **Анагаагч бурхан (Оточ Манал)**

Эд.№69.43.09. Хүрэл, цутгамал. Алтадмал, шороон будаг.

Хэмжээ: 30 х 18,5 см. Жин: 6850 гр.

Зураг 4.6.1а. Манал бурхны уран баримал. Хүрэл, цутгамал, алтадмал. 30х18,5 см. Нүүрэн талаасаа, ерөнхий байдал. Зураг 4.6.1б. Манал бурхны уран баримал. Хүрэл, цутгамал, алтадмал. 30х18,5 см. Бурхны нигур.

#### **Тайлбар**

Оточ бурхныг уламжлалт бурхан зурах аргаар, лам хувцастай, дунгуй нь зүүн мөр ба тохойг нь хучсан, баруун мөр нь ил гарсан, очир завилгаагаар морилж, баруун мутраа

<sup>34</sup> Ар үр буюу харитака хэмээх ургамал нь 30 метр өндөр, 1 метр диаметр голтой болтлоо ургадаг, мөнх ногоон навчит мод юм. Өмнөд ба Зүүн өмнөд Азид тааралдана. Аюурведийн 10 алтан ургамлын тоонд ордог, маш өргөнөөр хэрэглэгддэг болохоор олон янзын өвчнөөс анагаах шидтэй гэгддэг ургамал.

варада буюу өглөгийн мутарлагатай, зүүн мутраа бясалгалын мутарлагаар барьсан, алган дээрээ номын хүрдтэй байдлаар бүтээсэн ба таних тэмдэг болсон эд зүйлс нь алга болжээ. Сэнтийн суурь нь дугуй, давхар, хоёр тийш татагдсан дэлбээний доод тал нь хоёр цагаригтай, дээд талд нь сувдан хэлхээтэй. Самар дэлбээ хэлбэрийн дэлбээнүүд нь дээд доод талдаа тэгш хэмтэй.

Бурхны нигур нь Занабазар хийцийн бүх шинжийг агуулсан: нигур нь зөв хэлбэртэй, хамар уруулын орчмын үрчлээс байхгүй, цэвэрхэн тод зуувин хэлбэр, том төвгөр билгийн нүд, монхор хамар, урт бүйлс самар хэлбэртэй нүдтэй, чанх урагш харсан, цоолсон гэдэс бүхий урт чихтэй ажээ. Дунгуй ба шамтав нь товгор хээгээр чимэглэгдсэн, даавууны хээ нь уран нарийн.

### **Чойжин ламын сүм музейд буй Оточ Манал 1**

Эд. № О.42.75. Хүрэл, цутгамал, алтадмал. Хэмжээ: 31 x 14,5 x 20,5 см.

Бурхан бүтээх уламжлалт аргаар бүтээгдсэн, баруун мутартаа арүрийн үр барьжээ. Рашаантай аяга нь алга болжээ. Хагас дугуй суурь хоёр давхар бадамлянхуа цэцгийн дэлбээтэй. Доод тал нь гурван тойрогтой тахир шугаман сийлбэртэй (Зураг).

### **Чойжин ламын сүм музейд буй Оточ Манал 2**

Эд. №О.42.74. Хүрэл, цутгамал, алтадмал. Хэмжээ: 34,5 x 16,5 x 25 см.

Хагас дугуй суурь хоёр давхар бадамлянхуа цэцгийн дэлбээтэй энэ бурхан нь дээрхтэй адил. Баруун мутартаа арүр жимстэй, зүүн мутартаа рашаантай аягатай.

### **Эрдэнэ зуу хийдэд буй Оточ Манал**

Дээрх хоёроос арай бага хэмжээтэй бурхан Эрдэнэ зууд бий. Эд. №65-919. Гууль, цутгамал, алтадмал. Хэмжээ: 18 x 14 x 9 см. Бурхан бүтээх уламжлалт аргаар бүтээсэн.

### **Оточ найман Маналын шүтээн зураг**

Зотон 59 x 40 см. Шороон будаг, Өтгөн алтан түрхэцтэй. ХҮП зуун.

Кант нь хөх, хүрээ нь хүрэн. Эмжээр: Алтан цэцгэн хээтэй хул шаргал.

Энэхүү шүтээн зураг тод зурааснуудтай, өнгө нь тэгш хэмтэй, гол бурханаа тодруулж харуулсан, дугуй зохиомжтой. Шүтээн зургийн голд Шагжамуни бурхны том, тод дүр байх ба манал бурхных шиг цэнхэр өнгө туяаран харагдана. Энэ туяарч байгаа

өнгө, алтан цацрагтай улбар шар хүрээтэй тод хөх биеийг нь тойсон лагшингийн өнгөнөөс (самг.: prabhamandala) гарч байгаа юм. Оройн гэрэл нь (самг.: śiraścakra) нил ягаан хүрээтэй, зөөлөн ногоон өнгөтэй (Зураг 4.6.2).

Тэрээр очир завилгаагаар морилж, баруун мутар нь гэрчлэхийг уриалсан мутарлагатай, зүүн мутар нь бясалгалын мутарлагатай ба энэ мутарт буй номин эрдэнээр хийсэн бадар аяганд нь рашаан дүүрэн ажээ. Лам хүний гурван хувцас (самг.: tricīvara): хөх бүстэй улаан хүрэн шамтав, ногоовтор дотортой улбар шар дунгуйгаар хоёр мөрөө халхалсан, цайвар шар өнгийн орхимж нь өвдгийг нь халхалжээ. Хөх туяатай хар үс нь ов товтой, овоолсон зүгдорыг нь үнэт чулуун чимгээр тогтоосон, магнай дээрээ цагаан товгор билгийн нүдтэй, мутрын алга ба өлмийн уланд нь охор түрхэгдсэн, хөлийн улан дээрээ жижиг номын хүрдний дүрстэй. Олон өнгийн шүдэрхэг дэлбээнүүдтэй бадамлянхуа цэцгэн суурьтай мөнгөн саран дэвсгэр дээр морилжээ. Нимгэн уруул нь хөнгөн мөшөөн инээвхийлсэн, царайд нь баяр баясгалан гийсэн, өөгүй зөв нигуртай. Урлаач маань тэр яг одоо энд таны дэргэд байгаа мэтээр харц буулгаж бясалгаж хорвоогоос тасарсан ба хүрээлэн буй орчин тойрноо бүхэлд нь энэрэн хайрлаж буй байдлыг нэгэн зэрэг илэрхийлж чаджээ.

Шагжамуни бурхан уламжлалт монгол хүрээний голд буй мэт долоон Манал бурханаар хүрээлүүлэн морилжээ. Бурхдын нэрийг төвөд хэлээр алтан үсгээр мөргөлийн үтэйгээр бичжээ (дээрээс доошоо, баруунаас зүүн тийш).

1) Гол хэсгийн дээд талд Сунаман бурхан (самг.: sunāman, ston pa mtsan legs, монг.: sain neretü) байна. Баруун мутар нь номын хүрд эргүүлэх мутарлагатай, зүүн нь бясалгалын мутарлагатай, шамтав нь улбар шар, дунгуй нь алтан хээтэй улаан хүрэн, бадамлянхуа нь шар туяатай улаан хүрэн, оройн гэрэл нь ногоон, лагшингийн гэрэл нь нил ягаан.

Зураг 4.6.2. Найман оточ шүтээн зураг. Зотон 59 x 40 см. Шороон будаг, өтгөн алтан түрхэц. XVII зуун. А. Алтангэрэлийн цуглуулга.

2) Зүүн гар талын жавхлангийн эгшиг дуут бурхан (самг.: svaraghosa, төвөд: ston pa sgra dbyangs, монг.: jibqulanу-un egessig daуutu); баруун мутар нь өгөх мутарлагатай, зүүн нь бясалгалын мутарлагатай. Шамтав нь улаан хүрэн, дунгуй нь гурван эрдэнийн тэмдэг алтан хээтэй улбар шар өнгөтэй, бадамлянхуа нь нил ягаан, тэргүүнийг тойрон цацарсан гэрэл нь нил ягаан, лагшингийн гэрэл нь ногоон. Сварагхоша гэдэг нэр нь Сажын уламжлалын дагуу нэрлэсэн ба гэлүгбагийн ёсонд Раднаа чандра гэдэг [ВІТ 1986: 26].



3) Суварнапраба бурхан (самг.: *suvarnabhadra*, төвөд: *ston pa gser bsang*, монг.: *suvarṇaprabha*); Хоёр мутар нь хоёулаа номын хүрд эргүүлэх мутарлагатай, шамтав нь улаан хүрэн, дунгуй нь гурван эрдэнийн тэмдэг алтан хээтэй улбар шар, бадамлянхуа ба оройн гэрэлнь нил ягаан, лагшингийн гэрэл нь ногоон.

4) Зүүн доод талын Гаслан үгүй дээд бурхан (самг.: *aśokottama*, төвөд: *ston pa mya ngan med*, монг.: *ᠸасдang үgei degedü*); Хоёр мутар нь хоёулаа өгөх мутарлагатай, шамтав нь улбар шар, дунгуй нь улаан хүрэн, бадамлянхуа нь шар туяатай улаан хүрэн, оройн гэрэл нь ногоон, лагшингийн гэрэл нь нил ягаан.

5) Баруун гар талын Дармагирди бурхан (самг.: *dharma kīrti*, төвөд: *ston pa chos sgrags*, монг.: *dharm-a-kirti*); Хоёр мутар нь хоёулаа номын хүрд эргүүлэх мутарлагатай, шамтав нь улбар шар, дунгуй нь улаан хүрэн, бадамлянхуа нь шаргал туяатай улаан хүрэн, оройн гэрэл нь ногоон, лагшингийн гэрэл нь нил ягаан.

6) Арай доошоо байрласан Абинга бурхан (самг.: *abhijñāgāja*, төвөд: *ston pa mngon mkhyen*, монг.: *abinca*); баруун гар нь өгөх мутарлагатай, зүүн нь бясалгалын мутарлагатай. Шамтав нь улаан хүрэн, дунгуй нь гурван эрдэнийн тэмдэг алтан хээтэй улбар шар, тэргүүнээс цацарсан гэрэл нь нил ягаан, лагшингийн гэрэл нь ногоон.

7) баруун гар талын эмийн хаан оточ Манал бурхан (самг.: *bhaiṣajyaguru*, төвөд: *ston pa sman gyi bla*, монг.: *em-un qaᠸan*); баруун мутар нь өгөх мутарлагатай, ар үрны мөчир барьсан, зүүн нь бясалгалын мутарлагатай. Шамтав нь шар туяатай улаан хүрэн, дунгуй нь гурван эрдэнийн тэмдэг алтан хээтэй улбар шар, тэргүүнээс цацрах гэрэл нь нил ягаан, лагшингийн гэрэл нь ногоон, бадамлянхуа нь нил ягаан өнгөтэй.

8) Зүүн доод булангийн Шагжамуни бурхан (самг.: *śākyamuni*, төвөд: *ston pa shakya thub pa*, монг.: Шагжа бурхан); баруун мутар нь гэрчлэхийг уриалсан мутарлагатай, зүүн нь бясалгалын мутарлагатай. тэргүүнээс цацрах гэрэл нь улбар шар, лагшингийн гэрэл нь хөх, бадамлянхуа нь шар туяатай, улаан хүрэн өнгөтэй.

9) Баруун доод булангийн Занабазар (самг.: *jñya na' bajra*) лам хувцастай, улбар шар шамтав, улаан хүрэн дунгуй, шар жанчтай, гоёмсог хээтэй дөрвөлжин олбог дээр морилжээ. Сэнтийн түшлэгний алтан нацагдорж хээтэй хөх бүрээс лагшингийнх нь гэрлийг төлөөлжээ. Тэргүүндээ гэлүгбагийн ёсны үс нь дээшээ боссон шар малгай өмсжээ. Толгойг нь тойрсон тэргүүнээс цацрах гэрэл нь алтан цагаригтай улбар шар өнгөтэй ажээ.

Баруун мутартаа очир барьж, зүрхэн тушаа газартаа байрлуулсан, зүүн мутраа өвдөг дээрээ тавьж, хонх барьжээ. Хацар дээрх хонхорхой нь харагдана.

Төрөл бүрийн номнууд дээрх найман оточийн нэр өөр өөр байдаг ба энд Сажын уламжлалд хэрэглэдэг нэрээр нь бичжээ. Оточ Манал бурхныг хэрхэн зурах тухай тайлбарт лагшинг өөр өөр өнгөтэй бүтээнэ гэсэн байдаг ба төвөд уран зурагт ч бас өөр өөр лагшингийн өнгөтэй бүтээдэг. Уг шүтээн зурган дээрх бурхад хятад уламжлалд байдаг шиг алтан лагшинтай бүтээгджээ. Урлаач маань, мэдээж, оточ бурхадыг бүтээх хятад уламжлалыг мэддэг байсан бөгөөд үүнийг нь нэрийг бичихдээ багш гэсэн үг оруулснаас олж мэдэж болно.

Уулс нь ойгоор бүрхэгдсэн, тэгш хэмтэй гурвалжин хэлбэртэй. Олон янзын цэцэг, бут, халуун орны гайхалтай жимст моднууд байх ажээ. Бүх бурхад нэг ижил хэмжээтэй, нэг ижил хэлбэртэй, зүрх хэлбэрийн дэлбээтэй бадамлянхуа цэцгэн дээр морилжээ. Таван мэдрэхүйн өргөлийг арүрийн жимсний хэлбэртэй алтан вааранд хийж бадамлянхуа цэцгэн дээр тавьжээ.

Уг шүтээн зургийн ар дэвсгэрийн тэнгэр гүн хар хөх өнгөтэй, мөнгөлөг цагаан үүлстэй, зөөлөн ногоон байгальтай. Чанар сайтай алтан түрхэц, гүн өтгөн өнгөнүүд нь баяр баясгалан төрүүлнэ. Бурхдын тод цацарсан царайнууд, гүн хөх-ногоон өнгөн дээрх улбар шар алтлаг дүрсүүд хоршин дүрслэлийг багтаамж ихтэй бурхдыг баяр баясгалантай харагдуулна. Энэхүү бүтээлийн чухал онцлог нь Занабазар хэмээсэн гарын үсэгтэй өөрийнх нь хөрөг байгаа явдал юм.

## Урт наслуулах Аюуш бурхан

### *Шүтээний агуулга*

Аюуш бурхан (*самг.*: amitāyus, төвөд:tshe drag med; *монг.*: Аюш-Бурхан/Цаглашгүй наст – хязгааргүй урт насны бурхан) нь бадмын язгуурын бурхдыг үүсгэсэн Авид бурхны нэг хэлбэр бөгөөд улаан өнгийн лагшинтай, баруун зүгийг эрхшээдэг. Аюуш бурхан бол Монгол, Төвөдийн бурхны шашинд хамгийн их шүтэгддэг бурхдын нэг билээ. Учир нь хаана ч хэзээ ч хүн бүр урт наслахыг чухалчилдаг. Монгол, Төвөд, Буриад, Халимаг, Тувад хэрвээ хүний амь насанд цөвтэй болбол Аюуш бурхны “Насны ном” буюу Цэнд (*төвөд*: tshe mdo) уншуулж, сүм хийдэд өргөл өргөж, зул барьдаг.

Монгол Төвөдийн буддын шашинд Аюуш бурхны дүр маш олон тоогоор бүтээгдэж, урт наслуулах зан үйл, оршуулгын зан үйл зэрэгт зориулагдан тархсан байдаг. Уран гоё зурсан Аюуш бурхныг нэн олон тоотойгоор бүтээсэн хуйлаасан шүтээн зураг ихээр тархсан байдаг. Аюуш бурхны дүрийг дээврийн олон үүрт хөндийд олон тоогоор хувиран зурах явдал уран барилгад бий. Учир нь эдгэж илаарших зорилгоор хүмүүс Аюуш бурхныг олон тоотой бүтээдэг. Наймдугаар богд бүрмөсөн хараагүй болох аюул тулгарахад гурван мянган Аюуш бурхан бүтээсэн ба тэдгээрийн ихэнхийг Польш улсад захиалгаар хийлгэж байсан ба одоо эдгээр Аюуш бурхны баримал Улаанбаатарын Гандантэгчэнлин хийдэд байдаг.

Аюуш бурхныг голдуу улаан лагшинтай, цөөн тохиолдолд цагаан лагшинтай, нэг нигуртай, бясалгалын мутарлагтай хоёр мутартай бүтээдэг. Аюуш бурхан бадамлянхуа цэцэг, саран дэвсгэр дээр бадамлянхуа суудлаар морилж, амгаланг илтгэх чимэгтэй, өөрөөр хэлбэл, хааны хувцас, чимэгтэй байдаг. Гартаа мөнхийн рашаантай (*самг.*: amṛta) сав барьжээ. Таван дияан бурхны дүртэй титэм толгойдоо өмсжээ. Аюуш бурхныг мөн өөрийн юм Чандалитай нь (*санскр.* uḡanaddha “нэгд хоёр”; төвөд: yab-yum “эцэг эх”) бас бүтээсэн байдаг. Тэр хоёр хоёулаа таван өнгийн хадагтай сум, мөнхийн рашааныг барьсан байдаг.

Хүний нас бусад бүх бодьгалын адил биологи, газар зүй, нийгэм, сэтгэл зүй, үйлийн үр зэрэг олон нэгдмэл нөхцөл байдлаас хамаардаг боловч Энэтхэгийн их шидтэнгүүдийн дараа дараагийн үеийнхэндээ дамжуулсан бурхны сургаал ёсоор бол бодит зүйл ба хувь хүний хязгаарлалтыг даван гарч болох ажээ. Монголд ч, Төвөдөд ч “Бадам хатан”-ы домог их түгээмэл бөгөөд уг домогт ловон Бадамжунай Энэтхэгийн гүнж Мандарваагийн хамт Непалын хойд нутгийн Маратика хэмээх ариун агуйд урт наслах бясалгал хийжээ. Мандарваагийн аав нь охиноо тэнүүлч тарничтай холбогдохыг огт хүсэхгүй байсан болохоор хос хоёрыг галд шатаах тушаал өгчээ. Гэвч тэр хоёр галд шаталгүй гарч ирж, мөнх настай болсон байсан ба Мандарваа янз бүрийн шидийг эзэмшиж, солонгын биетэй болжээ. Энэхүү урт наслах тухай “Цэдүв Гондуй” гэгч номыг анх Аюуш бурхан өөрөө ловон Бадамжунайд өгч, тэрээр ҮШ зуунд нууц ном болгон бичээд, дараа үеийнхэндээ зориулж, Төвөдийн зүүн нутгийн хаданд нуужээ. XIX зуунд нууц номыг олж Намхайноров ринбүчи [Намкай Норбу, Джон Шейн. Кристалл и путь света. СПб.: Сангелинг, 1998 год — 216 с. ISBN 5-87885-003-X; Жизни и освобождение принцессы Мандаравы, индийской супруги Гуру Падмасамбхавы / пер. с тиб. Ламы Чонам

и Сангье Кхандро, пер. с англ. Игоря Калиберды — М.: Открытый мир, 2008. – гл.30] олж, шавь нартаа дамжуулжээ.

“Сукхавади-вьюха судар” (самг.: *sukhāvātīvyūha sūtra*, I век н.э.)-т Аюуш бурхныг Цаглашгүй урт настай бурхан хэмээн бичсэн байдаг. Агуу Авид бурхан амьтан бүхэн энэ богино насандаа номыг үр дүнтэй бүтээж чадахгүй зовж байгаад маш их шаналж, амьтан бүхэнд тусалъя гэсэн агуу их энэрэх сэтгэлийг төрүүлснээр Аюуш бурхан төржээ. Төгс амгаланг олсон Авид бурхны залбирлаар Сугавадийн ариун оронд бадамлянхуа цэцгээс Цаглашгүй урт наст бурхан төржээ. Авид бурхнаас тусдаа Аюуш бурхны ном IY зуунд “Аюушийн бясалгалын судар” хэмээх номын ачаар үүсжээ. Урт нас, эрүүл энх, элбэг хангалуун байдлыг хүсэж Аюуш бурханд мөргөдөг. Жишээ нь Нагаржунай намтарт шинээр төрөх хүү нь арав хоног ч амьд байж чадахгүй гэж аавд нь хэлэхэд тусгай бярман нарыг урьж, 7 нас хүртэл наслуулахаар болсон Нагаржунай Аюуш бурханаас ван аваад “бараг үхэшгүй мөнхийн бодисадва болж”, 600 насалжээ. Дараа нь түүнд насаа уртасгахын тулд лам бол гэж зөвлөсөн тул Нагаржуна лам болж, их шидтэн Сарахагаас Аюушийн мандлын тойрог дотор “сахил хүртэж”<sup>35</sup> долоон насныхаа хувь заяаныхаа шөнийг тэнд өнгөрөөжээ [Андросов 2018: т.1, с. 31, 52].

Төвөдөд Аюуш бурхны ном дэлгэрсэн нь бас Мьял богд (1052-1135) ба түүний уяман өвчтэй шавь Райчүнватай (1084-1161) бас холбоотой. Райчүнва хэрмэл бясалгагч нараас уяман өвчнийг эдгээх гайхамшигт арга байдаг гэж олж сонсоод, тэр аргыг хайж явсаар Гималайн нурууны өмнөх уулсад Сиддха-раджини (төвөд:*grub pa'i rgyal mo*) дагинатай уулзаж, Аюуш бурхан, Хаянхирваа зэрэг бурхдын бясалгалыг хийх эрх авчээ. Төвөдөд буцаж ирээд, энэ номын эрхээ эхлээд багш Мьял богд, дараа нь багшийнхаа болон өөрийнхөө шавь нарт өгчээ. Үүний дараа Аюуш бурхны ном Төвөдийн бурхны шашны бүх сургуулиудад тархжээ.

Авид бурхнаас тусдаа биеэ даасан Аюуш бурхныг шүтэх зан үйл хөгжихөд түлхэц өгсөн зүйл нь XIY зуунд Зонхавын түүнд зориулж бичсэн мөргөлийн үг байв. Энэхүү шүтэх зан үйл нь Төвөд Монгол, Хятадад XVI-XVIII зууны үед өргөн тархаж одоог хүртэл анхны ач холбогдлоо хадгалсаар иржээ. Аюуш бурхан нь Монгол ба Төвөдийн бурхны шашинд хамгийн их шүтэгддэг бурхдын нэг юм. Хаана ч хэзээ ч хүн урт насалж насаа уртасгахыг хүсдэг. Монгол, Төвөд, Буриад, Халимаг, Тувад хүний аминд аюул тулж

өвдөхөд “урт насны судар” буюу “Цэнд” (*төвөд*: tshe mdo) номыг Аюуш бурханд зориулан уншиж хийдэд өргөл өргөж зул барьдаг.

Өндөр Гэгээн Занабазар болон түүний шавь нар урт наслуулдаг бурхны дүрийг олныг бүтээсэн байдаг. Занабазарын намтраас харахад өөрийн ээж хатан хаан, Манжийн эзэн хаан Энх-Амгалан хааны (1654-1722) эмээд зориулж зуун Аюуш бурхны баримал хийж амилуулж байжээ. Занабазарын бүтээлүүд дотор Аюуш бурхан чухал байр суурь эзэлдэг. Занабазар ба түүний дэг сургуулийн янз бүрийн цуглуулгад Аюуш бурхны дүрүүд байдаг. Монгол төвөдөд Аюуш бурхны дүр маш олон тоогоор бүтээгдэж, урт наслуулах зан үйл, оршуулгын зан үйл зэрэгт зориулагдан тархсан байдаг. Маш уран гоё зурсан Аюуш бурхныг нэг дор олон тоотой бүтээсэн, хуйлаасан шүтээн зураг маш их тархсан байдаг. Аюуш бурхны дүрийг дээврийн олон үүрт хөндийд олон тоогоор хувиан зурах явдал уран барилгад бий. Учир нь эдгэж илаарших зорилгоор хүмүүс Аюуш бурхныг нэг дор олон тоотой бүтээдэг. Тухайлбал, наймдугаар богд бүрмөсөн хараагүй болох аюул тулгарахад гурван мянган Аюуш бурхан бүтээсэн ба тэдгээрийн ихэнхийг Польш улсад захиалгаар хийлгэж байсан ба одоо эдгээр Аюуш бурхны баримал Улаанбаатарын Гандан хийдэд байдаг.

### **Чойжин-ламын сүм музейд байдаг Аюуш бурхны уран баримал**

Хүрэл, цутгамал, алтадсан, өнгө будаг орсон.

Хэмжээ: 78 x 52 x 31 см. Жин 45380 гр. Суурьгүй.

Эд.№ О-42-9 /259/4/585. Государственный реестр, указ №126 от 1998 г. №80.

Занабазарын бүтээсэн Аюуш бурхны хамгийн том баримал Монгол улсын Улаанбаатар хотын Чойжин ламын музейд байдаг ба энэ нь агуу уран барималчийн хамгийн тансаг бүтээлүүдийн нэг юм. Бадамлянхуа суурь нь байхгүй бөгөөд маш гоё сийлбэртэй түшлэгтэй, арслангуудын өргөсөн сэнтийд морилжээ. Үүнтэй ижилхэн Монголд байдаг Занабазарын бүтээлийн нэг нь Базарсадын баримал бөгөөд мөн энэ Чойжин ламын сүм музейд үүнтэй ижилхэн алтадсан сэнтий дээр морилж байдаг. Энэ бурхны анхны зургийг Н.Цүлтэм [Цултэм 1982: с.54, Цултэм 1989: 84; MUGZ 2015: 14-17] хэвлүүлж байжээ.

Зураг4.7.1а. Уран баримал Аюуш бурхан. Хүрэл, цутгамал, алтадмал, өнгө будагтай. Хэмжээ: 78 x 52 x 31 см. Жин 45380 гр. Суурьгүй. Улаанбаатар хот, Чойжин ламын сүм музей.

Энэ уран баримлын ялгарах онцлог нь дэлбээ болгон дээр нь ялж төгс нөгчсөн дияаны таван бурхны дүрийг товойлгож таван хэсэгтэй титмийг дүрсэлсэн маш нарийн ажиллагаа юм. Голын хамгийн том дэлбээ дээр нь Аюуш бурхны харьяалагддаг бадмын язгуурын тэргүүн Авид бурхны дүрийг сийлжээ. Занабазарын бусад бурхдын адил Авид бурхан нь чийрэг бие бялдартай, өргөн мөртэй, нарийн бэлхүүстэй, жигд гөлгөр мутар, бойвтой цэвэрхэн зөөлөн арьстай бөгөөд үүнийг нь хүйтэн аргаар алтдаж хийсэн байдаг. Гарынх нь хуруунууд нь маш гоё жигдхэн бясалгасан хөдөлгөөн хийсэн ба үхэшгүй мөнхийн рашаан ба навч бүрийнх нь тусад нь цутгасан амин мод хийсэн алтан аягатай бүтээжээ. Аюуш бурхан нь бодисадвагийн найман чимэгтэй янз бүрийн хэмжээтэй сувс, цагариг, шигтгээ, унжлага, цэцгэн хэлхээ зэрэг нүүдэлчдийн урлагийн уламжлалт элементүүдээс бүрдсэн ажээ. Доти нь тэр чигээрээ цэцгэн хээ, захын хээгээр чимэглэгджээ. Бумба нь товгор унжлага, сувдан хэлхээнүүдээр чимэглэгджээ.

Зураг 4.7.1а Аюуш бурхан бясалгалын мутарлагатай, рашаантай бумбатай. Чойжин ламын сүм музейд байгаа уран баримлын хэсэг

Зураг4.7.1б. Чойжин ламын сүм музейд буй Аюуш бурхан. Зургийг С.С.

Буриад улсын Улаан-Үүд хотын **Р.Б** үндэсний музейд хадгалагддаг Аюуш бурхан  
Хүрэл, цутгамал, алтадсан, шорон будаг  
Хэмжээ: 55,0 x 36,5 см. Эд. № ОФ 999.

Өнөөдөр хамгийн их алдаршаад байгаа Занабазарын бүтээсэн томоохон уран баримлуудын нэг юм. Аюуш бурхан очир завилгаагаар (*самг.*: vajra paṅkaśana) дугуй бадамлянхуа суурин дээр хоёр мутраа бясалгалын мутарлагаар (*самг.*: dhyaṇi mudrā) байрлуулж, амин мод ургасан үхэшгүй мөнхийн рашаантай (*самг.*: amṛta) аяга барин суужээ.

Аюуш бурхан чийрэг биетэй, өргөн мөртэй, нарийнхан бэлхүүстэй, сайхан бясалгасан царайтай цэвэрхэн өндөр духтай, өндөр монхор хамартай, жижигхэн бумбагар уруултай ажээ. Бүйлсний самар шиг нүд нь чигээрээ бага зэрэг доош чиглэн харжээ. Маш

нямбай, дугуй хэлбэртэй дүрэлзэн гялалзсан эрдэнийн чулуун шигтгээтэй таван дэлбээтэй титэмтэй ажээ. Аюуш бурхан найман төрлийн бодисадвагийн хааны чимэгтэй. Өндөр овоолсон зүгдорыг нь сувдан хэлхээгээр ороож үнэт чулуугаар гоёжээ. Хоёр хэсэг үс нь мөрнийх нь урдуур унжжээ. Үс нь хөх өнгөтэй. Таван дэлбээтэй титмийг толгойных нь ард гурван хавчаараар тогтоож түүнийг тогтоон барьж байгаа тууз нь нүүр ба толгойг нь тойрон дэвүүр хэлбэрийн хамгаалалт үүсгэжээ. Дунгуй нь мөрөн дээр нь зөөлөн тунаж нуруун дээр нь додьёг шиг харагдана.

Хүзүүний чимэг нь цэцгэн эрих бөгөөд цээжин дээр нь гурвалжин хэлбэр үүсгэжээ. Урт сувдан хүзүүний зүүлт нь цэцгэн эрихтэй ба ардаа түгжээтэй. Шамтавных нь үзүүр товгор хээгээр чимэглэгдсэн ба Занабазарын уламжлалт бүтээлд байдаг ороомог ба цагариган хээнүүдтэй ажээ. Бүс нь үнэт чулуу бүхий унжлагуудтай. Зүүн мөрөн дээгүүрээ бясалгагчийн бүс болох сувдан эрих тохжээ.

Тал саран хэлбэртэй бадамлянхуа суурь нь гурван эгнээ сийлбэрлэсэн дэлбээнүүдтэй дээд эгнээний дэлбээнүүдийн завсраар цэцгийн дохиур харагдана. Ёроол байхгүй баримлын дотор талын хана нь жигдхэн гялгар байгааг харахад маш өндөр чанартай цутгамал болох нь мэдэгдэнэ. Нигур, хүзүүг нь хүйтэн аргаар алтадсан нь бүрзгэр болж баримлын бусад гялгар хэсгээс ялгарч харагдаж байна. Зүүн нүднийх нь доорх алтан бүрхүүлийг нь хуссан болохоор уг бурхныг уйлсан мэт харагдуулж байна (зураг 4.6.4а - г).



Зураг4.7.2а.

Зураг4.7.2в.



Зураг4.7.2б.

Зураг4.7.2г.

Зураг4.7.2д

Зураг4.7.2а.

**Аюуш бурхан. Улаанбаатар хотын Богд хааны ордон музей.**

Гууль, алтадсан, өнгө будагтай. Хэмжээ 26,2 x 17,9 см.

Эд.№ 1-47(1), 24-1-18. 2002 онд улсын бүртгэлд орсон. У-118 түүх соёлын үнэт өв №158. [МШУД, том 1, с.71].



(зураг 4.7.3).

Бурхныг уламжлалт аргаар бүтээжээ. Хүзүүний чимэг нь хэд хэдэн том сувснаас бүрджээ. Мөнхийн рашаан ба амин модтой аягаа хоёр мутраараа бясалгалын мутарлагаар барьжээ. Суурь нь “самар дэлбээ” хэлбэртэй давхар дэлбээтэй бадамлянхуа цэцэг бөгөөд толинд туссан мэт тэгш хэмтэй. Суурийн дээд хэсэг нь сувдан хэлхээгээр чимэглэгдэж доод үзүүр нь чимэглэлгүй гурван давхар цагариг ажээ.

#### **Эрдэнэзуу хийдийн Аюуш бурхан**

Гууль, алтадсан. Хэмжээ 25 x 12 x 16 см.

Эд.№65-04, 1/8 “Б”. Улсын бүртгэлд У-175 от 2000 г. №132. [МШУД, том 3, с.157]. Суурь нь давхар, хагас дугуй, дэлбээнүүд нь тэгш хэмтэй. Хүзүүний чимэг нь голлосон том (Зураг4.6.6).





Зураг 116-р хуудас

**Эрдэнэзуу хийдэд байдаг мөнгөн Аюуш бурхан**

Мөнгө, цутгамал, алтадсан. Занабазар хийц, XVIII зуун.

Хэмжээ: 24 x 14 x 10 см.

Эд.№ 65-309, 1/16

2004 оноос бүртгэлд орсон. У-108, №202 [МШУД, том 3, с.162]

Номин шигтгээ гоёлтой мөнхийн рашаантай сав нь дөрвөн нарийн навчтай, том дугуй бариултай тагтай. Хувцас нь сийлсэн хээнүүдээр чимэглэгдсэн (зураг 4.7.4).



Зураг 4.7.4. Суурь нь давхар, хагас дугуй, тэгш хэмтэй хоёр эгнээ дэлбээтэй.

**Монгол улс Улаанбаатар хот Занабазарын нэрэмжит дүрслэх урлагийн музейд  
буй**

**Аюуш бурхан**

Хүрэл, цутгамал, алтадмал, өнгө будагтай. Хэмжээ: 20,5 х 12,7 см. XVII зууны төгсгөл.

Эд.№ ДУМ 2012, 1260-1078. Улсын бүртгэл УПИКН У-118 от 2002 г. №163

[МШУД, том 1, с.186]. (Зураг4.7.4)



Зураг 4.7.5. Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей [зураг МШУД, том 1, с.186].

Бурхныг уламжлалт аргаар бүтээсэн ба гүйцэтгэлийн хэд хэдэн онцлог бий. Рашаантай бумбын дээд талд гал мэт дэвүүр хэлбэрээр цацарсан цацрагууд байна. Хоёр бугалган дээрээ тохсон орхимж нь хоёр тохойны дор тэгш хэмтэй гогцоо үүсгэж үзүүр нь суурийн хоёр талаар доош унжиж гурвалжин нугалаас үүсгэж суурийн доод үзүүрт хүрчээ. Суурь нь тэгш хэмтэй хоёр эгнээ бадамлянхуа цэцгийн дэлбээтэй, хагас дугуй хэлбэртэй, нүүрэн талын доод хэсэг нь гурвалжин хэлбэртэй хээгээр чимэглэгдсэн.

#### **Унгар улсаас буцааж өгсөн Аюуш бурхны баримал**

Уг уран баримал нь Унгар улсын нэгэн нэрт эрдэмтэнд хадгалагдаж байсан ба 2015 оны 4-р сард Будапешт хотын Е.Лораны их сургууль дээр болсон “Монголын бурхны шашин” олон улсын эрдэм шинжилгээний хурал дээр эрдэмтний өв залгамжлагчид нь Монголын Засгийн Газарт буцаан өгчээ.



Зураг 4.7.6. Будапешт хотын Е.Лораны их сургууль дээр болсон “Монголын Бурхны шашин” олон улсын эрдэм шинжилгээний хурал дээр эрдэмтний өв залгамжлагчид нь Монголын Засгийн Газарт буцаан өгч байх үеийн Аюуш бурхан. Хүрэл, цутгамал, алтадсан. Хэмжээ: 22 x 15 см. Зургийг С.С.

Уг бурхныг уламжлалт аргаар бүтээсэн ба суурь нь дугуй бадамлянхуа цэцэг ба самар дэлбээ хэлбэрийн дэлбээнүүдтэй ажээ.

**Москва хотод хувь хүний цуглуулгад байдаг Аюуш бурхны уран баримал**

Гууль, цутгамал, халуун аргаар алтадсан, хар өнгө орсон.

Хэмжээ 25 x 16 x 12 см. Жин 2750 гр.

Шүн нь байхгүй, ёроолын таг нь алга болсон.

Орос улс. Москва хот. Э.Мустафаевын цуглуулга.

Төвөд, Монголын бурхны шашны бурхан бүтээх тигийн дагуу бүтээгдсэн. Аюуш бурхны лагшин нь улаан, нэг нигур, хоёр мутартай ба хоёр мутраа бясалгалын мутарлагаар (*самг.*: dhyani mudrā) барьсан. Гарт нь мөнхийн рашаан (*самг.*: amṛta) байна. Уг бурхан саран дэвсгэр дээр очир завилгаагаар (*самг.*: vajra paṇyāṅkāsaṇa) морилсон, хаан хувцас гоёлтой байна. Овоолсон зүгдорыг хоёр уяагаар ороожээ. Дөрвөн дэлбээтэй титэмтэй ажээ. Мөрнийх нь урдуур хоёр хэсэг үс унжжээ. Үс нь хар будгаар будагдсан байснаа зарим газраа халцарсан байна.

Аюуш бурхан нь Занабазар хийцийн бусад бүх бурхдын адил бясалгасан, цэвэрхэн, залуу царайтай, завьжны үрчлээсгүй, нүд, хамар нь том, хоёр хөмсөгнийхөө дунд товгор билгийн нүдтэй. Нүд нь бүйлсний самар хэлбэртэй дээд зовхи нь бага зэрэг буусан (хүүхэн харааг нь зураагүй), хамар нь Занабазар маягийн монхор, уруул нь жижигхэн булцгар.

Зураг 4.7.7а. Гууль, цутгамал, халуун аргаар алтадсан, хар өнгө орсон. Хэмжээ 25x16x12 см. Жин 2750 гр.  
Э.Мустафаевийн цуглуулга.

Зураг 4.7.7в.

Зураг 4.7.7г.

Ялж төгс нөгчсөн таван дияан бурхныг бэлгэдсэн таван хэсэг бүхий титмийг толгойдоо өмсжээ<sup>36</sup>. Титмийг ар талд нь товч ба туузаар уяж тогтоосон байна. Асар том хүнд дөл хэлбэртэй ээмэгнүүд нь чихнийх нь нүхнээс доош унжиж, мөрөн дээр нь тогтжээ. Титмийн хэсгүүд, тууз, ээмэг, хүзүүний чимэг нь толгой, хүзүү, мөрний хамгаалалт болж чаджээ. Зүүн мөрөн дээгүүр нь давуулж биен дээгүүр нь ташуу хэлбэрээр зүүсэн чимэг бол бясалгагч хүний бүс юм. Гал хэлбэрийн шигтгээтэй чимгээр бугалга, бугуй, шагайг нь чимжээ.

Нимгэн зөөлөн, торгон хувцас өмсжээ. Бурхны их бие нь чийрэг, өргөн мөртэй, нарийн бэлхүүстэй, тэгшхэн хөлтэй, үеүд нь уян хатан, арьс нь цэвэрхэн зөөлөн ажээ. Мөрөн дээрээ нарийн тууз мэт болгосон орхимж (*самг.*: *uttārasanga*, *төвөд.*: *bla gos*, *монг.*: орхимж) тохсон нь нуруун дээр нь додьёог мэт харагдаж орхимжийн үзүүр нь бугалга, тохой ташаан дээр нь унжжээ. Шамтавных нь үзүүр (*самг.*: *antaravasaka*, *төвөд.*: *mthang gos/sham thab*, *монг.*: шамтав) өвдөг дээрээс нь унаж суурин дээр нь тунарч тэгш хэмтэйгээр унжжээ. Үзүүр нь цэцгэн эрих, цагариг, ороомог хэлбэрийн хээгээр чимэглэгджээ. Ташаан дээр нь үнэт чулуун унжлагатай бүс байх ба үндсэн хээ нь цэцгэн эрих ба шигтгээтэй дугуй багцууд юм. Гар нь жижигхэн булцгар дугуй сав барьсан хуруунууд нь маш гоё. Тэр сав нь торгон нугалаастай бүрээстэй ба дотроос нь цэцэг, шидэт жимстэй амин мод ургажээ. Бурхан зурсан уламжлал нь Бари-лодзавынх (≈1038-

<sup>36</sup> санскр.: *panca kula tathógata*, тиб.: *sangs rgyas rigs lnga*, монг.: Таван язгуурын бурхад - главы буддовых родов.

1109), энэ уламжлалын тухай Занабазарын урд дүр болох Төвөдийн эрдэмтэн Дарнатын (1575-1634) “Мянган бүтээл”-д<sup>37</sup> бичсэн байдаг.

Суурь нь хоёр давхар тэгш хэмтэй дэлбээтэй бадамлянхуа цэцэг ба гол хэсгээс нь дээш нь татсан мэт дээд талаараа хүрээтэй, доод талдаа сувдан хэлхээгээр чимэглэгдсэн бадамлянхуа цэцгийн дэлбээнүүд нь самар дэлбээ хэлбэртэй байгаа нь Занабазарын бүтээлд байдаг онцлог юм. Суурийг хэвтээ хэлбэрээр зүсэлт хийвэл хагас дугуй хэлбэртэй дээд талын хэсэг нь уран баримлын биетэй хамт цутгагдсан доод хэсэг нь хоёр төвгөр тойрогтой, түүний доод талдаа хүрээтэй, бадамлянхуа цэцэг байгаа хэсэгтээ гагнаастай.

### **Бадамлянхуа цэцгэн дээр зогсож буй лагшингийн гэрэлтэй Аюуш бурхан**

Хүрэл, цутгамал, алтадсан, эрдэнэсийн өнгөтэй.

Өндөр 68,5 см. Монгол улс, 17 зууны 70-аад он.

#### ***Тайлбар:***

Аюуш бурхан дугуй бадамлянхуа цэцгэн дээр цэх зогссон байх ба ард нь лагшингийн гэрэл нь харагдана. Гартаа аяга барьжээ (*самг.*: rātra, тиб. lhung bzed). Тайван царайтай, анхаарал нь төвлөрсөн хамрын хянганаас нь нарийн тахиралдсан хөмсөг эхэлж бүйлсний самар шиг хэлбэртэй урт нүдийг нь хүрээлжээ. Төмбөгөр магнайнахаа дунд төвгөр мэлмийн нүдтэй өндөр хамартай жижиг булцгар уруултай. Чанх урагшаа харсан харцтай, зовхио бага зэрэг буулгасан байна.

Биеийн харьцаа нь бурхан зурах тигийг яс баримталсан ажээ. Өргөн мөрөн дээр нь зөөлөн долгиотсон орхимж тохогдсон ба нуруун талд нь додьёог шиг харагдаж үзүүр нь гарыг даган доош унаж тохойны нугаларсан хэсэгт гогцоорчээ. Урт хар үснийхээ зарим хэсгийг зүгдөр болгон овоолж, заримыг нь доош унжуулсан нь өсгийг нь хүрчээ.

Зураг 4.7.8а

Зураг 4.7.8б.

Бодисадвагийн хааны найман чимэгтэй: таван дэлбээтэй титэм, мөрөн дээр нь тогтсон том ээмэг, сувдан хүзүүний чимэг, цээжийг гурвалжин хэлбэрээр хамгаалсан

<sup>37</sup> «Садхана сахасра» эсвэл Ринжун-гьяца (тиб.: rin 'byung brgya rtsa, бүтэн нэр нь: yi dam rgya mtsho'i sgrub thabs rin chen 'byung gnas) – “Ядамын бүтээлийн далай-эрдэнийн эх сурвалж”, XII зуун ба XIII зууны эхэн үеийн бурхан зурах тайлбар бүхий “Садхана самучайи” хэмээх Дарнатын зохиосон 483 хуудастай асар том бүтээл.

унжлага урт хүзүүний зүүлт, бугалга, бугуй, шагайн чимэгтэй, бүсэндээ унжлагатай, бясалгагч хүний бүсийг бэлгэдсэн сувдан хэлхээтэй ажээ.

Лагшингийн гэрлийг цул метал хуудсаар цэцгийн дэлбээ хэлбэрээр хийж нүүрэн талд нь сийлбэрээр гоёж ар талыг нь хэвээр үлдээжээ. Сийлсэн хээнүүд нь үнэт чулууг дүрсэлсэн эвэр хэлбэрийн хээ зэрэг монгол дүрслэх урлагийн уламжлалт элементүүд ажээ. Шамтавных нь хормойн ирмэгийн хээгээр гоёжээ.

Бадамлянхуа суурь нь Занабазар хийцийн өвөрмөц онцлогуудыг харуулжээ. Суурь нь гурван эгнээгээр сийлсэн дэлбээтэй цоморлог хэлбэртэй. Цэцгийн дэлбээнүүдийн завсраар дэвүүр шиг хэлбэртэй цэцгийн дохиурууд эгнэсэн байгаа нь онцгой анхаарал татаж байна. Ёроолын нацагдорж тэмдгийг төвгөр хийж алтадсан байна.

Уг уран баримал нь Хятад, Орос, Бразиль, Герман, Франц улсад элчин сайдаар ажиллаж байсан Италийн том дипломатч Витторио Черуттиний (1881-1961) цуглуулгад байсан юм. 1938 онд 57 настайдаа аавынхаа үйл хэрэгт эргэн ирж Banca popolare di Novara-ний ерөнхийлөгч болж янз бүрийн компанийн захирлуудын зөвлөлд оржээ. Авид бурхны уран баримлыг Миланд болсон Cambi Casa d'Aste дуудлага худалдаан дээр 3.900.000,0 еврогоор заржээ [<https://www.cambiaste.com/uk/auction-0310/a-large-and-rare-gilt-bronze-figure-of-a-stand.asp>].

Зураг 4.7.8в.

Зураг 4.7.8г.

### **Оросын холбооны улсын Эрмитажид байдаг Аюуш бурхан**

Хүрэл, цутгамал, алтадмал, өнгө будагтай. Өндөр 30,0 см.

Эд. №У-707. Э.Э. Ухтомскийн цуглуулгаас.



#### Зураг 4.7.9

Бадамлянхуа цэцгэн суурин дээр морилсон Аюуш бурхныг бурхан зурах уламжлалт аргаар бүтээжээ. Бодисадвагийн найман чимэгтэй, очир завилгаагаар морилсон бясалгалын мутарлагатай мутрууд дээрээ мөнхийн ус ба амин мод тавьжээ. Суурь нь өндөр, хагас дугуй, доогуураа бага зэрэг өргөссөн давхар бадамлянхуа цэцгийн дэлбээтэй. Энэ баримлын доод талыг онгойлгоогүй болохоор шүншиг нь хадгалагдсан бололтой. Ёроолын нацагдорж тэмдгийг төвийлгөж алтадсан байна. Ю.Е.Елихинагийн тодорхойлсноор энэ нь Эрмитаж байгаа цорын ганц Занабазарын бүтээл ажээ. [Елихина 2015: илл.88, с. 168-169] (зураг.4.7.9).

### 4.8. Ирээдүйн бурхан МАЙДАР

Майдар, *самг.*: maitreya; төвөд:jampra, *монг.*: maidar, Асрагч

#### *Шүтээний агуулга*

Намтар судлаач нарын бичсэнээр Занабазар Төвөдөд байхдаа Дарнатын барьсан Ганданпунцаглин хийдэд орж үзжээ. Хийдийн санд хадгалагдаж байсан олон арвин номын дотроос “зандан модны навчин дээр алтаар бичсэн Жадамба, Майдар, Локашвара, Дарь эх зэрэг олон онцгой ариун номуудыг олжээ”. Харин 1657 онд (гал тахиа жил) Эрдэнэ зууд Монголын 104 хошууны чуулган болж ирээдүйн бурхан Майдарыг угтах Майдар эргэх ёслол хийжээ [Зая-пандита (м): 10; История Эрдэни-дзу: 156/71]. Энэ цагаас хойш Монголын том хийдүүдэд энэ өнгөлөг зан үйлийг жил бүр хийдэг болжээ. Өндөр гэгээн Занабазарын бүтээсэн 72 см өндөртэй зогсож байгаа Майдар бодисадвагийн уран баримал нь нийслэлд байдаг Гандан хийдийн гол чухал шүтээнүүдийн нэг юм.

1816 онд 80 мутартай сууж байгаа асар том Майдар бурхан бүхий тусгай Майдарын хийд баригджээ<sup>38</sup>. Уг уран баримлыг Долоннуурын хятад урчууд цохих аргаар хийж олон хэсгээр зөөвөрлөн авчирч, нийлүүлжээ. Энэ арга хэмжээг Монголын алдартай эрдэмтэн Агваанхайдав (*төвөд*:ngag dbang mkhas grub 1779-1838) Тавдугаар богд гэгээний

<sup>38</sup> XIX зууны хоёрдугаар хагаст Байгалын чанадад Цугол, Агийн дацанд асар том Майдарын хөшөөтэй ийм сүм хийдүүд баригдаж байжээ. Энэ үед Оросын талаас хилийн хяналт тавьсан болохоор бурхадыг буюу Майдар бурхныг газар дээр нь Цуколийн дацан дээр буриад дархчууд бүтээсэн ба энэ тухай Байгалын чанад ба Монголд хэрийн шинжилгээгээр С. Ольденбургийн хамт материал цуглуулж явсан Андрей Руднев бичсэн байдаг [Руднев 1905].



ивээлээр (*төвөд*:rje btsun dam pa blo bzang tshul khirms ‘jigs med bstan pa’i rgyal mtshan 1815-1842) санаачилж 1833 онд уг уран баримал ба хийдийг равнайджээ. Энэ хийд нь уран барилгын холимог хийцтэй, тэгш өнцөгт хэлбэртэй, Төвөд хийцтэй боловч орой нь монгол гэр шиг бөмбөгөр байв [Uranchimeg 145-152]. Харамсалтай нь XX зууны 30-аад онд хийд ба уран баримлыг устгажээ. Энэ зууны эхээр Зүүн хүрээ Дашчойлин хийдийн хамба Дамбажав ламтан хийддээ Майдарын дуганыг босгож байна. Уран барималч Н.Оргил Занабазарын хийцээс загвар авч 1.6 метр хэмжээтэйгээр хуулбарлажээ. Энэ загвараас эх авч 22 метр өндөр баримлыг Сы чуаний Чендү хотод Төвөд, Непал урчууд бүтээжээ. Энэ бурхны нээлтийг 2018 оны зун хийжээ.

2014 онд Монгол Улсын нийслэлээс урагш 50 км зайд 108 метр өндөр суваргад багтаасан 54 метр өндөр Майдарын уран баримал гол объект нь болсон бурхны том цогцолборыг байгуулах ажлыг эхэлжээ. Энэ цогцолбор нь хэд хэдэн хийд, музей, номын сан, худалдаа, соёл амралт спортын талбайтай, цэцэрлэгт хүрээлэнтэй 1000 гаруй метр талбай эзэлсэн байгууламж болох юм. Ингэхдээ Занабазарын бүтээсэн улсын бэлгэдэл болсон соёмбо хэлбэртэйгээр байгууламжуудыг байрлуулах ажээ [Их Майдар төсөл 2015; Мөнх-Эрдэнэ 2017: 173-180].

Майдар бурхан бол бурхны шашны бүх уламжлал, тиг, сургуулиудын хүлээн зөвшөөрдөг цорын ганц бурхан юм. Майдар бурхны тухай хамгийн эрт илрээд байгаа эх сурвалж бол түүнийг Шагжамуни бурхны залгамжлагч гэж бичсэн хамгийн эртний мэдэгдээд байгаа эх сурвалж бол “Дикха-никайя” юм (III зуун). V зуунд Хятадын аялагч Фа сяны бичсэн Майдар бурхны хувилгаан дүр ирэх хүртэл Шагжамуни бурхны бадар аяга нууц байна гэсэн домгийг хэлсэн байдаг. Энэ домог бидний үеийг хүртэл явж ирсэн. Гэхдээ зөвхөн аяга ч биш, Гаяагаас холгүй Куккутапада ууланд Гаутама бурхны лам хувцсыг хадгалж байгаа Гашибын цогцос хүлээж байгаа юм. Майдар бурхан дэлхий дээр гарч ирэхээрээ тэр уулыг дундуур нь хувааж тэр цэцэн Гашибаас сүүлийн бурхны хувцсыг авах ажээ. Энэ домог нь Шагжамуни бурхны номыг үргэлжлүүлэх ирээдүйн бурхан ирнэ гэсэн итгэлийг маш тодоор харуулжээ [Рерих 2000: ??].

“Төвөдийн хуйлаасан уран зураг” хэмээх номыг бичих үндэслэл нь болсон Туччигийн цуглуулганд “Майдарын лүндэн” хэмээх шүтээн зураг байдаг ба зургийн зохиомж нь Бурхан багшийн амьдралын хэсгүүд ба Майдар бурхан морилох тухай зөгнөж өгүүлсэн бүтээл юм. Майтрейи (Авадана №17. Тангка №70, илл.106 (VI правая). Уг

шүтээн зурган дээр домгийн агуулга байгаа юм. Нэгэн удаа Бурхан багш Ганга мөрнийг нуруугаа бөхийлгөн цувж байрлан бүтээсэн могойнуудаас бүтсэн гүүрэн дээгүүр гаталж явжээ. Тэгээд Ялж төгс нөгчсөн бурхан голын ёроолд үнэт чулуун тахилын таяг байгаа гээд үүнтэй холбоотой түүхийг ярьж өгчээ. Бурхан багш тэнгэрт амьдарч байхдаа газарт Махапранада хаан (*төвөд*: mang pos bkur ba) дүрд хувилан төрөөд, бурхны хуулийн гайхамшигийг түүнд болон түүний харьяатуудад сануулаарай хэмээн Индрагаас гуйжээ. Индра түүнд тахилын таягийг өгөхөд хүмүүс тэр таягны сайхныг биширч ажлаа хийхээ больж, хаант төрийн ажил хэрэг уруудаж эхэлжээ. Тэгэхээр нь Махипранада хаан таягийг өшиглөн Ганга мөрөнд унагаад Шанка хэмээх хаан төрж, Пурохитын хүү Майдарт энэ таягийг өгнө. Майдар таягийг хэдэн хэсэг болгон хугалж, ядуу хүмүүст тарааж өгөөд дараа нь өөрөө бурхан болж, харин хаан сахил хүртэнэ. Ийнхүү Шанка Ратна-шики (*төвөд*: rin chen gtsug) бурхны үеийн урьд насныхаа аль нэгэн насандаа өргөсөн тангарагийнхаа үрийг амсаж, мөн бурхны шашин шүтдэг болсон Васава (*төвөд*: nor lha'i bu) хэмээх нэртэй өрсөлдөгчтэйгээ удаан хугацаанд тогтоосон өс хонзонд төгсгөл тавина гэж ярьжээ.

Энэ түүх голын дүрийн баруун гар талаас эхлэн өгүүлэгджээ. Эхлээд Будда могойнуудын тусламжтай гол гатлах гэж байна. Голын дунд нь суварга харагдана. <https://mail.google.com/mail/?tab=rm&ogbl>. Энэ зургийн яг дээд талд нь бурхан багш шавь нартаа түүх ба зөгнөлийг ярьж сууна. Түүнээс арай доошоо нөгөө суварга байх ба олон хүмүүс түүнийг шүтэж зогсоно, зөгнөж ярьж байгаа бурхны зүүн гар талд Махи Пранда гэдэг хаан гол уруу хөшөөг шидэж байна. Рамашигхина бурхны үед байсан өнгөрсөн амьдралынхаа тухай яриаг нь бурхны том зургийн дор товчхон бичжээ. Цаашлаад Майдар бурханд мөргөж байгаа Шанкху хааны дүрийг дүрсэлжээ. Түүний дор нь хааны эд зүйлсийн дотор суваргын хэсэг харагдана, хүмүүс олж авсан баялгаа аван тарж явж байна [Tucci 1949: 461-642].

Төвөдийн бүх сургуулиудад “Аламкарын их судар”, “Абхисама аламкара”, “Мадхьянта вибхага”, “Дхарма дхармата вибхага”, “Утгаратантра” гэдэг таван сэдвийг багтаасан “Майдарын таван номыг” заавал ч үгүй сурах хөтөлбөрийн тоонд оруулдаг. Эдгээр номын зохиогч нь Түшидийн орондоо шавь Асангагаа<sup>39</sup> авчирч өөрийн номоо

<sup>39</sup> Асанга (*санскр.*: asanga, *төвөд.*: thog me; объединитель, IV в.) Гандарт төрсөн, бясалгалын сургуулийг үндэслэгч, бурхны шашныг хөгжүүлэхэд асар их нөлөө үзүүлсэн мадьямака, авидарма, билиг барамидын хэд хэдэн зохиол бичсэн. Андросов БРЭ. Эл. Ресурс от 18.09.2020 (<https://bigenc.ru/philosophy/text/1833878>)-aac хар. Майдар бурхантай уулзаж, өөрөөс нь шууд ном сонсохын тулд ууланд ганцаараа олон жил даяанчилж суусан Асангагийн тухай нь олон янзын домог байдаг. Гэтэл Майдар үргэлж түүний хажууд байсаар байсан

дамжуулсан Майдар бурхан юм. Асанга түүнийг бичиж аваад “Уттарагийн тарнийн” тайлбар нэмжээ. Энэ Майдарын бурхны бүтээл нь бурхны шашны номын чухал асуудал болох бурхны мөн чанарын (*самг.:tathāgata garbha*) тухай өгүүлсэн байдаг. Төвөдийн түүх судлалаас харахад “Уттарагийн тарни” алга болж, харин 11-р зуунд хуучин суваргынх нь ангархайгаас [Майтрейя 2019: 3-11] Матрипа гэдэг Энэтхэг шидтэн олж дахин алдаршсан байдаг. Дундад зууны үеийн европын философичдын хоосон чанар (*төвөд.:rang stong/gzhan stong*) байдаг эсэх түүнээс хамаардаг эсэх тухай маргааныг зогсоож, эвлэрүүлж өгснөөрөө энэ эх сурвалж чухал юм. “Уттарагийн тарни” Майдарын таван ном нь Занабазар ба гэлүгвын шашин ба жонангийн шашны хооронд улс төрийн өрсөлдөөн гарсан 17-р зуунд байсан Монгол Төвөдийн харилцаанд онцгой чухал үүрэгтэй байв. Майдар бурхан ирнэ гэдэг нь Бурхны шашинтнуудын хувьд нийтээрээ эв нэгдэлтэй буянтай байх гэсэн утгатай юм. Майдар гэдэг үг нь хайрлах, хайр, сайхан сэтгэл (*монг.: өршөөгч, нөхөрлөл, сайн сайхныг хүсэгч, асрагч, энэрэгч*) [Бүрнээ 2017: 183-188] гэсэн утгатай ажээ. Майдарын зан үйлд түүнийг угтах маш гоё ёслолын ажиллагаа хийдэг. Энэхүү баяр нь анх 1409 онд Гэлүгвагийн уламжлалын тэргүүн Зонхавын (1357-1419) санаачлагаар хийгджээ. Маш өнгөлөг жагсаалын хувцастай хүмүүс хийд эсвэл суурин газраа бүхэлд нь тойрч явдаг. Майдар бурхан нь цагаан заан эсвэл ногоон моринд (Майдар бурхан дэлхий дээр ирэхээсээ өмнө амьдардаг Түшидийн оронд ногоон морь байдаг) хөллөсөн гоё тэргэн дээр заларч явдаг. Мөн Майдарын дээр шар шүхэр байрлуулсан байх ба тус хийдийн бүх лам шавь нар хөгжмийн зэмсэг, туг хиуртайгаар дагаж явах ба бурхны шашны ариун номуудыг барьсан сүсэгтнүүд бас араас нь дагадаг.

Хөндлөн чөхүр Түмэнхэн ноёны (1556-1640) ачаар Халхын хийдүүдэд анх Майдар бурхны дүр бий болсон энэ бол Далай лам Ёндонжамцыг оршуулсны дараа 1616 онд тэрээр Төвөдөөс гавал аягын хамт авчирсан мөнгөн баримал юм. Дараа нь энэ бурхандаа зориулж хийд барьж, хийд дотроо байрлуулсан. Хөндлөн чөхүр Түмэнхэн ноёны дараагийн дүр нь Занабазарын шавь Халхын Зая бандида Лувсанпэрэнлэй юм. Ирээдүйн бурхныг угтах Майдар эргэх зан үйл Монголд Занабазарыг байх үед 1653 онд Эрдэнэ зууд анх зохион байгуулагджээ.

Майдар бурхан бол Бэрозана бурхны үүсгэсэн Очирын язгуурын бурхан юм. Судрын ёсонд түүнийг бодисадва, харин тарнийн ёсонд Шагжамуни бурхны дараа ирэх

---

боловч Асангагийн өөрийнх нь мунхагаас болж харагдахгүй байжээ..

ялж төгс нөгчсөн бурхан гэж үздэг. Яг одоо бол тэр Түшидийн оронд заларч буй гэгддэг. Түүний цол нь ихэд хүндлэгдсэн буянтай (*самг.*: āḡya; төвөд: ‘phags pa/tje btsun) юм. Түүний гол ялгарах шинж нь Наг модны шар цэцэг, устай бумба (*самг.*: kuṅḍikā; төвөд: ril ba) мөн толгой дээрх суварга юм. Үндсэн биеийн хөдөлгөөн нь хөлөө бага зэрэг нугалан босож зогссон, (*самг.*: tribhaṅga; төвөд: ‘gying ba) эсвэл зүгээр л суугаа дүртэй байдаг юм (*самг.*: bhadrāsana; төвөд: bzang po’i dug stangs). Энэ байрлал нь ганцхан энэ Майдар бодисадвагийн байрлал бөгөөд ертөнцөд залрахад бэлэн байгаа учир хөлөө сэнтий дээрээсээ буулгасан гэсний бэлгэдэлтэй бүтээдэг юм. Майдар бурхан нь алтлаг өнгийн МАИМ үсгүүдээс хоосноос бий болно. Ниртипадын (санкр.: nirṭipāda; төвөд: tje btsun byams pa ni ri ti ra’i lugs) уламжлал ёсоор Арьяа Майдар нь алтлаг лагшинтай бүх сайн чанарыг өөртөө шингээсэн очир завилгаагаар морилсон торгон хувцас өмссөн бодисадвагийн бүх чимгээр чимэглэгдсэн ажээ. Баруун мутар нь ном айлдах мутарлагатай, зүүн мутар нь бясалгалын мутарлагатай замбага<sup>40</sup> модны ишнээс барьсан байх ба модны цэцэг нь түүний чихний орчимд байх ба дээр нь устай бумба байна. Үс нь урд талдаа суваргаар чимэглэгдсэн ажээ. Зүүн мөрөн дээр нь зээрийн арьс тохоостой ажээ. Түүнийг Ваджрасанамуни бурхан эсвэл Нагешвара-раджи бурхны дагуул эсвэл найман бодисадва бурхны нэг байдлаар дүрсэлдэг [TDB 2002: 49c; 92; 14b; 247]. Монгол Улсад энэ хоёр хувилбар хоёулаа байдаг бөгөөд зогсоо дүртэй, эсвэл алхаж байгаа залуу бодисадва, эсвэл суудал дээрээсээ хөлөө унжуулж суусан титэмтэй бурхны дүртэй байх ажээ.

### Дүрслэх урлагийн музейд байдаг Майдар бурхны шүтээн зураг

Эд. 66.01.11. 685-10. №234 (указ 116 ПМ 2005 г.) дугаартайгаар Монгол Улсын түүх соёлын үнэт өвийн тоонд орсон.

Зотон, хэмжээ: 55 x 37 см. XVII зуун.

Хүрээ: цагаан уяагаар эмжсэн хөх ба алтан хоргойн хүрээтэй шиллэсэн модон жаазанд байрлуулжээ. Майдарыг уламжлалт бурхан бүтээх тигийн дагуу бүтээсэн ба Абханга зогсолтоор буюу хөлөө нугалахгүйгээр гэхдээ бага зэрэг баруун тийш хазайсан

<sup>40</sup> Замбага мод (naga vṛkṣa) (лат. Magnolia champaca) нь Magnoliaceae төрлийн цэцэгт ургамал. Вечнозелёное дерево, достигает в высоту 50 м хүртэл ургадаг, мөнх ногоон мод бөгөөд навч нь урт, хурц үзүүртэй, хүний арьс мэт, анхилуун үнэртэй цагаан, шар цэцэгтэй, цэцгийн шүүсээр нь үнэртэй ус хийдэг. Зүүн өмнөд Азид (Хятад, Энэтхэг, Малайз, Мьянмар, Непал, Тайланд, Вьетнам) далайн түвшнээс дээш 200-1600 метрт өргөн навчит мөнх ногоон модтой ойд ургадаг.

байдалтай зогсжээ. Гоолиг алтлаг лагшинтай өргөн цээж, нарийн бэлхүүстэй, царай нь дугуй бөгөөд тодорхой, залуу арьс нь гялалзан харагдана. Бүйлсний самар шиг нүдээрээ чанх урагшаа харжээ. Том нүхтэй урт том чихтэй, чихэндээ ээмэггүй, нарийхан нумарсан үснийх нь эхлэлтэй адилхан хэлбэртэй хөмсөгтэй зүгдөр үсийг нь конус хэлбэрийн уяагаар уясан дээрээс нь эрдэнэсээр чимсэн ба мөрөн дээр нь хэсэг үс унжжээ. Зүүн мөрөн дээрээ эвэр туурайтай зээрийн хүрэн арьс тохжээ. Хөл нь шулуухан, хөлийнхөө тавхайг гадагш гишгэн зогсжээ. Баруун мутраа нугалан цээжнийхээ орчим номын хүрд эргүүлэх мутарлагаар байрлуулсан ажээ. Ингэхдээ эрхий долоовор хуруугаа нийлүүлж хүрд хэлбэр гаргасан. Улаан алга нь охороор бүрхэгдсэн ба хүмүүс уруу алгаа гадагш нь харуулсан алган дээр нь бурхны наян найргийн нэг болох жижигхэн алтан хүрд байна. Биеийнхээ дагуу унжуулсан зүүн мутартаа нарийн цорготой, тагтай бумба барьжээ. Хөх өнгийн гоё шамтаваа улбар шар бүсээр бүсэлсэн ба ташаан дээр нь ташуу хэлбэрийн нарийхан орхимж тохогджээ.



Зураг 4.8.1. Майдар. Шүтээн зураг. 55 х 37 см. XVII зуун. Улаанбаатар, Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей.

Майдар бурхан олон өнгийн тод дэлбээтэй бадамлянхуа цэцгэн суурь ба цагаан саран дэвсгэр дээр зогсоно. Ар талд нь навч хэлбэрийн лагшингийн гэрэл байна. Энэ нь

төв хэсэгтээ улаан өнгөтэй, хээ угалз олон өнгийн шигтгээ бүхий улбар шар хүрээтэй ажээ. Маш товч тодорхой зохиомжтой бөгөөд сайн хоршсон тод бүдэг толбонууд нь зээгт наамлын дүрснүүд шиг харагдана. Нэлээн дээгүүр зурагдсан хөндлөн зураас нь орон зайг цагаан үүлтэй тэнгэр ба бодит шилмүүст модтой гурвалжин уул бүхий цайвар ногоон газар болгон хуваажээ. Өмнө хэсэгт нь тэнгисийн цэнхэр давлагааг зуржээ. Бурхны өмнө бадамлянхуа суурийн доор таван мэдрэхүйд зориулсан өргөл бүхий улбар шар аяга тавьжээ. Шүтээн зургийн дээд талын зүүн баруун талд нь нар сар, дотроо суусан бурхантай хоёр алтан суварга харагдана.

### **Чойжин ламын сүм музей дэх Майдар бурхны уран баримал**

Гууль, цутгамал, алтадмал, өнгө будаг орсон. Хэмжээ: 68 х 45 см. XVII в.. Инв. № Ө-42.61. 81-251. №160 дугаартайгаар “Монгол улсын түүх соёлын ховор өвд” бүртгэгдсэн, 2002 оны №118 тушаал.

#### ***Тайлбар:***

Уг уран баримлыг дээр дурдсантай адилаар бүтээсэн боловч хэлбэр дүрсийг шийдэхийн тулд бага зэрэг өөрчлөлт хийжээ. Тэнцвэрийн цэгийг нь олж цутгахдаа зохиомжилсон байна. Майдар бурхан баруун хөлөө бага зэрэг өвдгөөр нь нугалснаас зүүн ташаа нь бага зэрэг зүүн тийшээ нугаларч баруун гар тал уруугаа бага зэрэг урагш тэмүүлэн хазайсан трибханга зогсолтоор зогсжээ. Гоолиг биетэй, өргөн мөртэй, нарийн бэлхүүстэй, царай нь дугуй, нээлттэй, залуу арьс нь гялалзан харагдана. Хамар нь нарийхан өндөр. Бүйлсний самар шиг нүд нь хамрын үзүүр уруу харсан. Том, урт, нүхтэй гэдэстэй, чих нь ээмэггүй ажээ. Нум хэлбэрийн нарийхан хөмсөгтэй ба хоёр хөмсөгнийх нь голд том билгийн нүд байна. Үс нь бараг шув шулуун. Зүгдорыг нь конус хэлбэрийн уяагаар уяжээ. Үснийх нь урд талд алтан суварга байсан ба одоо энэ нь хугарч дөрвөн дэлбээний суурь л үлдсэн бөгөөд хэдэн туг үс мөрөн дээр нь унжжээ. Зүүн мөрөн дээрээ эвэр туурайтай зээрийн арьс тохож мөн бараг өвдгөн дээр нь хүрсэн ташаан дээрх орхимж нь бага зэрэг дээш болсон бясалгагчийн бүсийг бас зүүн мөрөн дээр тохжээ. Баруун мутраа нугалж хуруугаараа номын хүрдний мутарлагыг цээжнийхээ орчимд хийжээ. Ингэхдээ эрхий хуруу долоовор хурууныхаа үзүүрийг нийлүүлжээ. Алгаа гадагш харуулсан, алган дээр нь жижигхэн номын хүрд бурхны наян найргийн нэг болж

харагдана. Зүүн гараа унжуулж тагтай нарийхан цорготой бумба барьжээ. Шамтаваа ташаан дээрээ бүсэлсэн ба орхимж нь ташуу харагдана (зураг 1).

Биеийн ил хэсэг нь сүүмгэр алтан түрхэцтэй бол хувцас ба бадамлянхуа суурь нь гялгар алтан түрхэцтэй. Үс нь хөхөөр будагдсан, нүдний хар цагаан нь ялгаран харагдана. Саяхан сэргээж будсан бололтой. Учир нь хуучин зурган дээр будаг нь халцарсан гарчээ. Суурь нь дугуй, завсар хооронд нь дохиурууд нь харагдсан дугуй, цутгамал дэлбээнүүдтэй, цэцэглэж байгаа цэцгийн цоморлиг шиг хэлбэртэй. Бадамлянхуа цэцгийн дэлбээнүүд нь Занабазар хийцийн онцлог болох болсон самрын боргоцой шиг үзүүр хэсгээрээ шувууны хошуу шиг болсон байдаг. Энэ бурхны зургийг Цүлтэмийн бүтээлд хэвлэсэн. 1989: №78; ММШД, I: с.136.

### **Гандан хийдийн Майдар бурхны уран баримал**

Гууль, цутгамал, өндөр нь 72 см.

Алтан түрхэцтэй, өнгө будагтай. XVII зуунд хамаарагдана.

Бурхан бүтээх тиг маяг нь Чойжин ламын сүм музейнхтэй адилхан, харин уран зургийн дүр нь Монголын дүрслэх урлагийн музейнхтэй адилхан. Тэнцвэрийн цэгийг нь олж цутгахдаа зохиомжилсон байгаа. Майдар бурхан баруун хөлөө бага зэрэг өвдгөөр нь нугалснаас зүүн ташаа нь бага зэрэг зүүн тийшээ нугаларч баруун гар тал уруугаа бага зэрэг урагшаа хазайсан трибханга зогсолтоор зогсжээ. Гоолиг биетэй, өргөн мөртэй, нарийн бэлхүүстэй, царай нь дугуй, нээлттэй, залуу арьс нь гялалзан харагдана. Хамар нь нарийхан өндөр. Бүйлсний самар шиг нүд нь хамрын үзүүр чигтээ харсан. Том, урт, нүхтэй гэдэстэй, чих нь ээмэггүй ажээ. Нум хэлбэрийн нарийхан хөмсөгтэй ба хоёр хөмсөгнийх нь голд том билгийн нүд байна. Үс нь бараг шув шулуун. Зүгдорыг конус хэлбэрийн уяагаар уяжээ. Үснийх нь урд талд алтан суварга байх ба хэдэн туг үс мөрөн дээр нь унжжээ. Зүгдорынх нь оройг дөрвөн дэлбээтэй суурьтай чимгээр чимэглэжээ.



Зураг 4.8.2. Зогсож байгаа Майдар бурхан. Занабазар, XVII зуун. Гууль, цутгамал, алтадсан, хөх будагтай. Хэмжээ: 68 х 45 см. Улаанбаатар. Чойжин ламын сүм-музей. Эд. № Ө-42.61. 81-251. Хэвлэгдсэн [Цултэм 1989: №78; ММШД, I: с.136].



Зураг 4.8.3. Зогсож буй Майдар. Занабазар, XVII зуун. Гууль, цутгамал, алтадсан, хөх, цагаан, хар будагтай. Өндөр 72 см. Улаанбаатар, Гандан. Хэвлэгдсэн. [Цултэм 1982: 64, ил.44, Цултэм 1989: ил.79].

Зүүн мөрөн дээрээ эвэр туурайтай зээрийн арьс тохож, мөн бараг өвдгөнд нь хүрсэн бясалгагчийн бүстэй, гэхдээ ташаан дээрээ зангидсан орхимж нь бясалгагчийн бүсийг бага зэрэг дээш нь болгожээ. Баруун мутраа нугалж хуруугаараа номын хүрдний мутарлагыг цээжнийхээ орчимд хийжээ. Ингэхдээ эрхий, долоовор хуруунуудынхаа үзүүрийг нийлүүлжээ. Гадагш харуулсан алган дээр нь жижигхэн номын хүрд бурхны наян найргийн нэг болж харагдана. Зүүн гараа унжуулж тагтай нарийхан цорготой бумба барьжээ. Шамтаваа ташаан дээрээ бүсэлсэн ба орхимж нь ташуу харагдана.

Биеийн ил хэсэг нь сүүмгэр алтан түрхэцтэй бол хувцас ба бадамлянхуа нь гялгар алтан түрхэцтэй. Үс нь хөх өнгөөр будагдсан, нүдний хар цагаан нь ялгаран харагдана. Саяхан сэргээж будсан бололтой. Учир нь хуучин зурган дээр будаг нь халцарсан гарчээ. Суурь нь дугуй, завсар хоорондын дохиурууд нь харагдсан дугуй, цутгамал



дэлбээнүүдтэй, цэцэглэж байгаа цэцгийн цоморлог шиг хэлбэртэй. Бадамлянхуа цэцгийн дэлбээнүүд нь Занабазар хийцийн онцлог болох болсон самрын боргоцой шиг хэлбэртэй, үзүүр хэсгээрээ шувууны хошуу шиг болсон байдаг. Энэ бурхны зургийг Цултэм өөрийн бүтээлдээ хэвлэж байв. 1989: №78; ММШД, I:

х.136. Зургийг нь хэвлэж байсан: Цултэм 1982: 64, зур. 44, Цултэм 1989: зур. 79.

### **Алтангэрэлийн цуглуулга дахь Майдар бурхны уран баримал**

Зэсийн хайлшаар хийсэн зохиомж нь бурхны бие, суурь, лагшингийн гэрэл (нөхөн сэргээсэн) гэсэн гурван хэсгээс бүрдэж байна. Халуун аргаар алтадсан, хар, цагаан, улаан, тод хөх өнгө хэрэглэгдсэн, өндөр нь 60 см, суурийн диаметр 20 см, өндөр нь 10 см. XVII зуунд хамаарагдана. Монгол Улсад хувь хүний цуглуулгад байна. Майдар бурхан залуу сайхан хөвгүүний дүрээр зүүн хөлөн дээрээ тулж бага зэрэг арагш чиглэсэн байдалтай зогсжээ. Өндөр зүгдөр үснэрийг нь олон дэлбээтэй үсний даруулгаар чимэглэн даруулжээ. Хоёр туг хөх үс доош унжжээ. Том нүүртэй, өндөр бүргэд хянган хамартай, магнай дээрээ төвгөр билгийн мэлмийтэй, мэлмийгээ нээсэн байдалтай, зүүн мөрөн дээрээ зээрийн арьс тохжээ. Баруун гар нь зүрхэн тушаа газраа ном номлох мутарлагатай доош буулгасан зүүн гартаа усны бумба барьжээ (алга болсон). Шамтавыг баруун, зүүн тийш нь нугалж зөөлөн бүсээр бүсэлсэн ба үзүүр хэсэг нь дарайж харагдана. Нарийхан орхимжоо хажуу талдаа хоёр уяагаар уяжээ. Нуруун дээр нь шүн хийх нүх гаргасан байна.

Бадамлянхуа суурь нь дугуй, бодитой цэцгийн дэлбээ дэлгэрч байгаа мэт хэлбэртэй, гурван давхар дэлбээнүүд нь тэгш хэмээр байрласан ба нэг эгнээнд нь 12 дэлбээ байна. Суурийн дээд хэсгийг сувдан хэлхээгээр гоёжээ. Шүн нь хадгалагдан үлдсэн боловч таг нь алга болжээ. Өндөр нум хэлбэрийн лагшингийн гэрлийг нөхөн сэргээжээ. Нигур ба үсийг нь шинээр буджээ. Энэ уран баримал нь өргөн бөгөөд дэлгэсэн хавтгай шамтавныхаа хормойны хүчээр нэлээн зузаан болжээ. Мутар ба нигурыг нь бага зэрэг болхидуу цутгажээ. Хормойг нь цэцгэн эрихээр даруухан чимэглэжээ.

Зураг 4.8.4а. Майдар. Өмнө талаасаа. Хүрэл, гурван хэсэгтэй цутгамал. Лагшингийн гэрлийг нь нөхөн сэргээжээ. Халуунаар алтадсан, хар, цагаан, улаан, тод хөх өнгөнүүд орсон. Өндөр нь 60 см, суурийн диаметр 20 см, өндөр 10 см. XVIII зуун. А. Алтангэрэлийн цуглуулга

Зураг 4.8.4в. Майдар. Доод тал. Бадамлянхуа суурийнх нь таг алга болжээ. А. Алтангэрэлийн цуглуулга.

Зураг 4.8.4б. Майдар. Ар талаасаа. Хүрэл, гурван хэсэгтэй цутгамал. Лагшингийн гэрлийг нь нөхөн сэргээжээ. Халуунаар алтадсан, хар, цагаан, улаан, тод хөх өнгөнүүд орсон. Өндөр нь 60 см., суурийн диаметр 20 см., өндөр 10 см. XVIII зуун. А. Алтангэрэлийн цуглуулга

Зураг 4.8.5. Майдар. XVII зууны төгсгөл – XVIII зууны эхэн Өндөр 32,3 см. АНУ хувийн цуглуулга. Занабазар хийц. [Beguin 2005, pl.11]

### Гадаадын цуглуулгад байгаа ижил төрлийн баримлууд

Занабазар хийцийн Майдар бурхны баримал АНУ-ын Нью-Йорк хотын Росси и Росси хэмээх музейн үзэсгэлэнд хувийн цуглуулгаас тавигдаж байсан ба Бегуины тайлбартайгаар зураг нь хэвлэгдэж байжээ. Суурь нь алга болсон модон тавиурт бэхэлсэн байжээ.

### Сэнтий дээр заларсан Майдар бурхны баримал

Хаан чимгээр чимэглэсэн Майдар бурхан нь түшлэгтэй бадамлянхуа цэцгийн суурин дээр хөлөө унжуулан суужээ. Шүр, оюу шигтгээтэй таван хэсэгтэй алтан титэм өмсжээ. Титмээс дээшээ үнэт чулуугаар чимсэн зүгдөр харагдана. Зарим туг үснүүд мөрөн дээр нь унжжээ. Урт гэдэстэй, том чихэнд нь том ээмэг мөрөн рүү нь унжжээ. Шүр оюу шигтгээтэй тансаг хүзүүний чимэг цээжийг нь бүрхжээ. Хоёр мутар нь цээжин дээрээ номын хүрд эргүүлэх мутарлагатай байрлажээ. Мөн бадамлянхуа цэцгийн ишийг чимхсэн байх ба цэцгийн цоморлог нь нигурных нь орчим ба өмнө нь цэцгэн дээр суварга, бумба байсан бөгөөд зүүн мутрын бадамлянхуатай хамт алга болсон байна. Зүүн мөрөн дээгүүрээ сувдан хэлхээт бясалгагчийн бүс тохжээ. Дугуй бадамлянхуа цэцгэн дээр морилж байгаа ба бадамлянхуа цэцэг нь арслан өргөсөн суурин дээрх цэцгийн цоморлиг хэлбэртэй ажээ. Ийм суудал нь Занабазарын суваргад түгээмэл байдаг хэлбэр юм. Доош буулгасан хөл нь мөн бадамлянхуа цэцгэн дээр байх боловч бадамлянхуа нь дугуй суурьгүй ажээ. Суудлын түшлэг нь бодь модны навч хэлбэртэй гол хэсэгт нь цацарсан цацрагтай дүрс байгаа нь энэ бурхны гэрэлтэж буй аура юм. Баримлын зохиомжийг Занабазарын хийц гэж музейн ажилчид үзэж байв. Харамсалтай нь чөлөөтэй үзүүлж болохгүй учраас уг баримлыг сайн ажиглаж чадаагүй билээ.

Зураг 4.8.6. Чөлөөтэй суусан Майдар бурхан. Хэмжээ 65 х 29,5 х 27 см. Гууль, алтадмал, Шүр номин шигтгээтэй. Монгол улс, Улаанбаатар, Чойжин ламын сүм музей.

### 4.9. Цэцэн ухааны бодисадва Манзушири

самг.: mañjuśrī / mañjughoṣa; төвөд: 'Jam dpal / 'jam dbyangs;

монг.: Манзушир бурхан / Зөлөөн Эгшигт

### *Шүтээний агуулга*

Өндөр Гэгээн Занабазарын [öndör gegen-u namtar] намтрын бүх хувилбаруудад Түшээт хан Гомбодоржийн гэрт төрсөн хөвгүүний авьяасын нэг гол зүйл нь Европ тооллоор 2 настай байхдаа “Манджушри-нама-самгити”<sup>41</sup> буюу “Манзушригийн нэрсийг тоолох” номыг уран яруу уншдаг байжээ. Өөрөөр хэлбэл, Манзушри бурхан Занабазартай Монгол хүний хувилгаан дүрийг авсан өдрөөс нь эхлээд л холбоотой байжээ. Тиймээс энэ урлаач маань энэ Манзушри бурхныг уран баримал, уран зурагт нэг бус удаа бүтээж байжээ. Цаашдаа улс төрийн нөхцөл байдлаас болж уг бурхны янз бүрийн ухагдахуунуудтай улам их холбогддог болжээ. Монголын язгууртнуудын хоорондын дайн байлдаан нь Манзушри бурхны домгийн эх орон гэгддэг хятадын эзэн хаантай хамтран ажиллах зайлшгүй байдалд оруулжээ. Энх-Амгалан хаантай (1654-1722) хамаатны харилцаатай<sup>42</sup> эвтэй найртай байсан нь Халх монголын эрхийг хэвээр нь хадгалах боломжийг Өндөр гэгээнд олгожээ. Энх-Амгалан хаан гэгээрлийг хөгжүүлэх гэж янз бүрээр хичээдэг байсан ба бурхны шашны бүх ажил хэрэг Бээжин хотын ойролцоо монгол, төвөд, манж хэлээр явагдаж Занабазар албан захидалдаа хятадын эзэн хааныг Манзушригийн хойд дүр гэж нэрлэж байжээ. Өндөр гэгээн нь сайн урлаач алдартай лам хүн боловч 1691оноос эхлэн бүхэл бүтэн арван жилийг Бээжинд эзэн хааны ордонд өнгөрөөх шаардлагатай болжээ. Эх сурвалжаас харахад Занабазар цэцэн ухааны бурхныг уран баримал ба шүтээн зургийн хэлбэрээр олон тоогоор бүтээж байжээ. Үүнд олон шалтгаан байв. Тэдгээрээс нэлээн алдартай нь Улаанбаатар хотын Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейд байдаг зогсож буй бодисадва Манзушрийн уран баримал юм. Бид энэ баримал болон бусад уран баримал шүтээн зургийг авч үзлээ.

**Бодисадва Манзушри** бол цэцэн ухааны бурхан бөгөөд мунхгийн харанхуйг арилгаж гэгээрлийн замд гарсан бүх саадыг үгүй хийж сурах үед цэцэн ухаан, авьяас бэлэглэдэг. Энэ бурхныг бурхны шашинтай бүх орон шүтдэг ба түүний олон тооны эрт дээр үеийн зургууд янз бүрийн улс орнуудад хадгалагдан үлдсэн байдаг. Манзушри ба Жанрайсиг бурхан бурхны шашны бурхад дотроосоо хамгийн их шүтэгддэг нь юм.

---

<sup>41</sup> тиб. ‘Jam dpal mtshan brjod - «Воспевание имён Манджушри», датируется серединой VIII века н.э., восхваляет Манджушри как «держателя линии эманаций будды, того, кто излучает различные эманации, чтобы соответствующим образом помогать существам». Среди перечисленных эманаций есть Праматха (тиб. ‘Joms byed), «Разрушитель».

<sup>42</sup> Энх-Амгалан хааны үзлийг баримталдаг Сюанье хааныг боржигин гаралтай монгол эмээ нь хүмүүжүүлжээ.

Түүнтэй холбоотой хамгийн эртний эх сурвалж бол МЭ 300 онд хамаарагдах “Ārya mañjuśrīmūla kalpa” , “Guhyaśamāja” хоёр юм. Бурхны ном сударт, тэр дундаа Ганжуурт дотор Манзушри 108 янзын нэртэй ба маш олон хэлбэр төрхтэй байдаг. Гэхдээ 16 настай хөвгүүний дүрээр түүний мөнхийн залуу насыг дүрслэх нь элбэг байдаг. “Sādhanamāla”-д Манзушри бурхны янз бүрийн дүрүүдийн 41 өөр бүтээл байдаг болохоор бурхны шашны нэг язгуурт хамааруулахад хэцүү. Тэр нь Авид бурхан шиг улаан лагшинтай эсвэл Минтүгва язгуурын бурхан шиг хөх лагшинтай ч байж болох ба мөн бусад язгууруудтай бас холбогддог. Манзушри бурхны гол ялгах тэмдэг нь илд, ном хоёр юм. Илд нь баригдахгүй байгаа эрдмийг олоход саад болдог мунхгийн харанхуйг таслан хаядаг зэвсэг юм.

Их хөлгөн ба Очирт хөлгөнд Манзушри бурхныг шүтдэг болсон түүх нь маш өвөрмөц. Энэ бурхныг Энэтхэг язгуургүй гэж таамаглах нь бий. Б. Бхаттачарья түүнийг “хүн гаралтай” гэж үздэг. Нагаржуна, Арьяндэв, Ашвагхша нар ба бусад бодисадва болсон алдартай эрдэмтэд түүнийг бурхан гэж үздэг [Bhattacharya 1958: 100-123]. Сваямбху Пуранд (X зуун) түүнийг Хятадаас ирсэн гэж бичсэн байдаг ба Хятадад байхдаа агуу гэгээн байсан Панчашарша (*үгч.* Таван шанхат уул буюу У тай шань) байсан гэж бичсэн байдаг. Түүнийг олон шавь нар нь шүтдэг ба тэдний дунд улсын хаан Дармагара ч байжээ. Нэгэн удаа энэхүү гэгээн нь Непалын Калидхара нууранд Анхны бурхан өөрөө гарч ирдэг тухай сонсоод тэр бурханд мөргөхөөр шавь нараа дагуулаад явжээ. Гэтэл тэнд очсон даруйд маш их үер болж нөгөө бурхан нь нуурын голд оччихсон ойртох аргагүй болсон байна. Тойроод явах гэтэл замыг нь нэг уул хаачихсан байв. Тэрээр илдээ өндөрт өргөж уулыг хоёр хэсэг болтол хага цохижээ. Тэгээд нуурын ус тэр завсраар урсаж дуусахад одоогийн Катаманду нэртэй өргөн хөндий үүсжээ. Гэгээн маань нуурын эрэг дээр ийм нэртэй хийд барьж өөрийнхөө шавь Дармагараг Непалын хаан болгожээ. Гэртээ буцаж ирээд, үхсэн биеэ огоорон бодисадва болж хувирчээ.

Монголын Юань эзэнт гүрэн (1271-1368) задран унаж Хятадын Мин гүрэн (1368-1644) түр зуур хүчирхэгжиж, Жүрчдийн нүүдэлчид 1616 онд “Алтан улс”-ыг байгуулж, улмаар Манж Чин улс (1636-1912) болж өргөжжээ. Энэхүү Манж Чин улсыг үндэслэгч Нурхачаасаа эхлээд (1616-1626) Манжийн хаад өөрсдийгөө Манзушри бурхны бүрүлбаа гэж үздэг байв. Тэд боловсрол, соёл, урлаг, бурхан шашны асуудалд ихээхэн анхаарал хандуулж иржээ. Жүрчидийн аймгууд хуучин нэрээ өөрчилсөн нь Манзушри бурхны

нэртэй холбоотой. Бурхны шашинтнууд Манзушри бурхны орныг Хятадын зүүн хойд зүгт Бээжингээс 250 км зайд байдаг У Тай шань ууланд байдаг гэж үздэг. Буриадууд У Тай шанийг дэлхий дээр байгаа бурхны 24 ариун газрын нэг гэж үздэг. Ийнхүү Манзушри бурхны зан үйл нь Төв Азид XVII – XVIII зуун заагт чухал байр суурь эзэлж байсан ба янз бүрийн хэлбэр уламжлалтай ажээ (Белый Манджугоша в традиции Кашмирского пандиты, оранжевый Манджугоша в традиции Сакья, Манджугоша Еше Ёnten традиции Самбу, Манджушри Дампа Сангье и др.).

### **Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейн Манзушри бурхны баримал**

Бодисадва Манзушри абханга зогсолтоор буюу хөлөө нугалахгүйгээр баруун хөлөн дээрээ хүчээ төвлөрүүлэн сойж, зүүн хөлөө үл мэдэг нугалсан байх ба хөл нь өсгийгөө өргөөгүй эрхий болон долоовор хуруугаараа бадамлянхуа цэцгийн ишийг цээжиндээ барьж баруун мутрынх нь алга гадагш харж зүүн мутар нь дотогш харжээ. Тэрээр бодисадвагийн найман чимэгтэй: Толгойдоо таван хэсэгтэй титэмтэй, чихэндээ том унжсан ээмэгтэй, бугалга, бугуй, шагайн чимэгтэй цээжийг нь халхалсан хүзүүний чимэг нь олон унжлагатай, урт урт сувстай бүс нь мөн олон унжлагатай ажээ. Мөн зүүн мөрөн дээгүүрээ тохсон доош их унжсан сувдан хэлхээ зүүсэн нь бясалгагчийн бүсийг бэлгэдэж байгаа юм. Урт шамтав нь бараг шагайг нь хүрсэн ба цагариг ороомог хэлбэрийн хээгээр чимэглэгджээ. Хоёр мөрөн дээр нь нимгэн орхимж нугларан тавигдсан ба үзүүр нь гар, ташааг нь дагаж хажуу тал нь хавтгай болсон мэт харагдана.

(Зураг 4.9.1)

Хөх үс нь зүгдөр болон овоологдож эрдэнэсээр чимэглэгдэж хоёр туг үс нь мөрөн дээр нь унжина. Толгой нь том бөгөөд хамар, мэлмий нь том, хоёр хөмсөгнийх нь завсар өргөн, төвгөр билгийн мэлмий нь хамрынхаа үзүүр чигт харжээ. Хамар нь өндөр, монхор, уруул нь нарийвтар, мөрнийх нь хажуудах бадамлянхуа цэцгэн дээр хэдэн талтай богинохон илд зүүн гар талд нь бодь сэтгэлийг бясалгах судар харагдана. Судрын урт, илдийн хэлбэрийг харахад Занабазар оролцоогүй эсвэл сүүлд сэргээн засварласан байж болох талтай. Чимэглэлийн бүх элементүүд нь сувс, мушгирсан хээ зэрэг Монголын дүрслэх урлагийн уламжлалт хэлбэрүүд байна. Гар, хөл нь жижигхэн булцгар.

Суурь нь хагас бөмбөлөг хэлбэртэй шүдэрхэг дэлбээтэй дохиуруудтай ёроолын хэсэг нь дэлгэрээгүй дэлбээнүүдтэй. Энэ уран баримлыг Занабазарын загвараар шавь нар

нь хийжээ. Зураг нь хэд хэдэн удаа хэвлэгдэж байсан [Цултэм 1989: с. 83; Өндөр Гэгээн 1995: 105-106, илл. 50а-с; ММШУД I: 184. и др.]. Хүмүүс гаднаас нь хараад таних боловч дүрсэлж бичиж байгаагүй ажээ.

### **Шүтээн зураг. Манзушри (Арабазана Манзугоша)**

Зотон 44 х 30 см. Шороон будаг.

Ургамлан хээтэй, торгон хүрээтэй.

XVII зууны төгсгөл. Улаанбаатар. А. Алтангэрэлийн цуглуулга.

Энэ бол Занабазарын нэлээн эрт үед бүтээж байсан бүтээлүүдийнх нь нэг юм. Зурааснууд нь цэвэрхэн, маш нарийн тодорхой, бурхны нигур нь тодорхой, өнгөний шийдэл нь зоригтой, шүтээний уламжлалыг сонгохдоо чөлөөтэй байгаа зэргээс нь харахад Занабазарын хийц мөн байна. Сажийн дэг сургуулийн уламжлалаар бүтээжээ<sup>43</sup>. Сажийн дэг сургууль нь XIII–XIV зууны Монголын эзэнт гүрний үед Монголын язгууртнуудын баримталдаг байсан сургууль юм. Энэ уламжлалын хэсэг хэсэг уламжлалууд монголчуудын дунд дараа дараагийн зуун жилүүдэд байсаар байсан юм. Занабазар Сажийн зан үйлээр Чингисийн удмын язгууртнуудаар дамжуулан ураг төрлийн өв уламжлал төдийгүй оюун ухааны дамжлагыг бий болгосон юм. Юу гэвэл өмнөх Жавзандамба хутагт буюу Төвөдийн эрдэмтэн Дарнатын (1575-1634) тэргүүлж байсан Жонан уламжлал нь Сажын уламжлалаас салбарлан гарсан байдаг ажээ.

*Зураг 4.9.2. Манзушри шүтээн зураг. Зотон 44 х 30 см. Шороон будаг. XVII зууны төгсгөл. Улаанбаатар. А. Алтангэрэлийн цуглуулга.*

#### ***Тайлбар:***

Шүтээн зурган дээрх Манзушри очир завилгаагаар (vajra paṅkaśana) морилсон ба лагшин нь алтлаг улбар шар өнгөтэй нэг нигуртай, хоёр мутартай ажээ. Баруун мутартаа өндөрт өргөсөн номин илдтэй зүүн мутраа ном номлох мутарлагатайгаар (vitarka mudrā) байрлуулж, цагаан бадамлянхуа цэцгийг шилбэнээс нь барьжээ (зураг 2, 3).

Бадамлянхуа цэцгэн дээр нь билиг билгүүний судар тавиастай ажээ. Толгой дээрх титэм нь таван үнэт чулуун дэлбээтэй, голын дэлбээн дээр Манзушрийн хамаарагддаг очирын язгуурыг үүсгэгч Минтүгва бурхныг дүрсэлжээ. Овоолсон Зүгдорыг хоёр давхар

<sup>43</sup> тиб.: sa skya lugs Arapatsana Mañjughosa / 'jam dbyangs a ra pa tsa na dmar ser sa lugs

хэлхээгээр ороож үнэт чулуугаар чимэглэжээ. Хоёр шанааных нь үс ар нуруу уруугаа унжжээ (зураг 2). Оройн гэрэл нь цайвар ягаан, лагшингийн гэрэл нь тоосгон улаан өнгөтэй ба бурхны лагшингаас цацарсан алтан цацрагуудтай. Мутрынх нь алга ба хөлийн ул нь охорын өнгөтэй улан дээр нь жижигхэн алтан хүрдэн тэмдэг харагдана. Шар дотио ногоон дотортой хөх бүсээр бүсэлжээ (зураг 4.9.2). Мөрөн дээр нь урт хоёр талтай ногоон чойгү намжир нөмөрчээ. Бадамлянхуа суурийнх нь цэцгийн дэлбээ нь долгиотсон бөгөөд хөх ногоон, хүрэн хар өнгөтэй ажээ.

Шүтээн зургийн ар дэвсгэр нь ногоон байгальтай модтой гурвалжин уулнуудтай, мод нь бодитой мэт харагдаж харин уулын орой нь монгол гэр шиг хэлбэртэй харагдана (зураг 6). Тэнгэр нь ер бусын хар өнгөтэй ба тод цагаан үүлнүүд нь шүдэрхэг оройтой толгод мэт харагдана. Зүүн гар талд нь дугуй шаргал сар, баруун гар талд нь гэрэлтсэн улаан нар харагдана. Шүтээн зургийн доод талд нь панчака ногуна буюу таван мэдрэхүйд зориулсан өргөлийг дүрсэлжээ. Эдгээр нь хөгжмийн зэмсэг, дугуй толь, жимс, анхилуун үнэртэй цагаан хясаа, улаан, шар хадаг бөгөөд энэ бүгдийг цэнхэр монгол аяганд хийсэн байна. Зураач энэ аягыг хоёр уулын хооронд зурсан нь анхдагч далайн үүргийг гүйцэтгэж байна. Шүтээн зургийн зохиомж нь маш товч тодорхой. Дүрснүүд нь маш нарийн маш цэвэрхэн. Өнгөний шийдэл маш зоригтой, аягатай зүйлээр далайг дүрсэлсэн нь зохиогчийн стандарт бус хошин мэдрэмжийг харуулж байна. Цэцэн ухааны бурхан нь оюун ухааныг илэрхийлдэг болохоор энэ шүтээн зурагт хүйтэн өнгөнүүд их голложээ. Ийм учраас хөх өнгийн илд нь шөнийн харанхуй геометрийн хувьд зөв хэлбэртэй цагаан үүлээр тэнцвэржсэн тэнгэрийг цавчиж хаях ажээ. Энэ бүгдээс харахад зураач маань маш их биеэ даасан өөрийн гэсэн онцлогтой, өөртөө итгэлтэй, ёжтой, зоригтой болохыг харуулж байна. Бурхны харьцаа нь тогтвортой, монгол царайтай, зураг нь оновчтой нарийн мутар бадамлянхуа нь онцлогтой, нүүр нь бясалгасан цэвэрхэн байгаа нь Занабазарын хэв маяг юм.

### **Эрдэнэзуу хийдэд сууж байгаа Манзушри бурхны уран баримал**

Эд.№65.513. Хүрэл, цутгамал, алтадсан, өнгө будаг орсон.

Өндөр 27,7 x 17 x 19 см. XVII - XVIII зуун. Монгол улс. Эрдэнэ зуу.

***Тайлбар:***

Бодисадва Манзушри нь гоолиг залуу ханхүүгийн дүртэй очир завилгаагаар морилжээ (vajra-paryāṅkāśana). Бүсэлхий хэсгээрээ бага зэрэг бөхийсөн тул тэнцвэрээ хадгалахын тулд зүүн тийшээ хазайж баруун мутартаа том илдийг толгойноосоо дээш өргөн барьж илдийн үзүүр нь зүгдорын үнэт чимэглэлийн араар оржээ. Баруун мутраараа харина мутарлага хийсэн нь хөөж арилгах карана мутарлагыг санагдуулах ба энэ нь мунхгийн харанхуйтай тэмцэж байгааг нь тодруулж өгч байна. Дашрамд хэлэхэд “Манзушри нама самгади” номд түүнээс гарсан бурхдын нэрсийн дотор Праматха (*төвөд* ‘Joms byed), “Сөнөөгч” гэсэн нэр байдаг. Зүүн гараа ном номлох мутарлагатайгаар (*vitarka-mudrā*) билиг бирамидын судар дээр нь тавьсан цагаан бадамлянхуа цэцгийн ишийг барьжээ. Толгой дээрх титэм нь таван үнэт чулуунаас бүрдсэн ба чихнийх нь ард торгон туузуудтай чихэн дээр нь таван дэлбээтэй цэцгэн эрихтэй ажээ. Өндөр зүгдорыг нь үс ба хоёр давхар хэлхээгээр ороож үнэт чулуунуудаар чимэглэжээ. Туг үс нь мөрнийх нь урдуур унжиж бараг тохойг нь хүрчээ. Хагас үс нь нурууных нь дагуу унжжээ. Цээжин дэх хүзүүний чимэг нь янз бүрийн хэлбэрийн цэцгийн дэлбээнүүдээс бүтсэн ба нийлээд гурвалжин хэлбэрийн цээжний хамгаалалт болжээ. Бугалга, бугуй, шагайн чимгүүд нь том том үнэт чулуу ажээ. Урт хүзүүний зүүлт нь бүс хүртлээ унжжээ. Дотиных нь дээд үзүүр энгийн цэцгэн хээн сийлбэртэй ажээ. Ташаан дээр нь том том дугуй унжлагатай бүс байна. Суурь нь өндөр, хагас дугуй, хоёр тийш дэлгэгдсэн давхар дэлбээнүүдтэй бадамлянхуа суурин дээрх дэлбээнүүд шатрын хөлөг шиг байрлажээ. Орхимж нь бугалган дээр нь гогцоорч үзүүр нь суурин дээгүүр унжжээ. Занабазарт байх ёстой онцлогууд дотроос хүзүүний зүүлт бясалгагчийн бүс хоёр байхгүй байна.





Зураг 4.9.3. Хүрэл, цутгамал, алтадмал, өнгө будаг орсон. 27,7 x17 x 19 см. XVII - XVIII зуун. Монгол улс, Эрдэнэ зуу.

#### А. Алтангэрэлийн цуглуулгад буй Манзушрийн уран баримал

Хүрэл, цутгамал, алтадмал, өнгө будаг орсон. Өндөр 21см. өргөн 13,5см. XVII – XVIII зуун., Монгол улс



Зураг 4.9.4. Скульптура Манджушри. Бронза, литье, позолота, пигмент. 21x13,5см. XVII - XVIII век. Коллекция А. Алтангэрэла. Монголия.

Энэ уран баримлын шүн нь хадгалагдан үлджээ. Ёроолынхоо таг дээр алтадсан нацагдорж тэмдэгтэй. Энэхүү уран баримал нь халуунаар алтадсан гайхамшигтай зөөлөн шаргал бүрхүүлтэй ажээ.

Хөмсөг, нүд нь хар цагаанаар, уруул нь улаанаар, үс нь хараар будагджээ. Илдээ барьсан нь маш өвөрмөц. Долоовор ба чигчий хуруу нь дээш өргөгдөн бухын эвэр шиг харагдана. Ертөнцийн дайчны дүрийг нь цээж мөрийг нь хамгаалсан додъёг мэт чимэг нь улам тодруулж өгчээ. Хүзүүний чимэг нь урд талдаа дэвүүр хэлбэрийн том том сувснуудтай ар талдаа торгон Чойгү намжир нь додъёг шиг харагдана. Баруун гарынх нь хөдөлгөөн нь хөөх туух заналхийлэхийг санагдуулж байна. Энэ арга техник

А.Алтангэрэлийн цуглуулгад байгаа Манзушри бурхны шүтээн зураг Минтүгва, Сосорбарам бурхдын уран баримлаас харагдана.

### Бодисадва Дарь-эх

#### *Шүтээний агуулга:*

Занабазар нь “Дарь эхээр хамгаалагдсан” гэсэн утгатай Дарнатын (1562-1634) хойд дүр болохоор амьдрал дээрээ ч бурхныхаа үйл хэрэгт ч Дарь эхэд онцгой ач холбогдол өгдөг. Дарнатыг бурхны шашинд гүнзгий орсныг “Ринченжунай” (төвөд: *Yi dam rgya mtsho'i sgrub thabs rin chen 'byung gnas* – Бурхны шашны бурхадын бүтээлийн үнэт эх сурвалж) зохиосноор нь мэдэж авч болно. “Бүтээлийн далай” хэмээх ном нь очирт хөлгөний бурхан зурах тухай маш их эрэлттэй эх сурвалжуудын нэг юм. Дарь эхийн зан үйлийн үндэс Төвөд Ганжуурын чуулганы Крия тарни и Ануттара бясалгалын бүлгийн тарнийн ном юм. Энэ бүтээлийг хийхдээ Дарь эхийг магтсан дууллыг уншиж хоёр дахь бүтээлийг хийдэг. Дарь эх нь олон дүр хэлбэртэй бөгөөд жишээ нь хорин нэгэн дарь эх байдаг (үнэн хэрэгтээ 21-ээс ч олон дарь эх байдаг). Бүгдээрээ нэг гол тарнтай боловч 21 дарь эх нь өөр өөр нэртэй байдаг. Тэд голцуу Энэтхэгийн хатан хааны хувцас өмссөн лагшингийн өнгө, мутрын байрлал, сууж байгаа байдлаараа ялгардаг. Монгол Төвөдийн том том зохиогчид Дарь эхийг бүтээж түүний тухай янз бүрийн зохиол бичсэн байдаг. Янз бүрийн сургуулиуд өөрийн гэсэн онцлогтойгоор бүтээдэг боловч Төвөдийн Дарь эхийн бүтээлийнх нь ихэнх хэсэг нь Адишагаас (самг.: *atiśa dīpaṅkara śrījñāna*, тиб.: *jo bo a ti sha dral mar me mdzad ye shes*) үүдэлтэй байдаг (982-1054). Адиша бол бурхны шашны номлогч, Төвөдийн Гаадам дэг сургуулийг үндэслэгч юм. Түүний намтраас харахад тэрээр Энэтхэгийн Наланда, Викрамашила<sup>44</sup> хоёр их сургуулийн уламжлалыг нэгтгэсэн байдаг. Өөрөө Наландагийн их сургуульд сурч байсан ба Викрамашилын их сургуульд багшаар ажиллаж байжээ. Жову Адиша цастын оронд ирэхийг Дарь эх бурхан урьдчилан хэлсэн байдаг. Дарь эх нь түүний өмнөх дүрүүдийг нь ивээдэг бурхан ажээ. Өөрийнхөө ивээлд

<sup>44</sup> Викрамашила –Энэтхэгийн ач холбогдлоороо Наланда сургуулийн дараа хоёрдугаарт орох их сургууль-сүм, Пала улсын хаан Дарамбал (783–820) VIII зууны сүүлээр байгуулсан ба 1235 онд лалын шашинтнууд нурааж устгажээ. 1000 лам, 160 шавь бандида нар нэгэн зэрэг сурч ажилладаг байсан Их хөлгөний боловсролын том төв бөгөөд Магадхад (одоогийн Бихар мужийн Бхагалпур дүүргийн Антикак тосгон)-д байжээ. Хамгийн чухал нь бодь модны дор оршсон Бурхан багш байсан зуун найман хэсэг бурхан тахил, тарнийн бурхдад зориулсан тавин гурван хийд, ерөнхий их хөлгөний бурхдад зориулсан тавин дөрвөн хийдтэй байжээ [8, р. 98–99]. Викрамашилийн дөрөв дэх их багш тарнийн бүтээлээрээ алдаршсан Адиша (982–1054) байв.

байгаа хүнийг бүр хүүхэд байхаас нь эхлэн хамгаалдаг. Түүнийг Төвөд явахынх нь өмнө Дарь эх: “Адиша чи зургаан зүйл хамаг амьтанд маш их ач тус өгч түгээсэн номын чинь хэмжээ хэмжихийн арга үгүй болно. Гэхдээ тийшээ очсоноор чиний нас маш их хорогдоно” гэж хэлжээ. 1042 онд Адиша Төвөдөд иржээ. Адиша алдарт Дарь эхийн дууллыг зохиосон ба энэ дуулал монгол буриад хийдүүдэд олон дахин хэвлэгдэж байжээ. 117 бүтээл туурвисны дөрвийг нь Дарь эхэд зориулсан ба тэдгээрийг Төвөд, Монгол, Буриадад лам болон энгийн иргэд одоо болтол уншсаар байна. Адишагийн ганцаараа болон хүмүүстэй хамтран самгарди хэлнээс орчуулсан 77 номын зургаа нь Дарь эхтэй холбоотой. Тэдгээрээс Зандрагоминагийн дуулал<sup>45</sup> ба нэгэн нэр нь үл мэдэгдэх зохиогчийн Цагаан дарь эхтэй холбоотой гурван номыг Вагишваракирти зохиожээ.

Эртний Энэтхэгийн ачарья Матричета Очирт хөлгөний хамгийн алдартай дарь эхийн дууллыг зохиосныг энд заавал хэлэх хэрэгтэй. Энэ бүтээл Төвөд, Монгол, Буриадад маш их алдаршсан байдаг. Энэ дууллыг лам нар төдийгүй олон энгийн хүмүүс мэддэг. Энэ дууллыг буриадын дацангийн хэвлэлийн газрууд нь нэг бус удаа хэвлэж байснаас харахад Дарь эхийн бүтээл байгалийн чанадад их түгээмэл байсныг харуулж байгаа юм. Матричета (санс.: *mātṛceta*, төвөд:*ma khol* – эхийн зарц) нь Төвөд Монголын бурхны шашинд их алдартай бөгөөд Лован Бавуу (төвөд:*slob dpon dra' bo*) нэрээр МЭ 2-р зуунд алдаршсан. Ловон Бавуу нь Нагаржунагийн<sup>46</sup> ойрын шавь байсан (II—III зуун) Арьяандэвийн<sup>47</sup> шавь нь байжээ. Дарь эхийн бүтээлийн түүхэнд Матричета нэртэй зохиогчид хэд хэд байдаг. Төвөдөд анхны бурхан бүтээх ном гарч байх үед буюу 11-12-р зууны үед орчуулагчдын дунд Матричета гэдэг нэр гарч ирдэг. Тэрээр Цүлтэмжалцаны

<sup>45</sup> Чандрагомин – Энэтхэгийн буддын шашинтан, эрдэмтэн бөгөөд амьдарч байсан үеийг нь янз бүрээр хэлдэг. Нэг хэсэг нь Чандракирти (VI–VII в.) амьдарч байсан үед гэдэг бол нөгөө хэсэг нь Наланда хийдийн уламжлалын дагуу маргаан мэтгэлцээнд оролцдог байсан, гурав дахь хэсэг нь Викрамашиледсурч, Занаширимэдрийн шавь байсан Ратнакиртигийн (XI в.) шавь гэдэг.

<sup>46</sup> Нагарджуна (санскр.: *Nāgārjuna*) – выдающийся индийский мыслитель Махаяны, развивший идею о «пустотности» дхарм; основатель школы Мадхьямаки. Принадлежит к числу 84 буддийских махасиддхов. Точные годы жизни Нагарджуны неизвестны, предположительно II–III в. н.э. Сведения о нем переплетаются с фантастическими и мифологическими сюжетами. Некоторые критики предполагают, что существовало пять разных ученых с таким именем [Андросов 1990; Андросов 2019]

<sup>47</sup> Арьядэва (санскр.: *Āryadeva*, тиб.: *'phags pa lha* – святой небожитель, или *lta ngan mu stegs tshar bcod phags lha*), известный также как Кáнадэва (санскр.: *Kānadeva* – Одноглазый) – индийский буддист-мыслитель, мастер дебатов и логики. Один из 84 буддийских махасиддхов. Арьядэва родился в семье брахманов, по некоторым сведениям, был принцем Шри-Ланки. Прибыл в Индию для встречи с Нагарджуной, стал его учеником и преемником. Путешествовал по всей Индии и участвовал в многочисленных диспутах, прославился в успешных дебатах против небуддистов. Сведения об Арьядэве противоречивы, и некоторые исследователи предполагают, что существовали два разных человека, живших в разные эпохи.

“Садхана шатапанча шатака” хэмээх бурхан зурах номын орчуулагч юм. Кадамын уламжлалд, дараа нь гэлүгвагийн уламжлалд 21 дарь эх байдаг бол Сажын уламжлалд 17 байдаг (төвөд:sgrol ma lha bcu bdun ma). Сажынхан дарь эхийг эрхэндээ авах шидтэй эрч хүчтэй Гүргүлэ эхийн хувцастайгаар хүлээж авдаг. Кагьют, Гампопын (1079-1153) сургуулийг үндэслэгчийн бүтээлтэй холбоотойгоор Цагаан дарь эхийн тусгай өргөлийг хийдэг. Олон багш Дарь эхийн хэд хэдэн урсгалын номыг үргэлжлүүлж байдаг. Ерөнхийдөө Төвөд болон Монголд Дарь эхийг Цагаан дарь эхийн, Ногоон дарь эхийн, 21 дарь эхийн гэсэн гурван аргаар бүтээдэг. Нартан джаца номд 1) Цагаан дарь эхийг (sgrol dkar - Долгар) хоёр мэлмийтэй, мутрууд нь гадагш чиглэсэн байдалтай, зүүн мутраараа бэлэглэх мутарлага үзүүлж, баруун мутраараа бадамлянхуа цэцгийн ишийг зүрхэн тушаа газраа барьснаар 2) Ногоон дарь эхийг (sgrol ljang - Должан) бурхан бүтээх түгээмэл аргаар бүтээжээ. XII зуунд Энэтхэгийн Абхаякара Гупта хэмээх тарнийн ухаанд мэргэжсэн эрдэмтэний зохиосон “Ваджравали” номонд ганцхан Ваджра Тара (төвөд:rdog rje sgrol ma) байсан. Гэхдээ энэ нь Очирдарын хамгийн чухал хэлбэр бөгөөд хамгийн түгээмэл бүтээл ялангуяа Энэтхэгийн бүс нутагт (орчин үеийн Бангладеш ба Энэтхэгийн зүүн муж улс Орисса) ихээхэн түгсэн байдаг. Шар лагшинтай дөрвөн нигуртай, найман мутартай Дарь эх ТАМ үсгээс гарч ирээд бадамлянхуа цэцэг, саран дэвсгэр дээр морилно. Голынх нь нүүр нь шар, баруун талынх нь цагаан, зүүн талынх нь улаан, ард талынх нь хөх. Баруун мутрууддаа очир, цалам, сум, дун бүрээ барьжээ. Зүүн мутрууддаа шар удвал цэцэг, нум, дэгээ барьжээ. Дөрөв дэх зүүн мутар нь аюул гэсэн мутарлагатай байна. Тэрээр хөлөө завилж заларсан, хадаг ба эрдэнэсээр чимэглэгдсэн байна.

Дарь эхийн дүрийг бүтээхтэй холбоотой бөгөөд одоо болтол дурсагдаагүй явсан өөр нэг эх сурвалж бол Садхана-мала” буюу “Садхана-самуччая” хэмээн алдаршсан Энэтхэгийн самгарди хэлээр бичигдсэн гар бичмэл юм. Энэ номонд хүмүүсийн нэг их мэддэггүй богино богино бүтээлүүдийг (mr̥tyu-vañcana-tāra, durgo-ttāriṇi-tāra, caturbhujā sita-tāra, ṣadbhujā sita-tārā, prasanna-tārā, mahāśri-tārā, mahācina-tārā) бичсэн байдаг. Тэдгээрийн заримыг нь Төвөдөд огт мэддэггүй ажээ. Гэхдээ тэдгээрийн судалгаа, тэдний гадаад байдлын янз бүрийн ухагдахуунуудыг дүрслэн бичсэн, тэдгээрийг ямар зураасаар гаргах арга зэрэг нь өнөөг хүртэл хадгалагдан ирж чадсан эсэх нь тодорхойгүй.

Хуучны уламжлалд 21 Дарь эхийг нэг л янзаар боловч өөр өөр цэцэгтэй, зүүн мутартаа ялгарах тэмдгээ барьснаар дүрсэлдэг. Энэ уламжлал Өндөр их хэмээх Жигмэд

Линбын ('jig med gling pa 1729-1798) бүтээлд гардаг Лончэн равжамбаас (klong chen rab 'byams pa 1308-1363) гаралтай.

“Таван зуун бурхан” хэмээх түүвэр зохиолыг ХҮШ зуунд зохиосон ба энэ бүтээлд найман аюулаас авардаг найман Дарь эхийг гал, ус, арслан, заан, хааны цааз, шулмас, хутга мэс, зэрлэг амьтан гэсэн найман аюулаас авардаг Арьяа Жанрайсигийн туслах гэсэн байдаг. Энэ бүлэг Ашта бхатраяни гэдэг нэртэй ба бүрэлдэхүүнд нь: Агни бхатраяни, Джала бхатраяни, Симкха бхатраяни, Хасты бхатраяни, Данда бхатраяни, Нага бхатраяни, Дака бхатраяни, Чора бхатраяни ордог. Эдгээр эх бурхад сансрын бургилсан далайд ахуй, амьдралын саад тотгорт зовсон хамаг амьтныг энэрэх сэтгэлээс төржээ.

Тижан ринбүчи, Жалва ринбүчи, XIV Далай ламын нотлон хэлснээр “Аштасахасрики” түүвэрт 21 Дарь эхийн бүрдэл Адиша гэгээний бичсэнээс арай өөр байдаг ба зөвхөн эхний дөрвөн Дарь эхийн нэр л адилхан байдаг. “21 Дарь эхийн дуулалыг” (rje btsun sgröl ma'i phyag 'tshal nyi shu'i rtsa gcin ma) “Аштасахасрики” ХХ зуунд Агын дацанд хэвлэж байжээ. Энэхүү бурхан зурах тухай номын хамгийн сүүлийн хянан тохиолдуулсан хувилбар ХХ зууны дунд үед хамрагдах ба энд найман аюулыг гүн ухаан сэтгэлзүйн үүднээс тайлбарласан байдаг. Бардамнал, мунхаг, уур, атаархал, буруу үзэл, тэвчээргүй зан, шунал тачаал, эргэлзээ гэсэн найман аюул дээр ухааныг мунхруулдаг “би”-ийн үзлийг нэмжээ. Энэхүү шинэ бурхдын чуулган дахь эх бурхдын дараалал өөр бөгөөд энэ аюул дээр ямар “би”-ийн үзэл давамгайлж байгааг тайлбарлан бичсэн байдаг. Эдгээр нь Мана-симкха-бхатраяни – арслангаар төлөөлүүлсэн Бардам зангаас аврагч; Моха-хасты-бхатраяни – заанаар төлөөлүүлсэн мунхагаас аврагч; Джинагни-прашамани – галаар төлөөлүүлсэн шунал тачаалаас аврагч; Иршья-саправи-прахарани – могойгоор төлөөлүүлсэн атаархлаас ангижруулагч; Кудристи-сора-упадрава-ниравани– Буруу үзлээс холдуулагч; Гхора-матсарья-шринкхала-мочани–тэвчээргүй шунахай зангаас суллагч; Рагаигха-вегаварта-шосани–долгионоор төлөөлүүлсэн тачаалыг унтраагч; Самшайя-пишача-бхатраяни– шулмаар төлөөлүүлсэн эргэлзээнээс аврагч юм.

Монгол болон Буриадад 8 аюулаас авардаг тухай энэхүү домог маш их алдаршсан байдаг. Монгол хэлээр тайлбарласан эх нь Жанрайсиг бодисадвагийн судар “qomsim bodisatv-a noᠮᠤᠭᠤᠨ dar-a eke ᠰᠠᠭᠠᠭᠠᠨ dar-a eke-yin sudur orusiba-Хомсим бодисадва Ногоон Дарь эх, Цагаан Дарь эхийн судар оршвой” хэмээх найман аюулаас хэрхэн аварч буй тухай ном юм. “Лэгбрима” (*төвөд*:legs bri ma, *букв.* Сайн зурагдсан) гэдэг зурагтай ном

маш түгээмэл. Энэ нь голд нь Ногоон Дарь эх сууж найман бурхан тойрсон бүтээл юм. Эдгээр бурхдад зориулсан Нэгдүгээр Далай лам Гэндэндүвийн (1391-1474) зориулга байдаг ба үүнд Дарь эхийг бадамлянхуа сэнтий дээр баруун хөлөө буулган морилсон хоёр мутартай маргад эрдэнийн өнгөт бурхан гэсэн байдаг. Тэрээр ид цэцэглэж яваа залуу насандаа байгаа ба хоёр хөх нь буяны өө сэвгүй эрдэнийн сан, сар мэт нигураа цагаан шүдээ гарган инээж чимжээ. Баруун мутар нь бэлэглэх мутарлагатай, зүүн мутар нь гурван эрдэнийн мутарлагатай. Тэрээр Кхадирака хэмээх бурхдын орны үзэсгэлэнт бөгөөд түүний зөөлөн мутрууд нь диваажингийн оюу модны мөчир мэт. Тэрээр арга, билгийн нэгдэл бөгөөд хэнийг ч ялгахгүй амар амгалан хайрлаж, амьтан бүхнийг найман төрлийн аюулаас авардаг. Түүний толгойноос дээш бадмаараг эрдэнийн гэрэлтэй Авид бурхан морилж, оройг нь Аюуш бурхан чимжээ. Энэ эх бурхан солонгоор гоёсон Сүмбэр уултай адилхан харагдана. Түүний баруун гар талд нь гуниггүй эх бурхан Осоржамаа (тиб. 'od gser can ma) амар амгалангийн нарны гэрлийг цацруулан байна. Зүүн гар талд нь гоо сайхан тэнгэрийг тулсан Ралжигмаа (тиб. ral gcig ma) бурхан зогсоно. Дарь эхчүүдийн чуулганы бурхад нь шүхэр, бөмбөрийн цохиур, биба, лимбэ зэрэг ялгах тэмдгүүдтэй ажээ. Тэд нь өөрийн эзэгтэйдээ мэхийж өргөл барьц өргөжээ. Найман аюул нь мунхгийн зовлон, “би”-гийн найман янзын үзэл, тэдгээрээс үүсэж байгаа зовлон нь өвчин, гэнэтийн үхэл, муухай зүүд, муу сүнснүүдийн саад хэлбэрээр илэрдэг.

Монголын бурхны шашинд “Дарь эхийн тарнийн түүх” гэдэг Дарнатын бичсэн зохиолууд онцгой ач холбогдолтой, их алдаршсан бүтээл юм. Буриадын дацангуудад бас хэвлэгдэж байжээ. Дарнатын “Дарь эхийн тарни үүссэн түүх” хэмээх зохиолд дайсан халдах, арслан дайрах, заан дайрах, галын аюул, хорт могой хазах, дээрэмчид халдах, шорон, далайн давалгаа, хүн иддэг хүмүүс, уяман өвчин, муу санаат сүнс, ядуурал, ойр дотнынхныгоо алдах, эзэд нь шийтгэх, аянгад нэргүүлэх, зорилгодоо хүрч чадахгүй байх гэсэн арван зургаан аюулыг дүрсэлж бичсэн байдаг. Дарнатын ийнхүү бичсэн нь уянгын халилгүй, эртний Энэтхэг ба дундад зууны үеийн төвөд хүмүүс юмыг шууд хүлээн авч байсныг харуулж байна. Энэ бүтээлийг 1600 онд бичсэн ба харин Дарь эхийн тухай өгүүлсэн үе нь Энэтхэгт бурхны шашин цэцэглэж байсан манай тооллын IX-X зууны үе юм.

Дарнатын “Ядам бурхдын далай” хэмээх алдарт түүвэр зохиолд 417 бурхныг, бүтээлийнх нь хамт товчхон бичсэн байдаг. Энд Дарь эхтэй холбоотой 42-оос доошгүй

ухагдахууныг оруулсан байдаг. “Ядам бурхадын далай” ном нь “Нартангийн 100 бурхан”, “Очирбал” хэмээх арай бага хэмжээтэй хоёр номын хамт хэвлэгдэж байжээ. Дарнат уг бүтээлүүдээс “эхлээд сайнуудыг нь” бүлэглээд, дараа нь Жанрайсиг, Дарь эх, Очирваань зэргээр бурхдынхаа нэрээр хуваажээ. Дараа нь тарнийн ёсны ангиллаар, бурхдын чуулганаар хуваажээ. “Төгсгөлд нь сайнуудыг нь” хэмээн бас хуваажээ. Дарь эхийн өөр өөр хэлбэрүүдийг тэдний хөтөлбөрөөр нь мэдэж авч болно.

Адишагийн уламжлал ёсны (төвөд:lugs kyi Sgrol dkar yid bzhin 'khor lo) Чинтамани-чакра-Тара. Энэ нь голдуу Цагаан Дарь эх нэр бөгөөд нэг нигур, хоёр мутар долоон мутартай, завилж морилсон бурхан юм. Түүний нэр “Хүслийг биелүүлэх хүрд” гэсэн утгатай Чандмань хүрд юм.

Нян лозава (төвөд:Gnyan lugs kyi Sgrol dkar yid bzhin 'khor lo) уламжлалын Чандмань хорол Дарь эх нь гурван мэлмийтэй. Гурав дахь нүд нь магнай дээрээ. Гар хөлийн тавхай дээр нь мэлмий байхгүй.

Маха-пандиты Ванаратны (Mahāraṇḍita Vana-ratna tāṛā, төвөд:Paṇ chen nags rin lugs kyi sgrol dkar yid bzhin 'khor lo) уламжлалын чандмань хорол дарь эх Адишагийн уламжлалын Цагаан дарь эхтэй ижилхэн.

Нян лозава (Gnyan Sgrol yan lag drug pa) уламжлалын зургаан гишүүнт Дарь эх. Энэ нь нэг нигур, хоёр мутартай ногоон дарь эх юм. Түүний нэрээс харахад Шананга бясалгын системтэй холбоотой байна.

Гаадам (төвөд:bka 'gdams lha bzhi'i sgrol ma)-ын дөрвөн бурхны нэг Дарь эх. Энэ бол Ногоон дарь эх бөгөөд нэг нигур, хоёр мутартай, зүүн мутартаа удвал цэцгийн ишнээс зүрхэн тушаа газартаа барингаа хязгааргүй их өгөөмөр сэтгэлийн мутарлага хийж зүүн хөлөө нугалж баруун хөлөө доош буулгажээ. Торго, эрдэнэсээр чимэглэгджээ.

Хачи бандида (төвөд:sgrol ljang kha che pa chen lugs) уламжлалын Ногоон дарь эх (бас нэг ногоон дарь эх гэсэн үг).

Хачи бандида (төвөд:sgrol ljang kha che pa chen lugs) уламжлалын Цагаан дарь эх. Хоёр мэлмийтэй, өөртэйгөө ижил найман бурхнаар хүрээлэгдсэн.

Өдөр нь амгалан, шөнө нь хилэнт дүр барьдаг дарь эх (төвөд: sgrol ma nyin zhi mtshan khro). Амгалан байхдаа яг Ногоон дарь эх шиг, хилигнэсэн үедээ нэг нигур хоёр гартай бадамлянхуа цэцэг, саран дэвсгэр дээр зогссон цагаан лагшинтай Дарь эх. Баруун мутартаа очир, зүүндээ аюул заналын мутарлагатай. Галаар хүрээлэгдсэн бөгөөд бар, ирвэсийн арьс нөмөрч могойн унжлагатай үнэт чулуун чимэгтэй.

Пицушвари Удияна Тара (*самг.*: rīthiśvaṛī uddiyāna-tārā, төвөд:U rgyan sgrol ma gnas kyī dbang phyug ma). Тус бүрдээ гурван мэлмийтэй дөрвөн нигуртай, найман мутартай, улаан лагшинтай, тарнийн бүжиг хийж буй дүртэй. Голын нүүр нь улаан, зүүн гар талынх нь ногоон, баруун гар талынх нь хар, дээд талынх нь шар. Баруун мутартаа дамар, гавал аяга, илд, очир, эрдэнийн чулуу барьжээ. Зүүн мутартаа удвал цэцэг, үнэт чулуу, бороохой, хонх барьжээ. Хатсан гавлын ясан титэмтэй, саяхан тасалсан хүний толгойн хүзүүний чимэгтэй, таван ясан чимэгтэй, барын арьсан ташааны бүстэй.

Чандмань Дарь эх (*төвөд*:sgrol ma yid bzhin nor bu). Шар лагшинтай, нэг нигур, хоёр мутартай, бадамлянхуа, саран дэвсгэр дээр зогссон. Зүүн мутраараа хүслийн модноос жимс тасалж, баруун мутраа өгөхийн мутарлагаар барьжээ. Тэрээр торгон хувцас эрдэнийн чимэгтэй ажээ.

Сажын уламжлалын Улаан Дарь эх (*төвөд*:sgrol ma dmar mo sa lugs). Улаан лагшинтай, нэг нигур, хоёр гартай, саран дэвсэр, улаан бадамлянхуа цэцгэн дээр суужээ. Баруун мутраа өвдөгнөөс дээхэнтээ байрлуулж, дэгээ барьж, зүүн мутартаа улаан удвалын ишнээс барьжээ. Энгийн байдлаар суужээ.

Баялаг бэлгэлдэг Дарь эх (*төвөд*: sgrol ma nor sbyin ma). Ногоон лагшинтай, дөрвөн мутартай, ордонд, бадамлянхуа цэцэг саран дэвсгэр дээр морилжээ. Баруун талын эхний мутар нь буян бэлэглэсэн мутарлагатай, дараагийнх нь эрих барьжээ. Хоёр зүүн мутраараа удвал цэцэг ба ном барьжээ. Торго, эрдэнэсээр гоёсон ба мөн чанарын суудлаар суужээ. Түүнийг гадаад төрх, лагшингийн өнгө өөр бусад найман Дарь эх ба ордны дөрвөн хаалгач хүрээлжээ.

Хоёр туслахтай Махапатиты Шакья Шри уламжлалын (*төвөд*: ma gser mo gtso 'khor gsum paṅ chen śakya śṛī'i lugs) шар Дарь эх. Шар лагшинтай, нэг нигур, хоёр мутартай, энгийн байдлаар суусан. Баруун мутар нь бэлэглэх мутарлагатай (варада-мудре), зүүн мутраараа шар удвал цэцгийг ишнээс нь барьжээ. Түүний баруун гар талд эрдэнэс, жимсээр дүүрсэн аяга, эрдэнийн зүйлээр бөөлжсөн хулгана барьсан шар Замбал бурхан заларчээ. Түүний зүүн гар талд ялалтын дуаз, хулгана барьж арслан унасан Намсрай бурхан байна.

Таван бурхны (*төвөд*: sgrol ma lha lnga) Дарь эх. Баруун мутрынх нь абхая мутарлагыг нь оруулахгүй гэвэл яг л ногоон Дарь эхтэй адилхан. Түүний зүүн талд Пратисара гэдэг чандмань эрдэнэ, аяганд хийсэн бадамлянхуа цэцэг байна. Түүний өмнө



талд шар Маричи, очир, бодь модны мөчир барьжээ. Баруун талд нь улаан Варахи гахай толгойтой бөгөөд гавал аяга хутга барьжээ. Хойд зүгт нь хар Экаджати гавал аяга, хутга барьжээ.

Найман мутартай Дарь эх (*төвөд:phyag brgyad sgrol ma*). Тэрээр ногоон лагшинтай, дөрвөн нигуртай, найман мутартай. Эхний хос гар нь зүрхэн тушаа газраа мэндчилсэн мутарлагатай ажээ. Үлдсэн гурван баруун мутартаа эрх, сум, хүрд барьжээ. Зүүн талын гурван гартаа туг, нум, аяга барьжээ. Тэрээр баруун хөлөө унжуулж суусан ба торго эрдэнэсээр чимэглэгджээ.

Арья-капали Тара (*самг.: ārya kāpali-tārā, төвөд:rje btsun ma kā pa li tā ra*). Тэрбээр хөх ногоон лагшинтай, нэг нигуртай, хоёр мутартай, париджата модыг налан зогсжээ. Баруун мутар нь буяныг бэлэглэсэн мутарлагатай, зүүн мутар нь хамгаалах мутарлагатай ба хөх удвал цэцгийг ишнээс нь барьжээ. Торгон хувцас, бодисадвагийн чимгээр гоёжээ.

Арья Чунда Тара (*самг.: ārya cundā-tārā, төвөд:‘phags ma tsunda tā ra*). Тэрбээр улаан лагшинтай, нэг нигур, хоёр мутартай, бадамлянхуа саран дэвсгэр дээр зандан модны дор суужээ. Задалсан үсээ сувдан хэлхээгээр чимжээ. Баруун мутартаа жимс, зүүн мутартаа дээр нь ном тавьсан бадамлянхуа цэцгийг ишнээс нь барьжээ. Завилан суусан ба торго эрдэнэсээр гоёжээ.

Жонан уламжлал нь Дарь эхийн бүтээлийг нэлээн ховор нандин аргаар хийсээр ирсэн ба өөрийн гэсэн тарни сургаал, нууц аман сургаал зэрэгтэй онцгой бүтээлтэй байдаг. Энэ онцгой хэлбэртэй Дарь эхийг бясалгалын Дарь эх буюу “Дулма налжирма” гэж төвөд хэлээр хэлдэг. Бясалгалын Дарь эх бол өөрийг нь оруулсан 25 бурхан бүхий мандалд байдаг найман мутартай Дарь эхийн догшин дүр юм. Энэ уламжлалыг Энэтхэгийн их шидтэн Буддха-гупта-натхай (*самг.: mahāsiddha buddhagupta nātha*) Төвөдөд оруулсан. Тэр бол Энэтхэгийн сүүлийн үеийн агуу шидтэнүүдийн нэг юм. Тэрээр 70 настай байхдаа Төвөд рүү явж 20 настай байсан Дарнаттай уулзжээ. Тэд ойролцоогоор 1594 онд Төвөдийн төв хэсгийн Нартангаас холгүй уулзжээ. Өөрийн нууц намтартаа энэ уулзалтын ач холбогдлын тухай Дарнат: “Дарь эхийн бясалгал хийхийн өмнөх шөнө... миний арьс илэг болж хувираад дээр нь заавар тайлбар бичиж болохоор болж, хавирга маань үзэг болж, цус маань бэх болж хувирав. Миний яс болон шөрмөс номыг үдэх хэрэгсэл болов”<sup>48</sup> гэж

<sup>48</sup> [Sheehy, 2009]-аас авсан ишлэл, [Tāranātha. Grub chen bud+dha gup+ta'i rnam thar rje btsun nyid kyi zhal lung las gzhan du rang rtog gi dri mas ma sbags pa'i yi ge yang dag pa. In Rje btsun tA ra nA tha'i Gsung 'bum, 'Dzam thang, 17, 313] түүвэрт орсон Дарнатын “Их бүтээлч Будхагуптын намтар”-ыг хэлжээ.

бичсэн байдаг. Дарнат бясалгалын Дарь эхэд бидний олж мэдсэнээр долоо, магадгүй түүнээс ч олон бүтээл зориулсан бөгөөд тэдгээрээс зүрхэн болон тайлбарласан тарни, хураангуйлсан тарни, мандал өргөх арга, өөрийгөө зориулах зан үйл, зориулга ба заавартай мандал өргөх арга нь ихэд алдаршжээ. Тэр өөрөө самгарди, төвөд хэлнээс орчуулж цөөн хэдэн шавьдаа өгсөн бөгөөд энэ бясалгалын Дарь эхийн зориулга нь Дарнатын дамжуулж өгсөн цөөн хэдэн зүйлийн нэг юм.

Зураг 4.10.1. Ногоон дарь эх. Г. Дзанабазар, 1706 он. Монгол улс. Улаанбаатар хот Богд хааны ордон музей.  
Зураг 4.10.2. Дарь эх Шри-Ланка, VI-VIII зуун. Британсий музей, Лондон.

Цагаан Дарь эх (*самг.*: sita tāṛā; *төвөд*:sgrol dkar, *монг.*: сагаγан getelgegci eke) Ногоон Дарь эхийн (*самг.*: śyāma tāṛā; *төвөд*:sgrol ljang, *монг.*: ноγцγан getelgegci eke) дүр нь Занабазарын хамгийн алдартай дээж бүтээлүүдийн тоонд орох ба энэ дүр нь Монгол Улсын бурхны шашны урлалын төлөөлөх чанартай бүтээл юм. Занабазар Дарь эх бурхантай оюун санааны хувьд маш гүнзгий холбоотой гэдэг нь түүний бүтээсэн ховор нандин дүр төдийгүй намтрынх нь хэд хэдэн баримтаар батлагдаж байна. Өндөр гэгээн Занабазар 1693 онд Манжийн хааны ордонд байхдаа Дарь эхийн (Дулмаа юлдог) тусгай зан үйлийн тусламжтайгаар өвчиндөө шаналсан Энх-Амгалан хааныг эмчилжээ. Занабазарын Цагаан Дарь эх ба Ногоон Дарь эхийн алдарт дүрүүд нь энгийн бөгөөд бодитой, тансаг байдал, хөдөлгөөний илэрхийлэл зэргийг өөртөө шингээсэн тул түүний өөрийнх нь ур хийцийн сор болоод зогсохгүй нинжин сэтгэлтэй, эх бурхны дүрээр монголын бурхны шашин дахь урлалын онцлогийг харуулсан дэлхийн хэмжээний хамгийн сайн дээж бүтээлүүдийн нэгд зүй ёсоор тооцогддог юм.

### **Занабазарын нэрэмжит дүрслэх урлагийн музейд буй Цагаан Дарь эх**

Эд. № 69.43.21. 67-640. Хүрэл, алтадмал, өнгө будагтай.

Өндөр 68 см, суурийн диаметр 45 см.

Энэхүү бүтээл Адишагийн (982-1054) уламжлалын бүтээлийн дүрслэлтэй таарч байгаа юм. Дарима (*монг.*: Дариймаа) гэж нэрлэгддэг Цагаан Дарь эхийн (*төвөд*: sgrol dkar bstod pa bzugs so) дууллыг Энэтхэгийн ачари Адиша зохиосон гэдэг. Охидыг их бурхны ивээлд оруулж түүний гайхамшигт нинжин сэтгэлийг аваасай гэсэндээ энэ нэрээр их

нэрлэдэг. Дарь эхийн ерөнхий тарни нь “Ум даарий дүд даарий дүүрэ суухаа” боловч тодорхой дүр бүрд нь өөрийн гэсэн тарнитай байдаг. Цагаан Дарь эх нь “Цагаан ум үсэгнээс үүсдэг. Цагаан Дарь эх найман аюул ба бүх өвчнөөс авардаг. Тэрээр бадамлянхуа цэцэг, саран дэвсгэр дээр очир завилгаагаар суудлаар суужээ. Намрын саран мэт лагшинтай, 16 настай охины лагшинтай, тод цагаан гэрлээр гэрэлтэх ба хүрдний найман хэсэг бүрд Дарь эхийн тарнийн найман үсэг бичигджээ. Тэр бол бүх дээд бурхдын гүнж байхын сацуу аврагч эх, гурван цагийн эх, урт нас бэлэглэдэг чандмань эрдэнэ, амьдралын бүх саад тотгорыг амирлуулдаг, өвчин, бүх саад тотгорыг арилгадаг хэмээн дуулалд бичсэн байдаг” [Андросов 2019: с. 340]. Адишагийн уламжлалын Цагаан дарь эх нь долоон мэлмийтэй, магнай дээрээ нэг мэлмийтэй, хоёр алга, хоёр хөлийн улан дээрээ мэлмийтэй байгаа нь хэзээ ч унтахгүй харж хамгаална гэсэн утгатай.

Цагаан Дарь эх нь зүүн мутраараа цэцэглэж байгаа бадамлянхуа цэцгийн ишнээс нь барьж, баруун мутар нь сайн сайхныг бэлгэдсэн мутарлагатай байна (Зураг 4.10.3). Уг бурхны уран нарийн царай нь гэрэлтэж, бясалгасан байдалтай мэлмийнүүд нь анхааралтай бөгөөд бага зэрэг доош төвлөрч, өнгөрсөн, одоо, ирээдүйг болгоох ажээ. Цагаан Дарь эхийн лагшин нь залуу сайхан, цэвэр гоо үзэсгэлэнтэй бөгөөд өмнөх үеийн энэтхэг Дарь эхүүд ба Ногоон Дарь эхийн тачаангуй байдал харагдахгүй байна. Тэрбээр эртний цэрэг хувцастай залуу хархүүтэй илүү адилхан. Түүний өндөр зүгдөр үснийх нь дүрс нь дундад зууны үеийн монгол цэргийн дуулганы бэхэлгээтэй адилхан байна. Занабазарын алдарт Цагаан дарь эх нь туйлын цэвэрхэн охины дүртэй, энгийн амьдралаас салж бясалгасан шинжтэй. Цагаан Дарь эхийн цэвэр тунгалаг дүр Бясалгалын бурхан ялж төгс нөгчсөн агуу Таван дияаны будда нартай хамт байдаг. Хамт байгаа нь тохиолдлын хэрэг бус юм. Эдгээр бурхад нэг ижил технологиор ижил хэмжээтэй уг барималчийн бусад бүтээлд огт давтагдахгүй гоо зүйтэйгээр бүтээгджээ. Ийм учраас Занабазарын нэрэмжит дүрслэх урлагийн музейд байгаа Цагаан дарь эхийг Таван дияаны бурхны үед буюу 1683 онд бүтээгдсэн гэж үзэж болно.

Зураг 4.10.3а. Цагаан дарь эх. Занабазар. Хүрэл, алтадмал, өнгө будаг орсон. Өндөр нь 68,9 см, Суурийн диаметр 44,8 см. Улаанбаатар хот. Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей.

Зураг 4.10.3б. Цагаан дарь эх. Занабазар. Хүрэл, алтадмал, өнгө будаг орсон. Өндөр нь 68,9 см, Суурийн диаметр 44,8 см. Улаанбаатар хот. Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей. Ар нуруунаас харагдах байдал.

Уг уран баримлын гадаргууг төгс сайн өнгөлсөн болохоор уян хатан, гөлчгөр, арьс нь эрүүл харагдана. Халуунаар алтадсаны үр дүн болсон хувцас чимэгний гялгар гадаргуу, хүйтэн аргаар алтадсаны үр дүн болсон ил харагдаж байгаа арьсны сүүмгэр гадаргуутай хоршиж, арьсыг бодитой амьд харагдуулж байна.

Таван хэсэгтэй титэмний голын хэсэгт бурхны магнай руу унжсан сувдан унжлагатай зээбад<sup>49</sup> байна. Титэмнийх нь хэлбэрийг маш нямбай гаргасан ба монголын үндэсний тоорцог малгайг санагдуулна. Хүзүүний чимэг, бугуйвч, ээмэг, титэмний хэсгүүд нь цагариг, амьтны эвэр дүрсүүдийг янз бүрээр хослуулсан монгол дүрслэх урлагийн энгийн элементүүдээс бүрджээ. Гоёл чимгүүд нь төвгөр, бурхны биен дээр унжиж байгаа нь тусад нь хийж, бэлэн болгоод уран барималд өмсүүлж, зүүлгэсэн гэсэн үг юм.

Зураг 4.10.3в. Цагаан дарь эхийн нигур. Улаанбаатар хот. Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей. Уран баримлын хэсэг.

Зураг 4.10.3г. Цагаан дарь эхийн үсний чимэг. Улаанбаатар хот. Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей. Уран баримлын хэсэг. р.

Зураг 4.10.3д. Цагаан дарь их хажуу талаасаа. Улаанбаатар хот. Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей. Уран баримлын хэсэг.

Зураг 4.10.3е. Цагаан дарь эхийн бадамлянхуа. Улаанбаатар хот. Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей. Уран баримлын хэсэг.

Зураг 4.10.3ж. Цагаан дарь эхийн зүүн мутрын мутарлага. Улаанбаатар хот. Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей. Уран баримлын хэсэг.

Зураг 4.10.3з. Цагаан дарь эхийн бүсний чимэг ба орхимжны үзүүр. Улаанбаатар хот. Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей. Уран баримлын хэсэг.

Торгон хувцас нь маш нимгэн болохоор биед өмсгөсөн нь бараг мэдэгдэхгүй, зөвхөн гоолиг биен дээрх унжиж тунарсан хэсэг, сэнтийн суурин дээрх унасан хэсгээр нь л хувцас байгааг мэднэ. Зөв математик харьцаатай, яг тэгш хэмтэй байдлаар завилж суусан нь Цагаан Дарь эхийг найдвартай, амар амгалан, нугаршгүй, сайхан сэтгэлтэй харагдуулж байна (Зураг 8).

### **Богд хааны ордон музейд байдаг Ногоон Дарь эх**

Хүрэл, цутгамал, алтадсан, өнгө будаг орсон.

Өндөр: 76,5 см. Жин: 54520,0 гр.

<sup>49</sup> Зээ бад (самг.: *kīrti-mukha*, агуугийн дүр төрх) – домгийн мангас бөгөөд өөрийнхөө биеийг өөрөө идээд, толгой, сувдан хэлхээ барьсан гар хоёр нь л үлджээ. Хийдийг хамгаалах, хаалганы бариул болж энэ дүрсийг хэрэглэгддэг. Мөнх бус ба орчлонд эргэлдэхийг бэлгэддэг.

### ***Шүтээний агуулга***

Ногоон Дарь эхийн самгарди нэр Сияма / Шьяма Тара (*самг.*: śyāma tāṛā)-г үгчлэн орчуулбал “Хар аврагч” гэсэн нь Цагаан Дарь эхээс ялгах гэж Хар ногоон аврагч гэсэн утгатай. Төвөд хувилбар нь Дулма (*тиб.* sdol ljan, *монг.* getelgegci noγuyan dar-a eke), яг тодруулбал Должин (*төвөд.*sgrol ljang) “Ногоон аврагч” ажээ.

Өнөө үед Ногоон Дарь эхийн том уран баримлыг ҮШ Богд гэгээний өвлийн ордон байсан бөгөөд одоогийн Богд хааны ордон музейд тусгай павильонд хорин нэгэн Дарь эхийн дунд байрлуулсан байна. Үлдсэн 21 Дарь эхийн баримал хэмжээгээрээ бага 40-42 см-ийн хооронд хэлбэлзэнэ. Өндөр гэгээний намтар судлаачдын нэг Лувсандондовын өгсөн мэдээллээр бол хорин нэгэн Дарь эхийг иж бүрнээр нь гал махбодтой улаан гахай жил (1706) бүтээж, Их хүрээнд Дарь эхийн тусгай хийд байгуулж байжээ. Монгол уламжлалаар хорин нэгэн Дарь эхийг бүтнээр нь, бүх хувцас чимэгтэй нь хамт хөөмөлдөн хийсэн ба гадна тал нь цул метал дотор тал нь хөндий болдог ажээ. Үнэхээр Ногоон дарь эх ба хорин нэгэн Дарь эх ба Цагаан дарь эхийн баримлуудын бүтээсэн арга гадна талаасаа үнэхээр ялгарч харагдана. Цагаан дарь эхийг Таван ялж төгс нөгчсөн бурхныхтай адил технологиор 1683 оны үед бүтээжээ. Өөрөөр хэлбэл Цагаан дарь эх нь Ногоон дарь эхээсээ ойролцоогоор 23 насаар “эгч” ажээ. Алтадсан хүрлийг өнгөөр ялгаагүй боловч урлаач маань өөр өөр давтагдашгүй царай, зан байдалтай бүтээжээ.

### ***Тайлбар***

Мула-Шьяма-Тара (*mula syāma tāṛā / rtsa ba'i sgröl ma ljang gu*) бол нэг нигур, хоёр мутартай хорин нэгэн Дарь эхээ удирддаг Ногоон дарь эх юм. Тэрээр баруун хөлөө буулган (*самг.*: ardha paryanka lalita āsana) баруун мутраа бясалгаж байгаа мутарлагатай (*самг.*:varada mudrā) болгож бадамлянхуа сэнтий дээр сууж зүүн мутраараа цэцэглэж байгаа удвал цэцгийн ишнээс цээжин тус газраа (*khaṭaka mudrā*) барьж, мөн дэлгэрээгүй цэцгийг бас барьжээ. Нигур нь өргөн дугуй, үл ялиг инээмсэглэсэн ажээ. Том магнай дээр нь бурхны нэг шинж тэмдэг болсон том билгийн нүд харагдана. Зулай дээр нь Авид бурхан байгаа нь Авид бурхны толгойлдог Үйлийн язгууртай гэдгийг нь баталж байгаа ба Авид бурхны газар дээрх хувилгаан дүр нь Банчэн лам юм. Хамар нь зөв, үл ялиг Занабазар маягийн монхордуу хэлбэртэй. Урт бүйлсний самар шиг хэлбэртэй нүдээрээ чанх урагш харжээ **(зураг)**. Хэрээний далавч шиг тас хар үс нь маш төвөгтэй байдлаар

сүлжигдэж өндөр зүгдөр болж дөрвөн эгнээ цэцэгтэй сувдан хэлхээ ба унжлагуудаар чимэглэгджээ.

Үзүүрээрээ буржийсан урт хар үс нь мөрнийх нь урдуур унжжээ. Нэг урт туг үс мөрөн дээр нь унжина. Толгойдоо таван дэлбээтэй титэмтэй, эрдэнэсээр чимэглэгдсэн туяхан биеэрээ зүүн гар тийшээ бага зэрэг хазайжээ.

Занабазар энэхүү эх бурхны хувцсыг уламжлалыг эвдэн шийджээ. Нимгэн торгон орхимж их биеийнх нь дээд хэсгийг халхалж ташуу хэлбэрээр зүүн мөрөн дээгүүр нь гарсан ба орхимжийн үзүүр нь мөрөн дээгүүрээ давсан байна. Биеийнхээ дээд хэсэгт нөмрөх ёстой дунгуйгаа өвдөг дээрээ хаясан нь дэвүүр хэлбэртэйгээр сэнтийний хажуугаар унжина. Ногоон Дарь эхийн хөх нь дугуй хэлбэртэй, толгой нь мөлгөр ажээ. Нимгэн доти нь хөл ташааг нь барьж гоолиг биеийг нь харагдуулах ба дотины даавуу нь маш нягт найман сайхан (*төвөд*:bkra shis tag brgyad) бадамлянхуа цэцэг навчин хээтэй ажээ. Ташаан дээр нь төвгөр, төвгөр унжлагатай бүс байна. Бугалга, бугуй, шагай, тавхайн чимэг нь чандмань эрдэнэтэй, бойв, мутар нь жижиг, булцгар, зөөлөн, нямбай хумстай, урт хуруунуудтай. Ногоон дарь эх нь монгол хүний биеийн хэлбэртэй болохоор хөл, гар нь жижиг байгаад зогсохгүй бойв, мутар нь дээд хэсгээрээ өргөн, төгсгөл хэсгээрээ нарийхан байна.

Бурхны найман чимгээс (титэм, ээмэг, хүзүүний зүүлт, урт хүзүүний зүүлт, бугалга, бугуй, шагайн чимэг, унжлагатай бүс) гадна зүүн мөрөн дээгүүрээ сувдан хэлхээ тохсон байдаг энэ нь түүнийг тарни мэддэг гэдгийг нь харуулсан бясалгалын бүс ажээ.

Зураг 4.11.1б Ногоон дарь эх. Занабазарын уран баримал. 1706 он. Хүрэл, цутгамал, алтадсан. Ар нуруунаас нь харсан байдал. Улаанбаатар. Богд хааны ордон музей.

Зураг 4.11.1в. Ногоон дарь эх. Занабазарын уран баримал. 1706 он. Хүрэл, цутгамал, алтадсан. Баруун талаас. Улаанбаатар Богд хааны ордон музей.

Биеийнх нь ил хэсгийг хүйтэн аргаар алтаджээ. Энэ нь энэ эх бурхны биеийг сүүмгэр туяатай, амьд хүний арьс шиг болгожээ. Энэ нь чимэг, хувцас зэрэг халуун аргаар алтадсан гялгар хэсэгтэй нь хоршиж харагддаг. Ер бусын уян налархай зөв харьцаатай энэхүү уран баримал нь амьд, дулаахан, амьсгалж байгаа, бодитой харагддаг.

Рис.4.11.1г. Нигур ба титэм. Ногоон дарь эх. Занабазарын уран баримал. 1706 он. Хүрэл, цутгамал, алтадсан. Ар нуруунаас нь харсан байдал. Улаанбаатар Богд хааны ордон музей.

Зураг 4.11.1д. Авид бурхан Дарь эхийн зулайг чимсэн нь. Дээд талаасаа. Занабазарын уран баримал. 1706 г.

Бадамлянхуа сэнтий нь маш өндөр, хагас дугуй хэлбэртэй, хэвтээ чиглэлээр нь огтолбол хоёр давхар дунд хэсэгтээ бөмбөгөр тэгш хэмтэй, давхар дэлбээнүүдтэй бадамлянхуа юм. Суурийн дээд ба доод ирмэгийг нь сувдан хэлхээгээр чимжээ. Сэнтийний доод хэсэг нь гурван давхар хүрээтэй. Бадамлянхуа цэцгийн дэлбээнээс нэг залуу нахиа гарч ирж түүн дээр баруун хөлөө тавьсан байдаг. Шүншиг ёроолын таг нь байхгүй. Сэнтийний ар талд нь лагшингийн гэрлийг нь тогтоох урт нарийхан нүх байгаа ба харамсалтай нь үүнийг нь олж чадаагүй байна.

Зураг 4.11.1е. Доти дээрх хээний хэсэг. Ногоон дарь эх. Занабазарын уран баримал. 1706 он. Хүрэл, цутгамал, алтадмал. Улаанбаатар. Богд хааны ордон музей.

Рис.4.11.1ж. Ёроолоосоо харагдах байдал. Ногоон дарь эх. Занабазарын уран баримал. 1706 он. Хүрэл, цутгамал, алтадмал. Улаанбаатар. Богд хааны ордон музей.

Занабазарын ногоон Дарь эхийг нас биед хүрсэн эмэгтэйн гоо сайхныг харуулсан гэж үздэг ба хүчтэй, эрч хүч дүүрэн, хүн амьтныг хайрладаг, хүсэл эрмэлзэлтэй эмэгтэй байна гэсэн сэтгэгдэл төрүүлдэг. Тэрээр маш их өрөвдөж хайрласан, бүхнийг уучилсан нинжин сэтгэлтэй, жинхэнэ ээж хүн шиг туслахад бэлэн байдалтай харагдана. Занабазарын найз байсан атаархагчдын явуулгаас болж залуугаараа нас барсан найз бүсгүйнх нь эмгэнэлт хувь заяаны тухай домог Ногоон дарь эхтэй холбоотой гэж ярьдаг.

Зураг 4.11.1з. Занабазарын уран баримлын хэсэг, Ногоон дарь эх, 1706 он. Баруун гарын өгөх мутарлага.

Зураг 4.11.1и. Сэнтийнээс доош унжиж байгаа орхимжны үзүүр. Занабазарын уран баримал. 1706 он. Хүрэл, цутгамал, алтадмал. Улаанбаатар. Богд хааны ордон музей.

Занабазарын ногоон Дарь эхэд хүмүүс маш их анхаарал хандуулж, маш гүнзгий хайрладаг. Монголын алдарт зохиолч С.Эрдэнэ Занабазар хэмээх романдаа ногоон Дарь эхийн баримлын тухай "... үнэндээ бол төгс тайвширсан, хүмүүсийн зовлонг ертөнцөөс чөлөөлөгдсөн, өршөөсөн, нинжин сэтгэл гаргасан дүртэй бөгөөд үүрд мөнх уруу оджээ. Урт тод мэлмий нь уян хатан, уриалгахан ухаанаар гэрэлтжээ. Гоё шулуун хамар, энгийн байдалтай жижиг бумбагар уруул, булцгар хацартай, хүүхэд шиг том бөмбөгөр магнай нь эх бурхны алтан титмийн дор ч гэсэн хэвээрээ харагдана. Эх дэлхийг тэжээж, үр удмыг нь үргэлжлүүлсэн эхийн хэвлийтэй, залуу охины гоё хөхтэй, дулаан ялгарсан, уян налархай нуруу нь горхи шиг баруун тийшээ бүсэлхийг нь хазайлгаж үзэсгэлэнтэй галбирыг нь тодруулан харуулна. Бүсэлхий нь нарийн ч биш, бүдүүн ч биш, мутар ба хөлийнх нь

байрлал номхон дөлгөөн байдалтай харагдана. Мэдрэмж ихтэй эмэгтэй хүний гоо үзэмжийг бурханлаг бодгальтай нууцлаг байдлаар нэгтгэжээ. Ногоон Дарь эх нь энэтхэг, төвөд бүтээлүүдтэй огт адилгүй бурхан зурах хатуу тиг ба тиг алдагдал хоёрын яг зааг дээр бүтээгдсэн. Хувцасгүй юм шиг мөртөө нүцгэн гэж хэлж болохооргүйгээр чимэг, зүүлттэй. Бурханлаг, хүнлэг, бодит ба бэлгэдлийн шинжтэй, дотоод ертөнц ба гадаад хэлбэр дүрсийг гаргаж чадсан. Урлаач хүний итгэл найдвар, нүдний ур, гарын урыг илэрхийлж чаджээ. Ухаан ба эрдмийг нэгтгэсэн. Энгийн бөгөөд ер бусын, ялж төгс нөгчсөн нинжин сэтгэл оргилон гарч нууцлаг байдлаар илэрсэн гунигийн аялгуу мэт. Монголоор сэтгэсэн монгол хүн. Уур хилэн, зовлон, итгэл, хайр хүндэтгэл, хүч, сүр хүч, хүсэл мөрөөдөл, урам хугаралт гээд бүгдийг Халхын ногоон Дарь эх өөртөө шингээжээ. Амьтан бүхэнд ашиг тусаа алдалгүй өгдөг ариун эх бурхан сияама тара буюу төвөдөөр Дулмаа, Аминагийн амилсан алтан дүр...” гэж бичсэн байдаг [Эрдэнэ 1989: с. 86].

### **Занабазарын хорин нэгэн Дарь эх**

Монгол улсын Улаанбаатар хотын Богд хааны ордон музейд байнгын үзмэр болон оршдог Занабазарын бүтээсэн уран баримлууд нь бүгд нэг загвараар Адишагийн бүтээл хийх зааврын дагуу бүтээгджээ. Гэхдээ өнгө, царайны илэрхийллээрээ ялгардаг. Зургаан цагаан, дөрвөн улбар шар, гурван шар, хоёр улаан хүрэн, хоёр хар лагшинтай бурхад ажээ. Ногоон Дарь эхийн Маричи, Экаджата хэмээх хоёр дагуул нь 21 Дарь эхийн тоонд ордоггүй. Ногоон Дарь эх нь хамгийн гол Дарь эх нь бөгөөд бусад 21 Дарь эх нь түүний дүр юм. Ийнхүү нийт 24 бурхан болж байгаа юм. Өндөр гэгээн Занабазар 21 Дарь эхийг бүтээхдээ багшийнхаа зааврыг дагасан болох нь уран баримлаас нь харагдаж байна. Богд хааны ордон музейгээс өгсөн нэрсийн дагуу дараах хүснэгтийг хийлээ [БХОМШУ 2011: с. 50-71].

Эдгээр бурхдын дунд Правира (*монг.*: Тара Түргэн Баатар Гэтэлгэгч, *самг.*: Praviṅgātārā, төвөд:rab tu dra' bo'i sgröl ma) алга байна. Мөн очир, бодь модны<sup>50</sup> мөчир барьсан Маричи бас алга байна. Ийнхүү энэ иж бүрдэл дотор гурван уран баримал дутуу байна<sup>51</sup>.

<sup>50</sup> Бодь мод (*лат.* Saraca asoca) Азийн халуун бүст ургадаг тод улаан цэцэгтэй мод. Уйтгар гунигаас салгадаг ариун мод гэж шүтдэг.

<sup>51</sup> Энэ иж бүрдлийн Маричи уран баримал нь Нью-Йорк хотын Рубины музейд байж магадгүй (Rubin Museum of Art). Тэнд байгаа бурхан гадаад байдал биеийн үзүүлэлтүүдээрээ таарч байгаа юм. (Өндөр нь 40,5 см). Хоёр дахь бурхантай адилхан бурхан хувийн цуглуулгаас дуудлага худалдаанд орж байжээ. Нигур, хумбага сав нь гэмтсэн байв. Одоо хаана байгаа нь мэдэгдэхгүй байгаа.



Дараах хүснэгтэд 21 Дарь эхийн тухай товч мэдээллийг оруулсан ба музейд тавигдсан дарааллыг баримтлаагүй болно.

№ п/п	Дарь эхийн нэр орос, монгол, самгарид төвд хэлээр	Лагшингийн өнгө; суудал; мутарлага; ялгах тэмдэг;	Дүр байдал; гүйцэтгэх үүрэг	Хэмжээ (см), жин (гр.), Эд. № Богд хааны ордон-музей
1.	Зеленая Тара/ Ногоон Гэтэлгэгч-эх/ Mula-syāma-tārā / Rtsa ba'i Sgrol ma ljang gu/	ногоон; баруун хөлөө доош унжуулсан түргэн туслах суудал; баруун мутар нь өгөхийн мутарлагатай + бумба + дэлбээлсэн бадамлянхуа; зүүн гар нь айдас үргээх мутарлагатай + дэлгэрээгүй бадамлянхуа	амгалан; чуулганы тэргүүн, аврагч	76,5x48x29,5 54500 гр. Эд.№24-1-96.
2.	Луноцветная буюу Успокаивающая Тара/ Ихэд амирлуулагч Candra-kānti-tārā / dkar mo zla mdangs kyi sgrol ma/	намрын сар мэт цагаан; баруун хөлөө доош унжуулсан түргэн туслах суудал; баруун мутар нь өгөхийн мутарлагатай + бумба + дэлбээлсэн бадамлянхуа; зүүн гар нь айдас үргээх мутарлагатай + дэлгэрээгүй бадамлянхуа	амгалан; амгаланг бүтээгч	41 x 26x16. 9855 гр. Эд.№24-1-97.
3.	Золотоцветная Тара/ Алтан өнгөт эх/ Kanakanānti-tārā / gser mdog can gyi sgrol ma	улаан алтны өнгөтэй; баруун хөлөө доош унжуулсан түргэн туслах суудал; баруун мутар нь өгөхийн мутарлагатай + бумба + дэлбээлсэн бадамлянхуа; зүүн гар нь айдас үргээх мутарлагатай + дэлгэрээгүй бадамлянхуа	амгалан; нас, баяр баясгаланг үржүүлэгч, буян үйлдэгч	40,5 x 26x16,7. 10450 гр. Эд.№24-1-98
4.	Тара, обладающая Ушнишей/ Тийн үснийрт эх/ Uṣṇīṣa-vijaya-tārā / gtsug tor nnam par rgyal ba'i sgrol ma /	уултай адил алтан; баруун хөлөө доош унжуулсан түргэн туслах суудал; баруун мутар нь өгөхийн мутарлагатай + бумба + дэлбээлсэн бадамлянхуа; зүүн гар нь айдас үргээх мутарлагатай + дэлгэрээгүй бадамлянхуа	амгалан; нас буяныг (жаргал) үржүүлдэг	40x26x16,5. 10385 гр. Эд.№21-1-99.
5.	Спасающая [мир] слогом “Хум”/ Хум дуун дуурсгагч Hūm-svara-nādinī-tārā / hum sgra sgrog pa'i sgrol ma/	шүрэн уул шиг улбар шар; баруун хөлөө доош унжуулсан түргэн туслах суудал; баруун мутар нь өгөхийн мутарлагатай + бумба + дэлбээлсэн бадамлянхуа; зүүн гар нь айдас үргээх мутарлагатай + дэлгэрээгүй бадамлянхуа <b>хөмсгөө зангидсан</b>	хагас амгалан; бусдыг нэгтгэж өгдөг	40x25,5x16,5 Жин 10330 гр. Эд. №24-1-100.
6.	Гурван ертөнцийг ялагч/ Тара, Победительница трех Миров/ Trailokya-vijaya-tārā / 'jig rten gsum las nnam par rgyal pa'i sgrol ma/	улаан хүрэн; баруун хөлөө доош унжуулсан түргэн туслах суудал; баруун мутар нь өгөхийн мутарлагатай + бумба + дэлбээлсэн бадамлянхуа; зүүн гар нь айдас үргээх мутарлагатай + дэлгэрээгүй бадамлянхуа <b>хөмсгөө зангидсан</b>	хагас амгалан; шулмасын ухааныг самууруулж, хор хөнөөлөөс нь авардаг	40,5x25,5x16,2. 9775 гр. Эд.№24-1-101
7.	Всерушачая Тара / Машид эвдэгч г. эх/ Vādi-pramardaka-tārā / rgol ba 'joms pa'i sgrol ma	темно-синяя, зүүн хөлөө доош унжуулсан түргэн туслах суудал; баруун мутар нь өгөхийн мутарлагатай + бумба + дэлбээлсэн бадамлянхуа; зүүн гар	Догшин; бусдын шидийг үгүй хийдэг	40,2 x 26x16. 9435 гр. Эд.№24-1-102.

		нь айдас үргээх мутарлагатай + дэлгэрээгүй бадамлянхуа; <b>билгийн нүдтэй ба хурц соёотой;</b>		
8.	Подавляющая омрачения/ Шулмас дарагч/ Duḥka-dahana-tārā / sdug bsngal bsreg ba'i sgröl ma	улаан хүрэн, баруун хөлөө доош унжуулсан түргэн туслах суудал; баруун мутар нь өгөхийн мутарлагатай + бумба + дэлбээлсэн бадамлянхуа; зүүн гар нь айдас үргээх мутарлагатай + дэлгэрээгүй бадамлянхуа хөмсгөө зангидсан.	хагас амгалан; дайсныг дардаг	40x26x16. 10310 гр. Эд.№24-1-103.
9.	Тара, символ Трех Драгоценностей/ Гурван эрдэнийн бэлгэдэл	цагаан; баруун хөлөө доош унжуулсан түргэн туслах суудал; баруун мутар нь өгөхийн мутарлагатай + бумба + дэлбээлсэн бадамлянхуа; зүүн гар нь айдас үргээх мутарлагатай + дэлгэрээгүй бадамлянхуа	амгалан; бүх аюулаас авардаг	40,5 x 26x16. 9815 гр. Эд.№24-1-104
10.	Подчиняющая своей власти мир / Ертөнцийг эрхэндээ Хураагч/	улаан; баруун хөлөө доош унжуулсан түргэн туслах суудал; баруун мутар нь өгөхийн мутарлагатай + бумба + дэлбээлсэн бадамлянхуа; зүүн гар нь айдас үргээх мутарлагатай + дэлгэрээгүй бадамлянхуа; хөмсгөө зангидсан.	Хагас амгалан; чөтгөрийг (дайсныг) дардаг)	40,5x25,5x16,5 см. 8995 гр. Эд.№24-1-105.
11.	Тара, избавляющая от Бедности/ Үгээгүйг арилгагч/ Vipanni-barhaṇa-tārā / phongs pa sel ba'i sgröl ma	улаан-шар; баруун хөлөө доош унжуулсан түргэн туслах суудал; баруун мутар нь өгөхийн мутарлагатай + бумба + дэлбээлсэн бадамлянхуа; зүүн гар нь айдас үргээх мутарлагатай + дэлгэрээгүй бадамлянхуа	амгалан; ядуугийн зовлонгоос авардаг	40,5 x 25,5x16 см 9550 гр. Эд.№24-1-106.
12.	Дарующая счастье/ Өлзий өгөгч/ Maṅgala-loka-tārā / bkra shis sbyin pa'i sgröl ma	алтан өнгөтэй; <b>очир завилгаа;</b> өгөхийн мутарлагатай + дэлгэрээгүй бадамлянхуа, зүүн гар нь өгөхийн мутарлагатай.	амгалан; Мөнхийн жаргал бэлэглэдэг	42 x27x12. 11400 гр. Эд.№24-1-111.
13.	Пылающая, как огонь <sup>52</sup> Гал мэт бадрангуй/ 'bar ba'i 'od can ma	Хар; баруун хөлөө доош унжуулсан түргэн туслах суудал; баруун мутар нь өгөхийн мутарлагатай + бумба + дэлбээлсэн бадамлянхуа; зүүн гар нь айдас үргээх мутарлагатай + дэлгэрээгүй бадамлянхуа; <b>билгийн нүдтэй, хурц соёотой</b>	догшин; саад тотгороос салгана	38x26x16,9. 9590 гр. Эд.№24-1-108.
14.	Гневающаяся Тара/ Агуурлыг үйлдэгч/ Bhṛkuṭī-tārā / khro gnyer gyō ba'i sgröl ma	Хар; <b>зүүн</b> хөлөө доош унжуулсан түргэн туслах суудал; баруун мутартаа <b>дигуг хутга</b> барьсан, зүүн мутар нь бясалгалын мутарлагатай + <b>гавал аяга; билгийн нүдтэй, хурц соёотой.</b>	догшин; дайсныг буцаадаг	41,8 x 25,7x17. 10855 гр. Эд.№21-1-107.
15	Тара великого покоя,	Цагаан;	амгалан;	40,5 x26 x 16.

<sup>52</sup> Үсний чимэг эрдэнийн чулууг салгаж авсан байв.

	Их амарлиулан г.э./ Mahā-sānti-tārā / zhi ba chen po'i sgrol ma	баруун хөлөө доош унжуулсан түргэн туслах суудал; баруун мутар нь өгөхийн мутарлагатай + бумба + дэлбээлсэн бадамлянхуа; зүүн гар нь айдас үргээх мутарлагатай + дэлгэрээгүй бадамлянхуа	амгаланг бүтээдэг	9375 гр. Эд.№ 24-1-110.
16	Спасающая от трех бед/ Гурван аюлыг дарагч/ 'jig rten gsum yon ... sgrol ma	цасан цагаан; баруун хөлөө доош унжуулсан түргэн туслах суудал; баруун мутар нь өгөхийн мутарлагатай + бумба + дэлбээлсэн бадамлянхуа; зүүн гар нь айдас үргээх мутарлагатай + дэлгэрээгүй бадамлянхуа	амгалан; муу муухайг амирлуулдаг	40,5 x 25,8x16. 9935 гр. Эд.№24-1-112
17.	Спасающая [слогом /] “Хум”Ухаан Хум-аар гэтэлгэгч/	улаан; баруун хөлөө доош унжуулсан түргэн туслах суудал; баруун мутар нь өгөхийн мутарлагатай + бумба + дэлбээлсэн бадамлянхуа; зүүн гар нь айдас үргээх мутарлагатай + дэлгэрээгүй бадамлянхуа	амгалан; газрын хүчийг нэмэгдүүлдэг	40,5x25,5x16,6. 9310 гр. Эд.№24-1-109.
18.	Очищающая от ядов/ Хор өвчнийг арилгагч/	Цагаан сувдны өнгөтэй баруун хөлөө доош унжуулсан түргэн туслах суудал; баруун мутар нь өгөхийн мутарлагатай + бумба + дэлбээлсэн бадамлянхуа; зүүн гар нь айдас үргээх мутарлагатай + дэлгэрээгүй бадамлянхуа; <b>хөмсгөө зангидсан</b>	хагас амгалан; бүх хорыг цэвэрлэдэг	40 x 26x16. 10760 гр. Эд.№24-1-113
19.	Освобождающая от страданий/ Зовлонг арилгагч Śokavino-dana-tārā / mya ngan sel ba'i sgrol ma	Сувд мэт гэрэлтэй, цасан цагаан; баруун хөлөө доош унжуулсан түргэн туслах суудал; баруун мутар нь өгөхийн мутарлагатай + бумба + дэлбээлсэн бадамлянхуа; зүүн гар нь айдас үргээх мутарлагатай + дэлгэрээгүй бадамлянхуа	амгалан; бүх зовлонгоос салгадаг	40x 25,5x16,5. 10100 гр. Эд.№24-1-114.
20.	Устраняющая заразные болезни (эпидемии)/ Хижиг өвчнийг арилгагч/	Үүрийн цолмонгийн өнгөтэй баруун хөлөө доош унжуулсан түргэн туслах суудал; баруун мутар нь өгөхийн мутарлагатай + бумба + дэлбээлсэн бадамлянхуа; зүүн гар нь айдас үргээх мутарлагатай + дэлгэрээгүй бадамлянхуа;	амгалан; өвчөн, халдварт өвчнөөс салгана	40,5x26x16,5. 10990 гр. Эд.№24-1-115
21.	Совершающая все деяния/ Үйлс бүхнийг бүтээгч/	Цагаан; баруун хөлөө доош унжуулсан түргэн туслах суудал; баруун мутар нь өгөхийн мутарлагатай + бумба + дэлбээлсэн бадамлянхуа; зүүн гар нь айдас үргээх мутарлагатай + дэлгэрээгүй бадамлянхуа	амгалан; үйлийг гүйцээхэд тусалдаг	40,5x25,5x16,5. 10440 гр. Эд.№24-1-116.

Цагаан ба Ногоон дарь эхийн ялгарах тэмдэг нь бадамлянхуа цэцгүүд юм. Цагаан Дарь эх нь нэг дэлгэрсэн бадамлянхуа цэцгийн ишнээс эрхий болон ядам хуруугаараа барьсан байдаг. Харин ногоон Дарь эх нь хоёр хөх удвал цэцэг барьсан байдаг. Нэг дэлгэрсэн цэцгийг баруун мутартаа барингаа бэлэглэх мутарлага үзүүлсэн байдаг. Нөгөө дэлгэрээгүй цэцгийг зүүн мутраараа зүрхэн тушаа газартаа барьсан байдаг. Цэцгийн

цоморлог нь бурхны мөрөн дээр харагдана. Дэлгэрсэн цоморлог нь Шагжамуни бурхныг, дэлгэрээгүй цэцэг нь ирээдүйн бурхан Майдар бурхныг илэрхийлдэг.

Занабазарын Дарь эхүүдийн ихэнх ялгарах тэмдэг нь барагдашгүй их эрдэнийн сав хумбага буюу бумба юм. Энэ хумбага нь хавтгай ёроолтой, дугуй их биетэй, нарийн хүзүүтэй. Энэ үнэт хумбагыг бурхны мандалд их өргөдөг ба үнэт чулуугаар чимж хүзүүг нь гоё торгон туузаар ороодог. Энэ хумбагаас шидэт мод ургадаг ба үр жимс, цэцэг нь хүсэл биелүүлж бүх төрлийн эрдэнэсийг бий болгож харин модны үндэс нь мөнхийн рашаанд нэвчсэн байдаг. Энэ хумбага нь дундаршгүй бөгөөд рашааныг нь хэчнээн гоожуулсан ч дүүрэн хэвээр үлддэг [Бир 2011: с.197].

Энэ сав нь хамаг амьтны амьдралын эх сурвалж, ээжийн үр хөврөл тээдэг хэвлий ба эмэгтэй хүний эхлэл ба бүх мөнх бус бодгалиудын буцаж шингэдэг агуу газрын хэвлий хоёрыг илэрхийлсэн эрт дээр үеэс явж ирсэн бэлгэдэлтэй юм. Заримдаа хумбага буюу бумбыг муу энергийг саармагжуулж сайн энерги баялаг буян тогтоохын тулд тавьдаг. Дарь эхүүд бараг бүгдээрээ Ногоон дарь эх шиг суудлаар буюу баруун хөлөө доош буулгаж бадамлянхуа цэцгэн дээр тавьсан байдаг. Харин 2 Дарь эх л зүүн хөлөө буулгасан байдаг. (Ногоон Дарь эхийн догшин дагуул Бригхути мөн догшин Вадипрамардака) Мангала-лока Тара очир завилгаа суудлаар морилдог).



Зураг 4.11.2. Намрын саран мэт Цагаан дарь эх. (санскр.: Candra-kānti-tārā/төвөд: dkar mo zla mdangs kyi sgrol ma/монг.:Ихэд амирлуулагч). Хэмжээ: 41 x 26x16 см., жин 9855 гр. Эд.№24-1-97. Монгол улс. Богд хааны ордон музей.




Рис.4.11.3. Уурласан дарь эх буюу Экаджати (санскр.: Bhṛkuṭī-tārā khro төвөд: gnyer gyuo ba'i sgrol ma/монг.: Агуурлыг үйлдэгч. Хэмжээ: 41,8 x 25,7x17. жин 10855 гр. Эд.№21-1-107. Монгол улс. Богд хааны ордон музей.



Зураг 4.11.4. Дундардаггүй рашаантай алтан хумбага нь 21 Дарь эхийн үндсэн ялгарах тэмдэг юм. (санскр. nidhana kumbha; төвөд.: gter gyi bum pa).



Зураг 4.11.5. Бараг бүх Дарь эх баруун бойвоо буулгаж Бадамлянхуа цэцгэн дээр тавьсан байдаг.

### Банзрагч (Махапратисара)

### ***Шүтээний агуулга:***

Панчаракши буюу (*самг.*: pañcarakṣā; *төвөд*:so sor 'bring ma lha lnga; *монг.*: banzarakc/sosorbaram Burhan) Таван сахиус бурхан. Банзрагчийн зан үйл буюу Таван сахиус бурхны зан үйл нь бүх монголчуудад маш алдартай бүтээл юм. Банзрагч судрыг унших нь Монгол Улсын бүх том сүм хийдүүдийн байнгын зан үйлийн нэг юм. Банзрагчийг сүсэгтнүүд маш их шүтдэг ба эдгээр нь хүүхэд эхийг хамгаалдаг бурхан юм. Зарим айлуудад Банзрагч судар, сахиус байдаг. Энэ бол таван хэсэгтэй, таван эх бурханд зориулсан уншлагатай судруудын эмхэтгэл бөгөөд монгол болон буриад айлуудын номын сан, бурхан тахилд нь түгээмэл тохиолддог.

Бурхны номд Банзрагчийн хүчийн тухай бичсэн байдаг. Бурхан багш Шагжамуни үнэнийг хайж гэрээсээ явах үед эхнэр Яшодара нь жирэмсэн, Рахул хүү нь гэдсэнд нь байжээ. Эхнэр хүүхэд хоёроо ирээдүйн аюулаас хамгаалахын тулд явахаасаа өмнө тэр Банзрагч бурхны хамгаалалтын хүчийг дуудсан байдаг. Дараа нь үеэл ах Девадатаас тэр хоёрт маш олон удаа аюул учруулж байсан боловч Банзрагч бурхны хүчээр тэд эрүүл саруул үлдсэн ажээ. Банзрагч бол төвөд хэлнээс монгол хэл уруу орчуулагдсан анхны бурхны номуудын нэг бөгөөд нэг биш удаа давтагдан орчуулагдсан байдаг ба 1308 онд Чойжи Одсэр Хүлэг хааны үед [Ligetī 1948: 328] орчуулсан байдаг. Шаравсэнгийн 1320 онд хийсэн орчуулгыг Тогоонтөмөр хааны (1333-1368) ивээл дор бараар 1345 онд хэвлэсэн байдаг [Sagaster 1973]. Энэхүү барласан ном эхнийхээ хуудаснаас эхлээд зурагтай байдаг (Рис.4.12.1(а-д)). Энэ номыг Энх-Амгалан хааны (1654-1722) үед хэд дахин хэвлэсэн байдаг ба Аюуш гүүш, Намхайжамц, Ойрадын Зая бандида нар орчуулжээ [Pañcarakṣa 1345]. Иймээс энэ ном буддын бурхан бүтээх тигтэй холбоотойгоор янз бүрийн орчуулгатай байдаг. Тухайлбал, “Алтан ганжуур”-т 14-р зууны алдарт эрдэмтэн Шаравсэнгийн хийсэн Банзрагч номын орчуулга харин “хар” Ганжуурт 16-р зууны сүүл үеийн Аюуш гүүшийн Банзрагчийн орчуулга байдаг.



Зураг 4.12.1(а-д). Раṅsarakṣā хэмээх судрын 1345 онд хэвлэгдсэн монгол барын орчуулга дахь таван Банзрагчийн зураг. Монгол улсын Үндэсний номын сан. Эд.№12883/97.

Таван сахиус Банзрагч (самг.: Pañca rakṣā; төвөд: so sor 'brang ma lha lnga) нь өөртөө: 1) самг.: Mahāpratisarā; төвөд: so sor' brang ma chen mo; Агуу дагуул; 2) Mahāmantrānusariṇī/gsang rjes' dzin ma; Тарнийн агуу эх бурхан; 3) Mahāshitavatī/sbil ba'i tshal/Сэрүүн агуйн агуу эх бурхан; 4) Mahāsāhasrapramardini / stong chen rab 'jom ma /Мянган дайсныг сөнөөгч агуу эх бурхан; 5) Mahāmāyūri /rma bya chen mo/Агуу тогос эх бурхныг тус тус багтаадаг. Эдгээр бурхад нь Крия тарнийн ёсны таван Dharaṇī эхийн цуврал бурхдын дүр юм. Эдгээр бурхад нь Их хөлгөний чуулган дахь Дарь эхүүд бөгөөд Ялж төгс нөгчсөн язгуурын бурхдын эх бурхад нь болдог. Янз бүрийн судлаач нар энэ дарь эхүүдийг манай тооллын IY-IX зуунд байсан гэж үздэг. Энэ шүтээн нь Энэтхэг, Непал, Япон, Төвөд, Бутан, Монголд их тархсан.

Олон тохиолдолд энэ таван бурханд хандацгаадаг. Тухайлбал, хүүтэй болох, зовохгүй төрөх, муу муухай зүйлээс зайлсхийх, өвчнөө эдгээх, халдварт өвчнөөс аврагдах, амьтан могой хордохоос аврагдахын тулд энэ бурханд ханддаг. Адишагийнх байна уу Бари лозавагийнх байна уу гэдгээсээ шалтгаалж эдгээр эх бурхдыг зурах тиг өөр байдаг. Банзрагчийн Непал хувилбар Садхана-самучайя, Улаан Ганжуур, Гурван зуун бурхны гэх мэт номонд буй хувилбар Очирбалыг [Bhattacharyaya 1958, ВIT 1986; Популярные буддийские тексты ... 2000, ДТВ 2002] олон янзын бүтээлийн уламжлалуудаас шалтгаалж

өөр өөрөөр бүтээдэг. Монгол цуглуулга дахь энэ бурхны дүр судар шигээ тийм их олон байдаггүй гэхдээ судар дээр нь энэ таван бурхныг зурсан байдаг. Одоохондоо бидэнд 17-р зууны үеийн зураг нь байхгүй байна. Өндөр гэгээн Занабазар (1635-1723) маш сайн номлосны хүчээр монголчууд 18-р зуунаас эхлээд Банзрагчийн номыг уншдаг болсон байж болох юм. Монголын эрдэмтэд Банзрагчийн баримлыг Занабазарын бүтээл гэж үздэг [Цултэм 1982; Ульзий 1992; Бира, 2001].

Банзрагчийн гайхамшигтай хүрэл баримал Гандан хийдэд байдаг ба гол шүтээнүүдийн нэг нь болдог. (Зураг 4.12.2).



Зураг 4.12.2. Махаприатисарын (Брайшир) уран баримал. Улаанбаатар. Гандан.

#### **А.Алтангэрэлийн цуглуулгад байдаг Банзрагч бурхан**

Торго, 48 х 34,5 см., шороон будаг, тушь. Хүрээ нь төвгөр луун хээтэй хул торго. XVII зууны төгсгөлд хамаарагдана.

Энэ шүтээн зурган дээр Адиша гэгээний зохиосон “Своду Нартан” Nartang Gyatsa [NG 429] -нд бичигдсэн таван Банзрагч бурхныг дүрсэлсэн байдаг. Тэд бүгдээрээ зөөлөн дүртэй бөгөөд бадамлянхуа суурин дээр чөлөөтэй байдлаар (сукхсана) морилсон байдаг. Ялж төгс нөгчсөн таван эх бурхан мандлыг бүрдүүлж байхад “13 Банзрагч бурхан” таван өөр өнгөтэйгөөр бий болж ертөнцийн тохирсон тохирсон зүгтээ очиж суудаг. Голлох бурхных нь байр өөрчлөгддөг [Танака 2013].



Гол дунд нь урт наслах, өвчин аюулаас хамгаалах Банзрагч бурхан дүрслэгдсэн байна. Энэ бурхан нь шүтээн зургийн бараг бүх зайг эзэлжээ. Цагаан өнгийн лагшинтай, арван мутар, гурав гурван мэлмийтэй, гурван нигуртай, бодисадвагийн бүх чимэгтэй, нигур бүрийнх нь дээр байгаа титэм нь таван өөр өнгийн эрдэнийн чулуугаар чимэглэгдсэн дугуй унжлагатай ээмэг, хоёр хүзүүний зүүлттэй, бугалга, бугуй, шагайндаа чимэгтэй, маш гоё дотио хөх өнгийн бүсээр бүсэлсэн, дотины дээд тал улаан хүрэн өнгөтэй бөгөөд алтан хээтэй. Олон өнгийн судалтай дунгуйных нь урт үзүүр нь уг бурхны өвдөг дээгүүр гарч, бадамлянхуа сэнтий дээр нь дэвүүр хэлбэрээр унажээ. Мөрөн дээрээ улаан шар дунгуй тохжээ. Ер бусын цэнхэр додиг тунарсан нь цээж мөрийг нь халхална. Өндөр зүгдөр үсийг нь эрдэнийн чулуун шигтгээтэй хэлхээгээр чимжээ.

Зураг4.12.3а. Банзрагчийн шүтээн зураг. Торго 48 х 34,5 см. А.Алтангэрэлийн цуглуулга. Монгол улс. Улаанбаатар хот.



Зураг 4.12.36. Махамантра-анусарини (самг.: Mahāmantrānusarīṅī, төвөд: gsangs rjes' dzin ma, Их тарнийн эх бурхан)



Зураг 12.3в. Махашитавати (санкр.: Mahāshitavati, тиб.: sbil ba'i tshal, Сэрүүн агуйн эх бурхан)



Зураг 4.12.3г. Махасахасра-прамардини (санскр.: Mahāsāhasrapramardīni, тиб.: stong chen rab 'jom ma, Мянган дайсныг сөнөөгч их эх бурхан) Зураг 4.12.3д. Махамаюри (санскр.: Mahāmāyūrī, тиб.: rma bya chen mo, Их тогос эх бурхан)

Маш гоё хуруунуудтай хумсыг нь маш нарийн зурсан янз бүрийн ялгах тэмдэгтэй гол хоёр гартаа илд, нум барьсан баруун мутрууддаа очир, сум, өгөх мутарлагатай, шүхэр барьсан, зүүн мутрууддаа ялалтын туг, чандмань, сүх, шар туузтай цагаан дун барьжээ. Алга ба хөлийн ул нь улаан өнгөтэй ба голд нь жижигхэн алтан хүрд харагдана. (Зураг 4.12.3з-и). Таних тэмдгүүд нь нарийн тодорхой зурагджээ. Жишээ нь, гялалзаж байгаа чандмань эрдэнээс бурхны алган дээр үнэт чулуу хэрхэн бутран унаж байгаа нь харагдана. (Зураг 5). Тэргүүнийг нь тойрон цацарсан оройн гэрэл нь (самг.: śīraśakra) ягаан өнгөтэй, биеэс нь цацарсан лагшингийн гэрэл нь цайвар, сарны гэрлийн өнгөтэй. Энэ эх бурхны тансаг, тод, бадамлянхуа сэнтий нь гурван давхар дэлбээтэй байна. Хамгийн том дэлбээнүүд нь хөх ногоон солбилзсон өнгөтэй, дээд талынх нь дэлбээнүүд нь алтан, дохиуруудын багц мэт харагдана. Доод талын дэлбээнүүд нь ягаан, хөх, ногоон өнгөтэй ажээ. Үлдсэн дөрвөн бурхан нь шүтээн зургийн дөрвөн буланд бадамлянхуа цэцгэн дээр чөлөөт байдлаар суужээ.

Зүүн дээд буланд нь Махамантра-анусарини (санкр.: Mahāmantrānusarīṅī, төвөд:gsangs rjes' dzin ma, Их тарнийн эх бурхан) байна. Түүний үүрэг нь саад тотгорыг арилгаж, муу муухай бүхнээс хамгаалах. Энэ бурханд хандвал өвчин зовлонгүйгээр урт удаан амьдарна. Тэр хөхөвтөр өнгөтэй (бүтээл дээр хар гэж бичсэн байдаг) нэг нигур, дөрвөн мутартай, дээш өргөсөн хоёр мутартай, илд, сүх барьж баруун доод талын гар нь өглөгийн мутарлагатай (varadamudrā) ба нөгөө гартаа цалам атгажээ. Шамтав нь хүрэн шаргал өнгөтэй, дунгуй нь ягаан өнгөтэй.

Баруун дээд буланд нь Махашитавати (санкр.: Mahāshitavatī, төвөд:sbil ba'i tshal, Сэрүүн агуйн эх бурхан) байна. Гараг эрхэсийн муу нөлөө, зэрлэг амьтан, хорт хорхой шавьжаас хамгаалдаг. Лагшингийн өнгө нь ягаавтар улаан, нэг нигур, дөрвөн мутартай, Их тарнийн эх бурхны адил зүйл барьсан, шар ногоон шамтавтай, шаргал дунгуйтай.

Зүүн доод буланд нь Махасахасра-прамардини (санкр.: Mahāsāhasra-pramardini, төвөд:stong chen gab 'jom ma, Мянган дайсныг сөнөөгч агуу эх бурхан) байна. Муу сүнснүүдээс хамгаалдаг. Шар лагшинтай (баруун дээд талын гурван мутар ба хүзүү нь хүрэн өнгөтэй), улбар шар шамтавтай, хөх унжлагатай, алтлаг ягаан дунгуйтай, гурван нигуртай (шар, хар, цагаан) Махапратисаратай адилхан зүйлс барьжээ.

Баруун доод буланд нь Махамаюри (самг.: Mahāmāyūrī, төвөд:rma bya chen mo, Их тогос эх бурхан) байна. Ногоон лагшинтай, нэг нигур, хоёр мутартай, ягаавтар улаан алтан хээтэй шамтавтай, хүрэн хөх дунгуйтай, баруун мутартаа тогосын өднүүд барьсан, зүүн мутар нь бясалгалын мутарлагатай (varadamudrā) ажээ. Тогосын өд нь бүх төрлийн хорноос хамгаалахын тэмдэг, учир нь тогос ямар ч хорыг идсэн хорддоггүй. Энэ бүх эх бурхад дугуй биетэй, монгол царайтай, нарийхан бэлхүүстэй, өргөн цээж, өргөн ташаатай. Царай нь тайван, найрсаг гэхдээ эд нар бол жинхэнэ хамгаалагч нар юм. Дөрвүүлээ муу зүйлийг тас цавчих илдтэй. Шүтээн зургийн голын доод талд нь таван мэдрэхүйд өргөсөн өргөлтэй алтан болон хүрэл аяганууд байна. Том аяганд нь хөгжмийн зэмсэг (самг.: vina), улаан-алтан торго, толь, сайхан үнэртэн уугьсан цагаан хясаа байна. Энэтхэгийн лийр хэлбэртэй айва (самг.: bilva) гэдэг жимс харагдана. Бурхны ар дэвсгэр нь ой мод, өвстэй ногоон толгод байна. Цайвар цэнхэр тэнгэр, саарал үүл, нар сартай. Өнгөний дизайныг маш уран хийж жинхэнэ торгоны шинж чанарыг уран нарийн ашиглаж бурхан өөрөө сар мэт зөөлөн гэрэлтэж шөнийн харанхуйг арилгаж байна.

### **Сосорбарам бурхны уран баримал**

(*төвөд*: Rdo rje gur las 'byun ba so sor brang ma; *монг.*: Сорорбарма).

Хүрэл, барилгын зүйл ба сэнтийг салангид цутгасан

Өндөр 25,5 см, өргөн 20 см., гүн 9 см.

Халуунаар зөөлөн шаргал туяатай алтадсан, хар хөх өнгө орсон.

XVII зуун –XVIII зууны эхэн үе. Монгол улсын Булган аймгаас авчирсан.

**Тайлбар:**

Амгалан дүрээр морилсон, тэгш хэмтэй нугалсан хөлтэй самбха-асана (*төвөд*: rting zlum po'i stang) морилсон байна. Маш залуухан түүний зөөлөн царай нь үл мэдэг инээмсэглэсэн. Хүүхдийнх шиг төвгөр, өндөр магнайтай, билгийн нүдтэй. Баруун гараа өндөрт өргөж очир бариултай илд барьж айлгах мутарлага (*самг.*: tarjanī mudrā, *төвөд*: zhi bai sdigs mdzub) үзүүлжээ. Зүүн мутраараа зүрхэн тушаа газраа номын хүрд барьжээ. Толгой дээрээ таван дэлбээтэй титэмтэй, тууз нь толгойн ард талд нь унжсан. Цэцгэн эрих нь чихэн дээр нь байрлажээ. Титмийнх нь тойрог нэгэн янзын цэцгэн эрихээр чимэглэгджээ. Үсээ маш уран нарийн янзалжээ. Өндөр овоолсон зүгдөр үсээ алтан хавчаартай гэрээр тогтоосон ба бадамлянхуа суурин дээр шигтгэсэн эрдэнийн чулуугаар чимжээ. Зүгдөрөнх нь өмнө талд нь цэцгийн дэлбээ ба голд нь Бэрозана бурхны дүр байна. Хөх туяатай хар үс нь мөр нуруун дээрээ хуваагдан унжсан байна. Хоёр нь мөр рүү нь хоёр туг үс, ар нуруу руу нь гурван туг үс унжжээ.

Олон давхар хүзүүний зүүлт нь цээжний дээд хэсгийг бүхэлд нь хагас дугуй хэлбэрээр бүрхжээ. Урт сувдан хоёр давхар зүүлт нь хүйс хүртэл нь унжжээ. Өргөн шамтав нь өвдөг хүртэл нь дээш өргөгдөж хормой нь бадамлянхуа суурины ард урд уруу нь унжжээ. Олон тооны үнэт чулуун унжлагатай тансаг бүс нь шамтавыг бүрхэж хөлийн өсгий хүртэл нь унжжээ. Бугалга, бугуй, шагайн чимэг нь титэм шигээ арвин. Торгон дунгуй нь нуруу мөрөн дээр нь зөөлөн долгиотож, урт үзүүр нь гар ташааг нь даган унжиж суурин дээр тунарчээ. Том хөхний толгойтой дугуй том хөхтэй. Бурхны ар тал шүн хийх дөрвөлжин нүх байв.

Бадамлянхуа сэнтий нь уртасгасан зууван хэлбэртэй гол хэсэгтээ давхар татагдсан цэцгийн самар дэлбээтэй ба дэлбээнүүд нь солбиж байрласан. Суурийн доод ба дээд ирмэгийг сувдан хэлхээгээр чимжээ.


Суурийнх нь шүн нь (*төвөд*: gzhung gzhing) хадгалагдан үлджээ. Ёроолынх нь таган дээр алтадмал Нацагдоржийг товойлгон хийжээ. Парист болсон үзэсгэлэнгийн дараа хул

шар өнгөтэй бас нэмэлт тамга даржээ. Суурийн ар талд нь лагшингийн гэрлийг тогтоогч байна. Энэ уран баримлын онцлог нь эх бурхны уян зөөлөн, залуу, сэтгэл хөдөлгөм дүр төрхийг цэргийн сүр хүчний элементүүдтэй хослуулсан явдал юм. Түүний ялгах тэмдгүүд нь бурхны номын бэлгэ тэмдэг болсон хүрдийг зүүн мутартаа барьсан байх ба энэ нь эмэгтэй хүний эрч хүч гэсэн илтгэжээ. Дээш өндөр өргөсөн баруун гарт нь буй илдийн айлгасан хөдөлгөөн нь эрэгтэй хүний билиг билгүүнийг илтгэж байна. Үснийх нь дугуй нүхтэй металл бүрхүүл нь 13-14-р зууны үеийн монгол цэргийн дуулгыг санагдуулам [Сыртыпова 2015].

Ваджрапанджара тарнийн ёсны Пратисара дагиныг Ваджрапанджара Пратисара гэж нэрлэдэг. Энэ нь Хэбазарын тарнийн ёсонд хамаарагддаг ба Панчаракши чуулганы Бхутадамара Ваджрапани, Цагаан Билиг билгүүн, Цагаан Пратисара бурхадтай бас холбоотой.



Зураг 4.12.4а. Сосорбарам бурхны уран баримал. Гууль, 25,5x20,0x9,0 см. А. Алтангэрэлийн цуглуулга. Өмнө талаасаа.




Зураг 4.12.4б. Сосорбарам. А. Алтангэрэлийн цуглуулга. Ар талаасаа.



Зураг 4.12.4в. Сосорбарам. А. Алтангэрэлийн цуглуулга. Ёроолын таг.



Зураг 4.12.4г. Сосорбарам бурхны уран баримал. Гууль, 25,5x20,0x9,0 см. А. Алтангэрэлийн цуглуулга. Хүзүүний чимэг.



Зураг 4.12.4д. Сосорбарам бурхны уран баримал. Гууль, 25,5x20,0x9,0 см. А. Алтангэрэлийн цуглуулга. Баруун хажуугаас



Рис.4.12.4е. Сосорбарам бурхны уран баримал. Гууль, 25,5x20,0x9,0 см. А. Алтангэрэлийн цуглуулга. Илд барьсан баруун гарын мутарлага.